



БРИТАНИЙН ЭЛЧИН
САЙДЫН ЯАМ



ТРАНСПЭРЭНСИ
ИНТЕРНЭШНА
МОНГОЛ

Дэлхий Нийтийн Авлигын ТАЙЛАН 2007

Шүүхийн авлига - улс орнуудын тайлан

ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ

DDC
345.0265
Д-893

Copyright © 2009 Транспэрэнси интернэшнл-Монгол

Транспэрэнси интернэшнл - Монголын бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү бүтээлийг Транспэрэнси интернэшнл-Монголын зөвшөөрөлгүй хэвлэн олшруулах, ишлэл хийлгүй хуулбарлан ашиглах, фото зураг авах, бичлэг хийх, цахим мэдээлэл болгон ашиглахыг хатуу хориглоно. Ашиглах тохиолдолд зохиогчоос бичгээр зөвшөөрөл авна.

Зохиогч: Транспэрэнси Интернэшнл
Хянан тохиолдуулсан: Ц.Цогт
Техник редактор: Н.Ганболд
Макет, дизайн: Ж.Хүрэлсүх

ISBN 978-99929-77-04-3

Их Британи Кембридж Дээд Сургуулийн “Пресс” төвөөс анхлан 2008 онд гаргасан. Кембридж, Нью-Йорк, Мельбурн, Мадрид, Кейп Таун, Сингапур, Сао Паоло Кембридж Сургуулийн “Пресс”
Эдинбургийн цамхаг, Кембридж, CB 8RU, Ихх Британи
www.cambridge.org
Англи хувилбарын талаар мэдээлэл авах хаяг.
<http://www.cambridge.org/catalogue/catalogue.asp?isbn=9780521727952>

© Transparebce International 2008

British Library-аас уг номын Англи хувилбарын каталогжсан бүртгэлийг судалж болно. Энэхүү Монгол хувилбар нь Англи хувилбарын нэгээхэн хэсэг болно.

ISBN 978-0-521-70070-2

Гарчиг

Удиртгал <i>Huguette Labelle, Chair of Transparency International</i>	6
Өмнөх үг <i>Dr Kamal Hossain</i>	8
Товч дүгнэлт: Шүүхийн авлигын тулгамдсан асуудлууд <i>Транспэрэнси Интернэшнл</i>	11

ХОЁРДУГААР ХЭСЭГ: Шүүхийн авлига – Улс орнуудын тайлан

Удиртгал	23
Алжир улсын шүүх засаглал: бүтэлгүй эхлэлээс бүрхэг ирээдүй рүү	29
Азербайжаны хуулин дахь шинэтгэл ба түүний хэрэгжилтийн зөрүүтэй байдал	35
Бангладешт шударга ёс замхарч байна	41
Камбож улсын шүүх засаглал дахь авлига	47
Чили Улс зарим талаараа амжилттай	53
Коста Рик улсад ил тод байдлыг дэмжсэн нь авлигатай тэмцэхэд тус болж байна	58
Хорват: Шилжилтийн процесс үргэлжилсээр	63
Европын холбоо ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа ч дээрээс доош чиглэсэн хяналтын тогтолцоо нь Чехийн шүүхийн шинэтгэлийг удаашруулж байна	68
Египетийн шүүхэд харьцангуй өөрчлөлт гарч байна	73
Гүрж улсад авлигын эсрэг шинэтгэл өрнөсөөр	79
Гана улсад компьютержсэн шүүхүүд хэргийг шуурхай шийдвэрлэж байна	84
Гватемала дахь шүүхийн авлига ба цэргийн уламжлал	88

Энэтхэгийн шүүхийн хойрго байдал	93
Израилийн Дээд шүүх: өөрсдийн санаагаа хэрэгжүүлсээр л	98
Кенийн шүүх дахь “эрс шинэчлэл”	103
Монголын хуульчдын хүрээн дэх авлига	109
Мароккогийн язгууртан дээдсийн эрх мэдэл ба шүүхийн хараат бус байдал	115
Балбын “доголдолтой” шүүхийн байгууллагад өөрчлөлт хийгдэх боломж тохиож байна	120
Нигер дэх эрх мэдлийн хуваарилалт	125
Пакистан: Шүүх дэх хүлцэнгүй байдлын тогтсон “дэг”	131
Туйлдуулсан дайн тулаан Палестины шүүх засаглалыг дордуулж байна	138
Шүүхийг хянаж буй байдал нь Панамын элитүүдэд ял завших боломжийг хангаж байна	143
Парагвайн шүүх дэх улс төр, ураг төрлийн хор уршиг	148
Филиппин: Шүүхийн дорвитой шинэчлэлийн хандлага	152
ПШГ (Папуа Шинэ Гвиней) –ийн шүүхийг шинэчлэхэд улс төрийн дэмжлэг чухал	158
Румыны шүүхийн үйл ажиллагааны авлига ба дутагдал	164
Зүй бус үйлдлүүд Өмнөд Африкийн шүүхийг сүйтгэн сүйрүүлж байна	169
Шри Ланкийн шүүх дэх авлига	175
Туркийн шүүхийн үйл ажиллагаа: авлигыг ул үндсээр нь устгах зорилготой байна	181
Их Британийн Нэгдсэн Вант улс (НВУ)–ын шүүхийн хариуцлага, ил тод байдлын тогтолцоог боловсронгуй болгох нь	187
Замбийн шүүхийг шинэчлэхийн төлөө тэмцэл	194

ТАЛАРХАЛ

Энэ номыг уншигч Танаа

Дэлхий нийтийн авлигын тайлан 2007 – Шүүх тогтолцоон дахь авлига, ном нь дараахь 3 хэсэгээс бүрдсэн юм. Үүнд:

Нэг дүгээр хэсэг: **Шүүхийн авлига - харьцуулсан шинжилгээ**

2-р дугаар хэсэг: **Улс орнууд - шүүхийн авлигын тухай тайлан илтгэл**

3-р дугаар хэсэг: **Судалгаа**

Энэ удаад Та бүгдийн гар дээр очиж буй энэ номонд 31 улс орны шүүх засаглалын тухай судалгаа, тайлан орсон болно. Эдгээр судалгааг тухайн оронд үйл ажиллагаа буй Транспэрэнси Интернэшнл байгууллагын салбарууд боловсруулсан юм.

Бидэнд энэ номыг хөрвүүлж өгсөн П. Өнөрмаа, Б. Оюунчимэг, Сутай дээд сургуулийн багш Б. Чинзориг, ариутган шүүж, мэргэжлийн туслалцаа үзүүлсэн Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч, Хууль зүйн сургуулийн багш Ц. Цогт, хууль эрх зүйн хичээл заадаг их, дээд сургуулиудын багш, хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудад зориулсан сургалт, семинарыг удирдан явуулж, презентаци хийх МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Дэд захирал, Философийн доктор, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, Профессор Н. Лүндэндоржид талархаж буйгаа илэрхийлж байна. Түүнчлэн, уг номыг монгол хэлнээ хөрвүүлэх, сургалт семинар зохион байгуулах боломж олгож, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Их Британийн Элчин сайдын яамны ажилтнуудад гүнээ талархаж байгаагаа уламжилж байна.

Бидний авлигын эсрэг тэмцлийг дэмжиж, сэтгэл гарган ажилладаг дээр дурдсан хүмүүс болон Н. Ганболд захиралтай “Бенби сан” компанийн хамт олонд үргэлж баярлаж явдгаа илэрхийлье.

Энэхүү тайлангуудыг 2006 оны сүүлийн улирлын байдлаар бэлтгэсэн байгаа тиймээс зарим орны тайланд буй мэдээллүүд хуучирсан байх тал байгааг эрхэм уншигч Та болгооно уу.

Хүндэтгэсэн,

Д. Сүхбүрэн,

Гүйцэтгэх захирал,

Транспэрэнси Интернэшнл - Монгол

УДИРТГАЛ

Huguette Labelle, Chair of Transparency International

Авлигатай хийх тэмцлийн үр дүн шүүх тогтолцооны үйл ажиллагаанаас шууд хамаардаг тул энэ жилийн Дэлхий нийтийн авлигын тайлан 2007 энэ салбар луу анхаарлаа чиглүүлсэн юм. Авлигын эсрэг хэрэгжүүлэх цогц арга хэмжээний гол цөм нь үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээ байдаг бөгөөд тэдгээрийн хэрэгжилт нь шударга, өрөөсгөл бус шүүх тогтолцооны үйл ажиллагаанаас шууд хамааралтай байдаг. Бусад салбартай харьцуулахад шүүх системд гарсан авлигын хор уршиг илүү ноцтой бөгөөд засахад маш их хэцүү байдаг. Шүүхийн авлига нь хүний ухамсар, ёс суртахууныг доройтуулж, хүний эрхийг зөрчиж, үндэсний хөгжлийн хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж, засаглалын чанарыг эрс бууруулдаг. Ийм учраас ард түмний төлөө ажилладаг төр засаг нь эрх зүйт төрийг байгуулаад зогсохгүй ард түмний хүсэл, шаардлагыг хангахуйц, хараат бус бие даасан, үр нөлөөтэй шүүх засаглалтай байх хэрэгтэй.

Шүүхийн ихэнх ажилтнууд өөрсдийн мэдлэг, ур чадварыг ард түмний эрх ашгийн төлөө үйлчлэхэд зориулж, үнэнчээр зүтгэдэг. Гэвч зарим албан тушаалтнууд баяжих, албан тушаал хөөцөлдөх, эрх мэдэлд шунах зэргээр өөрт олгогдсон эрх мэдлээ урвуулан ашиглах явдал цөөнгүй гардаг. Их, бага ямар нэг хэмжээгээр шүүх тогтолцоонд авлига байгаа цагт төрийн аль ч салбар, эдийн засгийн үйл ажиллагаанд авлига хуулиас гадуур оршсоор байдаг. Үнэн хэрэгтээ, хараат бус бие даасан шүүхгүй газар хээл хахууль нь шинэ “Эрх зүйт төр” болдог.

Транспэрэнси Интернэшнл нь олон оронд шүүх системийн авлигатай тэмцэх ажилд олон жил хүчин зүтгэж ирсэн. Тухайлбал, авлигын талаар судалгааны ажил хийх, авлигын асуудлыг задлан шинжлэх, улс орны шүүх тогтолцоон дахь шүүгчийн томилгооны процесст дүн шинжилгээ хийх, шүүх салбарын ажилтнуудын ёс зүйн стандартыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах, өөрийн үндэсний бүлэг байгуулагууд болон иргэний нийгмийн бусад байгууллагуудаар дамжуулан шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, шүүх системийг гажуудуулж буй нөхцөл байдлыг хаах үүднээс шаардлагатай хууль тогтоомж гаргахын тулд лобби явуулах зэрэг олон ажлыг нэрлэж болно.

Транспэрэнси Интернэшнл энэ салбарт дан ганц өөрийн хүчээр амжилттай ажиллах боломжгүй юм. Энэ ном хуулийн хэрэгжилтийг хангах байгууллагуудын үйл

ажиллагааг авлигын хор хөнөөлөөс ангижруулахын тулд олон хүн идэвхи зүтгэл, хүчин чармайлтаа хэрхэн зориулж байгааг харуулжээ.

Энэ номд хувь нэмрээ оруулсан зохиолчдын ихэнх нь хүний эрхийн төлөө тэмцэгчид юм. Учир нь авлигатай хийх тэмцэл нь ямагт хүний эрхийн төлөө тэмцэлтэй харилцан шууд хамааралтай байдаг.

Авлигын хор хөнөөлийг бууруулахад нөлөөлөх хүчин зүйлс, шүүхийн ажилтнуудыг авлигад өртөхгүй байлгахын тулд авч хэрэгжүүлж болох олон арга хэмжээний тухай энэ номд өгүүлжээ. Тухайлбал, шүүхийн авлигын хэргийг илрүүлэх, цээрлүүлэх хариуцлагын тогтолцоог сайжруулах, шүүхийг улс төр, эдийн засгийн болон зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгийн нөлөөнөөс хамгаалах арга замыг бий болгох, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, олон нийтийн зүгээс шүүх системийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг нэмэгдүүлэх, шүүхийн ажилтнууд албан үүргээ шударгаар гүйцэтгэх наад захын нөхцлийг бүрдүүлэх зэрэг арга замуудын тухай өгүүлжээ. Зохих ёсны хүндэтгэл хүлээж, хангалттай цалин хөлс авч буй шүүгч авлигад өртөх нь бага байдаг.

Өнөөдөр авлига өргөн дэлгэрсэн, заналхийлэл сүрдүүлэг ноёрхсон нийгэмд амьдарч буй олон эгэл иргэд хээл хахуультай идэвхитэй тэмцэж байна. Энэ номыг бүтээх явцад *Транспэрэнси Интернэшнл*-ийн (ТИ) гишүүд *Dr Ana Cecilia Magallanes Cortez-д TI 2006 Integrity Award* шагналыг гардуулсан билээ. *Dr Ana Cecilia Magallanes Cortez* Перугийн ерөнхийлөгч *Альберто Фужиморигийн* дотно найз, тагнуулын дарга асан *Vladimiro Montesinos*- оор ахлуулсан 1500 хүнтэй гэмт хэргийн бүлгийг мөрдөн шалгах ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэсэн юм. Одоо ерөнхийлөгч *Альберто Фужимори* ихээхэн хэмжээний авлига авсан хэрэгт холбогдон шалгагдаж байна.

Dr Magallanes нь Перугийн шүүхийн томоохон албан тушаалтнууд тухайлбал шүүхийн дарга, холбооны прокурор асан, дээд шүүхийн хэд хэдэн шүүгч, бусад шатны шүүгчид, прокуроруудыг баривчлах ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэсэн юм. Тэр Латин америкийн шинэ үеийн шүүгч, прокуроруудын бахархал болсон байна. Энэ номыг түүнд төдийгүй шүүхэд ажилладаг, шударга ёсыг тогтоох үйлсээсээ ухраагүй, түүнтэй адил олон хүнд зориулсан юм. Бид тэдний авлигын бүх хэлбэрийг үл тэвчих зан чанар, шүүхийн зарчимч байдлыг дээдлэн, нийгэмд ихээхэн хувь нэмэр оруулж буй үйл ажиллагаа зэргээс суралцах хэрэгтэй юм.

ӨМНӨХ ҮГ

Dr Kamal Hossain

Авлигын бүх хэлбэрт эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай хуулийг бий болгох нь авлигатай тэмцэх ажлын нэг гол бүрэлдэхүүн хэсэг юм. 10 гаруй жилийн өмнө *гадаадад хээл хахууль өгөх явдал* нь татварын хөнгөлөлт эдэлж, авлигач улс төрчид өөрсдийн хулгайн хөрөнгийг дэлхийн банкны төвүүдэд нууцаар найдвартай хадгалуулж болдог гэдгийг мэддэг байлаа. Тэр үеэс хойш үндэсний болон олон улсын хууль тогтоогчид уг асуудлыг нарийн судалсны дүнд авлигын дээрх үйлдлийг нарийн тодорхойлж, хориглох болсон.

Гэсэн хэдий ч авлигатай тэмцэх ажилд тулгарч буй бас нэг томоохон бэрхшээл бол шүүх тогтолцооны тусламжтайгаар шударга бус явдлыг таслан зогсоож, зөрчигдсөн эрхийг сэргээж, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явдал юм. Харин шүүгчийн, өргөн утгаараа шүүхийн алдаатай үйл ажиллагаа нь авлига газар авах хөрс суурийг бэлтгэж өгдөг. Ийм орчинд хамгийн сайн авлигын эсрэг хууль ч ач холбогдлоо алддаг.

Дэлхий нийтийн авлигын тайлан 2007–г (ДНАТ) шүүхийн үйл ажиллагаа руу чиглүүлсний гол шалтгаан нь авлигатай хийх тэмцлийн гол цөмтэй салшгүй холбоотой. Түүнчлэн үүнийг ТИ-ийн дэлхий нийтийн хөдөлгөөний 100 гаруй байгууллагын үйл ажиллагаанаас харж болно. Тухайлбал, тэдгээр үндэсний хэмжээний байгууллагууд нь шүүгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдний гаргаж буй шийдвэр үнэн зөв эсэхэд үнэлэлт өгөх, хэт ярвигтай процесст оролцож буй иргэдэд эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, шүүхийн албан тушаалд нэр дэвшиж буй хүмүүст тавих шаардлагын талаар нийтээр санал бодлоо илэрхийлэх, хуваалцах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. *ДНАТ 2007*–ийн өмнөх дугаарт манай үндэсний байгууллагуудын мэдээлснээр шүүхийн авлига нь тухайн улс орны хувьд хамгийн ноцтой асуудал болохыг дурьдсан байдаг. Үүний зэрэгцээ бусдын нөлөөнд амархан автдаг шүүгч, шүүхүүд нь авлигатай тэмцэх ажлын үр нөлөөг бууруулж, хэрэгжих явцыг сулруулж, эрх зүйт төрийг мөхөөдөг билээ.

Номын зарим бүлэгт шүүгч, шүүхийн ажилтнууд хэрхэн гадны шахалт дарамтаас болж авлигад автдагийг харуулсан ба төрийн эрх мэдлийг хэрхэн хуваарилах талаарх эрх зүйчдийн олон зууны туршид маргаж ирсэн шүүгч бие даасан байхын зэрэгцээ хариуцлагатай байх зохист харьцааг хангах талаарх асуудлыг авлигын

өнцгөөс харж, судалжээ. *ДНАТ 2004* –т улс төрийн авлигыг судалсан бөгөөд үндэсний эрх зүйн систем дэхь авлига нь ихэнх тохиолдолд улс төрчдийг гэмт хэрэгтэн болоход хүргэдэг гэдгийг энэ ном дахин батлан харуулжээ.

Номын хоёр дахь гол санаа нь шүүхийн авлигаас болж дэлхийн олон оронд жирийн иргэд хэрхэн зовж байгааг харуулахад чиглэсэн юм. Миний хувьд үүнийг дурьдах нь илүү чухал. Энэ байдлыг Бангладешийн нөхцөл байдлаас харж болно. Энэ орны гүйцэтгэх засаглал нь доод шатны шүүхийн бүх шүүгчдийн томилгоо, тэднийг албан тушаал дэвшүүлэх, шилжүүлэх болон сахилга батын хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлыг шийдвэрлэх эрх мэдлийг гартаа атгасан байдаг. Гэтэл Үндсэн хууль болон олон нийтийн зүгээс энэ эрхийг Дээд шүүхэд өгөх ёстой гэж үздэг бөгөөд ингэснээр улс төрийн нөлөөнөөс шүүх засаглалыг ангид байлгах зарчим хангагдана. Төрийн гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг албан ёсоор тусгаарлаагүй байдал нь шүүх системд авлига нүүрлэх нөхцлийг бүрдүүлдэг. 2005 онд Бангладешийн *Транспэрэнси Интернэшнлээс* хийсэн судалгаагаар доод шатны шүүхэд хандсан иргэдийн 2/3 нь ойролцоогоор нэг хэрэгт 108 ам. долларын хээл хахууль өгч байсан гэсэн судалгааны дүн байдаг. Энэ нь дэлхийн хамгийн ядуу оронд амьдардаг хүний жилийн дундаж орлогын 1/4 тэй тэнцэнэ. Шүүх ингэж арилжааны дэлгүүр болтлоо доошлоод зогсохгүй хүний эд хөрөнгийн эрх цаашлаад эрх чөлөөг зөрчиж байна гэсэн үг юм.

ДНАТ 2007 -ын ихэнх хэсэг нь хууль хэрэглэх түвшний шүүгч болон шүүхийн ажилтнуудын үйл ажиллагааг судлахад чиглэсэн. Гэвч шүүхийн систем нь үүнээс өргөн хүрээтэй бөгөөд тухайлбал цагдаа, хуульч, прокурор нь хэргийг шүүхэд шилжихээс өмнөх шатанд оролцдог бол хэргийг шийдвэрлэсний дараа шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий шүүхийн системийн бүрэлдэхүүнд ордог шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид болон бусад ажилтнууд энэ системд багтдаг. Бодит байдал дээр нийгэм дэхь авлигын ерөнхий түвшин нь шүүхийн авлигын түвшинтэй харилцан хамааралтай байдаг. Энэ нь авлигатай хийх тэмцлийн гол цөмд шүүх систем байх ёстой гэсэн үндэслэлийг бататгадаг. Магадгүй, шүүхийн ажилтнуудаас албан тушаалаа хувийн ашиг хонжоо олоход ашиглах байдал нь нийгэмд авлига улам газар авах болсныг харуулж байна гэж үзэх үндэстэй.

Иймээс *ДНАТ 2007*–д нэг төвтэй тойргуудын зарчмын дагуу эхлээд шүүхийн авлига, дараа нь түүний шалтгаан, шүүхийн авлигыг таслан зогсоох, эрүүлжүүлэх арга замыг, улмаар хууль тогтоох, хэрэгжүүлэх системийг, эцэст нь шүүх оршин буй тэр нийгмийг судалсан байна.

Энэ номд бичсэн эрдэмтдийн өгүүлэл, 32 орны шүүхийн системд хийсэн *ТИ*-ийн үндэсний байгууллагуудын судалгаа шүүмж, мөн холбогдох бусад сэдвээр хийсэн эмпирик судалгаанууд нь бидэнд энэ талаар цаашид авах арга хэмжээний зорилтуудыг тогтооход тус болох учиртай. Түүнчлэн энэ ном хуулийн сургуулийн оюутнууд, дагалдан шүүгчид болон шүүхийн мэргэжилтнүүдэд шүүхийн авлига нь хохирогчид ямар хүнд тусдаг болохыг танин мэдүүлэх, ийм байдалд орсон тохиолдолд хэрхэн зөв шийдвэр гаргах, олон улсын стандартыг зөв хэрэглэх

талаар мэдлэг олгоно. Жишээлбэл, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох асуудал одоо цагт хэцүү биш болсон.

Энэ ном нэг талаас үндэсний хэмжээний шинэчлэлийн хүрээнд авлигын эсрэг өргөн хүрээтэй тэмцэл хийж буй иргэдэд болон мэргэжилтнүүдэд шүүхийн авлигыг илүү гүнзгий танин мэдэхэд чухал ач холбогдол бүхий гарын авлага болно.

Хуулийн номын санд хэзээч очиж үзээгүй боловч бидэнтэй санаа нийлдэг хүмүүс, тухайлбал сэтгүүлч, хүний эрхийн төлөө тэмцэгчид, ТББ-ууд болон удаан хугацааны турш шүүхээр үйлчлүүлж, шударга шүүхийг шаардаж буй хүмүүсийн гар дээр очихын зэрэгцээ тэдний дуу хоолойг олон нийтэд хүргэнэ гэдэгт бид итгэж байна.

ТОВЧ ДҮГНЭЛТ: Шүүхийн авлигын тулгамдсан асуудлууд

Транспэрэнси Интернэшнл

Авлига нь дэлхийн олон оронд шүүх тогтолцоог сулруулж, хохирогч, яллагдагчийн шударга, тэгш эрхтэйгээр шүүхээр үйлчлүүлэх үндсэн эрхээ эдлэх боломжийг хязгаарлаж байна. Энэ бол ТИ-ийн Дэлхий нийтийн авлигын тайлан 2007-гийн гол дүгнэлт юм.

Авлигад автсан шүүх тогтолцооны нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг нарийн тогтоох амаргүй байдаг. Ийм шүүх тогтолцоо нь үндэстэн дамнасан гэмт хэрэг болон терроризмтай хийх олон улсын хамтын ажиллагааг сулруулж, худалдаа, эдийн засгийн өсөлт болон хүний хөгжлийг удаашруулж, ялангуяа иргэд хоорондын болон иргэд, төрийн байгууллага хооронд үүссэн маргааныг эрх тэгш байдлаар шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учруулдаг. Эцэстээ шударга бус харьцаа бүхий авлигад автсан шүүх нь нийгэмд хагарал үүсгэдэг. Шүүхийн тогтолцоонд хээл хахууль газар авснаар төр засагт итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулаад зогсохгүй төрийн үйл ажиллагааны бүх салбарт авлига газар авах нөхцлийг эрчимжүүлдэг. Энэ нь иргэдэд “Манай улс авлигыг нэгэнт хүлээн зөвшөөрчээ” гэсэн ойлголтыг төрүүлдэг.

Шүүхийн авлигын тодорхойлолт

Авлигыг “Хүлээлгэсэн итгэлийг буюу эрх мэдлийг хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах явдал” гэж ТИ тодорхойлсон байдаг. Үүнд санхүүгийн төдийгүй эдийн буюу эдийн бус ашиг хонжоог ойлгоно. Жишээлбэл, улс төрийн болон мэргэжлийн зорилгодоо урвуулан ашиглах г.м. Шүүхийн авлига гэдэг нь шүүх тогтолцоонд хамаарч буй аливаа этгээдээс шүүхийн шударга үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх явдлыг хэлдэг.

Жишээлбэл, шүүгч улс төрд болон нийгэмд нэр нөлөө бүхий этгээдийг хаацайлах, түүний гэм буруутайг нотлох баримтыг нуун далдлах эсвэл ингэх боломж олгох, шүүгч буюу шүүхийн албан хаагч нь хэргийн аль нэг талын ашиг сонирхолд нийцүүлэн шүүх ажиллагаа, хурал явуулах өдрийг товлох явдал гардаг. Түүнчлэн зарим оронд шүүх хуралдааны тэмдэглэлийг үгчлэн хөтөлдөггүйн улмаас болж аль нэг талд худалдагдсан шүүгч нь тогтоол гаргахын өмнө хуралдааны тэмдэглэлийг зүй бусаар товчлох буюу гэрчийн мэдүүлгийг өөрчилдөг. Мөн шүүхийн ажилтан нь ашиг хонжооны төлөө хавтаст хэргийг “санаатайгаар үргэдүүлэх” асуудал гарч болно.

Түүнчлэн шүүх тогтолцооны бусад шатууд нь шүүхийн авлигад нөлөөлдөг. Хэрэв цагдаа эрүүгийн хэргийн нотлох баримтыг өөрчлөх буюу прокурор нь цагдаагийн байгууллагын нотлох баримт цуглуулах ажиллагаанд зохих шаардлагын дагуу

хяналт тавиагүй тохиолдолд тухайн хэрэг шүүхийн шатанд шилжихээс өмнө авлигад өртдөг. Хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнөх шатанд прокурорын байгууллага голлох үүрэг гүйцэтгэдэг оронд авлигад автсан прокурорын үйл ажиллагаа нь зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалах боломжийг үгүйсгэдэг.

Засгийн газраас шударга ёсыг тогтооход зориулан олгох төрийн өмчийг хувьдаа завших нь шүүхийн авлигад тооцогдоно. Жишээлбэл, шүүгч өөрийн гэр бүлийн гишүүдийг шүүхийн байгууллагад ажилд авах буюу шүүхийн барилга, тоног төхөөрөмж худалдан авах гэрээг өөрт ашигтайгаар хийх явдал юм. Ер нь шүүхийн авлига нь шүүхийн анхан шатнаас эхлээд шүүх хуралдаан явагдах, шүүхийн шийдвэр гарах улмаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх шат хүртэлх хүрээг хамардаг.

Магадгүй давж заалдах шатны шүүхийн ажиллагаа өмнөх шатны шүүхийн гаргасан хууль бус шийдвэрийг залруулах нэгэн чухал арга зам болох хэдий ч мөн л авлигад өртөх боломжтой байдаг. Олонхи болсон улс төрийн хүчнүүд энэ шатны шүүгчийг томилох процессийг хяналтандаа авсан тохиолдолд давж заалдах шатны шүүхэд үнэнийг олно гэж итгэх нь “зэрэглээ” болж хувирах магадлалтай.

Хэдийгээр шүүгчдийн томилгоо зохих ёсоор хийгдсэн байлаа ч, тухайн хэргийг шийдвэрлэх ажиллагаа ил тод бус байх эсвэл хэргийг хэлэлцэхгүй удаан хугацаагаар дарах үе ч гардаг. Түүнчлэн хэргийг давж заалдах нь их мөнгөтэй талд ашигтай бөгөөд заргаа авах үндэслэлтэй нөгөө тал нь энэ шатнаас эхлээд заргаа алдах магадлал ихсэх хандлагатай байдаг.

Шүүхийн авлигын цар хүрээ

Авлигад идэгдсэн болон идэгдээгүй шүүхийн системүүд нь эрс ялгаатай. Шүүхийн авлигын үзүүлэлтүүд нь авлигын нийтлэг хэмжүүрүүдтэй давхцдаг. Жишээлбэл, төрийн байгууллагуудад авлига өргөн тархсан орнуудад шүүхийн авлига мөн л их байдаг. Эдийн засгийн өсөлтийн түвшин, шүүхийн авлигын түвшин хоёр харилцан хамааралтай байдаг. Учир нь гэрээ, хэлцэл бол бизнесийн хөгжил, өсөлт цэцэглэлтийн суурь болдог учир энэ талын маргааныг шударгаар шийдвэрлэх нь хөрөнгө оруулагчдад маш чухал байдаг. Хятад, Нигери зэрэг улсууд хараат бус бие даасан, өрөөсгөл бус шүүх нь улс орны худалдаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн хөгжилд чухал нөлөөтэй гэж үздэг.

Шүүхийн салбарт авлигыг янз бүрийн зорилгоор үйлддэг. Зарим тохиолдолд шүүн таслах ажиллагааг гүйвуулж, шударга бус шийдвэр гаргуулах зорилгоор авлига өгдөг бол олон хүн богино хугацаанд шийдвэр гаргуулахын тулд хээл хахууль өгөх нь бий. Гэвч аль ч тохиолдолд шүүхийн авлигыг зөвшөөрөх учиргүй. Яагаад гэвэл хохирогч нь шүүхээр эрхээ хамгаалуулж буй этгээд юм. Шүүхийн авлига их дэлгэрсэн орчинд, дээрх хоёр үйлдлийг шүүхийн эргэн тойронд ажилладаг этгээдүүд улам бүр өөгшүүлсээр байна. ТИ-ийн гаргасан Дэлхий нийтийн авлигын

хэмжүүр 2006 судалгаанд өгүүлснээр 62 орны 59,661 хүн оролцсон¹ судалгаанд тэдгээр улс орны гуравны нэгд нь, судалгаанд оролцогчдын 10 гаруй хувь нь өөрөө буюу гэр бүлийн гишүүд нь шүүхээр маргаан шийдвэрлүүлэхдээ “шударга” шийдвэр гаргуулахын тулд ямар нэг хэмжээгээр хээл хахууль өгсөн гэжээ.

Шүүхийн авлигын төрөл

Шүүхийн авлигын хоёр үндсэн төрөл байдаг. *Нэгд*, гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын нөлөө, *хоёрт*, хээл хахууль өгөх явдал орно.

А. Шүүхийн үйл ажиллагаанд дахь улс төрийн нөлөө

Хэдэн арван жилийн турш хийгдэж буй шинэчлэл, шүүхийн хараат бус бие даасан байдлыг баталгаажуулсан олон улсын баримт бичгүүдийн хэрэгжилтийг үл харгалзан олон оронд шүүгч, шүүхийн албан хаагчдын үйл ажиллагаанд улс төрийн хүчин, бизнесийн байгуулагууд хөндлөнгөөс оролцож, дарамт шахалт үзүүлсээр байна. Зарим улс оронд олон улсын хэм хэмжээг алдагдуулах явдал ч байсаар байна. Тухайлбал Орос, Аргентин зэрэг орнуудад улс төрийн хүчнүүдээс шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх явдал улам бүр нэмэгдсээр байна.

Нөлөөнд автсан шүүх нь эрх мэдэл бүхий этгээдүүдийн хөрөнгө завших, бусдад хууль бусаар давуу тал олгох, хөрөнгө хувьчлалыг танил талдаа ашигтайгаар хийх, хууль тогтоох байгууллага юмуу хэвлэл мэдээллийн хэрэгслийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарч болзошгүй маргаантай, хууль бус үйлдлүүдийг нь “хууль ёсны” мэт харагдуулах хэрэгсэл болдог. Тухайлбал 2006 оны 11 сард, Аргентины ерөнхийлөгч асан Карлос Менемийн томилсон нэг шүүгч сонгуулийн сурталчилгааны зардал хэтрүүлсэн эрх баригч намыг 2002 оны сонгуулийн сурталчилгааг санхүүжүүлэх тухай хуулийг зөрчөөгүй, учир нь тэд зардал хэтэрсэн тухай “мэдээгүй” тул санхүүгийн хариуцлага хүлээхгүй гэсэн шийдвэрийг гаргаж байжээ.

Улс төрийн нөлөөлөл нь шүүгчийг заналхийлэх, айлган сүрдүүлэх болон хээл хахууль өгөх, мөн шүүгчийн томилгоо, цалин хөлс болон үйлчилгээний нөхцлийг сайжруулах замаар ч илэрдэг. Алжирт “хэтэрхий” хараат бус гэж үзсэн шүүгч нарыг шийтгэж, алс бөглүү нутагт шилжүүлэн томилдог байна.

Кени улсад тодорхой улс төрийн хүчнүүдээс зохион байгуулсан авлигын эсрэг ажлын нэрээр халхавчлан шүүгчдийг үндэсгүйгээр гүтгэх, өөрт нь мэдэгдэлгүйгээр албан тушаалаас нь огцруулж байсан юм. Эрх мэдэлтнүүд асуудалтай гэж үзсэн шүүгчийг чухал албан тушаалаас нь бууруулж, оронд нь нөлөөнд автсан шүүгчийг

1 Судалгааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон хамрагдсан улс орнуудын жагсаалтыг 2006 оны Даян дэлхийн авлигын хэмжүүр-ээс үзнэ үү.

томилдог. Ийм явдал Перугийн ерөнхийлөгч асан Альберто Фужиморигийн үед мөн Шри-Ланкад тохиолдож байлаа.

Энэ төрлийн авлигаас сэргийлэх нэг арга бол шүүгчийг албан тушаалаас нь гэнэт огцруулах, өөр газар шилжүүлэх явдлыг гаргахгүй байх, тэднийг хамгаалах тухай Үндсэн хуулийн болон эрх зүйн бусад арга замыг бий болгох явдал юм. Энэ нь шүүхийн байгууллага, шүүгч болон шүүгчийн шийдвэрийг гадны нөлөөллөөс ангид байлгах нөхцлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.

Гэвч Турк, Пакистан, Непал зэрэг оронд шүүгчдийн халдашгүй эрхийг хууль тогтоомжоор хязгааргүй хамгаалснаас болж мөн л сөрөг үр дагавар гарах болсон байна. Харин хараат бус бие даасан байдлыг, хариуцлагатай байдалтай зөв хослуулах нь чухал бөгөөд ихэнхи төр засаг, шүүхийн ил тод байдлыг хангах шаардлагатай гэж үздэг.

Шүүх засаглалын бие даасан хараат бус байдал нийт ард иргэдийн түүнд итгэх итгэл дээр үндэслэдэг. Нэгэнт тухайн байгууллага дахь итгэлийг үндэс болдог утгаараа түүний үйл ажиллагааны шударга байдал чухал байдаг. Саяхныг хүртэл Их Британийн шүүх засаглалын тэргүүн нь нэгэн зэрэг парламентийн дээд танхимын даргын албыг хашдаг гүйцэтгэх засаглалын гишүүн байсан бөгөөд энэ нь ашиг сонирхлын зөрчлийг үүсгэдэг байсан. Шүүгчийн сонгуульд зориулж тэдэнд өгөх хандив нь ирээдүйд тэдний гаргах шийдвэрт нөлөөлөх нь зайлшгүй гэсэн болгоомжлол АНУ-д байдаг.

Шүүхийн болон улс төрийн авилга нь харилцан бие биенээ нөхцөлдүүлж байдаг. Шүүх байгууллага нь авлигад автсан оронд улс төрчдийг ятгаж, хээл хахууль өгдөг этгээдүүдэд хариуцлага тооцож чаддаггүй. Энэ байдал нь улс төр, төрийн албанд ажиллах үнэнч шударга иргэдийг шантрах, зайлсхийхэд хүргэдгээрээ илүү хор уршигтай.

Б. Хээл хахууль

Шүүхийн ажилтан хийх ёстой ажлынхаа төлөө мөнгө авах, өмгөөлөгч хэргийг түргэвчлэх эсвэл хойшлуулсаныхаа төлөө илүү төлбөр авах, авлига авдаг шүүгчээр өөрийн үйлчлүүлэгчийн хэргийг шийдвэрлүүлэх зэрэг хээл хахуулийн хэлбэрүүд нь шүүх засаглалын бүх харилцааны явцад гарч болно. Харин авлига авсан шүүгчид хэргийг түргэвчлэх буюу хойшлуулах, давж заалдахыг зөвшөөрөхгүй байх буюу зөвшөөрөх, бусад шүүгчид нөлөөлдөг байна. Урт удаан хугацаагаар үргэлжилдэг шүүхийн процедурыг түргэвчлэхийн тулд хүмүүс хээл хахууль өгөхөд хүрдэг нөхцөл байдлыг Энэтхэг, Бангладешийн жишээ харуулдаг.

Хэргийн хариуцагч, нэхэмжлэгч нар шүүгч болон шүүхийн байгууллагын үйл ажиллагааг шударга гэж үнэлдэггүй бол өөрсдийн зорилгод хүрэхийн тулд авлига өгөх магадлал их байдаг.

Хөгжиж буй улс орнуудад нийт хэрэг маргааны багахан хэсгийг шүүхийн

байгууллага шийдвэрлэдэг болохыг анхаарах нь зүйтэй бөгөөд ихэнхи улс оронд уламжлалт эрх зүйн тогтолцооны болон төрийн захиргааны байгууллага маргааны 90 орчим хувийг шийдвэрлэдэг. Маргаан шийдвэрлэх эдгээр хэлбэр нь төрийн байгууллагын удаан, зардал ихтэй процедурыг орлох ганц арга боловч авлига болон бусад асуудал² мөн л гардаг. Жишээлбэл, Бангладешт гомдол гаргагч тал тухайн хэрэг маргааныг шийдвэрлэж, шийтгэл ногдуулах ёстой нутгийн иргэдээс бүрдсэн “шалиш”-ын шийдвэрт ямар нэг байдлаар нөлөөлдөг гэгддэг “тоутс” хэмээх хүмүүст мөнгө төлөх ёстой байдаг. Түүнээс гадна эмэгтэйчүүд эрх зүйн хувьд адил тэгш эрх, нөхцөл эдлэх магадлал тун бага байдаг.

Шүүхийн авлигатай хийх тэмцэл

Шүүхийн авлига нь олон хэлбэртэй бөгөөд түүнд хууль эрх зүй, нийгэм соёл, улс төр, эдийн засгийн олон хүчин зүйл нөлөөлдөг болохыг 32 орны жишээн дээр хийсэн судалгаа харуулсан. Энэхүү төвөгтэй байдлын цаана шинэчлэлийг хэрэгжүүлэхэд анхаарвал зохих нийтлэг шинжүүд оршиж байна. Судалгаанд хамрагдсан улсуудад дараахь нийтлэг бэрхшээлүүд тулгардаг байна. Үүнд:

1. **Шүүхийн томилгоо.** Шүүгчийн ур чадварт үндэслэн шүүгчийг сонгож чадахгүй байх нь авлигад автах магадлалтай шүүгчийг сонгоход хүргэдэг
2. **Ажиллах нөхцөл.** Цалин хангалтгүй байх, баталгаагүй ажлын нөхцөл, урамшууллын болон албан тушаалд томилох журам шударга бус байх, түүнчлэн шүүгчдийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарахгүй байх зэрэг нь шүүгчид болон шүүхийн ажилтнууд авлигад өртөмтгий болоход хүргэдэг
3. **Сахилга ба хариуцлага тооцох асуудал.** Авлигад өртсөн шүүгчдэд хариуцлага хүлээлгэх, албан тушаалаас чөлөөлөх талаар шударга бус, үр нөлөө багатай тогтолцоотой байх нь эцэстээ улс төрийн шалтгаанаар шударга, хараат бус шүүгчдийг шүүх байгууллагаас чөлөөлөхөд хүргэдэг
4. **Ил тод байдал.** Тодорхой бус шүүхийн процедур нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн зүгээс шүүхийн үйл ажиллагааг хянах, шүүхийн авлигыг илрүүлэхэд саад болдог.

Сүүлийн 20 орчим жилийн хугацаанд улс орнуудын шүүхийн захиргаа, чадавхи нэмэгдүүлэхэд илүү чиглэж ирсэн шинэчлэлийн хөтөлбөрүүдэд дээр дурьдсан үндсэн асуудлууд хөндөгдөөгүй байдаг. Шүүгч үнэнч шударга ажиллах үндэс болох урамшууллын асуудлуудыг шийдвэрлэлгүйгээр шүүгчдийг зөвхөн сургалтад хамруулахад зориулж ихээхэн хэмжээний мөнгө зарцуулж байна. Хэрэв сахилга хариуцлагын асуудлыг сайжруулахгүйгээр гагцхүү шүүхийг автоматжуулах, эсхүл хэрэг шийдвэрлэх ажиллагааг хөнгөвчлөх, хэргийн ачааллыг багасгахад чиглэсэн ажилд хөрөнгө зарцуулсаар байвал шүүхийг илүү боловсронгуй хэлбэрээр авлига

2 OECD/DAC Network on Conflict, Peace and Development Co-operation, *Enhancing the Delivery of Justice and Security in Fragile States*, August 2006, 4.

авах нөхцлийг бий болгох магадлалтай байна. Шүүхийн процедураас зайлсхийх, түүнийг хөнгөвчлөх боломжийг хүмүүст олгодог нийгэм дэх хүмүүс хоорондын албан бус харилцааг анхаарч үзэхгүй байгаа явдал нь Төв болон Зүүн Европын улс орнуудад шүүхийн байгууллагуудад хэрэгжүүлсэн хамгийн боловсронгуй өөрчлөлт шинэчлэлийн ажлыг ямар ч үр дүнгүй болоход хүргэж байна.

Зөвлөмж

Шүүхийн авлигаас сэргийлэх талаар тэргүүн туршлагыг судалсны үр дүнд дараах зөвлөмжийг боловсруулав. Эдгээр зөвлөмж нь шүүхийн томилгоо, ажиллах нөхцөл, сахилга бат ба хариуцлага, ил тод байдал зэрэг өмнө дурьдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг санал болгоно³.

Шүүхийн томилгоо

- 1. Шүүхийн томилгоог хариуцсан хараат бус бие даасан байгууллага.** Гадны нөлөөнд автаагүй ил тод процесс нь хамгийн ур чадвартай шүүгчийг шилж сонгох боломжийг олгодог бөгөөд эцэстээ тэдгээр шүүгчид өөрсдийг нь томилсон хэн нэг улс төрийн эрх мэдэлтэн эсвэл шүүгчид өртэй үлдэхгүй. Энэ процессын үндэс нь гишүүдийг ил тод, гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат бус байж шүүгчийг томилох эрх бүхий байгууллага юм. Гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын төлөөлөл энэ байгууллагын гишүүдийн дийлэнх хувийг бүрдүүлэх ёсгүй.
- 2. Ур чадварыг үндэслэсэн шүүхийн томилгоо.** Шүүгчийг сонгох шалгуурыг ил тод, нээлттэйгээр олон нийтэд мэдээлэх, улмаар нэр дэвшигчид болон сонгон шалгаруулагчид шүүгчийг сонгох шалгуурын босго хаана байгааг мэдэх боломжийг олгох ёстой. Мөн нэр дэвшигчдэд нь түүний мэргэжлийн ур чадвар болон ёс зүй, шударга байдлын талаар мэдээллийг ил тод болгох шаардлага тавих ёстой.
- 3. Иргэний нийгмийн оролцоо.** Шүүгчид нэр дэвшигчийн ур чадварын талаар шийдвэр гаргахдаа шүүхийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн холбоо гэх мэт иргэний нийгмийн байгууллагатай зөвлөлдөх шаардлагатай.

Ажиллах нөхцөл

- 4. Шүүгчийн цалин хөлс.** Шүүгчийн цалин хөлс нь түүний албан үүргээ гүйцэтгэх хугацаанд түүний албан тушаал, дадлага туршлага, мэргэжлийн ур чадварын түвшинтэй адил хэмжээнд байх, шүүгч тэтгэвэрт гарсан бол зохих тэтгэвэр, тэтгэмжээр хангагдах ёстой.
- 5. Шүүгчийн эрх зүйн баталгаа.** Шүүгчийн цалин хөлс, ажиллах нөхцлийг

3 Эдгээр зөвлөмжүүдийг “*TI Checklist for Maintaining Integrity and Preventing Corruption in Judicial Systems*” номоос авав. Уг номд ахмад шүүгчид болон экспертүүдийн бэлтгэсэн материалуудыг Киела Лийки нэгтгэн оруулсан байна.

хуулиар тогтоох шаардлагатай бөгөөд ингэснээр гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын зүгээс тухайн засаг захиргааны ашиг сонирхолтой холбоотойгоор шийдвэр гаргасан шүүгчийг урамшуулах эсвэл шийтгэл ногдуулах боломжийг хязгаарлах юм.

6. **Шилжүүлэн ажиллуулах.** Шүүгчийг аль нэг газрын шүүхэд томилоход баримтлах тодорхой шалгууртай байх нь авлигад өртөлгүй хуулийн дагуу шударга ажилладаг шүүгчдийг алслагдсан, орон нутагт шилжүүлэн томилох байдлаар шийтгэх боломжийг хязгаарлана. Түүнчлэн шүүгчдийг түүний улс төрийн эсвэл бусад холбоо сүлбээ ихтэй газар, орон нутагт томилохгүй байх нь зүйтэй.
7. **Хэрэг хуваарилах болон шүүхийн менежментийн асуудал.** Хэрэг маргааныг тодорхой шалгуурын дагуу шүүгч нарт хуваарилж, хяналт тавих нь тухайн үеийн засаг захиргаа эсвэл бизнесийн ашиг сонирхлыг хамгаалах магадлалтай шүүгчид хэрэг маргааныг хуваарилахаас сэргийлж чадна.
8. **Мэдээлэл авах, сургалтанд хамрагдах боломж.** Шүүгчид нь албан тушаал хаших хугацааныхаа туршид хууль тогтоомж, хэрэг маргаан, шүүхийн бусад үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, албан тушаалд томилогдох үед болон өмнө нь холбогдох сургалтанд хамрагдах, шаардлагатай сургалтанд үргэлжлүүлэн хамрагдах эрхтэй байх нь зөв юм. Хууль зүйн шинжилгээ хийх, шүүхийн шийдвэрийг тайлбарлах, шийдвэрээ бичих, хэрэг маргааны менежмент болон ёс зүй, авлигын асуудал зэргийг энэ сургалтанд багтаах ёстой.
9. **Албан тушаалын бүрэн эрхийн хугацааны аюулгүй байдал.** Шүүгчид алба хаших хугацаа нь дуусгавар болох дөхөхөд ажиллах хугацаагаа сунгуулах үүднээс гаргадаг шийдвэрээ ямар нэг байдлаар өөрчлөх эсвэл ийм зорилгоор үйлдэл хийх магадлалтай байдаг тул алба хаших хугацааны аюулгүй байдлыг дахин сунгах эрхгүйгээр 10 орчим жилийн хугацаагаар тогтоох нь зүйтэй.

Сахилга бат ба хариуцлагын асуудал

10. **Халдашгүй дархан эрх.** Шүүгчийн чиг үүрэгтэй холбоотой үйлдэл, үйл ажиллагааг тодорхой хязгаартайгаар хуулиар хамгаалах нь шүүгчид аливаа гомдол, нэхэмжлэлээс айхгүйгээр шийдвэр гаргах боломжийг олгох бөгөөд энэ нь авлигын болон эрүүгийн хэргүүдэд хамаарахгүй юм.
11. **Хяналт шалгалтын процедур.** Хяналт шалгалтын дүрэм журам нь шүүхийн байгууллагаас байж болох аливаа таамаглалыг шалгах явдлыг баталгаажуулна. Шүүгчдийн эсрэг аливаа гомдлыг бие даасан байгууллага шалгаж, өөрийн гаргасан шийдвэрийн үндэслэлийг тайлагнах ёстой.
12. **Албан тушаалаас чөлөөлөх шударга, ил тод процесс.** Шүүгчийг албан тушаалаас огцруулах ажиллагаа нь тодорхой, нарийн стандартын дагуу явагдах ёстой. Шүүгчийг огцруулах механизм ил тод, шударга байх,

огцруулах тухай шийдвэр нь бодитой үндэслэлтэй байх шаардлага тавигдана. Хэрэв шүүгчийг албан тушаалаас огцруулах асуудал авлигатай холбоотой бол тухайн шүүгчийг эрүүгийн хуулийн дагуу яллах асуудал яригдана.

13. **Хянан хэлэлцэх, давж заалдах ажиллагаа.** Шүүгч нь шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн төлөөллийн үйлчилгээ авах, сахилгын асуудлаар давж заалдах эрхтэй байна.
14. **Ёс зүйн дүрэм.** Шүүгчийн ёс зүйн дүрэм нь шүүхийн үйл ажиллагааны хэр хэмжээ, удирдамж болдог бөгөөд үүнийг шүүхийн байгууллагаас боловсруулж мөрдүүлэх нь зүйтэй. Ёс зүйн дүрмийг зөрчсөн асуудлыг шүүхийн эрх бүхий байгууллага шийдвэрлэх нь зохимжтой.
15. **Whistleblower буюу зөрчлийг мэдээлэгчийг хүлээн зөвшөөрөх бодлого.** Гомдол гаргах, мэдээлэх нууц бөгөөд үр нөлөөтэй процедур чухал бөгөөд энэ нь ёс зүйн дүрэм зөрчигдөх, шүүгч, шүүхийн ажилтнууд болон бусад өмгөөлөгчид авлига авсан байж болзошгүй талаар өмгөөлөгчид, шүүхийн байгууллагаар үйлчлүүлэгчид, прокурорын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн төлөөлөгчдөөс асуудлыг мэдээлэх боломжийг олгоно.
16. **Бие даасан, нөлөө бүхий шүүгчдийн нийгэмлэг.** Шүүгчдийн бие даасан холбоо нь өөрийн гишүүдийн эрхийг хамгаалах бүх асуудлаар төр болон түүний байгууллагуудтай хамтран ажиллах ёстой. Энэ нь сонгуулиар байгуулагддаг, бүх шүүгчид гишүүн болох боломжтой, ёс зүйн холбоотой асуудлаар шүүгчдэд туслалцаа үзүүлдэг, хууль ёсны эрх ашгийнхаа талаар асуудалтай шүүгчдэд дэмжлэг үзүүлдэг байгууллага байх учиртай.

Ил тод байдал

17. **Ил тод байгууллага.** Шүүхийн байгууллага түүний үйл ажиллагаа, санхүүгийн тайланг жил бүр хэвлэн гаргах, байгууллагын удирдлага, засаглалын талаархи бодитой мэдээллээр олон нийтийг хангах ёстой.
18. **Ил тод үйл ажиллагаа.** Хууль тогтоомж болон түүнд орох нэмэлт өөрчлөлт, шүүхийн процедур, шийдвэр, шүүхийн байгууллага дахь ажлын орон тоо, ажил, албан тушаалд шалгаруулж авах шалгуур, шүүгчийг томилох журам, үндэслэл шаардлага гэх мэт мэдээллийг олон нийт олж авах боломжтой байх.
19. **Эрүүгийн гэмт хэрэгт яллах ил тод ажиллагаа.** Насанд хүрээгүй хүмүүстэй холбоотой хэрэг гэх мэт онцгой тохиолдлоос бусад үед гарсан шийдвэрийн үндэслэлийг мэдээлэх, яллах ажиллагаанд шийдвэр гаргагчдад удирдамж болох яллах ажиллагааны гарын авлага, бусад материалыг хэвлэн гаргах зэрэг байдлаар яллах ажиллагааг нийтэд ил тод явуулах ёстой.
20. **Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах.** Төрийн бусад албан хаагчдыг хөрөнгө орлогоо мэдүүлэхийг шаардаж байгаа тохиолдолд шүүгчид мөн адил

тодорхой хугацаа тутамд өөрийн орлого, эд хөрөнгийг олон нийтэд ил мэдээлэх ёстой.

- 21. Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх.** Шүүгчид өөрийн шийдвэрлэх хэргийн аль нэг талын эрх ашгийг илүүд үзэх байдалд орох, эсвэл тухайн хэрэгт өмгөөлөгчөөр, гэрчээр оролцож байсан, тухайн хэргийг шийдвэрлэх явдал нь тэдгээрийн эдийн засгийн ашиг сонирхол хөндөгдөх зэрэг нөхцөл байдал илэрвэл ашиг сонирхлын зөрчил байгааг мэдээлж, уг хэрэг маргааныг шийдвэрлэхээс татгалзах үүрэгтэй.
 - 22. Шүүхийн ажиллагаанд хүний эрхийг хангах.** Шүүх байгууллагын хууль дүрмийн дагуу албажсан механизм нь шүүхээр үйлчлүүлж байгаа талууд тэдэнд хууль, дүрэм журмаар олгогдсон эрх, үүрэг, түүний мөн чанар, хэмжээ хязгаарын талаар мэдээллийг шүүх ажиллагааны өмнө, явцын дунд болон түүний дараа авах боломжийг бий болгох ёстой.
 - 23. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө.** Сэтгүүлчдэд аливаа шүүх ажиллагааны явц болон авлига авсан эсвэл зүй бус нөлөөнд автсан байж болзошгүй нөхцөл байдлын талаар үнэн зөв мэдээлэл тайлбар өгөх боломжтой байна. Үндэслэлгүйгээр гүтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцсон, алдар хүндийг гутаан доромжлох хэрэгт хохирол нөхөн төлүүлэх эрхийг шүүгчид олгосон хууль тогтоомж нь эрүүгийн гэмт хэргийн асуудлыг хэвлэл мэдээллийн байгууллагаас эрэн сурвалжлах, мэдээлэхэд саад тотгор болдог.
 - 24. Мэдээллийн чанар.** Сэтгүүлчид, редакторууд шүүхэд болж байгаа үйл явдал, хууль эрх зүйн асуудлыг олон нийт хүлээн авч ойлгохуйц хэмжээнд мэдээлэх ур чадварт суралцсан байх нь зохимжтой. Эрдэмтэн судлаачид шүүхийн шийдвэрийн талаар эрх зүйн мэдээллийн сэтгүүл, хэвлэлд тайлбар бичих, үзэл бодлоо илэрхийлэх явдлыг дэмжих нь зүйтэй.
 - 25. Иргэний нийгмийн оролцоо, судалгаа, мониторинг болон тайлагнах.** Иргэний нийгмийн байгууллагууд нь авлигын хэргүүд, шүүхийн шийдвэрлэлтийн байдал, шийдвэрийн чанар зэрэг авлигын нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт өгөх байдлаар шүүхийн авлигатай холбоотой асуудлуудыг ойлгоход хувь нэмэр оруулж чадна.
 - 26. Хандивлагчдын үйл ажиллагааны шударга, ил тод байдал.** Шүүх засаглалын шинэчлэлийн хөтөлбөрүүд нь шүүх дэх авлигын асуудлууд руу чиглэх ёстой. Хандивлагчид нь шүүх процесс, түүний үйл ажиллагааны үр нөлөөг судлах, үнэлэлт дүгнэлт өгөх талаар харилцан мэдлэг туршлагаа хуваалцах, хамтран ажиллагч улс орнуудтай асуудлыг чөлөөтэй хэлэлцэх шаардлагатай.
- Эдгээр зөвлөмж нь шүүхийн хараат бус, зарчимч байдлын талаархи олон улсын хэд хэдэн стандарт, төрийн болон төрийн бус байгууллагаас боловсруулж гаргасан хяналт шинжилгээ хийх, тайлагнаж мэдээлэх загваруудад нэмэлт болж байна. Олон улсын эрх зүйн тогтолцоо нь шүүгчийн сахилга хариуцлагын асуудлыг орхигдуулсан байдлыг (цоорхой) нэгэн дуугаар анхааруулжээ. Транспэрэнси Интернэшнл нь нэлээд

хэдэн улс орны шүүхийн байгууллагаас боловсруулан гаргаж, улмаар НҮБ-ын эдийн засаг нийгмийн зөвлөлөөс 2006 онд баталсан Шүүхийн үйл ажиллагааны талаархи Банглорын зарчмууд буюу шүүгчдийн үйл ажиллагааны дүрэмд анхаарал хандуулж байна. Банглорын зарчмууд нь өмнө дурьдсан зохицуулагдаагүй асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг боловч энэ баримт бичигт нэгдэх асуудал сайн дурын хэвээр байгаа. Түүнчлэн шүүх засаглал дахь хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай холбоотойгоор сүүлийн арваад жилийн хугацаанд бий болсон анхаарал татсан асуудлыг шийдвэрлэх үүднээс шүүх байгууллагын хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмуудыг эргэн харах цаг болжээ.

Авлигын бүх хэлбэрт жигд тохирсон онцгой бүтэц тогтолцоо, эсвэл туршлага байхгүй. Энэхүү номын хоёр дахь хэсэгт байгаа улс орнуудын тайланд улс орон бүрийн өөрийн онцлог нөхцөл байдалд тохирсон, нийтлэг байдлаар бусад тохиолдлуудад авч ашиглах боломжгүй шүүхийн шинэчлэлийн зөвлөмжүүдийг санал болгосон. Олон янзын нөхцөл байдал нь өөр бусад тохиолдолд үр нөлөө өгч чадахгүй арга барилыг шаарддаг. Хэдий тийм боловч эдгээр зөвлөмжүүд нь шүүхийн хараат бус бие даасан байдал, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэчлэлийн ажлын удирдамж болдог бөгөөд шударга, үр нөлөөтэй шүүхийг дэмждэг. Хууль ёсыг гажуудуулж, олон сая хүмүүсийн амьдралыг үгүй хийдэг авлигыг хязгаарлаж, шүүх засаглалын үйл ажиллагааг сайжруулахад олон талт, цогц шүүхийн шинэчлэлийн ажил маш чухал юм.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Шүүхийн авлига - улс орнуудын тайлан

УДИРТГАЛ

ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНА

Энэ жилийн Дэлхий нийтийн авлигын тайлангийн “Улс орнуудын тайлангийн бүлэг”-т шүүхийн систем дэх авлигын тухай голлон өгүүлсэн нь түүний өмнөх жилүүдийнхээс ялгарах онцлог болсон юм. Ингэснээр тайлангийн нэгдүгээр бүлэгт дурьдсан шүүхийн авлигын талаарх харьцуулсан дүн шинжилгээг улс орон бүрийн жишээн дээр улам илүү тодорхой болгож харуулсан юм. Өнгөрсөн жилүүдтэй адил, улс орнуудын тайлангуудыг ихэнхдээ дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж байгаа ТИ-ийн үндэсний байгууллагуудын гишүүд бичиж ирүүлсэн. Өмнөх жилүүдэд ТИ-ийн үндэсний салбарууд тухайн жилийн өөрийн улсынхаа тайланд авлигатай холбоотой дурын сэдвийг өөрсдөө сонгох боломжтой байсан бол харин энэ удаа бүгд нэгэн дуугаар шүүхийн авлигын асуудалд анхаарал хандуулсан нь зүй ёсны хэрэг юм.

Энэ бүлэгт судлагдаж буй орнуудын шүүх эрх мэдлийн байгууллагуудын тогтолцоонд авлига системчлэгдсэн шинжтэй буюу тогтолцоог бүхэлд нь хамарсан байдлаар өргөн тархсан бөгөөд ТИ-ийн үндэсний салбар байгууллагууд ч түүнтэй хийх тэмцлээ нэгэнт эхлүүлсэн байна. Нэгж тайлан тус бүр тухайн улсын шүүхийн байгууллагыг тодорхойлох үзүүлэлтүүдээр эхэлж байгаа бөгөөд эдгээр нь дараагийн хэсэгт шүүхэд хандах боломж, шүүхийн үйл ажиллагааны хүртээмж, шүүгчийн цалин зэрэг шүүхийн систем дэх авлигыг өдөөгч болон няцаагч өөр бусад нөхцөлүүдийн талаарх дүгнэлт, тодорхойлолтын үндсэн суурь нь болж байгаа юм. Зарим улс орнуудын хувьд тодорхой хэсэг мэдээллийг олж авах боломжгүй байсан нь тэдгээр улс, орон дахь ил тод байдлын төвшинг илэрхийлж байгаа юм.

Доорх хүснэгтэд судалгаанд хамрагдсан орнуудын шүүхийн системд гарч буй авлигын гол асуудлуудыг тодорхойлсон ба тэдгээрийг шийдвэрлэх арга замуудын талаар энэхүү номын зөвлөмжийн хэсэгт тусгагдсан (хураангуй хэсгээс үзнэ үү). Тулгарч буй бэрхшээлүүдийг шийдвэрлэх арга зам, зөвлөмжийг эхний багананд, хэрэв эдгээр зөвлөмжид дурдсан нөхцөл, шаардлагууд хангагдаагүй, энэ талаар зохицуулалт байхгүй, эсхүл байгаа нь сул, ор нэр төдий, хэрэгжих боломжгүй зэрэг тохиолдолуудад авлига хэрхэн биелэлээ олж, бэхждэг талаар дунд багананд, эдгээр асуудлыг тайландаа тусгаж, тодорхойлон гаргаж ирсэн улс, орнуудын жагсаалтыг сүүлийн багананд тус тус харуулсан.

ЗӨВЛӨМЖ	ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД ГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ	ЭНЭ АСУУДАЛ ТАЙЛАНД НЬ НАРИЙВЧЛАН ХӨНДӨГДСӨН ОРНУУД
1. ШҮҮГЧИЙН ТОМИЛГОО		
<ul style="list-style-type: none"> Мэдлэг, ур чадварыг харгалзан томилох. <p>Томилох үйл явц нь шүүгч, хуульч, эрдэмтэн, мэргэжилтэн, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн хараат бус байгууллагын оролцоог хангаж, зохион байгуулагдах; Сул байгаа орон тоо, тухайн албан тушаалд тавигдах шаардлага болон сонгон шалгаруулалтын журам нь олон нийтэд өргөнөөр мэдээллэгдэж, сурталчилгдсан байх.</p>	<p>Ерөнхийлөгч ба гүйцэтгэх засаглал, эсхүл гүйцэтгэх эрх мэдлээс хараат шүүхийн байгууллага, дуулгавартай шүүгчдийг томилоно</p> <p>Мэргэжлийн ур чадварын хувьд шаардлага хангахгүй этгээдүүд шүүгчээр томилогдох (хамгийн адгийн тохиолдол нь албан тушаалаа худалдаж авах) Шүүгчээр ажиллах сонирхолтой хүмүүс тэднийг өөрсдийг нь сонгон шалгаруулах үзүүлэлт, нөхцөл шаардлагуудын талаар тодорхой ойлголтгүй байх</p>	<p>Алжир, Азербайжан, Бангладеш, Камбож, Чех улс, Египет, Гүрж, Израил, Кени, Кувэйт, Марокко, Непал, Пакистан, Панам, Өмнөд Африк, Шри Ланк, Их Британи, Замби</p>
2. АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, БАТАЛГАА		
<p>Шүүгчид туршлага болон мэргэжлийн ур чадварыг харгалзан ажиллах боломжит нөхцөлийг бүрдүүлж өгөх, хуулиар ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай эрх хэмжээ, нөхцөл, баталгаа, цалин хангамж олгох</p> <p>Шүүгчийн хувийн аюулгүй байдлыг хангасан ажлын таатай нөхцөлийг бүрдүүлэх; хууль тогтоогчоос шүүгчийн цалин хангамж, шүүгчээр томилох, албан тушаалд эвшүүлэх журам, ажлын нөхцөлийг өөрчлөх, ажлаас чөлөөлөгдсөний дараа эдлэх хангамжийг өөрчлөх боломжийг Үндсэн хуулиар хязгаарлах;</p>	<p>Айлган сүрдүүлэх: Хэргийн оролцогчдоос бага цалинтай шүүгчид хээл хахууль санал болгох, эсхүл шүүгч нь хэргийн оролцогчдоос мөнгөн хээх, авах эрсдэл өндөр байдаг.</p> <p>Чадварлаг шүүгчид өөр ажилд шилжих аюул: Шүүгчийн цалин хангамж хангалтгүйгээс болж өндөр мэдлэгтэй шүүгч, хуульчид ажлаасаа гарч хувийн хэвшилд шилждэг.</p> <p>Авлига оршин тогтносоор байх. Шүүгчийн нийгэмд эзлэх байр суурь доогуур байгаа нь хэргийн оролцогчдоос шүүгчид хээл хахууль санал болгох явдлыг бий болгоно.</p> <p>Шүүхийн төсөв, санхүү, менежментийг улс төрийн зорилгоор урвуулан ашиглаж, шүүгчийн цалинг зохиомлоор бага байлгаж, өөрсдийн □ гар хөл □ болдог шүүгчдэд урамшуулал олгох тогтолцоо бий болгодог.</p>	<p>Алжир, Аргентин, Азербайжан, Бангладеш, Камбож, Египет, Гүрж, Энэтхэг, Кени, Монгол, Непал, Пакистан, Палестин, Папуа Шинэ Гвиней, Филиппин, Өмнөд Африк, Турк, Замби</p>

ЗӨВЛӨМЖ	ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД ГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ	ЭНЭ АСУУДАЛ ТАЙЛАНД НЬ НАРИЙВЧЛАН ХӨНДӨГДСӨН ОРНУУД
<p>Шүүхэд ирсэн нэхэмжлэл, хэргийг тохиолдлын журмаар, ил тод хуваарилах. Тухайн орон нутгийн улс төрчидтэй ямар нэг байдлаар ойр дотно, холбоотой тохиолдолд тухайн газарт уг шүүгчийг томилохгүй байх;</p>	<p>Засгийн газрын болон хувийн хэвшлийн аль нэг байгууллагыг дэмждэг тэдэнтэй холбоотой шүүгчдэд тухайн хэргийг тохируулан хуваарилах явдал гардаг. Харин хараат бус бие даасан, нөлөөнд ордоггүй шүүгчийг хүнд нөхцөлтэй буюу алслагдсан газарт томилон ажиллуулах эсхүл олон нийтийн анхаарлыг татсан, өндөр ач холбогдол бүхий хэргийг тэдэнд хуваарилахгүй байх тохиолдол гарна.</p>	<p>Камбож, Пакистан, Турк улс, Шри Ланк</p>
<p>Мэргэжил дээшлүүлэх, шүүгчийн давтан сургалтыг зохион байгуулах. Нарийн хөтөлбөр бүхий системчилсэн, үргэлжилсэн сургалтад шүүгчдийг хамруулах. Сургалтыг шүүгчид болон хуульчдын холбооноос бүрдсэн шүүхийн хараат бус зөвлөл хариуцах;</p>	<p>Шүүхийн шийдвэр үндэслэл муутай байх. Шүүгчийн мэдлэг, чадвар дутах, маргаантай асуудалд дүншинжилгээ хийх чадваргүй, хууль хэрэглэх чадвар муутай, хариуцлагатай ажиллаж чадахгүй байх тохиолдол элбэг байдаг.</p> <p>Ёс зүйн хэм хэмжээ сул байх. Шүүгчид албан тушаалаа урвуулан ашиглах, хэргийн оролцогчдоос хээл хахууль шаардах, хувийн сонирхлоор хэрэг шийдвэрлэх процессыг удаашруулах зэрэг үйлдэл хийх явдал газар авдаг.</p>	<p>Алжир, Азербайжан, Камбож, Энэтхэг, Мексик, Марроко, Румын, Замби</p>

ЗӨВЛӨМЖ	ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД ГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ	ЭНЭ АСУУДАЛ ТАЙЛАНД НЬ НАРИЙВЧЛАН ХӨНДӨГДСӨН ОРНУУД
<p>Шүүхэд ирсэн нэхэмжлэл болон давж заалдах өргөдлийг хуульд заасан хугацаанд хурдан шийдвэрлэж байгаа эсэхийг магадлах. Шүүх байгууллага шаардлагатай бүхий л нөөцөөр хангагдсан байх, материаллаг хангамж болон хүний нөөцөөр хангах, тухайлбал шүүгч, шүүхийн ажилтны орон тоог нэмэх, техник хэрэгсэлээр хангах, хэт урт цагаар хуралдахыг хязгаарлах журам гаргах, шүүгчид хэргийг уншиж танилцах, шүүх хуралд бэлтгэх хангалттай цаг олгох, шүүхэд хэргийг удаан хугацаагаар дарахгүй байх үүднээс хэргийг ач холбогдлоор нь ангилах, шийдвэрлэгдээгүй хуучин хэргүүдийг эхэлж шийдвэрлэх;</p>	<p>Шүүгчийн ажлын ачаалал их байх нь шүүхийн үйл ажиллагааг удаашруулж, ажлын үр дүнг бууруулж, улмаар хэргийг хурдан шийдвэрлүүлэхийн тулд авлига үйлдэх нөхцөлийг бүрдүүлдэг.</p>	<p>Азербайжан, Бангладеш, Коста Рик, Чех улс, Гүрж, Гватемал, Энэтхэг, Нигер, Парагвай, Филиппин улс</p>
<p>3. ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГА БА САХИЛГА БАТ</p>		
<p>Иргэдээс гомдол хүлээж авах хялбар, хүртээмжтэй механизм бий болгох, гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд шүүгчийг огцруулах арга хэмжээ авах эрх хэмжээ бүхий бие даасан шүүхийн сахилгын хороо байгуулах; Шүүгчийн үйлдсэн заримноцтой үйлдлийн талаарх гомдлыг хүлээн авч, хэргийг хянан шийдвэрлэх, үндэслэлтэй тохиолдолд шүүгчийг албан тушаалаас нь огцруулах эрх бүхий байгууллагыг байгуулж, эрх хэмжээг нь Үндсэн хуулиар баталгаажуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулсны үндсэн дээр шийдвэр гаргах, шүүгчид хууль ёсны эрхээ төлөөлөгчөөр дамжуулан хамгаалуулах, шударгашүүхээр шүүлгэх, давж заалдах эрх, боломжийг олгох;</p>	<p>Шүүгчийг албан тушаалаас нь огцруулахад улс төрийн нөлөө орж буй тохиолдолд шударга шүүгчдийг хэд хэдээр нь зайлуулж, дуулгавартай шүүгчийг оронд нь томилох боломж бүрддэг.</p> <p>Харин шүүгчийн сахилгын хороог дан шүүгчдээр бүрдүүлбэл бусад шүүгчидээ зөөлөн хандаж, ингэснээр авлигын зөрчлийг илрүүлэх, түүнд шийтгэл ногдуулах бололцоог бууруулдаг.</p>	<p>Алжир, Аргентин, Камбож, Чех улс, Гүрж, Гватемал, Кени, Монгол, Нигери, Пакистан, Польш, Турк, Зимбабве</p>

ЗӨВЛӨМЖ	ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД ГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ	ЭНЭ АСУУДАЛ ТАЙЛАНД НЬ НАРИЙВЧЛАН ХӨНДӨГДСӨН ОРНУУД
<p>Шүүгчийн албан тушаалын бүрэн эрхийн хугацааг Үндсэн хуулиар хамгаалах; Хууль тогтоомжид заасан зөрчил гаргасан, мэргэжил, ур чадварын хувьд ажил албан тушаалдаатэнцэхгүйбайгаагаас өөр бусад ямарч шалтгаанаар шүүгчийг огцруулах боломжгүй байхаар зохицуулах хэрэгтэй.</p>	<p>Дуулгавартай шүүх: Зарим шүүгч хууль зөрчсөн төр, түүний албан тушаалтны эсрэг зоригтой шийдвэр гаргахаас айдаг. Учир нь гүйцэтгэх засаглалын байгууллагаас шүүгчийг албан тушаалаас нь огцруулах, сахилгын хариуцлага ногдуулах эрхтэй байдаг.</p>	<p>Алжир, Аргентин, Бангладеш, Кени, Пакистан, Парагвай</p>
<p>Зөвхөн үйлдсэн эрүүгийн хэрэгт хариуцлага хүлээлгэхээс бусад тохиолдолд шүүгч халдашгүй байх эрх нь баталгаажсан байх: Ийм халдашгүй байх эрхийг тэдний гаргасан шийдвэрийн хүрээнд олгох, гэхдээ хуулийн энэ заалт нь шүүгчийг авлигын хэрэгт холбогдуулан шалгахад саад болохгүй байх ёстой.</p>	<p>Гаргасан шийдвэр, үйл ажиллагаандаа халдашгүй байх баталгаагүй үед шүүгч зарим үед шударга, зөв шийдвэр гаргахгүй байх боломжтой, энэ нь хожим өөрийнх нь эсрэг ямар нэг хэрэг үүсгэх, арга хэмжээ авахаас айдагтай холбоотой. Бүрэн эрхийн халдашгүй байдлыг урвууланашиглаж, өөрийнхууль бус үйлдлийг халхавчлахыг оролддог шүүгчид нь шүүхийн нэр хүндийг унагаж, авлигын гэмт хэргээс ял шийтгэлгүй мултрах үзэгдлийг дэвэргэн өөгшүүлдэг.</p>	<p>Хорват, Гүрж, Непал, Палестин улс</p>
<p>4. ИЛ ТОД БАЙДАЛ</p>		
<p>Шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр, шүүхийн зардлын талаарх мэдээлэл ил тод байх: Шүүхийн үйл ажиллагааг нэгтгэсэн мэдээллийн сантай болгосноор шүүгчид хоорондоо мэдээлэл солилцох, шаардлагатай хэргийг богино хугацаанд олж судлах, шүүхийн процедур болон хууль тогтоомжид заасан хязгаартай, тодорхой хэдэн тохиолдлоос (хүүхдийн эрхийн асуудал гэх мэт) бусад хэргийн талаар гаргасан шийдвэрийг олоннийг үзэх боломжтой болно.</p>	<p>Хууль бус үйл ажиллагааг илрүүлэхгүй байх нь шүүгчдээс хөндлөнгийн байх, шийдвэр гаргахдаа хуулийг чандлан мөрдөж байгаа эсэхэд ямар нэгэн хяналтгүй байгаа мэтсэтгэлдэлийг төрүүлдэг. Шүүгчид мэдээлэл олж авах, харилцан шаардлагатай мэдээллийг солилцох боломж хомс байх тохиолдолд шүүгчийн гаргасан шийдвэр үндэслэл муутай болох нөхцөлийг нэмэгдүүлдэг. Зарим тохиолдолд хавтаст хэрэг алга болох явдал гарч хэргийг хурдан шуурхай шийдвэрлэхэд саад болдог бөгөөд энэ нь хэргийг хурдан шийдвэрлүүлэхийн тулд хээл хахууль санал болгох, шаардах боломжийг нэмэгдүүлдэг.</p>	<p>Алжир, Камбож, Хорват, Гүрж</p>

ЗӨВЛӨМЖ	ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД ГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ	ЭНЭ АСУУДАЛ ТАЙЛАНД НЬ НАРИЙВЧЛАН ХӨНДӨГДСӨН ОРНУУД
<p>Ашиг сонирхлын зөрчил (АСЗ)-ийг хязгаарлах товч бөгөөд тодорхой дүрэм журам боловсруулах, хөрөнгө орлогоо тогтмол мэдээлэх процедурыг бий болгох. АСЗ үүссэн буюу үүсэх нь тодорхой болсон, хэргийг хөндлөнгийн байр сууринаас шийдвэрлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд шүүгч энэ тухай мэдэгдэж, хэргийг шийдвэрлэхээс татгалзах хэрэгтэй.</p>	<p>Хөрөнгө орлогоо мэдүүлээгүй тохиолдолд авлигыг илрүүлэх боломжгүй, эсхүл илэрхий нүдэн дээр бий болж, нэмэгдэж байгаа хөрөнгийг хууль ёсны мэт болгож хээл хахууль авсан байх тухай хардлагыг үгүйсгэх боломж олгодог. Аль нэг талын эрх ашгийг илүүд үзэхгүйгээр, хөндлөнгийн байр сууринаас шударга шийдвэр гаргах нь сонгуулийн дүнд бий болдог шүүгчийн хувьд хэрэгжих магадлал багатай. Ялангуяа нэр дэвших үед хандив өгсөн этгээдийн талд ашигтай шийдвэрийг шүүгч гаргадаг.</p>	<p>Камбож, Коста Рик, Гүрж, Гватемал, Энэтхэг, Перу, Филиппин, Польш, Шри Ланк</p>
<p>Шүүхийн үйл ажиллагаанд мониторинг хийх, шүүгчийг томилох, чөлөөлөх, шүүх дэх авлигын болон шударга бус үйлдлүүдийг олж тогтооход чиглэгдсэн шийдвэрүүдийг гаргахад ТББ, шүүхээр хэргээ шийдвэрлүүлсэн этгээд, хэвлэл мэдээлэл, эрдэмтэд зэрэг иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах: И р г э н и й н н и й г м и й н байгууллагаас шүүхийн үйл ажиллагаанд шүүмжлэлт байр сууринаас хандахад чөлөөтэй нөхцөл бүрдсэн байх хэрэгтэй. Нууцлалын тухай заалтууд болон шүүхийг үл хүндлэх нэрээр халхавчлан шүүхэд шүүмжлэлттэй хандах, аливаа асуудлыг хэлэлцэх явдалд саад учруулах ёсгүй.</p>	<p>Шүүхийн шударга бус үйлдэл, авлигын талаар хэлэлцүүлэг өрнүүлэхийг хориглосноор авлигын хэрэг илрэхгүй байх боломж олгодог ба авлигад автагдсан этгээд хяналтаас ангид байгаага мэдэж үйлдлээ үргэлжлүүлэх боломжтой болно.</p> <p>Бодит бус, хангалтгүй мэдээлэлтэй иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаа нь шүүхийн бие даасан, хараат бус байдлыг дэмжихээсээ илүү шүүхийн шийдвэрийн талаар сөрөг мэдээлэл цацаж, хараат бус байдалд нь заналхийлэл болж хувирдаг</p>	<p>Камбож, Египет, Монгол, Пакистан, Палестин, Панам, Филиппин, Румын, Зимбабве</p>

Алжир улсын шүүх засаглал: бүтэлгүй эхлэлээс бүрхэг ирээдүй рүү

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мөрдөн шалгах зарчимд тулгуурладаг (Исламын хуулийн элемент агуулсан), прокурорын байгууллага нь шүүх эрх мэдэлдээ багтдаг

100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 3.0¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 635 ам доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 1,130-1,410³

Нэг хүнд ногдох ҮНБ: 2,730⁴

Шүүхийн жилийн төсөв: 310 сая ам доллар⁵

Жилийн нийт төсөв: 22.1 тэрбум⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 1.4

Шүүхийн бүх шийдвэрийг хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм, гэхдээ хүнд суртлын улмаас хүндрэл байнга гардаг

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Syndicat des Magistrats (2006)

2. Өмнөх ишлэл

3. Өмнөх ишлэл

4. World Bank Development Indicators (2005)

5. Loi de finances (2007)

6. Өмнөх ишлэл

1962 онд Алжир Улс тусгаар тогтнолоо олсон бөгөөд улс төрийн тогтолцооны хувьд нэг намын системтэй. 1989 оны үндсэн хуулийн өөрчлөлтийг хүртэл шүүгчдийг төрийн бусад албан хаагчидтай адил хэмжээнд үзэж, шүүх засаглалын нийгэмд гүйцэтгэх үүргийг тусгайлан анхаарч үздэггүй байжээ. 1969 оны хуульд заасны дагуу шүүх нь “социалист хувьсгалын үйл хэрэгт үйлчлэх чиг үүрэгтэй” бөгөөд төрийн эрхэнд буй намаас шүүгч болон хуулийн байгууллагын бусад ажилтнуудыг шууд удирдаж, заавар чиглэл өгдөг байв. Иймд тухайн үед шүүхийн хараат бус байдал гэсэн ойлголт байсангүй. Харин 1989 оноос тус улсад ихээхэн өөрчлөлт гарч Үндсэн хуульд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орж, ардчилсан нийгмийн үндэс тавигдсан байна. Мөн онд Шүүгч болон хуулийн байгууллагын ажилтны¹ эрх зүйн байдлын тухай хууль батлагдан гарч, шүүхийг бие даасан, хараат бус засаглал болохыг хуульчлан тогтоов. Үүнийг 1996 онд Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр улам баталгаажуулж “Шүүх нь бие даасан, хараат бус байна. Шүүх эрх мэдлийг гагцхүү хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Хамгийн өндөр албан тушаалтны шийдвэр эцсийнх болох нь...

Алжирт анхан шатны болон давж заалдах шатны гэсэн 2 шатны шүүх байдаг. Тэдгээрийн үйл ажиллагааг эцсийн шатанд нь Дээд шүүхээс зохион байгуулдаг.

1 Үүнд гол төлөв прокурор, шүүхийн бусад ажилтан ордог

Төрийн зөвлөл (State Council) нь захиргааны хэргийн шүүхүүдийн ажлыг зохицуулах үүрэгтэй. Дээд шүүх болон Төрийн зөвлөл нь улс орны хэмжээнд хууль дээдлэх ёсыг хангуулах, жишиг хуулийг тогтоох үүрэгтэй. Үндсэн хуулийн 147-р зүйлд заасны дагуу “шүүгч гагцхүү хуульд захирагдан ажиллана”. Дээд шатны 37 шүүхийн дэргэд прокурорын газар ажиллах ба тэдгээрийг төлөөлөн ажиллах Ерөнхий прокурорыг Хууль зүйн яамнаас томилдог.

Тус улсын Үндсэн хуулийн 72-р зүйлд заасны дагуу БНУ-ын Ерөнхийлөгч нь хуулийн байгууллагын хамгийн дээд албан тушаалтан байх ба бүх шатны шүүхийн шүүгчийг шилжүүлэх, албан тушаал дэвшүүлэх эрхтэй. Энэхүү шүүгчийг шилжүүлэх явдал нь байнга тохиолдох бөгөөд шалтгаан нь хэзээ ч тайлбарлагдаж байгаагүй. Шүүгчээс доогуур бусад албан тушаалтнуудыг Хууль зүйн сайд томилдог. Түүнчлэн Хууль зүйн сайд нь шүүгчийг прокурор буюу мөрдөн шалгах магистрат (шүүгч)-аар томилох буюу эсрэгээр магистрат болон прокурорыг шүүгчээр томилон ажиллуулах эрхтэй байдаг. Шүүгчийг байнга өөрчлөн томилох бөгөөд уг процесс нь ил тод бус, хаалттай явагдахын зэрэгцээ шийдвэрийн шалтгаан, үндэслэлийг тайлбарладаггүй. Түүгээр үл барам, шүүгчийн хууль бус үйлдэлд хариуцлага ногдуулахгүй байх явдал түгээмэл гардаг. Харин эсрэгээр, “хэтэрхий” хараат бус гэж тооцогдсон шүүгчийг алс бөглүү орон нутагт томилох нэрээр “цөлж” шийтгэх эсхүл уг шүүгчийг хээл хахуулийн хэрэгт зохиомлоор буруутган шийтгэдэг.²

Анхан шатны болон давж заалдах шатны шүүх хуралдаанд прокурор нь хурал даргалагч шүүгчээс илүү эрх мэдэлтэй оролцдог. Шүүхэд хүнд суртал их байдаг нь шүүгчээс бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэхэд саад болдог. 2006 оны дундуур Алжирт өмгөөлөгчид шүүгчдийн хээл хахууль авч буй явдлыг эсэргүүцэн шүүх хуралдаанд оролцохгүй бойкотлож байсан байна. “Улсын Ерөнхий прокурор, хуульч, өмгөөлөгчид, шүүгч, шүүхийн ажилтнуудыг авлигын гэмт хэрэгт сэжиглэж байгаа мэт ойлголт төрүүлж шүүгч болон хуульч, өмгөөлөгчдийн хооронд гарсан зөрчлийг улам дэвэргэж байна. Харин асуудал нь Ерөнхий прокурор прокурорын байгууллагыг өөрийн хувийн өмч мэт ашиглаж байгаад оршино” гэж энэ явдлын талаар нэртэй хуульч, Алжирийн хуульчдын холбооны Ерөнхийлөгч Абделмаджид Селлини хэлжээ³.

Тус улсын Үндсэн хуульд заасны дагуу Шүүхийн дээд зөвлөл (ШДЗ) нь шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эрхтэй ба энэ зөвлөлийг Төрийн тэргүүн болон Хууль зүйн сайд нар хамтран удирддаг. ШДЗ нь Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн удирдлаган дор хаалттай хэрбэрээр хуралдаж, шүүгчид сахилгын хариуцлага

2 www.abanet.org William D. Meyer, “Shifting the Power in Ajelgeria” Judges ’ Journal Spring 2003 ийм эдийн засгийн орчинд шүүгч хувийн журмаар туслалцаа үзүүлснийхээ төлөө төлбөр авдаг. Үүнийг хэн ч асуудал болгон авч үзэхгүй ч “марталгүй” санаж байх ба хэрэв шүүгч гэнэт хараат бус байдлыг шаардаж эхэлбэл, түүний хуучин хар хэргийг сөхөж, хариуцлага тооцох асуудал яригддаг.

3 El Watan сонин, (Algeria) 19 June 2006

хүлээлгэх буюу шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах эсэх асуудлыг шийдвэрлэдэг. Харин энэ зөвлөл шүүгчид холбогдох авлигын хэргийг шалгах эрхгүй. Энэ эрхийг Хууль зүйн сайдын дэргэдэх Ерөнхий хянан шалгах газар хэрэгжүүлж, гаргасан дүгнэлтээ ШДЗ-д танилцуулдаг. Уг шийдвэрийг нийтэд мэдээлдэггүй, давж заалдах эрхгүй байдаг. Шүүгчид холбогдох мөрдөн шалгах ажиллагаа тэр бүр шударга явагддаггүй. Жишээлбэл, 2006 онд Оран мужийн хуулийн байгууллагын хоёр ажилтанг “албан үүргээ хангалтгүй биелүүлсэн” гэдэг үндэслэлээр ажлаас халсан ба шалтгааныг олон нийтэд мэдээлээгүй юм.⁴

1992 онд Алжирт онц байдал зарласан нь улс орны нөхцөл байдлыг улам дордуулсан. Онц байдал зарласан нэрийн дор захиргааны болон цагдаагийн байгууллагууд эрх хэмжээгээ хэтрүүлж байсан төдийгүй шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх явдал цөөнгүй гарсан юм. Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрхийг бүдүүлгээр зөрчих явдал газар авсан. Алжирийн социологч Лахуари Аддигийн хэлснээр шатахууны үнэ тэнгэрт тултал өссөн явдал нь “тэрбумтнуудаас төрийн албан хаагчид, аюулгүй байдлыг хангах ажилтнууд болон хуулийн байгууллагын бусад ажилтнуудад хээл хахуулийг динараар бус хэдэн мянган еврогоор өгөх, өөрийн ажлаа ийм аргаар бүтээх явдал цагаандаа гарахад” хүргэсэн байна.⁵

Алжирт хавар ирж байна уу?

2004 оны 9 сард парламентаас “Шүүгч болон хуулийн байгууллагын ажилтнуудын эрх зүйн байдлын тухай хууль”-ийг батлан гаргаснаар шүүхийн шинэтгэлийн үйл ажиллагааны зогсонги байдлыг халах эхлэл болов.⁶ Энэ хүрээнд Шүүхийн дээд зөвлөлийг санхүүгийн хувьд хөл дээр нь босгох, шүүгчийн сургалт, тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг хариуцуулах, улмаар шүүхийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэхийг зорьсон юм. Гэвч шүүгчдэд сургалт явуулах, тэдэнд тэтгэвэр, хангамж олгох эсэх шийдвэрийг Ерөнхийлөгч, Хууль зүйн сайдын хамт дэмжсэн тохиолдолд баталгаажна. ШДЗ-ийн хараат бус байдлыг хангахын тулд юуны өмнө гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын нөлөөнөөс гаргах, зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэрийг олон нийтэд ил тод байлгах, зөвлөлийн бүх гишүүдийг сонгодог болгох хэрэгтэй байна.⁷

4 El Khabar, (Algeria) 26 June 2006

5 Le Monde diplomatique (France April 2006)

6 Liberte (Algeria) 13 June 2004

7 Шүүгчдийн үндэсний холбоогийн мэдээлснээр гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргасан 05\92 тогтоол нь шүүхийн үйл ажиллагаанд олон тооны тодорхойгүй байдал, зөрчлийг бий болгож, гүйцэтгэх засаглалын байгууллагаас шүүхийн үйл ажиллагаанд эрх мэдлээ хэтрүүлэн хууль бусаар нөлөөлөх, шүүгчдийг ор үндэсгүйгээр гүтгэх, шүүхийн ажилтнуудын нэр хүндийг унагах, ор үндэслэлгүй худал зүйлд тэднийг буруутгах нөхцөлийг бүрдүүлжээ. (Шүүгч болон хуулийн ажилтны эрх зүйн байдлын тухай хуульд санал өгөх материалаас авав)

1989-1992 оны хооронд Шүүхийн дээд зөвлөл жинхэнэ утгаараа хараат бус байсан. Өөрөөр хэлбэл 1989 онд тус зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүгч нараас сонгогдсон шүүгч болон хуулийн ажилтнууд ордог байсан ба шийдвэрээ бие даан гаргадаг байв. Харин 1992 онд тус улсад онц байдал зарлагдсаны дараа парламент тарж, Ерөнхийлөгч огцорч, хүчирхийлэл газар авч, зөвлөлийн зарим гишүүд огцорч, эрх мэдэл нь буурсан байна. Түүнчлэн засгийн газрын шийдвэрээр Шүүхийн болон хуулийн байгууллагын ажилтны эрх зүйн байдлын тухай хуулийг өөрчилж, зөвлөлийн эрх хэмжээг хумиж, шүүгч болон хуулийн байгууллагын бусад ажилтны эрх хэмжээг хассан юм.⁸ “Улс төрийн тогтворгүй байдал ийм алхам хийхэд хүргэлээ” хэмээн эрх баригчид гаргасан шийдвэрээ зөвтгөхийг оролджээ. 1992-1999 оны хооронд зөвлөл бараг хуралдаагүй. Харин 2006 оноос эхлэн шүүхэд бага зэрэг нааштай өөрчлөлт гарч ШДЗ-ийн шүүгчдээс сонгогдсон шүүгч гишүүд олонх болсон байна.⁹

2004 онд хийгдсэн шинэтгэлийн хэсэг болгож шүүгчдийн цалин хангамжийг нэмсэн нь шүүхийг авлигаас хамгаалахын тулд авсан нэг арга хэмжээ болов. Гэвч шүүгчийн сарын дундаж цалин зөвхөн 720 ам.доллартай тэнцэхүйц динар байгаа нь Марокко болон Туниссын шүүгчийнхтэй харьцуулахад бага юм. Түүнчлэн, хуулийн 29-р зүйлд нэмэлт өөрчлөлт оруулж, шүүгчийн бүрэн эрхийн хугацааг 10 жил болгон сунгаж, шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр шүүхэд шилжүүлэхгүй байхаар заажээ. Шинэ хуулиар шүүгчдийн албан тушаал дэвших, мэргэжлийн хувьд хөгжих бололцоог дахин сэргээн баталгаажуулжээ. Засгийн газраас НҮБ болон АНУ, Герман, Итали, Франц, Канад зэрэг орны засгийн газарт хандан шүүгчдийг сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дагнан мэргэшүүлэх тал дээр туслалцаа үзүүлэхийг хүссэн байна.

“Шүүгч бол тэнгэрийн элч биш”

Авлигатай тэмцэх ажлыг улс орны хэмжээнд өргөн хүрээнд зохион байгуулах нь илүү үр дүнтэй байдаг. Өөрөөр хэлбэл нэг, хоёр хууль гаргаж цөөхөн хэдэн эрх мэдэлгүй байгууллага ажилласнаар үр дүнд хүрэхгүй. 1996 онд Авлигын эсрэг үндэсний ажиглагч байгууллагыг байгуулсан ч түүнд хангалттай хэмжээний эрх

8 1992 оны 10 сарын 24-ны өдрийн 05/92 тогтоолоор шүүгч, шүүхийн ажилтанг томилох, тэдний бүрэн эрхийн хугацааг тогтоох эрх мэдлийг Хууль зүйн яаманд өгсөн ба зөвлөл урьд нь энэ эрхийг хэрэгжүүлдэг байв. Түүнчлэн, зөвлөлийн гишүүдийн тоог 17 болтол бууруулж, тэдний 6 нь шүүгч, шүүхийн ажилтны төлөөлөл байхаар тогтоожээ. Үүн дээр орон тооны бус даргалах шүүгч, Ерөнхий прокурорыг нэмээд ч шүүгчид, хуульчид цөөнх байна. Дөрвөн гол гишүүн буюу Төрийн албаны зөвлөлийн тэргүүн, Хууль зүйн яамны холбогдох газрын гурван захирлыг Ерөнхийлөгч томилоно.

9 2004 оны 09 сарын 6 өдөр Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу зөвлөлийн 10 гишүүн нь шүүгч, хуулийн байгууллагын ажилтан байх ба Ерөнхийлөгч 6 хүнийг өөрийн саналаар томилох эрхтэй юм. Үүн дээр Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор нар нэмэгдэнэ.

мэдэл олгоогүй нь энэ байгууллагыг жинхэнэ утгаараа ажиллахад саад болсон. Мөн авлигатай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзлэл дутсан бөгөөд 2000 онд тус байгууллагыг татан буулгажээ.

Алжир Улсад 2001 оноос эхлүүлсэн шүүхийн шинэтгэлийн ажил удааширч ирсэн бөгөөд энэ ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.¹⁰

2006 онд парламентаас авлигатай тэмцэх ажлын хүрээнд Авлигын эсрэг үндэсний цогц стратегийн баримт бичгийг батлан гаргасан байна. Эрх зүй судлаачид уг баримт бичгийг Эрүүгийн хуулийн цоорхойг нөхөхөд чиглэсэн гэж шүүмжилдэг. Уг стратеги бичигт авлигын хэрэг үйлдсэн буюу төрийн өмчийг хууль бусаар завшсан төрийн албан хаагч, шүүгч, хуулийн ажилтан, цагдаа болон захиргааны ажилтанг хорих буюу их хэмжээний мөнгөөр торгох ял ногдуулахаар заажээ. Авлигын эсрэг үндэсний цогц стратеги нь авлигатай үр дүнтэй тэмцэх аргачлал, зааварчилгаа өгөх, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд чухал үүрэг бүхий шинэ төвийг үүсгэжээ.¹¹

2006 оны 6 сарын 18-нд ШДЗ хоёр шүүгчийг авлигын хэрэгт холбогдуулан шүүгчийн албан тушаалаас нь огцруулжээ. Чухам ямар хэрэг үйлдсэн, шүүх процесс хэрхэн явагдсан талаар мэдээлэл нийтлээгүй байна. Огцрох шийтгэл хүртсэн шүүгчид давж заалдсангүй. 2005 оны сүүлээр ШДЗ торгуулийн шийтгэл хүлээсэн 17 шүүгчийн хэргийн материалыг судалсан байна. Үүнтэй холбогдуулан “Шүүгч бол тэнгэрийн элч биш” гэж Хууль зүйн сайд Таеб Белайз мэдэгджээ.

Энэ нь тусгаар тогтнолоос хойш анх удаа ийм олон тооны шүүгчид нийтэд ил тодоор албан тушаалаас чөлөөлөгдсөн явдал болсон. “Гэм буруутай нь тогтоогдсон 60 гаруй шүүгч, хуулийн ажилтанг ажлаас нь халсан нь шүүхэд их хэмжээний цэвэрлэгээ хийсэн хэрэг боллоо” хэмээн Хууль зүйн сайд үндэсний хэвлэлийн агентлагт ярилцлага өгөхдөө хэлжээ. “Ер нь шүүхийн шинэтгэлийн ажил нь богино хугацаанд хийгдэх ажил биш бөгөөд зөрчлийг үндсээр нь устгах хүртэл тогтвортой үргэлжлүүлэн хийх шаардлагатай юм.”¹²

Түүнчлэн Хууль зүйн сайд Белайз шүүгчдийг огцруулах шийдвэрийг зарлахын өмнө “Хариуцлагаас мултардаг цаг дууслаа” хэмээн хэлжээ.

10 Моханд Иссаад, олон улсын хуульч, Шүүхийн системийн шинэтгэлийн үндэсний комиссын дарга, хамгийн түрүүнд шүүхийн шинэтгэл зогсонги байдалд орлоо гэж хэлсэн бөгөөд төрд шүүхийн системийг шинэчлэх бодит хүсэл эрмэлзэл дутаж байна гэж тэмдэглэжээ. (Quotidien d.Algeria)2002 February 28)

11 Cabinet communiqué, April 13, 2005

12 El Watan (Algeria), 19 December 2005.

Халифагийн хэргийг шийдвэрлэхгүй удаашруулж байна

Халифагийн хэрэг бараг хоёр жилийн турш олон нийтийн анхаарлын төвд байв.¹³ Англид амьдардаг Рафик Халифа гэдэг бизнесмен Алжирийн төрийн байгууллагын бараг бүх төвшний албан тушаалтнуудтай сүлбэлдэн 2 тэрбум гаруй ам.долларын хөрөнгийг хувьдаа завшсан тухай дуулиант хэрэг гарсан юм. Хэрэг Блида (Алжираас 50 км зайтай) хотын шүүхээр хянагдаж байгаа ба хавтаст хэргийн нууцыг үл харгалзан энэ хэргийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацсан байлаа. Мөрдөн байцаалтын нууцыг задруулж буй нь хэвлэлийнхэн болон хуулийн ажилтнуудын хувьд шинэ зүйл биш байлаа. Халифагийн бүлэгийн удирдагчтай нягт холбоотой гэх Алжир хотын шүүхийн шүүгчийг тушаалаас нь маш нууцлаг байдлаар огцруулсан байна.¹⁴

Файсал Метатуи
(Ел Ватан, хэвлэлийн редактор)

13 Algeria Presse Service, Algeria, 15 December, 2004

14 Дэлхий нийтийн авлигын тайлан 2004, 2006-г үзнэ үү.

Азербайжаны хуулин дахь шинэтгэл ба түүний хэрэгжилтийн зөрүүтэй байдал

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мөрдөн шалгах зарчимд тулгуурладаг, прокурорын байгууллага нь шүүх эрх мэдэлдээ багтдаг

100,000 хүн амд ногдох шүүгчийн тоо: 4.1¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 11,756 ам доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: мэдээлэл байхгүй

Нэг хүнд ногдох УНБ: 1,240³ ам доллар

Шүүхийн жилийн төсөв: 31.2 сая⁴ ам доллар

Жилийн нийт төсөв: 3.9 тэрбум⁵ ам доллар

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.8

Шүүхийн бүх шийдвэрийг хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Гийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Гийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Үгүй

1. Council of Europe (2002)

2. Zerkalo, Azerbaijan, 9 May 2006

3. World Bank Development Indicators (2005)

4. Law on State Budget (2006)

5. Өмнөх ишлэл

Азербайжан улсад шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах болон шүүхийн авлигатай тэмцэх талаар зохих арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. 2000 оноос эхлэн тус улсын засгийн газар Европын зөвлөлтэй хамтран стратегийн шинэтгэлийн хүрээнд шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчийг томилох, сонгох үйл ажиллагааг ил тод, шударга болгох арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлсээр байна. Шинэтгэлийн үр дүн сайн байгаа ч энэ нь шийдвэрлэх чухал өөрчлөлтийг хийхэд хангалтгүй юм. Шүүхийн системийг зохицуулж байдаг хууль болон дотоод тогтолцооны үйл ажиллагааны хүрээнд дэвшил гарч байгаа боловч бодит байдал дээр хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

“Freedom House” олон улсын байгууллагын судалгаагаар Азербайжан улсын шүүхийн бие даасан байдлын индекс 2006 онд 5.75 байв. (7 нь хамгийн доод үзүүлэлт юм) Шүүхийн үйл ажиллагаанд, шүүхийн шийдвэрт улс төржих явдал их гардаг.¹ 2005 оны 2 сарын 11-нд тус улсын Ерөнхийлөгч Илхам Алиев шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаан, шүүхийн гаргасан шийдвэр нь шударга бус байх зэргээр шүүхийн зарим шийдвэр, үйл ажиллагаа эрх зүйт төрийн шаардлагад нийцэхгүй байгаа бөгөөд шүүхэд дорвитой шинэтгэл хийх хэрэгтэй байгааг

1 Freedom house, Nations in Transit, 2006 (New York Freedom house 2006) www.freedom-house.org

хүлээн зөвшөөрсөн юм. Ялангуяа хувийн компаниудын хоорондын маргааныг шийдвэрлэхэд шударга бус шийдвэр байнга гардаг. Харин Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ дорвитой шинэтгэл шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн боловч шүүхийн авлигын талаар хөндөөгүй байна.² Азербайжаны “Ардын фронт” сөрөг намын дэд дарга Фуад Мустафаевын хэлснээр Азербайжаны шүүгчид хоёр үндэслэлээр шийдвэрээ гаргадаг. Үүнд нэгд, улс төрийн шалтгаанаар, нөгөө нь, барилгын “тендерийн” хувьд, тендерт хамгийн өндөр санал хүргүүлсэн талд ашигтайгаар шийдвэрлэдэгтэй адилаар хамгийн өндөр үнэ амалсан талд шийдвэр гаргадаг.³ Өмгөөлөгчид бид хууль зүйн өмгөөлөл хийдэг субъект бус “брокерийн үүрэг” гүйцэтгэх этгээд болж хувирч байна хэмээн дургүйцэж байна.

Азербайжан дахь Транспэрэнси Интернэшнл байгууллагын нийслэл Баку болон Азербайжаны гурав дахь том хот болох Ганжа хотуудад ажиллуулж буй Хууль зүйн зөвлөгөө, төвийн судалгаагаар ажиллаж эхэлсэн эхний жилдээ тэдний нөлөөллийн хүлээн авсан авлигын талаарх өргөдөл, гомдлын тавны нэг нь шүүгчид, шүүхийн байгууллагын ажилтан болон шийдвэр гүйцэтгэгч нартай холбоотой байдаг гэсэн дүгнэлт гарсан байна. Тухайлбал, 2006 оны 6 сарын 30-ны байдлаар шүүхтэй холбоотой 286 гомдол бүртгүүлсэнээс дийлэнх хувийг шүүгч болон шийдвэр гүйцэтгэгч авлигын хэрэгт холбогдсон тухай байв.

Шүүгчдийг бэлтгэн гаргах

Азербайжан улсын шүүхийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг 1997 оны Шүүх болон шүүгчийн тухай хуулиар тогтоосон байна. 2005 оны 12 сард Шүүх-эрх зүйн зөвлөл (Judicial Legal Council)-ийн тухай хууль батлагдах үед тус хуульд нэмэлт өөрчлөлт орсон байна. Энэ хоёр хуульд заасны дагуу шүүгчийг томилохдоо сонгон шалгаруулалт явуулах болжээ. 2004 онд батлагдан гарсан Авлигын эсрэг хуульд заасны дагуу шүүгчид бусдаас албан тушаалтайгаа холбогдуулан бэлэг хүлээн авахыг хориглосон ба шүүгчийг сонгох мэргэжлийн хороо байгуулж, шүүгчид нэр дэвшигч нарт сургалт явуулахаар болжээ. Түүнчлэн, шүүхийн авлигын талаарх иргэд байгууллагаас гомдол, мэдээллийг хүлээн авах сувгийг бий болгожээ. Авлигын асуудалд холбогдсон шүүгчийг шалгах ажиллагааг эхлүүлэх эрхтэй тус зөвлөлд иргэд шууд хандах боломжийг нээж өгсөн.

2004 оны 12 сард бас хоёр өөр хууль батлагдан гарсанаар шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх журмыг энгийн болгох, хангалттай нотлох баримт бүрдсэн тохиолдолд шүүгчийн халдашгүй бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг тус тус заажээ. Шинжээчдийн үзэж байгаагаар энэ асуудлыг материаллаг эрх зүйн гэхээсээ илүү зөвхөн процессийн хувьд шийдвэрлэсэн шинжтэй болсон байна.⁴ Одоогоор шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсэн тухай мэдээлэл алга байна. й

2 Азербайжан, 2006-02-04

3 Vaku Kheber, Azerbaijan 24 April, 200044

4 Авлигатай тэмцэх ажлын хүрээнд хууль зүйн орчин болон байгууллагын үйл ажиллагаанд дүгнэлт хийхэд зориулан гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх мониторингийн ажлын баримт бичиг, 2006\06\13, OECD, Парис, 5-р хурал

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүхийн бүтэц зохион байгуулалттай холбоотой зарим өөрчлөлтийг хийсэн. Тухайлбал, 2005 оны 12 сард маргаан шийдвэрлэх процессийг хурдасгах зорилготойгоор орон нутагт нэмэлт шүүхүүдийг байгуулсан юм. Үүнд Баку, Ганжа, Сумгайт, Али Баярамли, Шеки зэрэг хотуудад давж заалдах шатны шүүхийг нэмж байгуулж, онц хүнд гэмт хэргийг шийдвэрлэх шүүхийг Накичеванд, Баку хотод эдийн засгийн шүүх хоёр, Сумгайт, Шекид тус тус нэгийг нэмж байгуулжээ.

2006 оны 1 дүгээр сард Ерөнхийлөгч зарлиг гарган тус улсын шинэ болон одоо байгаа шүүхүүдэд шаардлагатай байгаа шүүгчдийн орон тоог нэгтгэн гаргахыг Шүүхийн зөвлөлд үүрэг болгосон байна. Үүний зэрэгцээ шүүгчээс албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэх, урвуулах зэрэг хууль бус үйлдэл хийхгүй байх, шүүхийн авлигаас сэргийлэх үүднээс шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсруулан гаргахыг холбогдох байгууллагад үүрэг болгожээ.

Ерөнхийлөгчийн шийдвэр эцсийнх болох нь

2005 онд шүүхийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд шүүхийн зөвлөлийг байгуулсан. Тус зөвлөл нь шүүгчийг сонгон шалгаруулах, албан тушаал дэвшүүлэх болон шилжүүлэх, шүүхийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, авлигад автагдсан эсхүл чадвар сул шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэн шалгах чиг үүрэгтэй. Зөвлөлийн 15 гишүүнийг Ерөнхийлөгч, парламент, Үндсэн хуулийн цэцээс томилдог бөгөөд уг зөвлөл Хууль зүйн сайд, Дээд шүүхийн тэргүүн, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр 2, Накичеваны өөртөө засах мужийн Дээд шүүхийн нэг шүүгч, Хуульчдийн холбооны төлөөлөгч, Прокурорын газар болон Хууль зүйн яамны төлөөллөөс бүрдэнэ. Тэднийг сонгоход олон нийт оролцдоггүй. Хуулийн зохицуулалтаар бол (*De jure*) хараат бус шүүх засаглал тогтсон гэж үзэж болох бөгөөд шүүхийн зөвлөл 2.5 жил тутамд тэргүүнээ дотроосоо сонгох ёстой. Харин практикт гишүүд зөвлөлийн даргаар Хууль зүйн сайдыг “сонгох” хандлагатай байдаг. Энэ нь бодит байдал дээр (*De facto*) шүүхийн зөвлөлийг хянах, удирдах эрхийг буцаагаад гүйцэтгэх эрх мэдэлд олгосон байна гэсэн үг юм.

2005 оны сүүлээр шинэ шүүгчдийн сонгон шалгаруулалт явагдсан. 9 сард эрх зүйн мэдлэгийн тест, дараа нь 11 сард эссе бичлэгийн шалгалтыг тус тус авсан. 2006 оны 2 сард шалгарсан өрсөлдөгчид ярилцлага буюу ам шалгалтанд оролцох юм. Иргэний нийгмийн байгууллагууд болон олон улсын ажиглагчдын гэрчилснээр шалгалтын эхний хоёр үе шат ямар нэг зөрчилгүй явагджээ. Одоогоор нийт 56 өрсөлдөгч шалгаран үлдэж сургалтанд хамрагдаж байна. (энэ тайлан бэлтгэх үед шалгалтын эцсийн дүн гараагүй байлаа) Шүүхийн зөвлөлөөс ярилцлагад амжилттай тэнцсэн хүмүүсийн нэрсийг Ерөнхийлөгчид танилцуулах ба эцсийн томилгоог Ерөнхийлөгч хийнэ. Үүнээс харахад шүүгчийн томилгоо нь гүйцэтгэх эрх мэдлийн нөлөөн дор явагддаг. Үүний нэгэн адилаар Дээд шүүхийн шүүгчид, Ерөнхий прокурор хүртэл албан тушаалд томилогдохын тулд “гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хараат” байдаг.

Процедурын гажиг

Одоогийн системд шүүгч нь хуулийн тодорхой заалт хэрэглэлгүйгээр эсхүл үндэслэлээ тайлбарлалгүйгээр хэрэг үүсгэхээс татгалзах эрхтэй юм. Зарим тохиолдолд Азербайжан улсын хуульд заагаагүй үндэслэлээр эсхүл хуулиар олгогдсон хүний эрхтэй зөрчилдсөн шийдвэр гаргадаг. Жишээлбэл, Адил Гахрамановын холбогдсон нэг хэрэгт (Ерөнхийлөгч асан Аяз Муталибовын 5 дагалдагчийн нэг болох) шүүгч шүүгчдэгч болон хохирогчийн тайлбарт хоёр өөр дүгнэлт гаргаж, шийтгэсэн байна.⁵ (2001 оны 10 сард тус Ерөнхийлөгчийг төрийн эрх мэдлийг хууль бус аргаар булаан авахыг завдсан хэрэгт гэм буруутай нь тогтоогдсон)

Шүүхээр хэрэг, маргааныг шийдвэрлүүлэхэд цаг хугацаа их ордог. Ингэж цаг хугацаа алдахын оронд хувийн компаниуд нэхэмжлэлээсээ татгалзах эсхүл “шүүгчтэй тохиролцох”-ыг илүүд үздэг. Учир нь шүүх хуралдаанд хэргийн нөгөө тал ирээгүй тохиолдолд шүүх хэргийг хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэхийг хориглодог ба буруутай талд хариуцлага хүлээлгэх боломжгүй байдаг. Европ болон Төв Азийн бусад оронд компаниудын 30 хувь нь маргаанаа шүүхээр шийдвэрлүүлдэг бол Азербайжанд энэ тоо дөнгөж 5 хувьтай байна.⁶

Шүүгч нарт сахилга бат дутаж байна

Шүүгчдийн ажлын ачаалал их байхад эсрэгээр тэдний цалин хангамж бага байдаг. Азербайжанд 100,000 хүнд 4.06 шүүгч ногддог. Харин Германд энэ үзүүлэлт 25.3 байна. Энэ нь нэг хүнд ногдох шүүгчийн хувьд тухайн бүс нутгийн хамгийн доогуур үзүүлэлт юм. Азербайжанд орон нутгийн шүүхийн шүүгчийн жилийн дундаж цалин саяхан мэдэгдэхүйц өссөнөөр 11,637 ам доллар болсон, харин хөрш зэргэлдээ Эстони улсад 23,800 ам. доллар байна.⁷

Шүүгчид ажлын горимыг тэр бүр баримталдаггүй. Шүүхийн зөвлөл жил бүр Хууль зүйн яамнаас ирүүлсэн шүүгчдийн ажлын үнэлгээний тайланг хянадаг. 2006 оны 5 сарын байдлаар хувцаслалтын дүрэм зөрчсөн, шүүн таслах үйл ажиллагааг шүүх хуралдааны танхимаас өөр газар, ажлынхаа өрөөнд явуулсан, хуулиар тогтоосон хэрэг шийдвэрлэх хугацааг хэтрүүлсэн, бусад зөрчил гаргасан зэрэг үндэслэлээр нийт 10 шүүгчийг шийтгэсэн байна.⁸ Хэдийгээр хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийн байгууллагын мэдээлж байгаагаар практикт авлигын хэрэг, зөрчил олон гардаг гэдэг ч авлигын хэргээр нэг ч шүүгчийг огцруулаагүй байна.

5 Zerkalo Azerbaijan, 9 May 2006

6 World bank Press release, 29 June, 2006

7 Zerkalo, Azerbaijan, 9 May 2006

8 Давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн танхимийн тэргүүн шүүгч Асиф Аллахвердиевыг албан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэдэг үндэслэлээр ажлаас халжээ. Тэрээр үзэл бодлоо чөлөөтэй, шулуухан илэрхийлдэг, зоригтой шүүгч байжээ.

2005 онд Хууль зүйн яам болон прокурорын газраас прокурор, шүүгч, цагдаагийн ажилтнуудад зориулан хэд хэдэн удаагийн авлигын эсрэг сургалтыг зохион байгуулсан. Ингэхдээ сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажиллагаанд ТББ-уудыг оролцуулаагүй байна.

Бас нэг санаа зовоосон асуудал бол шүүгчийн мэргэжил, ур чадварын төвшин хангалтгүй байгаа явдал юм. Газрын тосны үйлдвэрийн ажилчдын эрхийг хамгаалах хорооны дарга Мирвари Гахраманли хэлэхдээ: *“Манай шүүгчид нийгэм эдийн засгийн маргааныг шийдвэрлэх талаар хангалттай мэдлэггүй. Тэдэнд хөдөлмөрийн эрх зүйн харилцаатай холбоотой асуудлаар сургалт явуулах зайлшгүй шаардлагатай”* гэжээ.⁹

Үүний зэрэгцээ мэдлэг боловсролтой өмгөөлөгчид дутмаг байна. Саяхныг хүртэл улсын хэмжээнд зөвхөн төрийн хяналт бүхий өмгөөлөгчдийн бүлэг болон хуульчдийн холбооны 370 гишүүн эрүүгийн хэрэгт өмгөөлөл хийдэг байсан. 1999-2000 онд шинээр гишүүн нэмэгдээгүй.¹⁰ 2004 оны 8 дугаар сард Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэ холбоо байгуулагдсан ба үүний дараа 36 хуульч шинээр эрх авч, Хууль зүйн яам сонгон шалгаруулалтад хориг тавьсанаар 220 гэрчилгээ бүхий хуульчид энэ эрхийг авч чадалгүй хасагдсан байна. Энэ өөрчлөлтийн дараа холбоо нийт 400 гишүүнтэй болсон боловч тэдний 50 нь л тогтмол эрүүгийн хэрэгт өмгөөлөл хийдэг.¹¹ Харин 2005 оны 8 сард хуульд дахин нэмэлт өөрчлөлт орж, эрхээ хасуулсан өмгөөлөгч шалгалт өгөлгүйгээр эрүүгийн хэрэгт оролцох эрхтэй болсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хангалтгүй байна

Шүүхийн системд тулгарч буй бусад бэрхшээлтэй асуудлыг дурдвал: шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид эрх мэдэл, мэргэжлийн ур чадвар дутах, шаардлагатай материаллаг хангамж хүрэлцэхгүй байх, шийдвэрийг гүйцэтгэхэд санаачлагагүй хойрго хандах зэрэг хүчин зүйлс ордог. Жишээлбэл, Хууль зүйн зөвлөгөө, нөлөөллийн төвийн 137/87 хэрэгт нэгэн даавууны үйлдвэрийн удирдлага шүүхийн шийдвэр гарсны дараа ч ажилчдынхаа үлдэгдэл цалинг олгоогүй тухай гомдол гарсан байв. Энэ хэргийн гол шалтгаан нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хийгээгүйгээс болсон байна. Бас 135/88 тоот гэрлэлт цуцлах тухай хэрэгт хүүхдийг эцгийн асрамжаас авч эхийн асрамжид шилжүүлэн өгөх шийдвэрийг шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлээгүй байна. Энэ нь хэдийгээр эдгээр хэргүүдэд авлигын шинж байгаагүй ч шүүхийн бүх шатанд төдийгүй шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх үед ч “бусдын гар харах” үзэгдэл байгааг харуулж байна. Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх нь шүүх болон шударга ёсонд итгэх олон нийтийн итгэлийг бууруулдаг.

9 Baku Kheber, Azerbaijan, 24 April 2006

10 OSCE, Report from the Trial Monitoring Project in Azerbaijan 2003-04 Baku OSCE, 2004, www.osce.org/odihr/item_11_13762.html

11 Өмнөх ишлэл

Шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд прокурорт гомдол гаргах ба үүний өмнө шүүгчид энэ тухай мэдэгдэх ёстой. Энэ нь практикт бараг хэрэгждэггүй. Шүүхийн шийдвэр хэрэгжихгүй байгаагийн бас нэг шалтгаан нь шийдвэр гүйцэтгэгч шүүхийн системд багтдаггүй харин гүйцэтгэх эрх мэдлийн удирдлага дор ажиллаж буйд оршдог.

Зөвлөмж:

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахын тулд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хамгийн гол нь:

- Шүүхийн зөвлөлийн Хууль зүйн яамны өмнө хариуцлага хүлээдэг байдлыг халах;
- Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүнд тэтгэвэртээ гарсан шүүгч, урлаг соёл, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оруулах;
- Шүүгч болон Ерөнхий прокурорыг томилохдоо тухайн хүний мэргэжлийн ур чадварыг харгалзан үзэх, Шүүхийн зөвлөлийн өргөн мэдүүлсэнээр парламентаас томилгоо хийдэг болох;
- Шүүхийн үйл ажиллагаанд мониторинг хийх үүргийг Хууль зүйн яамнаас салгаж Шүүхийн зөвлөлд шилжүүлэн өгөх;

Процедурын өөрчлөлт хийхдээ:

- Шүүгч хэрэг үүсгэхээс татгалзахдаа үндэслэлээ бичгээр гаргах;
- Мэтгэлцэхэд шаардлагатай боломжит хугацааг тогтоох;
- Шүүх хуралдаанд ирээгүй хэргийн оролцогчид хариуцлага хүлээлгэх;
- Шийдвэр гүйцэтгэгчид шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд шаардагдах техник хэрэгсэл, нөхцөлөөр хангах;
- Парламент, шүүх болон цагдаагийн байгууллагууд хамтран гэрчийг хамгаалах хөтөлбөрийг боловсруулах;

Шүүхийн шинэтгэлтэй холбоотой бусад чухал асуудал:

- Дээд шүүх, Эдийн засгийн хэргийн шүүх, Үндсэн хуулийн шүүхээс гаргасан бүх шийдвэрийг интернетэд байрлуулах замаар олон нийтэд хүртээх;
- Хуулийн бүх салбар байгууллагуудад авлигын талаар сургалт зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудыг идэвхитэй оролцуулах;
- Олон нийтэд авлигын эсрэг боловсрол олгох хэрэгтэй байна.

*Рена Сафаралиева,
(Транспэрэнси Интернэшл-Азербайжан, Баку)*

Бангладешт шударга ёс замхарч байна

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мэтгэлцэх болон холимог зарчимд тулгуурладаг (Исламын хуулийн элемент агуулсан), прокурорын байгууллага нь шүүх эрх мэдэлдээ багтдаг
100,000 хүн амд ногдох шүүгчийн тоо: 0.6¹
Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 1,212 ам доллар²
Дээд шүүхийн шүүгчийн цалин: 4,812³ ам доллар
Нэг хүнд ногдох ҮНБ: 470⁴ ам доллар
Шүүхийн жилийн төсөв: 38.5 сая⁵ ам доллар
Жилийн нийт төсөв: 10.4 тэрбум⁶ ам доллар
Жилийн төсөвт эзлэх хувь: 0.4
Шүүхийн бүх шийдвэрийг хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм
Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат
Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Үгүй
Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. CIA World Factbook
2. Bangladesh Observer (Bangladesh) 17 May 2005
3. Independent-Bangladesh.com/news/sep/12/12092005mt.htm
4. World Bank Development Indicators (2005)
5. Ministry of Finance
6. Өмнөх ишлэл

Бангладешийн нийгэмд авлига газар авсан төдийгүй анхан шатны шүүхийн хувьд тулгамдсан олон асуудлын нэг болжээ. Транспэрэнси Интернэшнлийн Бангладеш дахь салбарын 2005 онд хийсэн судалгааны дүнгээс харахад өнгөрсөн жил нэг хэрэгт шүүхийн ажилтнуудад өгсөн хээл хахуулийн хэмжээ дунджаар 108 ам.доллар байсан гэж шүүхээр үйлчлүүлсэн (18.8 хувь) судалгаанд хамрагдагсдын 2/3 хувь нь хариулжээ.¹ Энэ нь тэдний жилийн орлогын 25 хувьтай тэнцэх юм. Харин Дээд шүүх нь доод шатны шүүхүүдэд хяналт тавих оролдлого хийснээрээ нийт олны итгэлийг олж авч чадсан байна.

Үндсэн хуулийн зохицуулалтыг өөрчлөх нь

1972 оны Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч нь Ерөнхий шүүгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Дээд шүүхийн шүүгчдийг томилдог. Харин Дээд шүүх нь доод шатны шүүхийн шүүгчийг томилох асуудлыг хянаж, зохион байгуулдаг. 1975 онд Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу “Ерөнхий шүүгчтэй зөвшилцсөний үндсэн дээр” гэсэн хэсгийг хассан бөгөөд 1993 он хүртэлх хугацаанд Дээд шүүхийн шүүгчийн томилгоог хуучин байдлаар хийж ирсэн боловч мөн онд Ерөнхийлөгч 6 шүүгчийг Ерөнхий шүүгчтэй зөвшилцөлгүйгээр томилсон байна. (Тухайн үед энэ томилгоо олны шүүмжлэлд өртөж улмаар томилгоог

1 Тухайн жилд нэг хэрэгт нэг буюу хэд хэдэн удаа гэсэн үг юм

хүчингүй болгож, хуучин журмын дагуу шинэ томилгоо хийгдсэн) Шүүгчийг томилох ажиллагаанд улс төрийн нөлөөлөл, дарамт улам бүр нэмэгдэж байгаад хуульчид болон иргэний нийгмийн байгууллагууд санаа зовж байна.

1999 оны Масдар Хоссейны хэргийн² шийдвэрт Дээд шүүх шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавих, шүүгчийг томилох, албан тушаал дэвшүүлэх, шилжүүлэх эрх бүхий хараат бус комиссыг байгуулахыг засгийн газарт үүрэг болгожээ. Ингэхдээ Дээд шүүхтэй зөвшилцөх ёстой. Үүний дараа Дээд шүүхээс 12 заалт бүхий удирдамж гаргаж, цалин хангамжийн асуудал эрхлэх комисс байгуулах, доод шатны шүүхийн үйл ажиллагааг үндсээр нь шинэчлэн өөрчлөх, эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах, шүүгчийг сонгох, томилох, сахилга хариуцлагын талаар шинэ журам гаргах зэрэг асуудлыг тусгасан боловч Дээд шүүх тус удирдамжид Үндсэн хуульд шүүгчийн хараат бус байдлыг хангах талаар өөрчлөлт оруулахыг хангалттай олонхи (өөрчлөлт оруулахад шаардагдах суудлыг авсан) байсан засгийн газраас шаардаагүй байна.³

Дээд хүчин чадалтай хууль тогтоомжид шаардлагатай өөрчлөлтийг оруулахгүй орхивол энэ нь хэрэгжүүлж буй шинэтгэл эрчимтэй явагдахгүй, харилцан тал зассан байдалд орж, түүний хурдыг удаашруулах нөхцөл болдог. Дээд шүүхийн гаргасан удирдамжийг бүрэн биелүүлэхийн тулд дараа дараагийн засгийн газрууд 20 гаруй удаа нэмэлт хугацаа авч байлаа. 2004 оны 11 дүгээр сар хүртэл Засгийн газраас Шүүхийн албаны комисс (Judicial Service Commission)-ыг байгуулаагүй байна. Мөн холбогдох журам гарах хүртэл уг комисс үйл ажиллагаагаа явуулаагүй.⁴ Зарим өндөр албан тушаалтнуудыг дээд шүүхийн шийдвэрийг гуйвуулсан, буруу тайлбарлаж хэрэглэсэн хэрэгт буруутгагдсан.⁵ Энэ шинэтгэлийн удаашрал үргэлжилсээр, шүүхийг 5 жил гаруй хугацаанд зогсонги байдалд оруулжээ.

Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч магистрат шүүгч

Дээд шүүх нь давж заалдах шатны ба эцсийн шатны шүүх гэсэн 2 хэсэгтэй. Эцсийн шатны шүүх нь хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэх, доод шатны шүүхийн шийдвэрийг хянах эрхтэй. Доод шатны шүүх нь эрүү, иргэний шүүх гэсэн хоёр төрөлтэй, 64 дүүрэгт ажилладаг. Эрүүгийн шүүх нь дотроо 10 жилээс

2 Ministry of Finance vs. Masdar Hossain, Хоссейн нийт 400 шүүгчийг төлөөлж, 1981 онд баглагдан гарсан Төрийн албаны тухай хуулийн дагуу шүүгчийг төрийн бусад албан хаагчтай адил үнэлэх, хянах ёсгүй хэмээн шүүмжилсэн байна. Дээд шатны шүүх ч түүний талд шийдвэрээ гаргасан байна. Ө.х 1981 оны хуулийг Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзжээ. Харин засгийн газар энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд дахин давж заалдсан ч Дээд шүүх шийдвэрийг хэвээр үлдээжээ.

3 Asia foundation, Judicial Independence Overview and Country Level Summaries (Manila: Asian Development Bank, 2003)

4 www.bangladeshlaw.org/news

5 Bangladesh observer, Bangladesh, 23 October 2005

дээш хугацаагаар хорих ял ногдуулж болох хэргийг шийдвэрлэх шүүх, 7 хүртэл жилийн хорих ял ногдуулах хэргийг хянан шийдвэрлэх магистрат шүүх гэсэн хоёр хэсэг.

Шүүхийн албаны комиссыг байгуулагдах хүртэл давж заалдах шатны ба дээд шатны шүүхийн шүүгчээс бусад бүх шүүгчид нэг буюу хэд хэдэн яаманд үйл ажиллагаагаа тайлагнадаг байв. Жишээлбэл, хотын магистрат цагдаагийн байгууллагыг хариуцдаг Дотоод хэргийн яаманд,⁶ дүүргийн магистратууд Төрийн албаны удирдлагын яаманд тус тус тайлагнана. Зарим тохиолдолд Магистрат аль яаманд тайлагнахаас хамаарч татвар бүрдүүлэлт, төрийн өмчийн хяналтыг хэрэгжүүлэх гэх мэт шүүхийн бус ажил, үүрэг гүйцэтгэдэг. Шүүх эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас бүрэн тусгаарлаагүй байгаа нь Магистратаас шүүн таслах эрхээ хэрэгжүүлэхэд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хууль бусаар нөлөөлөх боломжийг бүрдүүлдэг. Энэ байдал нь өнгөн талаас нь харахад Магистратыг шүүгч мэт харагдуулах боловч үнэн хэрэгтээ гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллага болгосон байна.⁷ Энэ байдал нь албан тушаалтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд, цагдаагийн ажилтнуудаас үйлдсэн авлигын болон бусад эрүүгийн хэргийн хохирогчдод анхан шатны шүүхээс маргаанаа шударгаар шийдвэрлүүлэхэд маш том саад болдог.

Шийдвэрлэгдээгүй хуримтлагдсан хэргүүд шүүхийн үйл ажиллагааг улам бүр удаашруулж байна

Хариуцлага хүлээлгэх тогтолцоо сул байгаа нь Магистрат болон шүүгчдэд ихээхэн эрх мэдэл олгодог байна. Хэдийгээр дүүргийн шүүгчийн цалин нь joint “нарийн бичгийн даргатай”⁸ ижил хэмжээний цалин авдаг ч албан тушаал, эрх хэмжээ, статусын хувьд харьцуулах боломжгүй ажээ. Шүүгчийн одоогийн авч буй цалин хангамж нь гэр бүлээрээ хангалуун амьдрахад хүрэлцдэггүй бөгөөд шүүхийн нэр хүндийг өндөрт өргөж, хариуцлагатай, чин шударгаар ажиллах хүсэл эрмэлзлийг төрүүлэх эдийн засгийн хөшүүрэг болж чадахгүй байна.

Ажлын ачаалал хэт их байх, сахилга бат сахиулах дүрэм журам сул байх нь шүүгч хээл хахууль авах, авлигад өртөх явдлыг нэмэгдүүлдэг. Энэ улсад Дээд шүүхийн 77, бусад шатны шүүхийн 750 шүүгч нийт 150 сая хүнд шударга ёсыг сахиулах

6 Asian Human Right Commission, “Open letter to the UN Special Rapporteur on the independence of Judges and Lawyers, 11 August 2006

7 Өмнөх ишлэлийг харна уу

8 Жойнт нарийн бичгийн дарга гэдэг албан тушаал нь нарийн бичгийн дарга (Хамгийн өндөр албан тушаал)-ын зэрэглэлээс 2 шат доогуур албан тушаал бөгөөд төрийн өндөр албан тушаал юм. Жойнт нарийн бичгийн даргын доор 3 шат бий: орлогч, ахлах-туслах, туслах нарийн бичгийн дарга. Дүүргийн шүүгч нь жойнт нарийн бичгийн даргын зэрэглэлийн хэмжээний олон хангамжийг эдэлдэггүй ба орлого нь жойнт нарийн бичгийн даргынхаас бага байдаг. Түүний цалин 242 ам. доллар байдаг. Дүүргийн шүүгчээс доогуур шатны шүүгч үүнээс ч бага цалин авдаг.

үүрэг хүлээдэг. Масдар Хоссейны хэргээс шалтгаалан 1999 оноос хойш анхан шатны шүүхэд шинээр шүүгч томилогдоогүй, энэ нь Шүүхийн албаны комисс байгуулагдаагүй байсантай холбоотой. Гэтэл одоогоор 210 шүүгчийн орон тоо сул байна.⁹ Шүүх, шүүгч дутагдалтай байдал бол хамгийн тулгамдсан бэрхшээл бөгөөд түүн дээр шүүхийн туслах ажилтан хангалтгүй, шүүхийн байгууллагын материаллаг хангаж муу, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар сул, шүүгчид хэргийн хугацааг сунгах эрх байхгүй зэрэг нь шударга ёсыг хэрэгжүүлэхэд саад болж байна. 2003 оны баримтаас харахад шийдвэрлэгдэх шатандаа байгаа 968,305 хэрэг, үүнээс анхан шатанд 344,518, магистратад 395,905, давж заалдах шатны шүүхэд 127,244, Дээд шүүхэд 4,946 хэрэг тус тус хүлээгдэж байлаа.¹⁰ Энэ их үлдэгдэл хэрэгтэй байгаа байдал нь хууль дээдлэх ёс, хэрэг, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж буйн нотолгоо юм. Түүнчлэн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхээр дугаар буюу дараалал олгох үйл ажиллагаанд авлига гарсаар байна.

Авлига хуулийн системийг бүхэлд нь хамарчээ

Шүүгч болон магистрат нар авлигад автагдсан хуулийн системийн байгуулагуудын ажилтнуудтай өдөр тутам харьцаж байдаг. Жишээ нь шүүхийн бичиг хэргийн ажилтан өргөдөл гомдлыг бүртгэж, хэргийн материалын бүрдлийг хангуулах ба хэргийн оролцогчдод хэрэгтэй мэдээлийг хээл хахууль өгсөн тохиолдолд гаргаж өгөх буюу эрүүгийн хэргийн магистратад нөлөөлөх боломжийг хангаж өгсөний төлөө мөнгө шаарддаг. 2005 оны ТИ-ын судалгаа өмгөөлөгч нь хариуцагч, хохирогч нараас хээл хахууль нэхэж авдаг болохыг илтгэсэн. 3,000 гэр бүлийг хамруулсан судалгаа явуулахад 392 хүн шүүхийн үйлчилгээ хүртэхийн тулд хээл хахууль өгсөн гэсэн дүгнэлт гаргасан. Тэдгээрийн 39 хувь нь өмгөөлөгчөөрөө дамжуулан шүүгч болон магистратад, 4 хувь нь прокурорт тус тус хээл хахууль өгчээ.

Бас нэг хүндрэл учруулж буй асуудал бол шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй байгаа явдал юм. Шүүхээс засгийн газарт хүргүүлдэг зөвлөмж, удирдамжийг хүнд сурталтай захиргааны байгууллагууд болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үл ойшоож, бүрэн хэрэгжүүлдэггүй байна.

9 Daily star, Bangladesh, 15 October 2005 and 11 May 2003, Bangladesh institute of law and international Affairs

10 Transparency international national integrity survey Bangladesh (Berlin) TI 2003, Дакагийн хотын шүүхэд 30000 хэрэг нэг жилээс дээш хугацаагаар хадгалагдсан байгааг судалгаагаар тогтоожээ.

Улс төржсөн шүүх тогтолцоо

“Миний үед одоогийнх шиг шүүгчдийг аль нэг намынх, тухайлбал Авамигийн талын шүүгч, БНП-гийн шүүгч, Жамаатийгийн шүүгч гэж ялгаж байсангүй” хэмээн Дээд шүүхэд 15 жил ажиллаад одоо тэтгэвэртээ гарсан шүүгч Наймуддин Ахмед хэлжээ.¹¹ Онолын хувьд Дээд шүүх нь шүүгчээс албаны чиг үүргээ хэрэгжүүлэхэд хууль бусаар хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн аливаа үйл ажиллагаанаас шүүгчийг хамгаалах, хууль бусаар нөлөөлөх оролдлого хийсэн этгээдийг шийтгэх эрхтэй. Шүүгч Ахмед, Дака хотын Друта Бичарын 2-р шүүхийн нэгэн шүүгчид тохиолдсон хэргийн тухай цааш ярихдаа: “Нэгэн шүүгчийг эрүүгийн хэрэгт шалгаж байгаа яллагдагчийг барьцаагаар суллахгүй бол өөр шүүхэд шилжүүлнэ гэж хоёр прокурор сүрдүүлсэн ба уг шүүгч Дээд шүүхээс хамгаалалт хүсчээ. Харин Дээд шүүх шүүгчээ хамгаалах арга хэмжээ авахын оронд түүнийг өөр шүүхэд шилжүүлсэн” тухай эргэн дурсжээ.¹² Шүүгчийн нас болон мэргэжлийн туршлагыг харгалзан албан тушаал дэвшүүлэхийн оронд туршлагагүй залуухан шүүгчийг өндөр албан тушаалд дэвшүүлж байгааг улс төрийн нөлөөлөлтэй холбон тайлбарлаж болно.¹³ “Өнөө үед шүүгчийг томилох, дэвшүүлэх болон өөр шүүхэд шилжүүлэхдээ чадварлаг, үр бүтээлтэй, зарчимч, зоригтой байх зэрэг шинжүүдийг харгалзан үзэхээ нэгэнт больжээ” гэж Ахмед бичсэн байна.

Шүүхийн дээд зөвлөлд Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон хамгийн ахмад настай хоёр шүүгч ордог ба тус зөвлөл нь Дээд шүүхийн шүүгчид холбогдох ёс зүйн зөрчлийн хэргийг шалгах эрхтэй. 2004 оны 4 сард уг зөвлөл анх удаа Дээд шүүхийн Эцсийн шатны шүүхийн шүүгчийг албан тушаалаас нь огцруулсан байна. Учир нь шинээр томилогдсон шүүгч Шахидур Рахманд урьд өмнө өөрөөр нь үйлчлүүлж байсан нэг этгээдийн гуйлтаар түүний хамаатны хэрэгт нааштай шийдвэр гаргуулахад туслахаар амлаж, хариуд нь мөнгө авсан байна. Энэ хэргийн талаар Хуульчдын холбооны Ерөнхийлөгч Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид мэдээлсэн байна. Уг шүүгч шийдвэрийг давж заалдсан боловч Дээд шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Шүүхийн дээд зөвлөлийн энэ шийдвэр нь бусад шүүгчээс ажилдаа өндөр хариуцлагатай хандаж, мэргэжлийн ёс зүйгээ чанд баримтлахыг шаардсан хэрэг болсон юм.

Шинэтгэлийн үр дүн

“Эрх зүй ба шүүхийн чадавхийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Дэлхийн банк болон бусад санхүүжүүлэгч байгууллагуудаас шударга ёсыг хүргэх, шүүхийн үйл ажиллагааг үр дүнтэй, хариуцлагатай болгох ялангуяа Бангладешийн эмэгтэйчүүд болон ядуу иргэдэд энэ үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор нийт 60 сая ам. долларын тусламжийг үзүүлсэн байна. 2001-2007 оны хооронд хэрэгжүүлэх зургаан жилийн хугацаатай төслийн хүрээнд шүүхийн хэрэг хуваарилалтын менежментийг сайжруулах, шүүхийн удирдлагыг боловсронгуй болгох, шүүхийн мэдээллийн

11 New Age (Bangladesh) 28 July 2006

12 Өмнөх ишлэл

13 Мөн тэнд

системийг үе шаттайгаар автоматжуулах, дүүргийн шүүхийн шүүгч болон шүүхийн ажилтнуудыг давтан сургах, шүүхийн барилгыг сэргээн засварлах ажлуудыг хийхээр төлөвлөжээ. Одоогоор Дээд шүүх болон зарим дүүргийн шүүхийг сонгон төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд амжилттай хэрэгжсэн тохиолдолд төслийг цаашид өргөжүүлэх юм. Системийн мэдээллийн сан бий болгож улмаар шүүхийг ил тод болгох, хэргийн шийдвэрлэлтийг сайжруулах зорилготойгоор ажилсан байна. Түүнээс гадна, Канадын Засгийн газрын санхүүжилттэйгээр Эрх зүйн шинэтгэл төсөл хэрэгжиж байгаа бөгөөд үүний хүрээнд насанд хүрээгүй иргэнд холбогдох хэргийг шийдвэрлэх, тэдгээрт хууль зүйн болон өмгөөллийн туслалцаа үзүүлэх, хэрэг, маргааныг шийдвэрлэх алтернатив аргыг заах чиглэлээр Жессор болон Газипур дүүргүүдэд Бангладешийн холбогдох яам болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

2004 оны 11 дүгээр сард гурван комиссараас бүрдэх Авлигатай тэмцэх комисс байгуулагдсан ба даргаар нь Дээд шүүхийн шүүгч Султан Хуссейн Хан ажилладаг. Тус комисс авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнд ногдуулах шийтгэлийг тогтоох эрхтэй. Хэдийгээр энэ комисс байгуулагдсанаасаа хойш хэдэн зуун албан тушаалтны эсрэг хэрэг үүсгэж, ял төлөвлөсөн боловч цөөхөн хэд нь шийтгүүлжээ. Тэдгээрийн заримыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын шийдвэрээр буюу шүүхээс тогтоогдоогүй гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ.¹⁴

Зөвлөмж:

- Масдар Хоссейны хэргийг цаашид шуурхай шийдвэрлэх;
- 2004 онд байгуулагдсан Шүүхийн дээд зөвлөлийн 7 гишүүний гагцхүү 2 нь л шүүгч байгааг анхааран үзэх;
- Шүүгч болон шүүхийн ажилтныг томилж буюу сонгохдоо шударга байх, хөндөнгийн байх зарчмыг баримтлах ба шүүгчийн бүрэн эрхийн хугацааг баталгаажуулах. Шүүгч, магистрат, цагдаа, прокурорын цалин хангамжийг нэмэгдүүлэх;
- Шүүгч, магистрат, цагдаа нараас анх ажилд орох, албан үүргээ гүйцэтгэж байгаа хугацаандаа тогтмол, шүүхийн албанаас гарахдаа өөрийн болон гэр бүлийн гишүүний хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг механизмыг бүрдүүлэх. Бие даасан, хараат бус байгууллагаас уг мэдүүлгийг шалгадаг байхын зэрэгцээ Авлигын эсрэг комисст шүүгч нарт холбогдох авлигын хэргийг мөрдөн шалгах, яллах эрхийг олгох;
- Шүүхийн хэргийн бүртгэлийн онлайн системийг бий болгох, шүүхийг компьютержүүлэх, хэргийн талууд болон өмгөөлөгчөөс тэдгээр системд хандан шаардлагатай мэдээллээ авах боломжоор хангах явдал юм.
- Төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагууд шүүхийн системийн доголдлын талаар олон нийтэд мэдээлж байх, уг ажлыг эрчимжүүлэх үүднээс 1923 оны Мэдээллийн нууцлалын тухай хуулийг хүчингүй болгож мэдээлэл хүртэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

*С.И. Ласкар
(ТИ Бангладеш, Даха)*

14 Daily star (Bangladesh) 13 August 2005

Камбож улсын шүүх засаглал дахь авлига

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мөрдөн шалгах зарчимд тулгуурладаг, прокурор нь шүүх эрх мэдэлдээ хамаардаг

100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 1.0¹

Шүүгчийн цалин эхлэх хэмжээ: 3,804² ам.доллар

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 5,268³ ам.доллар

Нэг хүнд ногдох ҮНБ: 380⁴ ам.доллар

Шүүхийн жилийн нийт төсөв: 13.1 сая⁵ ам.доллар

Улсын жилийн нийт төсөв: 599.4 сая⁶ ам.доллар

Улсын жилийн нийт төсөвт эзлэх хувь: 2.3

Шүүхийн бүх шийдвэрийг хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага:

Харьцангуй сайн хэмжээнд хараат бус

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Үгүй

Шүүгчийн ёс зүйн дүрэм: Боловсруулж байгаа

1. Дэлхийн банк (2000)

2. Хууль зүйн яам

3. Өмнөх ишлэл

4. World Bank Indicators (2005)

5. Камбожийн Үндэсний Сэтгүүл (2006)

6. Си-Ай-Эй (CIA) Дэлхийн Баримт ном

Камбож дахь тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд дарангуйлагч Кхмер дэглэмийн үед олон хүнийг залхаан цээрлүүлж байсан этгээдүүдэд холбогдох хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаа явагдаж байгаа энэ цаг мөчид нийгэмд гол анхаарал татсан асуудал бол шүүхэд гарч буй авлига болон гүйцэтгэх засаглалаас шүүхэд үзүүлэх дарамт, шахалтын асуудал болоод байна. Хамгийн хариуцлагагүй, итгэл үл даах төрийн албан хаагчаар шүүгч, шүүхийн албан хаагчид, хамгийн хариуцлагагүй байгууллагаар анхан, доод шатны шүүхүүд тодроод байна.¹ Бизнесийн үзэж байгаагаар, шүүх нь хэрэг маргааныг үнэн зөв шийдвэрлэж шударга ёсыг тогтоох чадваргүй, хээл хахууль, авлигад хамгийн их идэгдсэн төрийн байгууллага (иргэдийн эсрэг зэвсэг) болчихоод байна.² Шүүхийн санхүүжилт бага байх, өндөр албан тушаал хашиж буй этгээдэд бэлэг өгөх заншил үйлчилсээр байгаа нь шүүх тогтолцоонд жижиг авлига цэцэглэхэд нэмэр болж байна.

Жирийн иргэдэд үзүүлж буй дарамт

Шүүхээр хэргээ шийдвэрлүүлж буй хэн боловч юун түрүүнд хувийн ашиг хонжоо хайсан албан тушаалтантай тулгардаг. Нийгмийн Хөгжлийн Төв (НХТ)-ийн

- 1 Asia Foundation, 'Public Opinion Surveys on Judicial Independence and Accountability. Country Report: Cambodia' (Asian Development Bank, September 2004).
- 2 Cambodia Daily (Cambodia), 13 July 2006.

судалгаанаас харахад иргэд ёс суртахууны хувьд шүүхийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг “буруу” гэж үздэг ч уг зөрчилтэй тэмцэхийг хүсдэггүйгээр үл барам хүлээн зөвшөөрч иржээ.³ Иргэдийн хувьд хоёр ялгамжтай хээл хахуулийн төрөл оршиж байгааг тодорхойлж байна. Үүнд: нэгд, шүүхийн шийдвэрт нөлөөлөх зорилго бүхий хээл хахууль, нөгөө нь, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдасгах, хялбарчлах зорилготой өгөх хээл хахууль юм.

Анхан шатны шүүхийн хуралдаан нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу явагддаггүй, ил тод бус, хуулийг үл баримтлах, процессийн алдаа завхрал их гардаг. НХТ-ийн судалгаанаас харахад дунджаар хэргийн нийт шүүгчдэгчдийн 10 хүрэхгүй хувь нь цагаатгагдсан бөгөөд шүүх хүнд ноцтой, ээдрээтэй хэргийг ч ердөө 10 хүрэхгүй минутын дотор шийдвэрлэж, маш хатуу ял шийтгэл ногдуулдаг байна.⁴ Саяхан Пном Пэнын орон нутгийн шүүхэд болсон нэгэн шүүх хуралдаанд мотоцикл дээрэмдэхээр завдсан шүүгчдэгчид 5 жилийн хорих ял ногдуулсан бөгөөд шүүх шийдвэрээ гагцхүү сэжигтний гэм буруугаа хүлээсэн мэдэгдэл дээр үндэслэжээ.⁵ Ихэнх тохиолдолд гэрчийн мэдүүлгийг цагдаагийн албан хаагчийн бүрдүүлсэн материалаас уншиж сонсгосноор мэдүүлэг өгсөнд тооцдог. Өмгөөлөгчид тэдгээр мэдүүлгийг шалгах, тайлбар гаргах, няцаах, шүүх хуралдаанд мэтгэлцэх боломжийг өгдөггүй. Мөн Үндсэн хуульд зааснаар эрүүгийн хэрэгт яллагдаж буй этгээдийг өмгөөлөгчөөр хангах ёстой ч Хууль зүйн яамнаас гаргасан эрх зүйн актын дагуу яллагдагчийг өмгөөлөгчгүйгээр шүүх хуралдаанд оролцуулах боломжтой юм. Ойролцоогоор яллагдагчийн 50 орчим хувь нь өмгөөлөгчгүйгээр шүүх хуралдаанд оролцдог.⁶

Шүүхэд гарч буй авлигын үр дагавар

Шүүхийн материаллаг хангамж муу, шүүгчийн цалин хөлс бага, шүүхийн санхүүгийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт нь Камбожийн шүүхийн авлигын нэг гол шалтгаан болж байна. 2006 онд засгийн газраас нийт 55.2 тэрбум риэл буюу 13.1 сая ам.долларыг шүүхийн санхүүжилтэд зарцуулсан ба өөрөөр хэлбэл анхан шатны шүүх тус бүрт жилд 23,100 ам.долларыг хуваарилсан.⁷ Камбож нь ойролцоогоор нийт 225 шүүгч ажилладаг буюу нэг сая хүнд 17 шүүгч, 300 хүрэхгүй өмгөөлөгч ногдож байна.⁸ Шүүхийн төсөв, санхүүгийн хүрэлцээгүй байдлын наад захын жишээг Камбожийн шүүхийн барилгаас харж болно. Кандал

3 Christine J. Nissen, *Living Under the Rule of Corruption: An Analysis of Everyday Forms of Corrupt Practices in Cambodia* (Phnom Penh: Center for Social Development, 2006).

4 Court Watch Bulletin (Phnom Penh: Center for Social Development, September 2005).

5 Observation in Phnom Penh Municipal Court, 13 June 2006.

6 Phnom Penh Post (Cambodia), 10–23 March 2006.

7 Cambodian National Gazette, January 2006.

8 Bar Association of the Kingdom of Cambodia, *Directory of Lawyers 2005–06* (Phnom Penh: Bar Association of the Kingdom of Cambodia, 2006).

дүүргийн шүүхийн шүүх хуралдааны танхимын хана нь цуурч, хөгцөрч муудсан, өрөөнүүд хуучин бичиг баримтаар дүүрсэн бөгөөд тус шүүх нь хэдхэн бичгийн машинтай.⁹

Шүүхийн авлигыг бууруулах, шүүгч болон шүүхийн ажилтнаас хээл хахуул авах явдлыг хязгаарлах зорилгоор 2002 онд шүүгчийн цалинг 10 дахин нэмэгдүүлсэн. Энэ нь сарын 1.4 сая риэл буюу 360 ам.доллар болох ба авлигын бууралтад дорвитой нөлөө үзүүлж чадаагүй. Учир нь шүүгчийн ажлын ачаалал, онцлог зэргийг үл харгалзан цалинг тэгшитгэн нэмсэн юм.¹⁰ Ажиглагчдын үзэж байгаагаар цалингийн энэ хэмжээ нь шүүгчийн буюу хариуцлагатай ажил эрхэлдэг хүний амьдралын наад захын стандарт шаардлагыг хангахад хүрэлцэхээргүй бага юм. Шүүгч болон прокурорыг бэлтгэдэг сургуульд орох албан ёсны шалгуур нь ердийн л нэг стандарт тестын шалгалт өгөх явдал байдаг.

Камбожид шүүхийн нарийн бичгийн дарга, туслахууд багагүй эрх мэдэлтэй байдаг, учир нь тэд шүүгчид нэвтрэх, тэдэнтэй харилцах гол суваг байдаг бөгөөд шүүн таслах ажиллагааны бүхий л баримт, тэмдэглэлийг хөтөлдөг. Тэдний үйлдсэн авлигын хэргийг илрүүлсэн тохиолдол байхгүй ч албан бус баримтаас харахад энэ төвшинд жижиг авлига маш их гардаг. Шүүхийн нарийн бичгүүд хэрэг, маргааны хүнд хөнгөн эсэхээс хамаарч хэргийн оролцогчдоос их бага хэмжээний төлбөр авдаг. Эдгээр туслах ажилтнууд хэргийг хэрхэн шүүгчид хуваарилах ёстой талаар зохицуулсан ил тод журам байдаггүй.¹¹ Шүүгчийн туслахууд авсан хээл хахуулийн хэсгийг дараа дараагийн хэрэг шийдвэрлэх явцад нөлөөлөх боломж олж авах үүднээс шүүгч нарт өгдөг гэсэн мэдээлэл байдаг. Өмгөөлөгчид тэдний үйлчлүүлэгчдийн хэрэг маргаантай, хүнд хэрэг бол илүү их хээл хахуул өгөх ёстой гэдгийг ч бүр мэдэж байдаг. Шүүхийн нарийн бичгийн дарга нар сард төрийн албан хаагчийн дундаж цалин болох 130,000 риэл буюу 33.35 ам.долларын цалин авдаг¹² бөгөөд энэ нь өртөг өндөртэй Камбожийн хотод амьдрахад хүрэлцдэггүй. 2005 онд шүүхийн нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалтын програм шинээр бий болж, түүнд нийт 800 хүн хамрагдсан ажээ. Цаашид шүүхийн нарийн бичгийн дарга нарыг мэргэжлийн аттестатчлалд хамруулах, ажлын үр дүнг харгалзан цалинжуулах бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эрх мэдлийн зохисгүй хуваарилалт

1993 онд олон улсын мэргэжилтнүүд либерал ардчилсан загварыг сонгож Камбожийн Үндсэн хуулийг боловсруулжээ. Энэ загварын дагуу шүүх эрх мэдэл

9 Interview with Khieu Samet, President of Kandal provincial court, 8 June 2006.

10 Raquel Z Yrigoyen Fajardo, Kong Rady and Phan Sin, Pathways to Justice: Access to Justice with a Focus on Poor, Women and Indigenous Peoples (Phnom Penh: Ministry of Justice and UNDP, 2005).

11 Interview with Ry Ouk, partner in Bou, Nou and Ouk law firm, 15 July 2006.

12 Pathways to Justice (2005), op. cit.

нь бусад хоёроосоо хараат бус, бие даасан байх учиртай. Гэвч Үндсэн хуулийн энэ зарчим нь бодит практикт биелэлээ олоогүй юм. Олон шүүгч ямар нэг хэмжээгээр эрх баригч Камбожийн Ардын Намтай холбоотой байдаг учир шүүгч нь төр болон намын гишүүдтэй холбоотой хэрэг маргаанд нэг талыг баримталсан, нөлөөнд автсан шийдвэр гаргадаг.¹³

Одоогоор Камбожид шүүгчийг өөр шүүхэд шилжүүлэх, албан тушаал дэвшүүлэх, огцруулах талаар албан ёсны нийтлэг, тогтсон стандарт байхгүй байна. 2005 оны 3 дугаар сард Ерөнхий сайд Хун Сэн улс орны хэмжээнд хэрэгжүүлэх авлигад автагдсан төрийн албан хаагчдийн эсрэг “Төмөр нударга”-ны бодлогоо эхлүүлсэн байна. Тэрээр 2005 оны 5 дугаар сард Шүүхийн дээд зөвлөлийг Үндсэн хуулийн бие даасан шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага байх ёстой гэсэн зохицуулалтыг эсрэгээр Хууль зүйн яам руу шилжүүлсэн. Энэ бодлогын хүрээнд, 2006 оны дунд үе гэхэд Пном Пен болон Баттамбанга хотод хоёр шүүгчийг шүүхийн сахилгын хурлаар оруулсан. Гэвч ажиглагчдын үзэж буйгаар уг хоёр шүүх ажиллагаа нь авлигын хэргийг илрүүлэх гэхээсээ илүү улс төрийн тооцоо сэдэлттэй үйл ажиллагаа болж өнгөрчээ. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Камбож дахь Тусгай төлөөлөгч Яаш Гаин хэлснээр Ерөнхий сайд Хун Сэнгийн уг үйлдэл нь Үндсэн хуульд нийцсэн гэж хүлээн зөвшөөрөхөд эргэлзээтэй юм.¹⁴

Камбожийн хуульчдын холбооны тэргүүнд өөрийн хүнийг томилсон нь засгийн газрын хяналтыг улам бүр баталгаажуулсан алхам болжээ. 2004 онд хуульчдын холбооны тэргүүн солигдсон ба шинэ тэргүүн нь Хун Сэн болон бусад хэд хэдэн өндөр албан тушаалтнуудад өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон ба тэдний мэргэжлийн ур чадвар болон бусад шалгуурыг харгалзан үзээгүй юм.¹⁵ Хуульчдын холбооны хуучин ерөнхийлөгч албан тушаалаасаа огцрохоос эрс татгалзсан тул шинэ ерөнхийлөгч сонгогдсон боловч бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. Үүний уршгаар хуульчдын холбоон дээр хэдэн зуун өргөдөл улс төрийн шалтгаанаар шийдвэрлэгдэлгүй хуримтлагдаж, гацаанд орсон ба шүүхийн системд шүүгч өмгөөлөгчдийн эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдсэн. Эдгээр асуудлуудаас шалтгаалж, Камбожийн шүүхийн нэр хүнд унаж, шүүхийг үл хүндэтгэх, шүүхэд үл итгэх байдал газар авсаар байна.

Хууль болон шүүхийн шийдвэрийн олон нийтэд хүртээмжтэй байдал

Парламентаас батлан гаргасан шинэ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан яам, агентлагийн эрх зүйн актууд олон нийтэд тэр бүр нээлттэй байдаггүй. 2005 оны 8 дугаар сард Архивын тухай хуулийг батлан гаргаж, үндэсний аюулгүй

13 Commission on Human Rights, ‘Report of the Special Representative of the Secretary-General for Human Rights Yash Ghai’, 8 February 2006.

14 Өмнөх ишлэл

15 Өмнөх ишлэл

байдлаас бусад асуудлаарх бүх хууль эрх зүйн актыг нийтэд мэдээлэх, нээлттэй байлгах талаар шийдвэр гарсан боловч энэ байдал амьдрал дээр хэрэгжихгүй байна. Түүнчлэн засгийн газраас мэдээлэл авах энэхүү эрхэд нарийн хяналт тавьдаг.¹⁶

Шүүхийн шийдвэр бүр ил тод, нээлттэй байж чаддаггүй.¹⁷ Дээд шүүхээс гаргасан шийдвэрүүдийг хуулийн сургуулийн хэрэгцээнд зориулан хэвлэдэг бөгөөд доод шатны шүүхүүдэд ховорхон хүргүүлдэг. Өмгөөлөгчид болон бусад эрх бүхий этгээдүүдэд зориулсан эрх зүйн нэгдсэн эх сурвалж байхгүй. Анхан шатны шүүх хуралдаан дээр шүүгчийн аливаа захирамж болон бусад шийдвэрийг шүүгч уншиж сонсон, шүүхийн нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлнө.¹⁸ Хуульд зааснаар шүүгч шүүх хуралдаан дээр өөрийн гаргасан шийдвэрийн үндэслэл, тайлбарыг хэлэх ёстой бөгөөд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэлд тусгах ёстой ч энэ нь практикт бараг хэрэгждэггүй.¹⁹

Эрх зүй-шүүхийн шинэтгэлийн арга хэмжээ

2004 оны 12 дугаар сард засгийн газраас шүүхийн үйл ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох зорилгоор багц 8 хуулийн төслийг 2005 оны эцэс гэхэд боловсруулахаар шийдвэрлэсэн боловч 2006 оны 8 дугаар сарын байдлаар эдгээрийн нэг нь ч хууль болж батлагдаагүй байна. Хуулийн төсөл ч олон нийтийн анхаарлыг төдийлөн татаагүй юм. Үүний нэг нь Авлигын эсрэг хуулийн төсөл байсан байна. Хуулийн төсөлд зааснаар хээл хахууль авсан, хээл хахуулийг дэмжсэн төрийн бүх шатны ажилтан, албан хаагч, шүүгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ. Авлигын эсрэг хуулийн төслийг анх 1994 онд боловсруулж, 2006 оны 3 дугаар сард шинэчлэн найруулсан боловч 2006 оны 6 дугаар сарын байдлаар Үндэсний ассемблейгаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулаагүй байна.

Түүнчлэн, төрөөс иргэний болон эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгохоор шийдвэрлэсэн. Шинээр боловсруулсан Иргэний процессийн хуулийг ч өдий хүртэл хэлэлцээгүй байна. Ил тод байдлыг сайжруулахад энэ хууль чухал үүрэг гүйцэтгэх юм.

Албан бус буюу шүүхээс гадуур хэрэг, маргааныг шийдвэрлэх (ШГХМШ) механизмыг орон нутаг, тосгоны төвшинд нилээд өргөн нэвтрүүлсэн. Тус

16 US Department of State, Country Report on Human Rights Practices 2005 – Cambodia (Washington D.C.: US Department of State, 2006). Available at www.state.gov/g/drl/rls/hrrpt/2005/61604.htm

17 Interview with Nou Teperith, partner in Bou, Nou and Ouk, 15 July 2006.

18 Interview with Kim Sathavy, Supreme Court judge and former dean of the Royal School of Judges and Prosecutors, 30 May 2006.

19 Interview with So Mosseny, Center for Social Development, 13 June 2006.

механизмыг боловсронгуй болгох зорилгоор “Зуучлагч”-ийн үүрэг гүйцэтгэж буй тосгоны ахлагч нарт хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж эхлээд байна.²⁰ ШГХМШ механизм нь авлига, хээл хахуульд харьцангуй бага өртөх, төрийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдээс илүү уламжлалт аргыг мэддэг, хямд өртөгтэй, туршлагатай хүмүүсийн хүчинд тулгуурлах юм.

Тус оронд хэрэгжиж буй бас нэг төсөл бол Австралийн засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж буй Кандалийн загвар шүүх (Kandal Model Court) юм. Энэхүү загвар шүүхэд гэрчийн өрөө бий болгож, камер суурилуулсан байна. Шүүгчдээс шаардах нэг зүйл бол өөрсдийн гаргасан шийдвэрийн үндэслэл, шалтгааныг маш сайн баримтжуулан тэмдэглэн үлдээх, ялангуяа дээрх төслийн хүрээнд шүүхийн баримт бичгүүдийг компьютерийн тусламжтайгаар үйлдэх, хадгалах тоног төхөөрөмжөөр хангаж байгаа тохиолдолд энэ зайлшгүй хийгдэх зүйл юм.

Камбожийн хүний эрхийг хамгаалах лиг, Камбожийн хүний эрх, хөгжлийн нийгэмлэг, Камбожийн эрх зүйн туслалцааны нийгэмлэг, Камбожийн өмгөөлөгчдийн төсөл гэх мэт төрийн бус байгууллагууд хэдийгээр хүн хүч, хөрөнгө мөнгөний дутагдалтай ч сайн дурын эрх зүйн төлбөргүй туслалцаа үзүүлж, шүүгчдэгчийг өмгөөлөх үйл ажиллагааг явуулж байна. Нийгмийн хөгжлийн төвөөс зарим шүүхийн үйл ажиллагаанд мониторинг хийж, тэдгээрийн шийдвэрлэсэн хэрэг, маргааны талаарх мэдээллийг улирал тутам хэвлэн нийтэлдэг болжээ. Мөн Паннасастра их сургуулиас ядуу болон хөдөөгийн иргэдэд эрх зүйн боловсрол олгох чиг үүрэг бүхий оюутны хууль зүйн клиник төвийг ажиллуулж байна. Төрийн бус байгууллагууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан засгийн газарт нөлөөлөхийг хичээж байгаа бөгөөд уг ажлын үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд ТББ-ын ажлыг уялдуулах, зохицуулах арга хэмжээ авах шаардлагатай юм.

Шүүхийн санхүүжилт болон шүүгчийн цалин хангамжийг нэмэгдүүлэх нь шүүхийн шинэтгэлийн анхаарал хандуулах ёстой нэг гол асуудал юм. Шүүгч болон шүүхийн ажилтны мэргэжлийн ур чадвар, ухамсрыг дээшлүүлэх гол механизм нь хэрэгжүүлж болохуйц ёс зүйн дүрэм бөгөөд шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлын механизмыг сайжруулахын тулд шүүхийн тайлан мэдээг электронжуулан компьютерт хадгалах явдал юм. 2006 оны дунд үед Хууль-шүүхийн шинэтгэлийн хороо нь ёс зүйн дүрмийг боловсруулах ажлыг хийж байна. Өндөр боловсролтой, шинэ залуу үе гарч ирж, албан тушаалын хувьд ч ахиж байгаа учраас цаашид шүүхийн үйл ажиллагаа болон нөхцөл байдлыг сайжруулах бодит боломж байгаа юм. Гэвч санхүүгийн хувьд бие даасан бус, бүх шатандаа авлигад гүн идэгдсэн шүүх байгаа цагт тухайн улс оронд авлигатай үр дүнтэй тэмцэх нь амаргүй байх болно.

*Саманта Форд ба Теари С. Сенг (Нийгмийн хөгжлийн төв,
Пном Пен болон Мичиган хотын хууль зүйн сургууль)*

20 Pathways to Justice (2005), op. cit.

Чили улс зарим талаараа амжилттай

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мэтгэлцээний зарчимд тулгуурладаг

100,000 хүн амд ногдох шүүгчийн тоо: 5¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 52,260 ам доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 98,616³

Нэг хүнд ногдох УНБ: 5,870⁴ ам доллар

Шүүхийн жилийн төсөв: 240.5 сая⁵ ам доллар

Жилийн нийт төсөв: 24.8 тэрбум⁶ ам доллар

Жилийн төсөвт эзлэх хувь: 1.0

Шүүхийн бүх шийдвэрийг хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Үгүй

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Үгүй

- | | |
|---|---|
| 1. Justice Studies Center of the Americas (2004-05) | 2. Direccion de Presupuestos www.dipres.cl |
| 3. Өмнөх ишлэл | 4. World Bank Development Indicators (2005) |
| 5. Direccion de Presupuestos www.dipres.cl | 6. Өмнөх ишлэл |

Чили улсын шүүхийн шинэтгэлийг тавин хувийн амжилттай байна хэмээн дүгнэдэг. Эрүүгийн болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид шийдвэрээ “худалддаг” явдал их байдаг ч үүнийг баримтаар нотолсон нь тэр бүр үгүй. Түүнчлэн одоогоор шүүхийн захиргааны үйл ажиллагаан дахь авлигын төвшин буурсан эсэхийг тогтоох боломжгүй байна. Гэхдээ Чилид эрүүгийн хэргийг шийдвэрлэх шүүхийн хаалттай үйл ажиллагааг тодорхой хувиар нээлттэй болгож чадсан нь авлигын гаралтыг бууруулахад зохих нөлөө үзүүлсэн гэж үзэх үндэслэлтэй.

Харамсалтай нь олон нийт энэ дүгнэлттэй санал нийлэхгүй байна. 2005 онд Centre Instituto Libertad y Desarrollo байгууллагаас явуулсан судалгаагаар авлигад хамгийн их идэгдсэн салбарыг шүүх тэргүүлж, мөн тэр жил ТИ-ийн байгууллагаас явуулсан Mori судалгаанд шүүх улс төрийн намын дараа хоёрт орсон юм. Бас Centro de Estudios de la Realidad Contemporanea байгууллагын судалгаагаар олон нийтийн шүүхэд итгэх итгэл 1990 оноос буюу шүүхийн шинэтгэл эхэлсэн үеэс буурч эхэлсэн байна.

Төрийн бусад байгууллагуудтай харьцуулахад шүүх нь ардчилсан өөрчлөлтийг нэвтрүүлэхэд хамгийн хойрго хандсан салбар юм. Үүнийг тайлбарлахын тулд 1990 оны шүүхийн шинэтгэл эхэлсэн цаг үеийг авч үзэх хэрэгтэй. Энэ үед эхэлсэн шүүхийн шинэтгэлийн гол зорилго нь тухайн үед Пиночетийн дэглэмд үйлчилж байсан Дээд шүүхийн нөлөөг бууруулахад байлаа. Дээд шүүх хараат бус бие

даасан байх гэдэг зарчмыг сөргүүлэн тавьж, ил тод, хариуцлагатай байх зарчмыг эсэргүүцэж, шинэтгэлийн гадна үлдэхийг чармайж байлаа.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд Дээд шүүхийн энэ байр суурийг өөрчлөхийг хичээхийн зэрэгцээ тухайн үед шүүхийн авлигын асуудлыг тусгайлан авч үзээгүй ч шинэ шүүгч томилон ажиллуулах болон шүүгчдийг давтан сургах үед үйлдэх авлигын өөгшүүлдэг хэлбэрийг багасгаж чадсан юм. 1990 онд шүүхийн шинэтгэлийн арга хэмжээний эхний шатанд Шүүхийн академийг байгуулсан ба шүүгчийг бэлтгэх, тэдний албан тушаал дэвших бодлогыг тодорхойлоход чиглэсэн байна. Үүний дараа 1995 онд дараагийн чухал өөрчлөлтийг эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагаанд хийсэн. Энэ нь мэтгэлцээний зарчимд шилжих явдал бөгөөд ингэснээр ял шийтгэл ногдуулах үйл ажиллагааг ил тод болгож, яллагдагчийн эрхийг хамгаалах бололцоог өргөжүүлж, шүүхээс өмнө цагдан хорих явдлыг хязгаарлаж, онц хүнд ноцтой хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх болж, шүүхийн захиргаа ба өмгөөллийн үйлчилгээг сайжруулахад анхаарсан байна. Шүүхүүдийг шинэ барилгад нүүлгэн оруулж, шүүгч болон шүүхийн ажилтнуудыг сургах ажлыг онцгой анхаарч үзжээ.

Гэвч шүүхэд шийдвэрлэх асуудал байсаар л байна. Тухайлбал, эрүүгийн шүүхийн тогтолцоо нь дээрээс доошоо чиглэсэн, шатлан захирагдах ёсны дагуу ажилладаг ба дээд шатны шүүх нь доод шатны шүүхийн шүүгчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэдэг ба тэдний цаашдын албан тушаалын дэвших төлөвийг тодорхойлдог. Энэ байдал нь анхан шатны шүүхийн шүүгчид давж заалдах шатны шүүгчдээс айх, эмээх байдлыг бий болгодог ба давж заалдах шатны шүүх үйл ажиллагаагаа гүйцэтгэх засаглалын байгууллагатай ойр дотно харилцаатай байх сонирхлыг төрүүлдэг. Учир нь тэд шүүгчдийг томилох үйл ажиллагаанд нилээдгүй оролцоо, нөлөөтэй байдаг.¹ Түүнчлэн энэ босоо тогтолцоо нь хариуцлагын асуудлыг улам бүрхэг болгодог. Харин иргэний шүүхийн хувьд шинэтгэлийн үйл ажиллагаа харьцангуй муу хийгдсэн ба хэргийг шийдвэрлэхгүй удааширч, үйл ажиллагаа олон нийтэд ил тод бус байдаг.

Хээл хахууль өгөх явдал багассан ч шүүхийн шинэтгэл бүрэн хэрэгжиж дуусаагүй байна

Чилийн шүүхийн авлигын асуудалд дүн шинжилгээ хийхийн тулд шүүхийн системийг задлан үзэх хэрэгтэй. Эрүүгийн шүүхийн хувьд шүүхийн шинэтгэлийг сүүлийн 5 жилд огцом жигд бус байдлаар хийсэн бөгөөд зарим шүүх шинэ арга барилаар ажиллаж байхад нөгөө хэсэг нь дөнгөж 2005 оноос эхлэн өөрчлөлтийг хэрэгжүүлж эхэлсэн байх жишээтэй. Энэ нь бодит буюу гарч болох авлигын нөхцөл байдал өөр өөр байх шалтгаан болдог.

1 Дээд шүүх нь Дээд шүүх болон давж заалдах шатны шүүхэд нэр дэвшсэн хүмүүсийн нэрсийг, харин давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн нэрийг Ерөнхийлөгчид оруулдаг ба энэ жагсаалтаас томилгоо хийдэг.

Шинэтгэлийн үйл хэрэг иргэний хэргийн шүүхэд маш бага хэрэгжсэн ба гэр бүл, хөдөлмөрийн харилцаатай холбоотой хэргийг шийдвэрлэхэд бага зэрэг ахиц гарсан ч хөрөнгө оруулалт болон зохион байгуулалтын хувьд хангалтгүй байв. Чили улсад иргэний хэргийн шийдвэрлэлт маш удаан бөгөөд дунджаар 6-8 жилийн дараа л шүүхийн шийдвэр гардаг. Засгийн газар ч энэ байдлыг өөрчлөх талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй төдийгүй цаашид ч тийм төлөв харагдахгүй байна. Шүүхээс шинжээч томилох процесс хаалттай, тэдгээрийн сонирхлын зөрчлийг хязгаарлах дүрэм журам хэрэгждэггүй.

Шинэтгэлийн арга хэмжээ авахын өмнө, хэргийг хуралдаанаар хэлэлцүүлэх жагсаалтад урагшлуулан бичих, хэргийн материалыг “алга болгох” зэрэг үйлдэл хийсний төлөө хэргийн оролцогчдоос хээл хахууль авах явдал шүүхэд гарч байсан. Мөн тодорхой өмгөөлөгчдөөс Дээд шүүх болон давж заалдах шатны шүүгчид хээл хахууль өгсөн хэрэг гарсан тухай мэдээлж байсан ч баримтаар нотлогдоогүй юм. Харин шүүхээс гарах шийдвэрт нөлөөлөхийн тулд хээл хахууль өгсөн тухай баримт одоогоор байхгүй байна.

Эрүүгийн хэрэг шүүн таслах ажиллагааны хувьд, шинэтгэлийн өмнөх хамгийн ноцтой авлигын хэргүүдэд шүүгч гэхээсээ илүүтэйгээр шүүхийн нарийн бичгийн дарга, шүүн таслах үйл ажиллагаанд туслах чиг үүрэгтэй ажилтнууд, шинжээч нар илүү ихээр өртөж, холбогддог байсан. Хамгийн тод жишээ бол, шүүх хуралдаанаас өмнө урьдчилан хоригдож буй этгээдийн хэргийг хурдан шийдвэрлэх үүднээс шүүгдэгчийн гэр бүлээс мөнгө нэхэх явдал юм. Шүүгдэгчийн процессийн эрхийг үл хангах болон гагцхүү шүүгчийн хэрэгжүүлэх ёстой шүүн таслах эрх мэдлийг шүүхийн болон захиргааны ажилтнуудад хэтрүүлэн шилжүүлсэн нь энэ хэрэг гарах хоёр гол шалтгаан болдог байна.

Шинэтгэлийн үр дүнд эрүүгийн хэргийн шүүхэд ихээхэн ахиц гарсан ба хуучныг бодвол авлигын хэргийн гаралт эрс буурч, нэг талаас хэргийг мөрдөн шалгах, яллах, нөгөөтэйгүүр шүүн таслах үйл ажиллагаануудын зааг ялгаа тодорхой болжээ. Шүүхийн үйл ажиллагаа улам бүр ил тод болж, зарим шүүхийн авлигыг “гааруулах”, “даамжруулах” нөхцөлийг бүрдүүлж байсан чиг үүргийг устгаж, үгүй хийсэн байна. Хуучин тогтолцооны үед улс орны хэмжээнд эрүүгийн хэргийг шийдвэрлэх (хэргийг мөрдөн шалгах, ял ногдуулах, шүүн таслах чиг үүргийг бүгдийг хэрэгжүүлэх) үүрэгтэй 79 шүүгч байсан. Тэр үед шүүгчид ажлын ачааллаас болж хэргийг мөрдөн шалгах, ял ногдуулах үүргээ шүүхийн бусад ажилтнуудад шилжүүлэн өгдөг байсан ба тэдгээр “үүрэг гүйцэтгэгч” нь мэргэжил ур чадварын хувьд тэр бүр шаардлага хангасан байж чаддаггүй байв. Шинэтгэлийн хүрээнд эдгээр “үүрэг гүйцэтгэгч”-ыг халж, эрүүгийн хэргийн улсын өмгөөлөгчдийн байгууллагыг байгуулсанаар хувиараа өмгөөлөл эрхлэгч нарын хэрэгцээ буурсан байна.

Авлигын төлөөс

Чилид шүүхээр эрхээ хамгаалуулах эрхийг хүн бүр адил тэгш эдэлж чадахгүй байна. Өндөр төлбөртэй сайн өмгөөлөгчдийг хөлслөн авах, шинжээчийн зардал төлөх мөнгөтэй хүн л эрхээ сайн хамгаалуулж чаддаг. Шүүхээр адил тэгш байдлаар үйлчлүүлэх эрхийг хангах үүрэгтэй этгээдүүд бол гадны нөлөөнд автагдахаас зайлсхийх ёстой шүүгч, шүүхийн ажилтнууд юм. Эрүүгийн хэргийн хувьд шүүгдэгчийг батлан даалтад гаргахын тулд мөнгө төлөхийн зэрэгцээ хээл хахууль өгөх, авах явдал их гардаг. Харин одоогоор Чили улсад шүүхэд хандах хүний эрхийг хясан боогдуулсан буюу шүүхийн авлигаас болж хүний эрхийг зөрчсөн асуудал гараагүй байна.

Хийвэл зохих ажлууд

Шүүхийн шинэтгэлийн үр дүнд эрүүгийн хэргийн хувьд шүүхийн үйл ажиллагаа ил тод болж, шүүх хуралдаан мэтгэлцээний аргаар, нээлттэй явагддаг болжээ. Гэсэн хэдий ч өөрчлөх шаардлагатай олон зүйл бусад хэргийн тухайд байна. Тухайлбал, гэр бүлийн шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгохын тулд хуульд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулах шаардлагатай байгаа ч улс төр, санхүүгийн дэмжлэг хүлээгээгүй, сайтар төлөвлөж, зохион байгуулаагүй зэргээс хэрэгжээгүй байна. Үүний үр дүнд, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн хэргийг шийдвэрлэх болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааныг шийдвэрлэх үүрэгтэй шүүхийн үйл ажиллагаа доголдож, шинэтгэлийн үр дүнг хүлээж байсан хумүүсийн хувьд итгэлгүй болж, иргэний хэргийн шүүхийн тогтолцоо гажигтай болж байна. Мөн хуульчид, өмгөөлөгчдийн хамтын ажиллагааг сайжруулсанаар шүүхийн авлигыг бууруулах боломжтой. Чили бол хуульчид нь сайн дураараа Хуульчдын холбоонд элсэх боломжтой Латин Америкийн цөөхөн орны нэг юм.² Хуульчдын холбоонд элсээгүй хуульчдад тус холбооноос гаргасан ёс зүйн дүрэм үйлчлэхгүй. 2003 онд бүх хуульчдад хамаарах ёс зүйн дүрмийг хэлэлцсэн боловч дэмжлэг авч батлагдаагүй. Хэрэв аль нэг хуульч, өмгөөлөгч хууль бус үйлдэл хийсэн нь тогтоогдвол нийт мэргэжил нэгтнүүд нь түүнээс сургамж авч авлигын асуудалд нэгдмэл байдлаар илүү хариуцлагатай хандах учиртай.

Харин прокурорын хувьд зөрчил гаргасан прокурорыг дотоод хяналтын газраас шалгах хэрэгтэй бөгөөд ингэснээр хэргийг аль нэг талын эрх ашгийг илүү үзэхгүйгээр шударга шийдвэрлэх боломжтой болно. Хэргийг хурдан, шуурхай шийдвэрлэх үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байх бололцоог эрх зүйн хүрээнд бүрдүүлэх шаардлагатай байна.

Чилийн шүүх тогтолцоог улам ил тод болгох, шүүхийн авлигатай хийх тэмцлийн хүрээнд дор дурдсан ерөнхий зөвлөмжийг өгч байна. Үүнд:

2 1981 онд Хуульчдын мэргэжлийн холбоог татан буулгаж, хувийн холбоонуудыг байгуулсан

- Шүүгч, хуульч нарт сургалт явуулахдаа төрийн албаны үйл ажиллагааны онцлог болон ёс зүйн асуудлыг сургалтын хөтөлбөрт оруулж өгөх;
- Шүүхийн гаргасан шийдвэр, шүүхээс ногдуулсан шийтгэлийг нийтэд мэдээлэх төдийгүй үндэслэл, учир холбогдлыг ойлгомжтой болгох, тайлбарлах;
- Анхан шатны шүүхийн шүүгчийг томилох, дэвшүүлэх болон ажлыг үнэлэх процедурыг өөрчлөх, өөрөөр хэлбэл “дээд шатны шүүх болон гүйцэтгэх засаглалд үнэнч байх” шинжээр бус мэргэжил, ур чадварын хувьд шаардлага хангасан байхыг гол үндэслэл болгох;
- Шүүхийн төсвийн удирдлага, санхүүжилтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;
- Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах.

*Давор Харасик,
(Чилийн Транспэрэнси Интернэшнлийн салбар, Сантьяго)*

Коста Рик улсад ил тод байдлыг дэмжсэн нь авлигатай тэмцэхэд тус болж байна

Эрх зүйн тогтолцоо: Эрх газрын эрх зүй, шүүн таслах үйл ажиллагаа нь мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явагдаг

100,000 хүн амд ногдох шүүгчийн тоо: 16.0¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 12,139 ам доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 22,725³ ам доллар

Нэг хүнд ногдох ҮНБ: 4,590⁴ ам доллар

Шүүхийн жилийн төсөв: 208.4 сая⁵ ам доллар

Жилийн нийт төсөв: 5.5 тэрбум⁶ ам доллар

Жилийн төсөвт эзлэх хувь: 3.8

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат бус

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Poder Judicial, Compendio de indicadores (2004)
2. Poder Judicial indice salarial (2006)
3. Өмнөх ишлэл
4. World Bank Development Indicators (2005)
5. Poder Judicial, Presupuesto (2006)
6. Asamblea Legislativa: Resumen Global Presupuesto (2006)

Коста Рик улсад 1990 оноос хойш шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хүний эрхийг хамгаалсан ардчилсан төрийг байгуулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох тал дээр багагүй амжилт олсон байна. Эрх зүйт төрийг дээдэлсэн, өмчийн олон хэлбэр бүхий эдийн засгийг бий болгох шинэтгэлийн хүрээнд Коста Рик улсын засгийн газраас олон улсын хандивлагч байгууллагуудтай нягт хамтран ажилласны үр дүнд тодорхой амжилтанд хүрчээ. Сүүлийн арван жилийн хугацаанд Коста Рик улсын шүүхийн системд олон дэвшил гарсан ба тус улс Төв болон Латин Америкийн улсуудын дотор хамгийн бага авлигатай орон гэгддэг болжээ. Гэхдээ шүүхийн үйл ажиллагаанд одоо ч зарим нэг дутагдал гарсаар байгааг үгүйсгэх аргагүй юм.

Шүүхийг чадавхижуулах талаар авсан арга хэмжээ үр дүнгээ өгч байна

Тус бүс нутагт орших бусад оронтой харьцуулахад Коста Рик улсын шүүх засаглалын бие даасан байдал харьцангуй өндөр юм. Нэг шүүгчид ногдох хэргийн тоо буюу ажлын ачаалал бага, шүүхэд итгэх олон нийтийн итгэл сайн, шүүхийн үйл ажиллагаа ил тод байдаг.¹ 1949 оны Үндсэн хууль шүүхийн хараат бус байдлыг баталгаажуулж, шүүх гагцхүү хуульд захирагдах тухай зааж өгсөн байдаг. Хэрэв шүүхийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бол энэ тухай Дээд шүүхтэй зөвшилцөх ба конгрессийн 57 гишүүний 2/3-ын саналыг авах ёстой. Мөн Үндсэн хуульд заасны дагуу

1 www.cejamerica.org

улсын жилийн төсвийн 6-гаас доошгүй хувийг шүүхийн системд хуваарилах ба энэ нь шүүхэд санхүүгийн хувьд хараат бус байх боломжийг олгодог. Шүүхийн бүх хэрэгцээг хангахад энэ төсөв хүрэлцэхгүй байна хэмээн зарим хүмүүс шүүмжилдэг бөгөөд учир нь энэ төсвийн 1/3 орчим хувь нь шүүхээс хэргийг шалгах ажиллагаа болон прокурорын үйл ажиллагааны зардал, өмгөөлөгчийн хөлсөнд зарцуулагддаг.² Цаашид энэхүү 6 хувийг гагцхүү шүүх болон шүүгчийн хэрэгцээнд зарцуулах тухай санал боловсруулж байгаа болно.

Байгууллагын бие даасан байдлын хувьд шүүхэд хязгаарлалт бий. Тухайлбал, хууль тогтоох байгууллагаас магистратуудыг сонгодог ба зарим томилгоонд улс төрийн нөлөө орсон гэж үзэж болохоор байдаг ч энэ нь баримтаар нотлогддоггүй. 2001 онд конгресс дотор Томилгооны комиссыг байгуулсан ба гол зорилго нь шүүгч болон магистратуудыг шударга шалгуураар томилох техник процедурыг тогтоох явдал байв. Үндсэн хуульд зааснаар магистратуудын бүрэн эрхийг гагцхүү Дээд шүүхийн шүүгчдийн 2/3-оос дээшгүй хувийн нууц саналаар түдгэлзүүлж болдог. Харин хууль тогтоох засаглалд ийм эрх олгоогүй.

1993 онд Шүүхийн дээд зөвлөл (Supreme Judicial Council)-ийг байгуулсан ба тус зөвлөл нь шүүхийн захиргааны үйл ажиллагаа, шүүгчийн сахилгын асуудлыг шийдвэрлэх эрхтэй ба Дээд шүүхийн удирдлага дор ажилладаг. Мөн энэ онд Шүүхийн албан тушаалтны тухай хууль (Judicial career law) батлагдан гарсан ба бүх насаараа томилогддог шүүгчид гомдол гаргасны дагуу “туршилтын шүүгч” нэртэй боловч тодорхойгүй хэдэн жил шүүн таслах ажиллагаа эрхэлсээр байгаа практикыг халсан. 2000 онд дотооддоо зохион байгуулсан төвшин тогтоох өрсөлдөөнт шалгаруулалтаар шүүгчдийг өөрийнхөө албан тушаалд тэнцэх эсэхийг тогтоож, олон жил ажиллаж байсан туршилтын шүүгчдийн орон тоог бүх насаараа томилогдсон шүүгчид шилжүүлэн авчээ.

Шүүхийн мөрдөн шалгах газар (Tribunal of judicial inspection) нь бие даасан байгууллага бөгөөд магистрат, Ерөнхий прокурор болон түүний орлогч, шүүхийн мөрдөн шалгах байгууллагын дарга, дэд дарга нараас бусад шүүхийн ажилтнуудын эсрэг гаргасан гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэдэг.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүхийн үйл ажиллагааг ил тод болгох асуудалд гол анхаарлаа хандуулсан ба Америкийн орнуудын хөгжлийн банк (Inter American Development Bank)-аас шүүгч, прокурор, омбудсман нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, шүүхийн ил тод байдлыг хангах зорилгоор холбогдох хууль тогтоомж, төсөв, ажлын гүйцэтгэлийн тайлан, бараа үйлчилгээ худалдан авсан тайлан, аудит, үйл ажиллагааны жилийн тайлан болон бусад материалуудыг онлайн болгох зэрэг үйл ажиллагаанд зориулан тодорхой хэмжээний хөрөнгийг зарцуулжээ. Түүнчлэн, шүүхээс хэргийн электрон санг үүсгэж, олон нийтээс хяналт тавих бололцоог бүрдүүлэхээр шийдвэрлэсэн байна.³

2 2006 www.poder-judicial.go.cr/frames_transparencia.htm хаягаар орж 2006 оны жилийн төсвийн тухай баримтаас үзнэ үү.

3 Коста рик улсын шүүхийн мэдээллийн системд 1989 оноос хойш батлагдан гарсан хууль тогтоомж, Дээд шүүх, хяналтын шүүх, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүдийг нийтэлсэн байдаг.

Шүүхийн авлигын талаарх төсөөллийн төвшин буурах хандлагатай байна

1990 оны шинэтгэлийн арга хэмжээний дотор улам бүр өсч байгаа авлигын гэмт хэрэгтэй шүүхээс үр дүнтэй тэмцэхэд шүүхийн байгууллагын чадавхийг сайжруулах асуудал багтсан юм. Прокурорын байгууллагын дэргэд Эдийн засаг, татвар, авлигын хэргийг шийдвэрлэх туслах прокурорыг бий болгож, засгийн газрын эсрэг гэмт хэрэг болон татварын залилангийн зарим хэргийг дагнан шийдвэрлэх шүүхийг тусад нь байгуулж, хууль бусаар баяжсан төрийн албан хаагч болон төрийн албан хаагчид холбогдох бусад хэргийг мөрдөн шалгах үүргийг ногдуулжээ. Шүүхийн сургалтын байгууллагаас төрийн албан хаагч, татварын байцаагч, прокурорын байгууллагын ажилтан болон эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажилтнуудад давтан болон үргэлжилсэн сургалтыг тогтмол хугацаанд явуулдаг.

Шинээр эдгээр байгууллагуудыг байгуулсан хэдий ч авлигын зарим дуулиант хэргүүдийг, тухайлбал, Банко Англо Костарикенсийн хэргийг шүүх шийдвэрлэж чадахгүй арваад жил болжээ. 2004 онд Ерөнхийлөгч асан 3 хүнд холбогдох төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хувийн компанид давуу эрх олгон хээл хахууль авсан тухай хэрэг хэвлэл мэдээлийн хэрэгслээр цацагдсан ба (Дэлхий нийтийн авлигын тайлан 2005-аас үзнэ үү) одоо 2 Ерөнхийлөгчийг мөрдөн шалгаж байна.

Эдгээр олны анхаарлыг татсан хэргүүд нь нийгмийн сэтгэл зүйг 2 хуваасан ба нэг хэсэг хүмүүс эрх мэдэлтнүүдэд хууль үйлчлэхгүй байгаа бөгөөд үүнд хэргийг шүүхээр хурдан шийдвэрлэхгүй байгаа нь нөлөөлж байна гэх сөрөг үзэл, нөгөө нь шүүхийн бие даасан байдлын ачаар Ерөнхийлөгчийг хүртэл мөрдөн шалгаж байна хэмээх өөдрөг үзэл юм. Харин бүгд нэгэн адил авлигын талаарх мэдээллийг өгсөн эх сурвалжийг хамгаалах бодлого үгүйлэгдэж байгааг энд дурдсан байна.

1999 онд Дээд шүүхээс шүүхийн бүх ажилтны ёс зүйн дүрмийг боловсруулан баталжээ. Түүнчлэн шүүхийн ажилтнуудад хориглох зан үйлийг тодорхойлсон “хууль 7,333”-ыг батлан гаргасан байна. Тухайлбал, шүүхийн ажилтнуудад албан үүргээ гүйцэтгэсэнтэй холбогдуулан хэргийн оролцогчдоос ямар нэг шан харамж авахыг бүрэн хоригложээ. Мөн шүүхийн албанд ажиллаж байхдаа тусгайлан заасан хэдэн тохиолдлоос бусдад өөр байгууллагад албан тушаал хаших, давхар ажил эрхлэхийг хориглосон.

2004 онд батлагдан гарсан Хууль бусаар баяжихын эсрэг хуулинд зааснаар Дээд шүүхийн шүүгчид, тэдгээрийн орлогчид, Ерөнхий прокурор нарт хөрөнгө орлогоо жил бүр мэдүүлж байхыг үүрэг болгожээ. Тэдний гаргасан хөрөнгө орлогын мэдүүлгийг Хянан шалгагч нарын газар хүлээн авч, шалган баталгаажуулах үүрэгтэй. Мэдүүлгийн агуулга олон нийтэд нээлттэй биш боловч мэдүүлгээ гаргаж өгсөн эсэхийг хүссэн этгээд мэдэх эрхтэй.

Эдгээр өөрчлөлтүүд нь авлигын талаарх иргэдийн төсөөллийг бууруулж, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлсэн боловч, энэ нь олон нийтийн итгэлийг бүрэн олоход

хангалтгүй юм. 2006 онд Коста Рикийн Их сургуулиас явуулсан судалгаанд хамрагдагсдын 48 хувь нь шүүхэд итгэдэггүй, 23 хувь нь шүүхэд итгэдэг, 58 хувь нь Дээд шүүхийн шүүгчид авлигад автсан гэж хариулжээ.⁴ Үүнийг 73 хувь нь шүүхэд итгэхгүй, 71 хувь нь Дээд шүүх авлигад автагдсан гэж хариулсан 2000 оны судалгааны дүнтэй харьцуулж дүгнэх боломжтой.

Сул тал байсаар л байна

Хэдийгээр Коста Рик улсын шүүх нь авлигатай амжилттай тэмцэж буйн жишээ болж байгаа ч тус системд зарим нэг доголдол гарсаар байна. Жишээлбэл, шүүгчийн хариуцлагыг сахиулах албан ёсны механизм байхгүй. Дээд шүүхийн шүүгчдийг сайн дураараа үйл ажиллагаагаа тайлагнахыг санал болгодог ч одоогийн байдлаар 22 шүүгчээс зөвхөн 4 нь л сайн дураараа тайлангаа тавьсны нэг нь Дээд шүүхийн одоогийн тэргүүн бөгөөд хууль тогтоох хуралдаан болон олон нийтийн өмнө өөрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл хийсэн юм.⁵

Коста Рик улсын шүүхийн системд гарч буй авлигын багагүй хувийг банк болон бизнесийн томоохон байгууллагуудаас иргэний болон худалдааны хэргийн шүүхэд хэргийг хурдан шийдвэрлүүлэх зорилгоор нөлөөлж буй зохион байгуулалттай холбоотой авлига эзэлдэг. Иргэний болон захиргааны хэргийг шийдвэрлэхэд 10 гаруй жил зарцуулагдах магадлалтай. Хэргийн агуулгаас шалтгаалж хэргийг хянан шийдвэрлэх хугацаа сунжирдаг. Харин Үндсэн хуулийн шүүх жилд 20,000 орчим хэргийг хянан шийдвэрлэдэг нь харьцангуй хүрэлцэхүйц нөөц бололцоотой байгааг харуулна.

Эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд цаг хугацаа их ордог тул авлига гарах боломжийг нээж, эрсдэл өндөр болно. Нарийн төвөгтэй, эдрээтэй хэргийн хувьд шийдвэрлэлт улам илүү удааширдаг бөгөөд өмгөөлөгчид цаг хожих бүхий л аргыг хэрэглэж, хөөн хэлэлцэх хугацааг дуусгахыг хичээдэг. Дээр дурдсан Ерөнхийлөгчид холбогдох хэргийн тухайд л гэхэд тус хэргийг 18 сарын турш мөрдөн шалгасан байна.

Эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд гарч буй бас нэг хүндрэл нь авлига болон эдийн засгийн гэмт хэргүүдийг зөвхөн прокурорын газраас шалгахаар төвлөрүүлсэн явдал юм. Үүний улмаас жил бүр эрүү үүсгэсэн хэргийн тоо нэмэгдэж, харин шийдвэрлэсэн хэргийн тоо буурсаар байна. Хэргийн шийдвэрлэлт удаан байгаа нь зөвхөн хэргийн эдрээтэй, нарийн төвөгтэй байдалтай холбоотой байж болох хэдий ч шүүхийг авлигад хардах, авлигад автагдсанаар төсөөлөх байдлыг нэмэгдүүлдэг. Бас түүнчлэн, ял шийтгэлээс мултардаг, ял шийтгэлгүй үлддэг байдал нь авлига болон үр нөлөөгүй системийн үр дүн болж харагддаг талтай. 2001 онд Centro de Estudios Democraticos para America Latina байгууллагаас явуулсан

4 Коста рикийн улсын их сургууль www.ucr.ac.cr/documentos/Encuesta_opinion_2006.pdf

5 PNUD-FLACSO, Challenges of democracy: A proposal for Costa Rica San Jose 2006

судалгаагаар судалгаанд оролцогчдын 85 хувь нь “шүүгдэгчид ялгүй, шийтгэл хүлээдэггүй байдал нь Коста Рик улсын шүүхийн авлигыг харуулж буй гол хүчин зүйлсийн нэг мөн” гэжээ.⁶ 2003 онд шинээр томилогдсон Ерөнхий прокурор авлигын гэмт хэрэг үйлдсэн өндөр албан тушаалтнуудын эсрэг зоригтойгоор эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан, прокурорын байгууллагын төсөв, орон тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авсан зэрэг нь олон нийтийн зүгээс өндөр үнэлэлт авч, дээрх төсөөлөлд эерэг өөрчлөлт гарсан юм.

Зөвлөмж

- Шүүхийн байгууллагын тогтонги зан үйлийг өөрчлөх, удирдлагын хуучин арга барилыг халах талаар шүүхийн байгууллагаас олон чухал шинэтгэлийн арга хэмжээг авсан ч энэ нь авлигатай тэмцэхэд хангалтгүй юм. Анхан болон алслагдсан шүүхүүдэд, ялангуяа хар тамхи наймаалахтай холбоотой хэргийг шийдвэрлэдэг зарим алслагдсан нутгийн шүүхүүдийн үйл ажиллагаанд Дээд шүүхээс тэр бүр хяналт тавьж чадахгүй байна.
- Хээл хахууль өгдөг талуудыг хумих, үүнд хэргийн оролцогчид ялангуяа банк болон бизнесийн томоохон байгууллагуудаас шүүхэд хээл хахууль өгөхгүй байхыг сурталчлах, таниулах шаардлагатай байна.
- Шүүгчийн ямар үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох тухай дэлгэрэнгүй тайлбар гаргах, шүүхэд гарч буй зөрчил, дутагдлын талаар судалгаа мэдээллийг гаргаж нийтлэх, зарим нэг хэргүүд ижил хэргээс илүү богино хугацаанд шийдвэрлэсэн тохиолдолд шалтгааныг тогтоох, тэдгээрт ногдуулсан ялын хэмжээг харьцуулан судлах зэрэг арга хэмжээ авч болох юм.
- Ерөнхий прокурорын газарт ёс зүйн асуудал хариуцсан прокурорыг ажиллуулж, төрийн албан дахь соёлыг дээшлүүлэхэд анхаарч ажилласнаар шүүх эрх мэдлийн системийн байгууллагуудад цэвэрлэгээ хийх хэрэгтэй байна. Хэдийгээр Коста Рик улсын шүүх нь хараат бус, бие даасан, хүчтэй байгууллага мөн боловч авлигатай хийх тэмцлийг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхийн тулд иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийнхний оролцоог хангах шаардлагатай юм.

*Роксана Салазар ба
Хосе Пабло Рамос, Сан Хосе*

6 Josй Manuel Villasuso, Cristina Rojas and Marco Vinicio Arroyo, *Corrupciyn en Costa Rica (Corruption in Costa Rica)* (San Josй: CEDAL/Friedrich Ebert Stiftung, 2003)

Хорват: Шилжилтийн процесс үргэлжилсээр

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь дийлэнхдээ мөрдөн шалгах зарчимд тулгуурладаг, прокурор нь шүүх эрх мэдэлдээ хамаардаг

100,000 хүн амд ногдох шүүгчийн тоо: 43.7¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 29,651 ам доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 67,330³ ам доллар

Нэг хүнд ногдох ҮНБ: 8,060⁴ ам доллар

Шүүхийн жилийн төсөв: 345.1 сая⁵ ам доллар

Жилийн нийт төсөв: 16.4 тэрбум⁶ ам доллар

Жилийн төсөвт эзлэх хувь: 2.2

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Боловсруулж байгаа

1. Justice Ministry, 2006

2. Ишлэл 1

3. Ишлэл 1

4. World Bank Development Indicators 2005

5. Official Gazette no148, 2005

6. Ишлэл 5

Хуучин социалист нийгмийн ул мөр болон 1990-ээд онд хийгдсэн үр дүнгүй, хагас дутуу шинэтгэлийн бодлогын үр дагавар зэрэг нь Хорватын шүүх засаглалын үйл ажиллагаанд багагүй хэмжээгээр сөргөөр нөлөөлсөн. Хорват улс социалист Югославын бүрэлдэхүүнд байх үед шүүхийн үйл ажиллагаа бүхэлдээ улс төржсөн байлаа. Тухайн үеийн төрийн бодлогыг хурцаар шүүмжилсэн олон сэхээтнүүдийг улс төрийн захиалгаар шүүж, шийтгэж байсан.¹ Мөн энэ үед цагаан захтны буюу авлигын хэрэг маш их гарч байсан ч тэдгээр нь эрх баригч намын хамгаалалтад байсан тул буруутай этгээд шийтгэгдэх нь ховор байв. Хээл хахууль өгсөн этгээдүүд тухайлбал, компанийн захирал, удирдлагууд эрх баригч намын гишүүн тул нэг нэгнийгээ хуулийн хариуцлагаас хаацаалдаг сүлжээ үүссэн байна.

1990 оны эхээр Хорватын ардчилсан холбоо парламентын сонгуульд ялж, парламентад дийлэнх олонх болсон бөгөөд улс орны бүхий л салбарт түүний дотор шүүхэд шинэтгэл хийхээр шийдвэрлэсэн байна. Энэ үед шинэ дэглэмийг эсэргүүцсэн нэг хэсэг, өндөр цалин амалсан хувийн хэвшилд эсхүл өмгөөлөл хийхээр олон хүн шүүгчийн албан тушаалаа орхисон байна. 1991-1995 оны Иргэний дайн (Homeland War)-ийн үед Хорватын шүүх хэвийн ажиллахын тулд

1 Тэдний нэг нь тэмцэгч Владо Готовак байсан бөгөөд түүнийг 1981 онд хоёр жилийн хорих ялаар шийтгэсэн ба гол үндэслэл нь гадаадын сурвалжлагчид төрийн үйл ажиллагааг шүүмжилсэн ярилцлага өгсөн явдал юм. Дараа нь түүнийг гэрийн хорионд оруулжээ.

багагүй чармайлт гаргаж байсан ч шийдвэрлэгдээгүй хэргийн тоо эрс өсч байлаа. Хэргийг хурдан шийдвэрлүүлэхийн тулд хээл хахууль өгөх байдал түгээмэл байсан ч тухайн үед хэвлэл мэдээллийн эрх чөлөө хязгаарлагдмал, улс төрийн сөрөг хүчин байгаагүй зэргээс болж энэ үед шүүхийн авлигын байдал улам дордсон эсэхийг бодитой тогтоосон судалгаа хийгдээгүй байна.

Энэ бүх хүчин зүйлс шүүхийн үйл ажиллагаанд одоо ч сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд шүүхэд ил тод байдлыг тогтооход саад болсоор байна. 2006 оны 3 сард парламент Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан гаргасан ба улс оронд нүүрлээд байгаа авлигын асуудал нь тус улсыг Европын холбоонд элсэхэд саад болж буй хамгийн том хүчин зүйл болохыг тэмдэглэжээ. Мөн 2005 оны 11 сард Европын холбооноос гаргасан үнэлгээний тайланд Хорватын шүүхийн үйл ажиллагаа муу байгаа нь тус улсыг Европын холбоонд элсүүлэхэд гол саад болж байгаа бөгөөд хамгийн гол нь авлига тус улсын нийгэм, хүний эрхэнд ноцтой заналхийлж байна гэж дүгнэжээ. Түүнчлэн тус комиссоос авлигын хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, шийтгэл ногдуулах бүх үе шатанд ил тод байдлыг хангах, хяналтын үр дүнтэй системийг байгуулах шаардлагатай гэж зөвлөжээ.

Асуудлын шинж чанар ба хамрах хүрээ

Олон нийтийн дунд явуулсан судалгааны дүнгээс харахад Хорватчууд шүүх бол авлигад хамгийн их идэгдсэн салбаруудын нэг хэмээн дүгнэсэн юм. Хорватын Транспэрэнси Интернэшнл байгууллагын салбарын судалгаа ч үүнийг баталж байна. 2003 онд явуулсан судалгаанд хамрагдагсдын 80 гаруй хувь нь “Та шүүхийн системд авлига өргөн тархсан гэдгийг хүлээн зөвшөөрч байна уу” гэхэд “Тийм” гэж хариулжээ.²

Иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн илрүүлж нийтэлсэн шүүхийн үйл ажиллагаанд гарч буй авлигын хэргийн талаарх зарим нэг мэдээллээс шүүхийн авлигын гэмт хэргийн шинж чанарыг судалж болно. 2006 оны 9 сард Авлига болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газраас Гвозд хотын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчээр ажиллаж байсан Звонимир Ёосиповичийг хээл хахууль авах, залилан мэхлэх, албан тушаалаа урвуулан ашиглах хэрэгт холбогдуулан мөрдөн шалгасан байна. Энэ шүүгч хэргийг хурдан шийдвэрлэнэ хэмээн амлаж хэргийн оролцогчдоос дээд тал нь 4,000 ам.доллар хүртэлх хэмжээний хээл хахууль авдаг байжээ. 2005 онд түүний хөрөнгө 240,000 ам.доллартай тэнцүү байсныг илрүүлж мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж эхэлжээ.³

Хорватын ТИ–аас 2004 онд байгуулсан Хууль зүйн зөвлөгөө, нөлөөллийн төвд хадгалагдаж буй авлигын гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн өргөдөл, гомдлын байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд тус оронд авлигын цар хүрээ

2 Хорватын ТИ-ийн асуулгаас (Zagreb TI Croatia, 2003)

3 Hrvatska radiotelevizija (Croatia) 27 September 2006 vijesti.hrt.hr/ShowArticles.aspx?ArticleId_15242

ямар байгааг мэдэх боломжтой. 2006 оны 6 сарын байдлаар энд цугларсан нийт гомдлын тал хувийг шүүхийн авлигатай холбоотой хэрэг эзэлж байлаа. Шүүхээс хууль зүйн үндэслэлгүй, санаанд оромгүй ял шийтгэл ногдуулсан тухай, мөн шүүгч хэргийг хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор үүсгэхгүй байсаар хэрэг үүсгэж, шалгах боломжгүй болгодог бөгөөд ямар нэг тайлбар хийдэггүй гэсэн гомдол түгээмэл байв.

Хорватын шүүгчдийн холбооноос шүүгчдийн дунд авлига цөөнгүй гарч байгааг хүлээн зөвшөөрдөг хэдий ч юуг авлига гэж үзэх вэ гэдэг талаар хязгаарлагдмал ойлголттой байдаг. Тэдний үзэж байгаагаар “Буруу, үндэслэлгүй шийдвэрийг дээд шатны шүүхээс залруулдаг, буруу шийдвэр гаргасныг авлига гэж үзэх боломжгүй юм ” гэж тус холбооны тэргүүн Джура Сесса хэлжээ.⁴

Энэ тайланг бичиж буй мөчид зөвхөн нэг шүүгч авлигын хэрэгт гэм буруутай нь тогтоогдсон байна. Шүүгч Жураж Болжковак авлигын хэрэгт шийтгүүлсэн ба тэр шүүгч хэргийн яллагдагчийг батлан даалтад гаргахын тулд 15,000 евро буюу 19,000 ам.долларын хээл хахууль авсан болох нь тогтоогдсон байна. Түүнд 3.5 жилийн хорих ял ногдуулжээ.⁵ Энэ хэргийг шийдвэрлэх ажиллагаа нийт 3 жил гаруй үргэлжилсэн байна. 2006 оны эхний хагасын байдлаар шүүгчийг томилох, удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий байгууллага болох Шүүхийн төрийн зөвлөл (State Judicial Council)-өөс нийт 5 шүүгчийг авлигын хэрэгт холбогдуулан шалгажээ.

Авлигын хэрэгт холбогдуулан шалгаж буй шүүгчийн хэргийг удаашруулах нь шүүхийн салбарт авлигатай хийх тэмцлийг удаашруулж байна гэсэн үг юм. 2005 оны байдлаар Хууль зүйн яамны мэдээлснээр нийт 1.5 сая хэрэг шийдвэрлэгдээгүй байна.⁶ Тэдгээрийн ихэнхийг эрүүгийн хэрэг эзэлж байгаа ба анхан шатны шүүхээр шийдвэрлэх хэргүүд байна. Үүний нэг шалтгааныг 1990 онд цөөнгүй шүүгч ажлаасаа гарч оронд нь шинэ залуу буюу туршлагагүй шүүгчид орж ирсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

Шүүхэд гарч буй авлигын хэргийн цөөнгүй хэсэг нь аж ахуйн нэгжийн дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үед гарч байгаа ба 2006 оны 2 сард прокурорын газраас Загреб хот дахь худалдааны давж заалдах шатны шүүхийн хэд хэдэн шүүгчийг хувьдаа хөрөнгө завшсан хэрэгт буруутгасан ч Шүүхийн төрийн зөвлөлөөс тэдгээр шүүгчдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэхээс татгалзсан тул мөрдөн шалгаж чадаагүй. Дампуурлын хэргийн оролцогч компаниас шүүхийн байгууллага зээл авсан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр цацагдсан байна.⁷ Тухайлбал, худалдааны хэргийн шүүх нь Загребт үйл ажиллагаагаа явуулдаг Дерма хэмээх

4 Хорватын шүүгчдийн холбооноос гаргасан мэдээлэл 2006 оны 3 сарын 3-ны өдөр

5 Radio free Europe /radio liberty 23 Sep 2003

6 Статистик мэдээ, Хууль зүйн яам, 2006 он, Загреб

7 Nacional Croatia, 27 Feb 2006

компаниас түүний дампуурлын тухай хэргийг шийдвэрлэж байхдаа шүүхийн барилгад засвар хийх нэрийдлээр нийт 600,000 ам.долларын зээл авсан байна. 1992 онд үүссэн хэрэг 2001 онд шийдвэрлэгдэх үед шүүхийн зээл дансанд бүртгэлгүй болж, ор мөргүй хасагдсан байв.⁸ Дээр дурдсанчлан, дампуурлын хэргүүд дээр шүүх болон дампуурлын хэрэг гүйцэтгэгч нар үгсэн хуйвалдаж, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эд хөрөнгийг завшдаг байна.

Шүүхийн авлигатай тэмцэл хийх оролдлогууд

Хорват улс тусгаар тогтнолоо олсон цагаас эхлэн улс орныхоо шүүхийн системийг сайжруулахын тулд эхний ээлжинд шүүгчийг улс төрийн нөлөөллөөс хамгаалахад голлон анхаарч иржээ. Гэвч томилгооны процесс зохион байгуулалт сул байгаагаас шалтгаалан шүүгчийн томилгоонд их бага ямар нэг хэмжээгээр улс төрийн нөлөө орсоор байна. Шүүгч болон прокурорыг томилох, сахилгын шийтгэл ногдуулах эрх бүхий байгууллага (комисс)-ыг байгуулах ажил их учир дутагдалтай явагдсан ба хамгийн гол алдаа нь бол түүний бүрэлдэхүүнийг сонгох явдлыг удаашруулсанд байв. Комиссын үйл ажиллагааг зохицуулсан хуулийг 1993 онд батлан гаргасан ч комиссын орон тоо бүрдээгүй шатгаанаар 1994 он хүртэл ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй юм. Комиссын гишүүнд Дээд шүүх, Хууль зүйн сайд, Ерөнхий прокурор, Хорватын өмгөөлөгчдийн холбоо, хуулийн сургуулиудаас нэр дэвшүүлдэг. Ихэнх тохиолдолд нэр дэвшигчид олонхийн дэмжлэг авч чадаагүй, Ерөнхий прокурор сүүлийн 15 гишүүний 13-ыг нэр дэвшүүлсэн байв. Шүүгчдийг улс төрийн намын харъяллыг харгалзан томилох явдлыг таслан зогсоож чадахгүй байна хэмээн тус комиссыг байнга шүүмжилдэг.

1996 оноос эхлэн шүүгч нь 3 жил тутамд мэргэжлийн шалгалт өгдөг байсныг халж, эхний удаа 5 жилийн туршилтын хугацаагаар ажиллах ба уг хугацаанд ямар нэг зөрчил гаргаагүй тохиолдолд дараа нь тэтгэвэрт гарах хүртэл нь ажиллуулах болсон нь шинээр хийгдсэн өөрчлөлтийн нэг юм. Энэ өөрчлөлт нь хэрэг, маргааныг хурдан шуурхай шийдвэрлэх процесс, шүүгчийн ажлын үр дүнд ямар нэг хэлбэрээр шууд эерэг нөлөө үзүүлэхгүй ч шалгалтанд тэнцээгүй шүүгчдээс үйлдэх авлигыг хаасан гэж үзэж болно.

Бас нэг чухал алхам бол 2005 онд Хууль зүйн яамнаас газар өмчлөлийн эрхтэй холбоотой мэдээллийг дижитал буюу онлайн хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэн интернетэд байрлуулсан явдал бөгөөд олон нийтээс энэ төрлийн мэдээллийг чөлөөтэй олж мэдэх, ашиглах бололцоог хангаснаар авлигын хэргийг бууруулахад зохих нөлөө үзүүлж чадсан байна.⁹

2006 онд батлагдан гарсан “Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр”-т орон нутгийн удирдлага, улс төр, төрийн алба, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, шүүх,

8 Slobodna Dalmacija, Croatia, 1 April 2006

9 Дэлхий нийтийн авлигын тайлан 2006 -г үзнэ үү.

эрүүл мэнд, спорт зэрэг салбарт хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг цогц байдлаар тусгасан. Ингэхдээ шүүх эрх мэдлийн хүрээнд: ил тод байдлыг нэмэгдүүлэх, шүүхийн шийдвэрийн үр нөлөөг сайжруулахын тулд тодорхой арга хэмжээ авахаар төлөвлөсний заримд хэргийг шүүгч нарт хуваарилах үндэслэлийг тогтоох, уг хуваарийг олон нийтэд онлайн хэлбэрээр харуулах системийг бүрдүүлэх, шүүгч, прокурор нь өөрийн болон гэр бүлийн гишүүний хөрөнгө орлогын байдлыг мэдүүлэх механизмыг бүрдүүлэх, улс орны хэмжээнд авлигын асуудлыг бүхэлд нь шинжлэн судлах, шүүгчийг албан тушаал дэвшүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, шүүхийн байгууллагын ажилтнуудыг байнга давтан сургах ажлыг зохион байгуулах зэрэг асуудлууд оржээ.

Дүгнэлт

Хэдийгээр Хорват улсын шүүхийн системд гарч буй алдаа, дутагдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох талаар хангалттай хэмжээний мэдээлэл олдож байгаа ч шүүхийн систем дэх авлигын төвшинг нарийн тодорхойлох боломж одоогоор бүрдээгүй байна. Шүүхийн байгууллагын төлөөлөгчдийн үзэж байгаа шиг 1990 оноос хойш зөвхөн нэг шүүгч авлигын хэрэгт шийтгүүлснийг эс тооцвол энэ салбарт авлигын гаралт бага байна гэж үзэх нь хангалтгүй юм. Учир нь олон нийтийн зүгээс авлигын нөлөө ороогүй л бол шүүхийн шийдвэр ингэж гарахгүй байсан гэх хардлага байнга гардаг. Түүнчлэн ил тод байдлыг хангах үүднээс шүүгч өөрийн гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг хэргийн оролцогчдод тайлбарлах нь шүүхийн системд байгаа эсхүл байж болох авлигыг бууруулах арга зам болж болох юм. Хуулийн байгууллага, тэр дундаа анхан шатны шүүхэд итгэх олон нийтийн итгэл бага байгаа нь шүүхийн үйл ажиллагаа иргэдэд ойлгомжтой биш, ил тод бус байгаатай холбоотой. Хорватын Дээд шүүхээс гаргасан бүх шийдвэрүүдээ онлайн хэлбэрээр нийтэлдэг ч бусад шүүх энэ жишгийг тэр бүр дагахгүй байна. Энгийн иргэн хүний хувьд шүүх хуралд биечлэн, чөлөөтэй оролцох боломжтой боловч шүүхийн шийдвэрийн үндэслэлийг ойлгож мэдэх нь амаргүй байдаг.

Транспэрэнси Интернэшнал-Хорват, Загреб

Европын холбоо ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа ч дээрээс доош чиглэсэн хяналтын тогтолцоо нь Чехийн шүүхийн шинэтгэлийг удаашруулж байна

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, мөрдөн шалгах болон холимог зарчимд суурилсан

100,000 хүн амд ногдох шүүгчийн тоо: 28.8¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 25,610 ам доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 53,569³

Нэг хүнд ногдох ҮНБ: 10,710⁴

Шүүхийн жилийн төсөв: 514.3 сая⁵

Жилийн нийт төсөв: 43.6 тэрбум⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 1.2

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат бус

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм, 2005 онд батлагдсан, гэхдээ зөвхөн

Шүүгчдийн холбооны гишүүдэд үйлчилдэг (шүүгчдийн бараг хагас нь гэсэн үг)

1. Хууль зүйн яам, 2006

2. Ишлэл 1

3. Ишлэл 1

4. World Bank Development Indicators (2005)

5. Төсвийн тухай хууль 543\2005

6. Ишлэл 1

Ямар нэг баримттай судалгаа байхгүй тул Чех улсын шүүхийн систем дэх авлигын цар хүрээ, шинж чанарын талаар хангалттай, баттай мэдээлэл өгөх боломжгүй юм. 1990 оноос хойш ердөө 5 шүүгч авлигын хэрэгт шийтгүүлсэн ба шүүхийнхэн өөрсдөө шүүхийн салбарт авлига газар авсныг хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд энэ талаарх тоо баримтыг зохиомлоор өсгөсөн гэж тайлбарладаг. Түүнчлэн авлигын хэргийн талаар тусгай телефон утсаар мэдээлэл хүлээн авах үйлчилгээний мэдээлэлд тулгуурлан Хууль зүйн яам ч энэ тайлбарыг улам бататгаж, авлига байхгүй хэмээн мэдэгддэг. 2004 оноос эхлэн энэ утсыг ажиллуулсан бөгөөд мөн онд нийт 100 гомдол, мэдээлэл хүлээн авч, 59-ыг нь мөрдөн байцаалт явуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлсэн боловч нотлох баримт хангалтгүй гэсэн үндэслэлээр уг хэргүүдийг шүүхэд шилжүүлээгүй байна. Улмаар 2005 онд утсаар мэдээлэл ирэх нь эрс багассан бөгөөд Хууль зүйн сайд үүнийг тайлбарлахдаа “Шүүхийн үйл ажиллагаанд авлига их гардаг хэмээх ойлголт нь буруу юм. Хэрэв тийм биш байсан бол хэдэн мянган хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч нар ямар нэгэн арга хэмжээ авах байсан” гэв.¹

1 Ministerstvo spravedlnosti ČR, Protikorupční linka Ministerstva spravedlnosti – vyhodnocení za rok 2005 (Anti-corruption Hotline of Justice Ministry – 2005 Assessment) (Prague: Ministerstvo spravedlnosti ČR, 2006).

Харин практикт, өөр бусад байдлаар шүүхийн систем нь авлигад өртөх өндөр магадлалтай болохыг харуулсан хэд хэдэн нотлох баримтыг нэрлэж болно.

Нэгдүгээрт, шүүн таслах ажиллагаа ихэнх тохиолдолд удаан хугацаанд үргэлжилдэг. Хууль зүйн яамнаас мэдээлснээр 2004 онд эрүү болон иргэний хэргийг бүсийн шүүхүүдэд дунджаар 550-800 өдөрт шийдвэрлэсэн тухай мэдээ байна.² Хүний эрхтэй холбоотой асуудлыг богино хугацаанд яаран шийдвэрлэж болохгүй ч шүүх ажиллагаа удаан хугацаагаар үргэлжлэх нь шүүгчийг хэргийн оролцогчдын нөлөөнд автах магадлалыг нэмэгдүүлдэг. (Европын хүний эрхийн шүүхэд хэрэг маргааныг амжилттай шийдвэрлэж байгаа тухай тоо баримт олон байгааг дурдах хэрэгтэй)

Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа удаан байгаа нь дор дурдсан шалтгаантай. Үүнд:

- 1990 оны эхний хагаст улс орны эдийн засгийн дэглэм эрс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор эрүүгийн болон иргэний хэрэг, маргааны тоо эрс өссөн. Зарим шүүх одоо болтол шийдвэрлэх ёстой хэргүүдээ дарагдсан хэвээр байна.
- Шүүхийн системийн удирдлага, зохион байгуулалт муу. Хууль зүйн яамнаас хуваарилж буй материаллаг хангамж хүрэлцдэггүй. Ажлын ачааллаас болж шүүгч хуульд заасан хугацаан дотор хангалттай үндэслэл бүхий чанартай шийдвэр гаргаж чаддаггүй.³ Түүнчлэн, мэдлэг, чадвартай шүүхийн туслах ажилтнууд хангалтгүй байгаа нь шүүгч захиргааны ажлыг давхар хийх шаардлагыг бий болгодог.
- Шүүгчийн ажлын үр дүн, үйл ажиллагааг үнэлэх нэгдсэн, албан ёсны, ил тод, шударга систем байхгүй байгаа нь шүүхийн системд хүний нөөцийн зохистой бодлого хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд саад болдог.
- Зөвхөн бүс нутгийн шүүхүүд шүүгчдийнхээ үйл ажиллагаанд үнэлгээ өгдөг бөгөөд хэрэглэж буй шалгуур үзүүлэлтүүд нь харилцан адилгүй, өөр хоорондоо зөрчилтэй байдаг.⁴

Хоёрдугаарт, шүүхүүд тухайн төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэж буй нийтлэг жишигт нийцэхгүй шийдвэрийг маш олон гаргадаг. Үүнийг Шүүхийн хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх тухай стратегийн баримт бичигт Хууль зүйн сайд хүлээн зөвшөөрсөн байдаг ба албан ёсны статистикаас харахад давж заалдах шатны шүүхээс доод шатны шүүхийн гаргасан шийдвэрийн тэн хагасаас илүүг нь өөрчилсөн байдаг.

2 portal.justice.cz/ms/ms.aspx?j_33&o_23&k_3397&d_47145

3 Pona Bažantovb and Marek Loužek, eds., *Potřebuje české soudnictví reformu?* (Does the Czech Judiciary Need Reform?)(Prague: Centrum pro ekonomiku a politiku, 2004).

4 Michal Štíčka, *Seeking a Balance between Judicial Independence and Accountability* (Prague: TI ČR, 2004).

Шүүгчид өөр өөр шийдвэр гаргаж байгаа нь дараах шалтгаантай:

- Жил бүр олон шинэ хууль тогтоомж батлагдан гардаг ба тогтмол хэрэглэгддэг хуулиуд түүний дотор Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд ч бас байнга өөрчлөлт ордог.
- Шинэ шүүгчид ажлын гараагаа анхан шатны шүүхээс эхэлдэг. Хэрэв тэд давж заалдах шатны шүүхэд, туршлагатай ахмад шүүгчдийн удирдлаган дор ажиллавал анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрхэн залруулах ёстойг сурах боломжтой юм.
- Шүүхийн шийдвэрийг давж заалдах систем үр дүнгүй байна. Өөрөөр хэлбэл хэргийн харъяалал тодорхой бус байгаагаас шалтгаалж шүүх хооронд “хэргийг бие биерүүгээ түлхэх” байдал цөөнгүй гардаг.

Гуравдугаарт, Хууль зүйн сайд эрх мэдлээ хэтрүүлэн шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх боломжтой. Үүнийг 2005 оны 9 сард Ерөнхий прокурор Мариа Бенешоваг, 2006 онд Дээд шүүхийн тэргүүн Ива Брожоваг огцруулсан хэргийн жишээнээс тус тус харж болно.⁵ Ерөнхий прокурор Мариа Бенешова болон Хууль зүйн сайд Павел Немец нарын удаан жилийн тэмцэл нь Катарын хунтайжийг нутгаасаа хөөн гаргасантай холбоотойгоор эцэстээ тулж, энэ нь Ерөнхий прокурорыг огцруулах албан ёсны үндэслэлийн далд шалтгаан нь болсон юм.⁶ (Зарим талаар Ерөнхий прокурор нь улс төрийн албан хаагч)⁷

Брожовагийн хэргийн хувьд, Хууль зүйн сайд асан Ярослав Буреш Дээд шүүхийн шүүгч, улмаар Ерөнхий шүүгч болохыг хүсч буйгаа удаа дараа илэрхийлж байсантай холбоотой ба үүнийг нь Брожова эсэргүүцэж байснаас үүдэлтэй гэх тайлбар бий.⁸ Брожова дараа нь Үндсэн хуулийн болон Захиргааны хэргийн дээд шүүхэд давж заалдсан ба Дээд шүүхийн эхний шийдвэрээс үндэслэн дүгнэвэл тэрээр заргаа бүрэн авах төлөвтэй байна. Шүүх болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын засаглалын эрх мэдлийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс энэ шийдвэр нь Чехийн хувьд зөв алхам болсон.

Түүнчлэн шүүхийн шийдвэрт улс төрийн хүчнээс нөлөөлөх оролдлого гардаг. Чех улсын шүүхийн захиргааны удирдлагын тогтоолцоонд Хууль зүйн сайд голлох эрх мэдэлтэй, тэрээр шүүхийн болон прокурорын газрын даргыг томилох, чөлөөх эрхтэй. Энэ эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг зохистой механизм байхгүй бөгөөд өөртөө захирагддаг, дуулгавартай этгээдийг томилох, улмаар тэдгээр нь өөрсдийн удирдлаганд байгаа хүмүүсийн шийдвэр, үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх боломжтой.

5 Дээд шүүхийн тэргүүнийг томилох, чөлөөлөх шийдвэрийг Ерөнхийлөгч гаргах хэдий ч уг асуудлыг хөндөж тавих, санаачлах эрхийг сайд хэрэгжүүлдэг.

6 MF Dnes Czech Republic 30 Sep 2005

7 MF Dnes Czech Republic 3 Feb 2006

8 MF Dnes Czech Republic 01 March 2006

Шүүхэд ирүүлсэн дампуурлын хэргүүд дээр шүүх болон дампуурлын хэрэг гүйцэтгэгч нар үгсэн хуйвалдаж зээлдэгч болон зээлдүүлэгчийн эд хөрөнгийг завших явдал цөөнгүй гардаг. Учир нь энэ талаарх хуулийн зохицуулалт хангалтгүй, хууль тогтоомжид дампуурлын хэрэг гүйцэтгэгчийг шүүгчээс томилох, солих үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах тухай заалт үгүйлэгдэж байна.⁹ 2005 оны 4 дүгээр сард Усти Над Лабем хотын шүүхийн шүүгч Иржи Берка хэд хэдэн компанийг зохиомлоор дампууруулж, эд хөрөнгийг нь хувьдаа завшсан хэрэгт буруутгагдан шийтгүүлжээ.¹⁰

Авлигын хэргийг мөрдөн шалгаж буй цагдаа, прокурорын үйл ажиллагаа ч бас хангалтгүй, шаардлагатай хэмжээнд хүрэхэд хол байна. Ийм төрлийн маш цөөхөн хэргүүдэд л нотлох баримт хангалттай бүрддэг.¹¹ Хамгийн гол нь эдийн засгийн ноцтой хэргүүд, улс төрчдөд холбогдох авлигын хэргүүдийг шийдвэрлэхэд улс төрчид байнга саад болж, дарамт үзүүлдэг.¹²

Хараат бус шүүхтэй байх шаардлагыг Европын холбоо (ЕХ) тавихгүй байна

“Маастрихт гэрээ болон Копенгагены шалгуур”-ын аль алинд ч шүүхийн шинэтгэл хийхийг ЕХ-д элсэн орох хүсэлтэй орнуудад тусгайлан тавигдах урьдчилсан шалгуур болгон заагаагүй юм. Гэхдээ ЕХ-ны гишүүн орны шүүгчдийг тодорхой хэргүүдэд ЕХ-ны хуулийг хэрэглэх, Люксембург дахь ЕХ-ны шүүхтэй хамтран ажиллахыг зүй ёсоор шаарддаг. Тиймээс ЕХ шинээр гишүүнээр элсэх орнуудын шүүхийн системийн шинэтгэлийн асуудалд анхаарал хандуулах нь зүй ёсны үзэгдэл.¹³

Чех улсыг ЕХ-нд гишүүнээр элсэхтэй холбогдудан ЕХ-ноос шүүхийн албан тушаалын шинэ тогтолцоог бий болгох үүрэг өгсөн ба үүнээс өөр шаардлага тавиагүй байна. Энэ үйл ажиллагаанд Германы шүүгчид туслах бөгөөд цаашид хийгдэх шинэтгэлийн хамгийн гол үндэс суурь болох юм.¹⁴ Түүнчлэн, Чех улс нь ЕХ-той хамтран шинжээчдийн багийг ажиллуулах, үнэлгээ хийлгэх, шүүхийн байгууллагын техник хангамжийг сайжруулах, шүүхийн ажилтнуудад сургалт явуулах юм. ЕХ-ноос Чех улсыг гишүүнээр элсүүлэхээр бэлтгэл ажлыг хангах явцад гаргасан тайланд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урт,

9 Дэлхий нийтийн авлигын тайлан 2005-ыг үзнэ үү.

10 Czeck business Weekly, 14 August 2006, US Bureau of Democracy, Human rights and labor, Country reports on Human rights practices 2005

11 Ministerstvo vnitra ČR the report on the corruption in Czech republic and on fulfillment of the updated government al programme on combating corruption in 2004 Prague 2005

12 MF Dnes Czech Republic 30 May 2006

13 Ivo Šlosarčík, The Reform of the Judiciary and EU Accession (Prague: Europeum – Fyrum pro evropskou politiku, 2002).

14 Ekonom Czech republic 24 Nov 2005

удаан хугацааг шүүмжилсэн. Хэдий тийм боловч, энэ тайланд “Хүн бүр хуулиар хамгаалагдсан эрхээ мэдэхгүй байж болох ч шүүхэд хандах эрхийг бодитой хангасан” гэж дүгнэжээ.¹⁵ Чех улсыг ЕХ–нд элсүүлэх үйл ажиллагааны үр дүнд шүүхийн үйл ажиллагаанд ийм бага дэвшил гарах болсон 3 шалтгаан нь:

- ЕХ-ноос тус орны шүүхийн системийн бүтэц, тогтолцооны талаар ямар нэг тодорхой шалгуур тавиагүй. Өөрөөр хэлбэл шинэтгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг гишүүн оронд өөрт нь үлдээсэн.
- Сүүлийн 16 жилийн хугацаанд Чех улсын Хууль зүйн яам маш тогтворгүй ажилласан. Өнгөрсөн 16 жилд нийт 15 удаа сайд солигдсон. Сайд нар бүгд өөр өөрийн улс төрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийг зорьсон боловч нэг нь ч дорвитой амжилт олоогүй.¹⁶
- Энэхүү тогтворгүй байдлыг нь парламент болон олон нийтийн зүгээс шүүх шударга ёсыг хамгаалахын тулд захиргааны хувьд хараат бус, бие даасан байх хэрэгтэйг ойлгохгүй байсан нь даамжруулсан байна.¹⁷

Одоогоор шүүхийн системийг цэвэрлэх ажиллагаа хийгдэж байна. 2005 оны 11 дүгээр сард шүүгчдийн холбооноос “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг Банглогрын зарчимд тулгуурлан боловсруулсан. Түүний үр дүнг хэлэлцэх арай эрт байна. Шинэтгэлийн тэргүүн ээлжинд:

- Шүүгч захиргааны удирдлагын хувьд бие даасан, хараат бус байдлыг хангах. Үүнд шүүхийн төсөв болон боловсон хүчний асуудлыг шийдвэрлэхэд шүүхийн төлөөллийг оролцуулах;
- Шүүгчийн албан тушаалд томилох, дэвшүүлэхэд баримтлах шинэ журмыг нэвтрүүлж хэрэгжүүлэх, шүүгчийн албан тушаалд томилохдоо мэдлэг, ур чадварыг үндэслэх, шүүгчийн ажлын гүйцэтгэлийг зөв үнэлэх системийг бий болгох. Шинэ, залуу шүүгчийг давж заалдах шатны шүүхэд, туршлагатай шүүгчийн удирдлаган дор эхлээд ажиллуулах, шүүхийн сургалтыг одоогийнх шиг Хууль зүйн яамны биш өөр хараат бус академиас зохион байгуулах;
- Давж заалдах шатны шүүхүүд хэргийн харъяаллаар өөр хоорондоо маргахгүй байх арга хэмжээг авах;
- Хуульд байнга өөрчлөлт оруулах, шинээр олон хууль гаргадаг зэргийг зогсоож хууль боловсруулах үйл ажиллагааг сайжруулах.

*Михал Штичка
(Чехийн ТИ-ийн салбар, Прага)*

15 www.evropska-unie.cz/cz/file_system/folder.asp?folder_id_18.

16 Өмнөх ишлэлийг үзнэ үү

17 Олон нийтийн үзэл бодол, хандлагыг өөрчлөхийг байнга оролдож байгаа бөгөөд ерөнхийдөө тодорхой амжилтад хүрсэн гэжээ.

Египетийн шүүхэд харьцангуй өөрчлөлт гарч байна

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, мөрдөн шалгах болон мэтгэлцэх зарчим (Исламын хуулийн элемент агуулсан), прокурор нь шүүх эрх мэдэлдээ багтдаг

100,000 хүн амд ногдох шүүгчийн тоо: 16.4¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 1,313 ам доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 10,245³ ам доллар

Нэг хүнд ногдох ҮНБ: 1,250⁴ ам доллар

Шүүхийн жилийн төсөв: Мэдээлэл байхгүй

Жилийн нийт төсөв: 30.4 тэрбум ⁵ ам доллар

Жилийн төсөвт эзлэх хувь: Мэдээлэл байхгүй

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Үгүй

1. CIA World Factbook and National Democratic Party website

2. Прокурорын албаны хамгийн доод шатны албан тушаал,

Шүүхийн эрх мэдлийн тухай хууль

4. World Bank Development Indicators (2005)

3. Ишлэл 2

5. CIA World Factbook

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын тухай хөндөхгүйгээр Египетийн шүүхийн систем дэхь авлигын тухай асуудлыг ярих боломжгүй юм. Дээрх хоёр асуудлын харилцан уялдааг 2003 онд давж заалдах шатны шүүхийн шүүгч Яахья Ал-Рефай албан тушаалаасаа огцрохдоо хийсэн мэдэгдэлдээ Хууль зүйн яамнаас шүүгчдэд хууль бусаар хэрхэн нөлөөлдөг, дуулгавартай шүүгчдийг байнга шагнаж урамшуулдаг, харин шударга, хараат бус шүүгч бага цалин хөлсөөр тарчиг амьдардаг, яамны захиалгын дагуу зарим чухал албан тушаалтны эсрэг эрүүгийн гэмт хэргийн болон иргэний хэрэгт холбогдох материалыг гаргаж өгдөг байсан тухай олон баримтыг дэлгэн харуулсан байна.¹ Үүнээс хойш, шүүгчдэд үзүүлж буй улс төрийн нөлөө, хууль бус элдэв дарамт шахалтын талаар зоригтойгоор мэдээлэх шүүгчдийн тоо өссөөр байна.

Тус оронд хэрэгжиж буй шүүхийн шинэтгэлийн үйл хэрэгт 1939 онд байгуулагдсан Шүүгчдийн клуб гол үүрэг гүйцэтгэдэг. Тус байгууллага байгуулагдсанаасаа хойш хэдэн арван жилийн хугацаанд өсөн хөгжиж, шүүхийн мэргэжлийн холбоо болтлоо өргөжсөн төдийгүй шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахын тулд гүйцэтгэх засаглалын байгууллагаас үзүүлдэг хууль бус дарамт, шахалтыг эсэргүүцсээр ирсэн ойрх дорнодод нэр хүнд бүхий хүчтэй байгууллага юм. 1969 онд Гамал Абдел Нассерыг Ерөнхийлөгчөөр ажиллаж байх үед шүүгчдийг Арабын социалист намд элсэхийг шаардсан ба үүнийг

1 Дэлхий нийтийн авлигын тайлан 2004 ыг үзнэ үү

тус Клубын гишүүд эсэргүүцсэнээс улбаалан 100 шүүгчийг албан тушаалаас нь огцруулжээ. Энэ үйл явдлыг түүхэнд “шүүхийн хамгийн том ялагдал” гэж үздэг бөгөөд Шүүгчдийн клуб уг явдлаас эхлэн өөрсдийн тэмцлийг эхлүүлсэн гэдэг.²

Хэдийгээр дээрх байдлыг халж, ажиллах нөхцөлийн хувьд шүүгчид таатай орчинд үйл ажиллагаагаа явуулдаг ч шүүхийн төсвийг батлах, шүүгчид сахилгын хариуцлага ногдуулах эрх Хууль зүйн яаманд хадгалагдсаар байна. Шүүхийн дээд зөвлөл (The Supreme Judicial Council) нь шүүхийн системийн үйл ажиллагааг хянаж, яамны дээрх шийдвэрүүдийг баталгаажуулах эсэхийг шийдвэрлэх эрхтэй байдаг ч засгийн газартай ойр, нягт ажилладаг тул нөлөөнд нь байнга автдаг.

Засгийн газраас эрүүгийн эрх зүйн системийн гол манаач болсон Ерөнхий прокурорыг томилдог. Энэ нь ямар нэг хэмжээгээр улс төрчид, бизнесийнхэн болон худалдагдсан шүүгчдээс үйлдсэн авлигын хэргийг хараат бусаар бие даан мөрдөн шалгах боломжийг алдагдуулдаг.³

Шүүгчдийн клубээс 20 жилийн турш засгийн газраас шүүхэд үзүүлж буй хууль бус дарамт, шахалтыг арилгахын тулд 1972 оны “Шүүх эрх мэдлийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж ирсэн байна. 1986 онд хуралдсан шүүгчдийн үндэсний зөвлөлгөөнөөс гаргасан зөвлөмжийг 1991 онд шинэ хуулийн төсөл болгон боловсруулж, уг хуульд, шүүхийг санхүүгийн хувьд бүрэн хараат бус болгох, шүүхийн сахилгын хороог Хууль зүйн яамнаас салгаж, Шүүхийн дээд зөвлөлд шилжүүлэх, шүүгчийн тэтгэврийн сангийн зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг тусгажээ. 2004 оны 11 дүгээр сард Египетийн шүүгчдийн ерөнхий чуулганаас энэ төслийг удаа дараа дэмжсэн боловч засгийн газар үүнийг хууль болгохыг хүсэхгүй байгаа юм.⁴

Сонгууль шүүхийн шинэтгэл хийх боломжийг олгосон нь

2005 оны 2 дугаар сард Ерөнхийлөгч Хосни Мубаракийн шийдвэрээр мөн оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагаанд сөрөг хүчнээс нэр дэвшүүлэхийг хориглосон заалтыг халсан нь олон жилийн турш Шүүгчдийн клубээс хүсч байсан бие даасан шүүхтэй болох хүсэл биелэгдэх боломжийг олгожээ. 1980 оны Үндсэн хуульд зааснаар “*Сонгуулийн саналын хуудсыг шүүхийн байгууллагын төлөөлөгчийн хяналтан дор тоолох ба шүүгчдийг энэ зорилгоор томилон ажиллуулах журмыг хуулиар тогтооно*” гэсэн байдаг.⁵ Энэ бол улс орны хэмжээнд 9,000 гаруй шүүгчийг 54,000 орчим сонгуулийн хэсэг, хороонд ажиллуулна гэсэн үг юм.

2 Nathan J. Brown and Hesham Nasr, ‘Egypt’s Judges Step Forward’, in Carnegie Endowment for Internal Peace, Policy Outlook, May 2005. Available at www.carnegieendowment.org/publications/index.cfm?fa_view&id_16988&proj_zdrl

3 Өмнөх ишлэл

4 Arab Center for the Independence of the Judiciary and the Legal Profession (ACIJLP), 3 April 2005. Available at www.acijlp.org

5 www.egypt.gov.eg/english/laws/constitution/index.asp

Шүүгч сонгуульд хяналтын үүрэг гүйцэтгэснээрээ сонгуулийн дүнд хууль бусаар нөлөөлсөн явдлыг баталгаажуулах магадлалтай бөгөөд 2000 онд ийм хэрэг гарсан бөгөөд Шүүгчдийн клубын гишүүд үүнийг эсэргүйцэн үймэн дэгдээсэн байна.

2005 оны 4 сард Шүүгчдийн клубын Александра дахь салбараас сонгуулийн бэлтгэл ажлын үеэс эхлэн сонгуулийн дүнг сонсгох хүртэлх бүхий л үйл ажиллагааг шүүгчид бүрэн хянах эрх олгох, түүнчлэн хууль тогтоогчоос шүүхийг гүйцэтгэх засаглалаас хараат бус болгох талаар хууль гаргах хүртэл сонгуулийн үйл ажиллагаанд оролцохгүй, бойкотлох тухай мэдэгдсэн байна.⁶ Нэг сарын дараа энэ “тэмцэл” Каир хотод давтагдаж, 5 сарын 13-ны өдрийн Шүүгчдийн клубын ээлжит бус хурал дээр 2,000 шүүгч үүнийг дэмжиж байгаагаа илэрхийлжээ.

Парламентын сонгуулийн эхний шатны дараа тус клубээс байгуулсан ажлын хэсгээс сонгуулийн үеэр хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, сонгогчийг сүрдүүлсэн, цагдаагийн ажилтнуудаас бусдын эрхэнд хууль бусаар халдсан, хяналт тавьж буй шүүгч хангалтгүй ажилласан зэрэг нийт 133 хэргийг шалгуулахаар зохих байгууллагад хандсан байна.⁷ 2006 оны 5 дугаар сард Египетийн Дээд (хамгийн эцсийн давж заалдах шатны) шүүхийн Ерөнхий шүүгчийн орлогч болох Махмуд Мекки, Хишам Бастависи нарыг сонгуулийн үеэр хууль бус үйлдэл хийсэн байж болзошгүй хэмээн сэжиглэгдэн шалгагдаж буй шүүгчдийн нэрийг хууль бусаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр задруулсан хэргээр сахилгын шүүхэд дуудагдсан байна.

2006 оны 4-6 сард шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын төлөөх тэмцэл оргил цэгтээ хүрчээ. Иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлэл, сөрөг хүчний нам, олон улсын хүний эрхийн төлөөх байгууллагууд ч энэ тэмцлийг дэмжсэн байна. Үүний хариуд засгийн газар зарим жагсагчдыг хорьсон ба 2 шүүгчид сахилгын арга хэмжээ авсан ч шүүхээс тэднийг гэм буруугүй гэж үзжээ. Удалгүй 300 гаруй шүүгч Каирын Дээд шүүхийн гадаа эсэргүүцлийн дуугүй жагсаал хийсэн ба эцэстээ засгийн газар тэдний тавьсан зарим шаардлагыг хүлээн авсан байна.⁸

2006 онд Шүүхийн эрх мэдлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэ нь 1972 оны хуулиас сайжирсан боловч энэ өөрчлөлтийг оруулахдаа Шүүгчдийн клубын саналыг аваагүй тул шүүгчид хуулийг сэтгэл дундуур хүлээн авчээ.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр Шүүхийн дээд зөвлөлд шүүхийн төсвийг удирдах, хуваарилах бүрэн эрхийг өгч, прокурорын байгууллагыг гүйцэтгэх засаглалын байгууллагаас салгасан боловч шүүгчид холбогдох хэргийг мөрдөн шалгах,

6 ББС-ийн мэдээ 2005\05\04 news.bbc.co.uk/1/hi/world/middle_east/4509682.stm

7 Al Jazeera 28 November 2005

8 BBC News, 25 May 2006. Available at news.bbc.co.uk/1/hi/world/middle_east/4546333.stm

шүүгчийн албан тушаалд томилох, дэвшүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг Хууль зүйн яам болон Шүүхийн дээд зөвлөлд хэвээр үлдээсэн байна. Түүнчлэн засгийн газраас Ерөнхий прокурор болон Шүүхийн дээд зөвлөлийн даргыг томилох эрхийг эдэлж байгаа нь шүүхийг гүйцэтгэх засаглалын нөлөөн дор байлгах нөхцөлийг бүрдүүлсээр байна.

Шинэ хуульд шүүгчид өөрсдийн эрх ашгаа хамгаалах үүднээс мэргэжлийн холбоо байгуулах, шүүгч нарт сургалт зохион байгуулах, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах эрхтэй байх талаар ямар нэг заалт ороогүй. “Шүүгчдийн клуб нь гишүүдийн хурлаас сонгосон удирдах зөвлөлөөр удирдуулсан, ямар нэг байгууллагад тайлагнах үүрэг хүлээдэггүй, бие даасан байгууллага юм” хэмээн Махмуд Мекки хэлсэн юм.⁹ Тэрээр цааш нь хэлэхдээ шинэ хуулиар үүнийг баталгаажуулаагүй бөгөөд хэн нэгнээс Шүүгчдийн клубын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох явдал гарч болзошгүй байна гэжээ.

Төрийн төлөө ажилладаг прокурор

Шүүхийн байгууллагаас авлигын гэмт хэрэг, албан тушаалтнаас эрх мэдлээ урвуулан ашиглах, гэмт хэрэгтнүүдэд хариуцлага ногдуулах ажиллагааны үр дүн нь прокурорын зарчимч байх, хэргийг хараат бусаар, бие даан мөрдөн шалгах, хэрэгт тохирсон ял ногдуулах үйл ажиллагаанаас ихээхэн шалтгаалдаг билээ. Одоо хүчин төгөлдөр хуулийн дагуу, Египетийн прокурорын газар шүүх системд хамаардаг бөгөөд “Шүүхийн эрх мэдлийн тухай хууль”-д прокурорын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхой заасан ба гүйцэтгэх засаглалын шийдвэрээр түүнийг огцруулах боломжгүй байдгаараа шүүгчтэй яг ижил статустай.

Прокурорын газар нь анх 1875 онд байгуулагдсан (эмэгтэй хүн прокуророор ажиллах эрхгүй байв) ба цаг хугацааны эрхээр колонийн засгийн газар, хаант болон бүгд найрамдах засгийн үед ч өөрийнх нь эрх мэдлийн эсрэг хүч болгочихгүйн тулд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага ихээхэн анхаарч ирсэн. Өнгөрсөн хугацаанд, прокурор аяандаа шүүх эрх мэдлийн бус засгийн газрын байгууллагын нэг хэсэг болж хувирсан.

Прокурорыг зарчимч байдлаар ажиллуулахын тулд шүүх шүүхийн хараат бус байдлыг баталгаажуулахыг улам бүр шаардсаар байлаа. 2006 онд хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу прокурор болон дүүргийн өмгөөлөгчид (district attorneys) Хууль зүйн яаманд ажлаа тайлагнах үүрэггүй болж, Хууль зүйн яам нь гагцхүү прокурорын байгууллагын захиргааны үйл ажиллагааг хянах төдий эрхтэй үлдэв.¹⁰ Түүнчлэн Хууль зүйн сайд прокурорын эсрэг сахилгын хэрэг үүсгэх эрхгүй болсон ба энэ эрхийг одоо гагцхүү Ерөнхий прокурор эдэлнэ. Онолын хувьд энэ нь прокурорыг хөндлөнгийн аль нэг этгээдээс хараат бусаар үйл

9 ACJLP report, cited in Daily star (Egypt) 5 July 2006

10 Шүүхийн эрх мэдлийн тухай хууль, 125-р зүйл

ажиллагаагаа явуулах эрх зүйн хамгаалалт болсон.¹¹ Түүнчлэн прокурор болон дүүргийн өмгөөлөгчийг томилоход Шүүхийн дээд зөвлөлийн “санал”-ыг авах төдий байсан бол одоо “зөвшөөрөл”-ийг авах шаардлагатай болжээ.¹²

Гэсэн хэдий ч дээрх өөрчлөлт нь Ерөнхий прокурортой холбоотой хамгийн түрүүнд хийгдэх ёстой байсан өөрчлөлтийг хийж чадаагүй, энэ нь Ерөнхий прокурорыг тус улсын Ерөнхийлөгч дангаараа томилдогийг өөрчлөх явдал байсан. Өөрөөр хэлбэл түүнийг томилоход ямар нэгэн хэлбэрээр Шүүхийн дээд зөвлөлтэй зөвшилцөх, түүний зөвшөөрлийг авах шаардлаггүй юм. Энэ нь Ерөнхий прокуророос зарчимч байдлаар үйл ажиллагаагаа явуулахад сөргөөр нөлөөлдөг.¹³ Энэ утгаараа ч Ерөнхий прокурорыг шүүхийн систем дэх авлигатай хийх тэмцэлд бүрэн, идэвхитэй оролцохгүй, томилгооны энэхүү хараат байдлыг өөрчлөхийг хүсэхгүй байна гэж шүүмжилдэг. Энэхүү байдал өөрчлөгдөөгүй үлдсэнээр энэ албан тушаалд гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс өөрт нь үнэнч хүмүүсийг томилоход хүргэдэг.

Прокурор “ял шийтгэлээс мултрах” явдлыг хаацайлдаг

2006 оны 6 сард мэргэшсэн прокурор Абдел Мегюд Махмудыг Ерөнхий прокуророор томилсон ба олон хүн энэ шийдвэрийг талархан хүлээн авсан. Харин зарим хүн түүнийг засгийн газарт үнэнч, өмнөх прокурорын орлогчоор 7 жил ажилласан тул гүйцэтгэх засаглалын эрх ашгийн төлөө ажиллана гэж үзсэн.

Энэ албан тушаалд томилогдсоноор насан туршийн баталгаат ажлын байртай болохын зэрэгцээ тэтгэвэртээ гарсны дараа өөр илүү нэр хүндтэй албан тушаалд ажиллах бололцоотой болдог юм. Үүнийг Ерөнхий прокуророор ажиллаж байсан сүүлийн хэдэн хүмүүс тэтгэвэрт гарахдаа дээд шатны шүүхийн шүүгчээр томилогдох буюу эсхүл парламентад сонгогдож байсан жишээнээс харж болно.¹⁴ Шүүгч эсхүл Ерөнхий прокуророор ажиллаж байгаа бөгөөд тэтгэвэртээ гарсны дараа өөр албан тушаал хашихыг хүсч байгаа этгээд өөрийнх нь хянаж, хууль зөрчсөн бол хариуцлага тооцож байх ёстой тэр л хүмүүс тэдгээрийн албан тушаал хашиж байх үедээ бие даасан, хараат бусаар үйл ажиллагаа явуулах гэж оролдох эсэхийг маш нарийн судалж байдгийг мэднэ.

Энэхүү чухал албан тушаалд үнэнч хүнийг олж томилох, мөн тэднийг үнэнч хэвээр байлгахын тулд цаашид албан тушаал дэвшүүлэх амлалт өгөх нь маш өндөр үр нөлөө бүхий стратеги болох нь батлагдсан юм.

11 Мөн хууль, 129 –р зүйл

12 Мөн хууль, 1-р зүйл

13 Мөн хууль, 119 –р зүйл

14 Махер Абдел Вахид 2006 онд Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхий шүүгч, Рагаа Ел Араби парламентийн дээд танхимд тус тус сонгогдсон байна.

Дотоод яамны тагнуулын албаны үйл ажиллагааг мөрдөн шалгана, шийтгэнэ гэж бараг үгүй. Эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлсэн Тагнуулын албаны болон цагдаагийн зарим албан тушаалтнуудад холбогдох хэрэгт холбогдогчид ял шийтгэлгүй мултарсан тухай албан тушаалтнаас эрх мэдлээ урвуулах явдлыг дэмжсэн хэрэг хэмээн олон нийтийн зүгээс Ерөнхий прокурорыг шүүмжлэх нь улам нэмэгдсэн.¹⁵

Төрийн албан хаагчдаас үйлдсэн авлигын хэрэг болон хууль бус аливаа үйлдлийг илрүүлэн гаргаж, тэмцэл хийхгүй байгаа Ерөнхий прокурорын үйлдэл нь Үндсэн хуульд заасан “иргэдийн эрх ашгийг хамгаалах” үүргээсээ ухарч, төрийн дэглэмийг хамгаалагч болсныг харуулж байна. 2006 оны 3 сард явуулсан HRInfo.net байгууллагын судалгаанд нийт 1,910 хүн оролцсоноос 40 хувь нь Ерөнхий прокурорыг Ерөнхийлөгч Хосни Мубаракийн намыг хамгаалдаг, 34.5 хувь нь засгийн газрыг, 13.6 хувь нь цагдаагийн байгууллагыг, дөнгөж 12 хувь нь иргэдийг хамгаалдаг гэж хариулжээ.¹⁶

*Хоссам Багхат (Хүний хувийн эрхийг хамгаалах
Епитетийн санаачилга хөдөлгөөн, Каир)*

15 Синай дахь бөөнөөр баривчилгаа болон харгис үйлдэл. (Human right watch Feb 2005) 2004 онд Табад дотоод, гадаадын жуулчдыг бөмбөгдсөн хэргийн дараа олон хүнийг баривчилж, харгис хэрцгийгээр эрүүдэн шүүсэн хэрэг гарсан юм. Үүнийг эсэргүүцэн прокурорууд давж заалдах гомдол гаргасан ч ямар ч мөрдөн шалгах ажиллагаа явуулаагүй.

16 www.hrinfo.net/sys/poll/index.php?poll_id_39

Гүрж улсад авлигын эсрэг шинэтгэл өрнөсөөр

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, мэтгэлцэх зарчим, прокурор нь шүүх эрх мэдэлдээ хамаардаг

100,000 хүн амд ногдох шүүгчийн тоо: 6.2¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 9,858 ам доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 20,397³ ам доллар

Нэг хүнд ногдох ҮНБ: 1,350⁴ ам доллар

Шүүхийн жилийн төсөв: 27.5 сая⁵ ам доллар

Жилийн нийт төсөв: 1.6 тэрбум⁶ ам доллар

Жилийн төсөвт эзлэх хувь: 1.7

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат бус⁷

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм (Гэхдээ заавал мөрдөх албагүй)

1. Department of Common Courts (2006)

3. Мөн тэнд

5. Мөн тэнд

2. Georgian Law on Remuneration, 2005

4. World Bank Development Indicators (2005)

6. CIA World Fact book, 2005

Гүрж улс 1998 оноос эхлэн бүх шүүгчээс мэргэжлийн шалгалт авч, мэргэжил, ур чадварын хувьд албан тушаалдаа тэнцэхгүй байгаа шүүгчийг ажлаас нь халж, оронд нь шинэ хуульчдыг томилох замаар хуучин социалист шүүхийг бүрэн шинэчлэх ажлыг идэвхитэй өрнүүлж эхэлсэн боловч харамсалтай нь удалгүй энэхүү “шинэтгэлийн хурд саарсан” байна. Нийгмийн бүх шатанд авлига дахин газар авч, шүүхэд итгэх олон нийтийн итгэл эрс буурчээ. Авлига ийнхүү өргөн тархсан байдал болон 2003 оны 11 дүгээр сард явуулсан парламентын сонгуулийн шударга бус үйлдэлтэй давхацсанаар сонгуулийн дараа иргэд Тбилис хотод жагсаал хийж, тус орны Ерөнхийлөгч Эдуард Шеварнадзе албан тушаалаасаа огцроход хүргэсэн юм. Үүний үр дүнд, 2004 онд одоогийн Ерөнхийлөгч болон парламентыг сонгосон байна.

Шинээр байгуулагдсан засгийн газраас улс орны хэмжээнд өөрчлөлт, шинэтгэлийг эрчимтэй хийх зорилт тавьж, 2004-2005 оны хооронд боловсролын салбар, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, төрөөс лиценз, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа г.м олон салбарт дорвитой өөрчлөлт хийсэн боловч шүүх эрх мэдлийн шинэтгэлд ач холбогдол өгөөгүй байна. АВА/СЕЕЛ зэрэг гадаадын болон олон улсын байгууллагаас 2005 оны 9 сард гаргасан Шүүхийн шинэтгэлийн индекс үнэлгээнд үзүүлснээр “Гүрж улсын шүүхийн системийн үйл ажиллагаанд янз бүрийн доголдол, дутагдал гарч буйн нэг нь гүйцэтгэх засаглалаас шүүхэд үзүүлж буй хөндлөнгийн дарамт, шахалт бөгөөд энэ нь 2003 оноос хойш улам бүр нэмэгдсэн” гэжээ. Түүнчлэн судалгаанд оролцогчдын зарим

нь “Гүржид бие даасан, хараат бус нэг ч шүүх байхгүй” гэж хариулжээ.¹

2004 оныг хүртэл шүүхэд үндсэн хоёр төрлийн авлига гардаг байв. Шүүгч нэг бол хээл хахууль өгсөн хүний эрх ашигт нийцүүлэн шийдвэр гаргах ба, эсхүл гүйцэтгэх засаглалын байгууллагаас өгсөн зааврын дагуу шийдвэрээ гаргадаг байв. Энэ хоёр авлигын төрөл өөр хоорондоо нягт холбоотой. Учир нь шүүгчийн цалин хангамж амьдралд нь хүрэлцдэггүй бөгөөд засгийн газар энэ талаар ямар нэг арга хэмжээ авахгүйг тэд мэддэг; мөн засгийн газар шүүгчийг хээл хахууль авч байгааг мэдсэн ч хориглох арга хэмжээ авдаггүй учир нь шүүгч гүйцэтгэх засаглалын эсрэг шийдвэр гаргавал хожим түүний авлигын хэрэгт буруутган дарамтлах боломжийг олгодог.

2004 оноос эхлэн шүүгчийн цалин, хангамжийг нэмэгдүүлснээр шүүгч нь хамгийн өндөр цалинтай төрийн албан хаагч болсон ба хээл хахууль авах явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд шүүгчид тавих хяналтыг чангатгасан байна. Түүнчлэн 2004–2005 оны хооронд хэд хэдэн шүүгчийг хээл хахууль авсан хэргээр албан тушаалаас нь огцруулжээ.²

Энэ бүх арга хэмжээний үр дүнд шүүгчдээс хээл хахууль авах явдал ихээхэн хэмжээгээр буурсан ч шүүгчийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд гүйцэтгэх засаглалын байгууллагаас хууль бусаар хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх байдал гарсаар байв.³

Гүрж улсын хуульд заасны дагуу тус улсын Ерөнхийлөгч нь Шүүхийн дээд зөвлөлийн саналыг үндэслэн ердийн шүүхийн шүүгчийг томилдог.⁴ Шүүгчийн сонгон шалгаруулалтыг бичгийн болон аман шалгалтын хэлбэрээр зохион байгуулдаг ба бичгийн шалгалтыг олон асуудлыг хамарсан цогц байдлаар боловсруулж, зохион байгуулалт сайтай авдаг боловч эцсийн шат буюу ярилцлагыг ил тод бус, хаалттай, тогтсон нарийн шалгуургүй байдлаар явуулдаг. Энэ нь тухайн хүний мэдлэг, ур чадварыг үнэлэх бус танил тал, хувийн харьцаа болон улс төрийн байр сууринаас асуудалд хандах нөхцөлийг бүрдүүлдэг.

1 www.abanet.org/ceeli/publications/jri/jri_georgia.pdf

2 www.freedomhouse.org

3 2004 онд прокурорын байгууллагаас шүүхэд хууль бус дарамт үзүүлж байсныг АНУ-ын Төрийн Департаментээс мэдээлжээ. \Country records on human rights practices 2004 28 Feb 2005\ at www.state.gov/g/drl/rls/hrrpt/2004/41682.htm. Амнести интернэшнл мөн энэ байдалд санаа зовж буйгаа илэрхийлжээ. web.amnesty.org/library/Index/ENGEUR560022005?open&of_ENG-2U4

4 Шүүхийн дээд зөвлөл нь Ерөнхийлөгчийн удирдлаган дор ажилладаг, түүний зөвлөх байгууллага юм. 19 гишүүнтэй, үүнд: Дээд шүүхийн тэргүүн, парламентын эрх зүйн хорооны дарга, Хууль зүйн сайд, Ерөнхийлөгчөөс томилогдсон 2 гишүүн, Парламентаас \4 нь парламентын гишүүн\ томилогдсон 5 гишүүн, Дээд шүүхийн тэргүүний зөвлөмжөөр шүүхийн нэгдсэн хуралдаанаас үлдсэн 9 гишүүнийг сонгодог. Одоогийн санал болгож буй төслөөр бол Ерөнхийлөгчөөс шүүгчийг томилох ба харин шүүгчид ямар байгууллага сахилгын хариуцлага хүлээлгэхийг тусгайлан заах юм.

Шүүгчид хууль бусаар нөлөөлөх аргын нэг нь сануулахаас эхлээд шүүгчийг албан тушаалаас нь огцруулах хүртэлх сахилгын шийтгэл ногдуулах явдал юм. Саяхан Ердийн шүүхийн тухай хууль (Law on Common Courts)-д заасны дагуу “Хуулийг давтан зөрчсөн, илэрхий алдаа гаргасан тохиолдолд шүүгчийг албан тушаалаас нь огцруулж болно” гэсэн нэмэлт, өөрчлөлт орсон⁵ ба энэхүү хэт ерөнхий заалт нь Шүүхийн дээд зөвлөлөөс хэд хэдэн шүүгчийг сайн дураараа чөлөөлөгдөх хүртэл шахалт үзүүлэх, түүнчлэн Дээд шүүхийн хэд хэдэн шүүгчийг улс төрийн сэдэлтээр албан тушаалаас нь огцруулах үндэслэл болжээ.⁶

2005 онд анхан шатны шүүхүүдийг бүсийн шүүхүүдтэй нэгтгэх замаар шүүхийн бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт хийж, Шүүхийн дээд зөвлөлөөс олон шинэ хүмүүсийг шүүгчээр томилсон байна. Харин ингэхдээ тодорхой шалгуур ашиглахгүйгээр үл барам тайлбар өгөлгүй туршлагатай шүүгчдийг “Нөөцийн жагсаалт”-нд оруулж, туршлага багатай шинэ шүүгчдийг шүүгчээр томилж байсан байна. Хамгийн хачирхалтай нь туршлагатай шүүгчид ажилгүй байсаар байтал шүүхийн нийт орон тооны 1/3 нь багагүй хугацаанд хоосон байсан ба үүний уршгаар шийдвэрлэгдээгүй хэргийн тоо эрс өсчээ. Энэ нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд гүйцэтгэх засаглалын байгууллагаас хэрхэн хууль бусаар нөлөөлж байгаа гэх сэжиг, таамгыг улам нэмэгдэх болсоныг харуулж байна.⁷

Бас нэг жишээ бол Дээд шүүхийн тухай хууль (Law on the Supreme Court)-д орсон нэмэлт өөрчлөлт юм. Энэ нь шүүгчид 2005 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө сайн дураараа албан тушаалаасаа чөлөөлөгдвөл одоо авч буй цалинтай тэнцэх хэмжээний буюу 555.5 ам. долларын тэтгэвэр олгох тухай заалт юм. Тус заалтыг зарим шүүгчдийг тэтгэвэр, хангамж эдлэх эрхгүйгээр албан тушаалаас нь огцруулна хэмээн сүрдүүлэхэд ашиглаж байсан юм.⁸

Мэргэжил, ур чадварын зохих шаардлага хангасан боловсон хүчин, байр, техник хангамж болон санхүүгийн нөөц бололцоо хангалтгүй⁹ байгаа нь шүүхийн үйл ажиллагааг доголдоход багагүй хэмжээгээр нөлөөлдөг. Түүнчлэн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх явдал хангалтгүй¹⁰ байгаа бөгөөд үүнээс улбаалан жил ирэх тусам иргэдээс шүүхэд хандах байдал буурсаар байна. АВА\СЕЕЛ байгууллагын судалгаанд хамрагдсан Гүржийн иргэдийн тал хувь нь шүүхээр хэргээ шийдвэрлүүлэхгүй байхын төлөө боломжтой бүхнийг хийнэ гэжээ. Түүнчлэн шударга бус, найдваргүй шүүхийн үйл ажиллагаа нь гадны

5 Шүүхийн тухай хуулийн 1-р бүлгийн 2-р зүйлийн 1 дэх хэсэгт хэргийг шийдвэрлэхэд илэрхий алдаа гаргавал гэсэн заалт байдаг

6 www.ihf-hr.org/viewbinary/viewdocument.php?download_1&doc_id_6847

7 www.abanet.org/ceeli/publications/jri/jri_georgia.pdf

8 Georgian |Online \magazine 26 Dec 2005

9 www.abanet.org/ceeli/publications/jri/jri_georgia.pdf

10 Хэдийгээр шүүх гаргасан шийдвэрээ өөрөө хэрэгжүүлэх үүрэггүй ч түүнийг хэрэгжүүлэхгүй байх нь шүүхийн үйл ажиллагааны чанарт сөргөөр нөлөөлдөг.

хөрөнгө оруулалтыг татахад сөргөөр нөлөөлж байгааг дурьдах хэрэгтэй. 2004 онд татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан ба эдийн засгийн холбогдолтой маргааныг шүүхээс гадна арбитраар шийдвэрлүүлэхээр заажээ. Энэ нь шүүхээс төрийн эрх ашгийг илүү хамгаалж, түүний төлөө шийдвэрээ гаргадаг гэсэн бизнесийн байгууллагуудын шүүмжлэлтэй холбоотой юм. Харамсалтай нь ихээхэн хэмжээний мөнгөтэй холбоотой хэд хэдэн хэрэгт засгийн газар заргаа алдсаны дараа арбитрын шүүхийг татан буулгасан байна.¹¹

Олон улсын болон Гүржийн дотоодын иргэний нийгмийн байгууллагуудаас шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах талаар дорвитой арга хэмжээ авахыг засгийн газарт удаа дараа уриалсаар ирсэн. ТББ-ууд хамтран энэ тухай уриалга гаргасан. Үүний зэрэгцээ засгийн газраас Европын холбоо (ЕХ)-той нягт хамтран ажиллах, Европын зөвлөл болон ЕХ-ны хөрш орнуудын нэгдсэн шалгуурыг хангахаар хичээн ажиллаж байна. 2006 оны 5 дугаар сард Ерөнхийлөгч М. Саакашвили шүүхийн шинэтгэлийг хэрэгжүүлэх засгийн газрын комиссыг байгуулснаа зарлаж, засгийн газар шүүхийн системд хийх шинэтгэлийн асуудалд тэргүүн ээлжинд анхаарал хандуулахаа мэдэгдсэн байна. Тус комисст дотоод, гадаадын байгууллагуудын төлөөллийг оруулахаар төлөвлөсөн юм.¹²

Шүүхийн шинэтгэлийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан арга хэмжээнүүдийн цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд засгийн газраас эдгээрийн заримыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Үүнд:

- Шүүгчээс цаашид албан тушаалдаа үлдэх эсэхийг тодорхойлох нэгдсэн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах. Шүүгчийн албан тушаалд шинээр томилох үйл ажиллагааг ил тод болгох, шинэ залуу шүүгчийг мэргэшсэн, хараат бусаар ажиллах бололцоог хангах;
- Шүүгчийн нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулах замаар шүүгчээс хууль бус үйлдэл хийх, авлигад автагдах явдлаас урьдчилан сэргийлэх;
- Шүүхийн дээд сургууль (High school of Justice) буюу шүүхийн сургалтын төвөөс шүүгчдэд зориулж, чанартай сургалт, давтан сургалтыг зохион байгуулах, шүүгчийн мэдлэг, ур чадварыг шударгаар үнэлэх, шүүгчийн сургалтын хөтөлбөр, агуулгыг сайжруулах, сургагч багш нарын мэдлэгийг дээшлүүлэх, сургалтын төвийн материаллаг хангамжийг сайжруулах;
- Засгийн газраас тангарагтны шүүхийн хэлбэрийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хийх, юуны өмнө бодит хэрэгцээ, хэрэгжих боломжийг нарийн судлах;

11 2005 оны 4-р сард Татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг арбитрыг татан булгасан байна.

12 2006 оны 6 сарын байдлаар тус комиссоос хэрэгжүүлсэн дорвитой ажил алга байна.

- Шүүхэд хэргийг хэдэн жилээр хэлэлцдэг явдлыг халах, шүүгчдийн орон тоог нэмэх;
- Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг бодитой хангах зорилгоор хянагдаж байгаа хэргийн талаарх мэдээлэл, шүүхийн шийдвэр зэргийг олон нийтэд электрон/онлайн байдлаар хүргэх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна.

Засгийн газраас шүүхийн шинэтгэлийг бодитой зорилт дэвшүүлэн, ил тод болон хууль ёсны аргаар хэрэгжүүлж чадвал шүүхийн шинэтгэлийн хөтөлбөрийн үр дүн тогтвортой байж, удаан хугацаанд үргэлжилнэ. Холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулахдаа сонирхогч талуудын хууль ёсны оролцоог бүрэн хангах хэрэгтэй бөгөөд засгийн газраас шүүхийн системд хэрэгжүүлж буй шинэтгэлийн бодлогоо олон нийтэд танилцуулж, иргэдийн санал бодлыг сонсох нь чухал юм.

*Тамуна Каросанидзе ба Камрин
Кристенсен (ТИ, Гүрж, Тбилиси)*

Гана улсад компьютержсэн шүүхүүд хэргийг шуурхай шийдвэрлэж байна

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, мэтгэлцэх болон холимог зарчим
100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 0.9¹

Шүүгчийн цалигийн эхлэх хэмжээ: 5,290 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 8,488 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 450 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 17.4 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 3.2 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.5

Шүүхийн шийдвэрийг хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Үгүй

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Дэлхийн банк (2000)

3. Мөн тэнд

5. Гана дахь шүүхийн үйлчилгээ

2. Гана дахь шүүхийн үйлчилгээ (2006)

4. Дэлхийн банкны хөгжлийн үзүүлэлт (2005)

6. CIA Дэлхийн үйл явдлын товчоон (2005)

Ганад өргөдөл, гомдол гаргагчид, шүүхээр үйлчлүүлэгчид, хуульчид шүүх тогтолцоонд тархсан авлигын талаар гомдол мэдүүлж, тэдгээрийг нь мэдээллийн хэрэгсэлд нийтлэх нь олонтаа. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Кингсли Акуа энэ асуудал оршин буйг хүлээн зөвшөөрөөд, 2003 онд томилогдсоноосоо хойш шүүхийн шинэтгэлд анхаарлаа хандуулсаар ирсэн. 2005 оны 11 сард Аккрад болсон Ерөнхий шүүгчдийн 4 дэх удаагийн чуулган дээр, тэрээр авлига нь үндэсний хэмжээний асуудал болсоныг дурдаад, шүүгчдийг шүүмжилж буй явдлыг алдаагаа засах, авлигыг хяналтандаа байлгах гэсэн утгаар хүлээн авах ёстой гэж мэдэгдсэн.¹

Гана улсын хувьд Дээд шүүх нь Үндсэн хуулийг тайлбарлах, хэрэгжүүлэх мөн давж заалдах эцсийн шатны шүүх юм. Давж заалдах шүүх нь эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх 2 дахь шатны шүүх байна. Дээд шатны шүүх (high court нэртэй) нь эрүү, иргэний мөн хүний эрхтэй холбоотой хэргийг анхан шатны журмаар авч хэлэлцэнэ. Цэргийн дэглэмийн үед (1982-1988) байгуулагдсан бүс нутгийн “трибунал” нь төрийн эсрэг гэмт хэргийг авч хэлэлцэнэ. Эцэст нь анхан шатны шүүх байх бөгөөд энэ нь тойргийн шүүх, тойргийн трибунал, дүүргийн магистратын шүүх, дүүргийн трибуналаас бүрдэнэ.

1 Дээд шүүхийн дарга Кингсли Акуа, Аккра дахь Ерөнхий шүүгч нарын 4 дэх удаагийн чуулган (ШДЧ), 2005 оны 11 сарын 22, Гана улсын тмэдээ (Гана), 2005 оны 11 сарын 23. ghanareview.com/review/index.php?class_all&date_2005-11-23&id_12472 вэб хуудаснаас үзэх боломжтой.

Шүүхийн авлигыг судалж үзэхэд, өнөөгийн шүүхийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт нь шүүх хариуцлагатай тэр шаардлагын багахан хэсгийг л хангадаг. Өргөдөл, гомдол гаргагч давж заалдах шатанд хээл хахууль эс өгвөл авлигатай холбоотой доод шатны шүүхийн шийдвэрүүд нь өөрчлөгдөх боломжтой. Авлигын өөр нэгэн баримт: шийдвэрүүд нь байнга хүчингүй болдог шүүгч албан тушаал ахих боломжоо алдах эрсдэл болон хувирах тохиолдол бий. Тиймээс гомдол гаргагчийг давж заалдах боломжгүй болгохын тулд хянан шийдвэрлэх ажиллагааг хаах, түдгэлзүүлэх зэргээр эрх мэдлээ хэтрүүлдэг тохиолдол гардаг юм.² Өмнө нь шүүгчид өөрийн гаргасан шийдвэрийн чанараар үнэлгээ авч, албан тушаал ахидаг байв. Энэ нь илүү хүнд нийлмэл хэргийн шийдвэрийг үндэслэлтэй, оновчтой болгох нэгэн арга байсан. Харин одоо Дээд шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрээ бичгээр гаргадаггүй шүүгчид байдгийг олж мэдээд тэднийг үнэлэх шинэ аргыг танилцуулсан. Энэ нь албан тушаал ахих гэж буй шүүгч нь “шийдвэр боловсруулан бичих” шалгалт өгөх ёстой юм.³

Авлигын талаарх олон нийтийн төсөөлөл

Судалгаанаас үзэхэд олон нийт шүүхийн тогтолцоо авлигад автсан хэмээн дүгнэж байна. Дэлхийн банкнаас засаглалын талаар хийсэн судалгаанд оролцогчдын нилээдгүй (40 хувь) нь шүүх “ямар нэгэн байдлаар”, 39 хувь нь “маш их хэмжээгээр буюу бүхэлдээ” авлигад идэгдсэн гэж итгэж байгаагаа илэрхийлжээ. Харин шүүх эрх мэдэлтэй харьцуулахад, 80.2 хувь нь хууль тогтоох эрх мэдлийн байгууллага “дунджаас дээгүүр буюу ихэнхи нь” авлигаас ангид, 66.3 нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд мөн адил хэмээн итгэдэг байна. 2005 онд “Афробарометр” байгууллага төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх судалгаа явуулсан байна. Энэхүү судалгаагаар, шүүх нь хамгийн их итгэл алдсан институциер тодорч, үүний дараа 2002-2005 онд бага зэрэг ахиц гаргасан цагдаагийн байгууллагыг оруулжээ.⁴ Уг судалгаа нь, шүүхийн туслах ажилтнууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлийг түргэн бичих, хэргийн баримт бичгүүдийг зохих албан тушаалтанд шилжүүлэхэд бага хэмжээний мөнгө авдаг “захиргааны авлига”, мөн шүүгчийн шийдвэрт нөлөөлөх гадаад шалтгаан, дарамтууд болох “үйл ажиллагааны авлигыг” ялган үзээгүйг тэмдэглэх нь чухал билээ. Шүүхээр үйлчлүүлэгчид, тэдний өргөдөл, гомдол, бичиг баримтыг зохицуулж байгаа шүүхийн ажилтантай харьцахдаа “захиргааны авлига”-тай

2 Нэгэн шүүгч Христийн Апостолийн сүмийн эсрэг зарга мэдүүлэх гэж байсан хүнийг хориглосон захирамж гаргаж, хээл хахууль авсан тухай мэдээлэлд дурдсан байдаг. Тэр шүүгч гомдол гаргагчид давж заалдах боломжийг олгохгүйн тулд өөрийнхөө шүүн таслах ажиллагааны тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан. Ганы он цагийн товчоон (Гана), 2000 оны 6 сарын 21.

3 Гана улсын тойм мэдээ (Гана), 2005 оны 11 сарын 23.

4 Афробарометр ‘3 дахь үеийн судалгаа’ (2005). www.afrobarometer.org вэб хуудаснаас үзэх боломжтой.

тулгардаг бол шүүгчтэй ихэвчлэн өмгөөлөгчид харьцдаг учир “үйл ажиллагааны авлигыг” илрүүлэх, нотлох боломж хомс байдаг.

Авлигын эх сурвалжийг тодорхойлоход бэрхшээлтэй байдагийн тод жишээг шүүгч Антони Абадагийн хэргээс харж болно. Тэрээр 2004 оны 2 сард хээл хахууль авсан хэрэгт сэжиглэгдсэн боловч ял, шийтгэл хүлээгээгүй. Жарфро Ларкай хэмээх нэгэн түүний танил эр нэхэмжлэгчийн өмгөөлөгчид шүүгчийн нэрийг барьж, шүүгчээр “зөөлөн” шийдвэр гаргуулна хэмээн 5 сая (560,000 ам.доллар)-ын хээл хахууль өгөхийг шаардсан бөгөөд зуучлагчийн үүргийг гүйцэтгэж буйгаа мэдэгдсэн. Цагдаагийн байгууллагаас мөрдөн байцаах ажиллагаа явуулсны дараа, шүүгч Абада энэ талаар юу ч мэдээгүй бөгөөд ямар ч мөнгө аваагүйг тогтоож, харин Ларкай төрийн түшмэдэд хөндлөнгөөс нөлөөлөхөөр хээл хахууль авсаныхаа төлөө ял шийтгэл хүлээсэн байна.⁵

Зарим хэрэгт энэ нь илүү тодорхой харагдана. Жишээ нь, дээд шатны 2 шүүгч болох Боатэнг, Овусу болон шүүхийн нэгэн ажилтны хамт, хэсэг газрын маргаан шийдвэрлүүлэхээр өргөдөл өгсөн нэхэмжлэгчийн байршуулсан мөнгийг эскроу данснаас хулгайлсныхаа төлөө баривчлагдсан байна. Тэр 2 шүүгч нь тухайн мөнгөний хүүг хувийн ашиг сонирхолоор зарцуулсан шүүхийн ажилтныг дэмжсэн хэмээн буруутгагдсан. Шүүхийн зөвлөлийн Сахилгын хороо нь, уг хэргийг шалган үзээд уг хэргийг илт хулгайн хэрэг гэдгийг тогтоож эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар Ерөнхий прокурорт шилжүүлсэн юм. Прокурорын удирдлагаас дээрх 3 этгээдийг яллаж, Аккрагийн дээд шатны шүүхэд шилжүүлсэн бөгөөд энэ хэргийн шүүн таслах ажиллагаа үргэлжилж байна.⁶

Шүүн таслах ажиллагааг хялбаршуулах, үр дүнд хүргэх арга хэмжээнүүд

2000 онд шүүхийн үйл ажиллагааг шуурхай болгож, үр дүнг нь дээшлүүлэх хэд хэдэн арга хэмжээнүүдийн эхлэлийг тавьсан. 2005 онд Шинэчлэл, төслийн удирдлага ба шүүхийн үйлчилгээг хүргэх хэлтэс нь бүх шинэчлэлийн төслүүдийг хянан үзсэн. Шүүхийн зөвлөл нь шүүгчдийн ажиллах нөхцөлийг хянаж үзээд, төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай 50 тэрбум (5,6 сая ам.доллар)-ыг дараагийн төсвийн төсөлд оруулах хүсэлт гаргав.⁷

2003 оны 10 сард Шүүхийн үйлчилгээний Шалган байцаах, гомдол гаргагчдын хэлтэс байгуулагдан авлигатай холбоотой гомдлуудыг хүлээн авч эхэлсэн нь бага зэрэг нөлөө үзүүлсэн. 2003-2004 онд 3, 2004-2005 онд ердөө 4 гомдол хүлээн авчээ. Эдгээр нь, шүүхээс, ялангуяа орон нутгийн тойргийн шүүхээс, хэрэгтэнийг шүүхийн зардлыг нөхөн төлөхийг хууль бусаар шаардаж дарамталсан, мөн хэрэгт

5 www.ghanatoday.com 2004 оны 12 сарын 20

6 Дэйли График (Гана), 2005 оны 4 сарын 20. Сахилгын хороо нь мэдээллийг олон нийтэд хүргээгүй.

7 Шүүгч Нана Гямира Товэй, Магистратуудын хамтын нөхөрлөл ба Шүүгчдийн холбоо /МХНШХ/- ны хурал. Аккра. 2005 оны 7 сарын 31- 8 сарын 4

холбогдогч талуудыг шүүгч нар сүрдүүлж, дарамталсантай холбоотой гомдлууд байв. Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн үзэж буйгаар, шүүх эрх мэдлийг ингэж урвуулан ашиглаж байгаа нь хэргийн нөгөө тал тухайн ажлыг хариуцсан шүүхийн ажилтныг авлигад өртсөн хэмээн тодорхойлох нөхцөл болсон байж болох гэнэ.⁸

2005 оны 1 сард шүүгч, шүүхийн ажилтнуудын ёс зүйн дүрэм батлагдаж, шүүгчид, магистратууд шүүгчийн ёс зүйн сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулахаа Дээд шүүхийн Ерөнхий шүүгч мэдэгджээ. 1 сарын дараа Шүүхийн сургалтын институтыг шинээр байгуулах хөрөнгийг шүүхийн байгууллага хүлээн авсан ажээ.⁹

Үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх бусад арга хэмжээнүүд авагдсан бөгөөд, “шуурхай шалгах шүүх” нь хэргийг үүсгэснээс 3 сарын дотор шийдвэрлэж дуусгах, холбогдох баримт бичиг болон тэмдэглэлийг 24 цагийн дотор танилцах боломжтой болгох зорилготойгоор байгуулагдсан, зарим шүүхүүдэд электрон процессын ажиллагааг түршиж,¹⁰ 2005 оны 3 сард худалдааны шүүхийг байгуулсан.

Олон нийттэй харилцах нь

Шүүхийн авлигыг бууруулах дээрх шинэчлэлүүд амжилтанд хүрсэн эсэх нь нээлттэй хэвээр үлдлээ. Үр дүнгийн талаарх олон удаагийн хэлэлцүүлэг, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн сонордуулсанаар дээрх арга хэмжээнүүд нь ямар нэгэн байдлаар сайн нөлөө үзүүлсэн гэж үзэхэд буруутахгүй хэмээн дүгнэжээ. Вэб сайтаар шүүхийн талаарх мэдээллийг хүргэж, өргөдөл, гомдлоо хэрхэн гаргах тухай заавар өгч байна. Шүүхийн үйлчилгээний байгууллага нь 2004 оноос хойш жил бүр тайлангаа гаргаж танилцуулан,¹¹ Германы хөгжлийн агентлаг GTZ-ийн дэмжлэгтэйгээр “Шүүхийн ажиглалт”-ыг бий болгох мониторингийн төсөл хэрэгжиж байна.¹²

Хэдийгээр авлига үйлдсэн тухай баримтууд байдаг ч одоог хүртэл шүүхийн авлигыг амжилттайгаар мөрдөн шалгаж, шийтгэсэн практик байхгүй байна. Шүүгч Боатэнг, Овусу нарын хэрэг нь хойшлож, прокурорын эрүүл мэнд муу, “шүүхийн шинэ барилгын ажил” зэрэг шалтгаанаар өдийг болтол шийдвэрлэгдээгүй.¹³ Хэрэв уг хэрэг зөв шийдвэрлэгдвэл авлигатай тэмцэх үйлсэд өөрийн мөрөө үлдээж, улс төрийн хүсэл зоригийг өдөөх болно.

*Доминик Эйн (Нийтийн ашиг сонирхолын хуулийн төв),
Мехтилд Рюнгер (GTZ) ба Даниэль Батидам
(Ганийн шудрага ёсны нийгэмлэг, Аккра)*

8 Шүүгч Кингслэй Акуй, МХНШХ -ны хурал

9 www.judicial.gov.gh/publications/ICB_IPT_JTI.htm

10 www.judicial.gov.gh/court_automation/human_resources/home.htm

11 www.judicial.gov.gh/about_us/legal_year/home.htm

12 GTZ, ‘Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэхэд хөгжиж буй орнуудад туслах нь’, PN2004.2169.3. www.gtz.de/de/dokumente/en-uncac-pilot-activities.pdf

13 www.ghanatoday.com 2006 оны 1 сарын 17

Гватемала дахь шүүхийн авлига ба цэргийн уламжлал

Эрх зүйн тогтолцоо: Эрх газрын эрх зүй, мэтгэлцэх болон холимог зарчим
100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 5.9¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 15,360 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 42,396 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 2400 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 87.9 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 4.2 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 4.2

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

- | | |
|---------------------------------------|--|
| 1. Америкийн хууль зүйн сургалтын төв | 2. Гватемалагийн харьцуулсан эрх зүйн сургалтын институт |
| 3. Мөн тэнд | 4. Дэлхийн банкны хөгжлийн үзүүлэлт (2005) |
| 5. Конгрессын декрет, 2004 оны 35 | 6. Америкийн хууль зүйн сургалтын төв (2005) |

Хүний эрхийг хамгаалах талаарх шүүхийн тогтолцооны алдааны нэгэн төлөөс бол 1960-1996 он хүртэл зэвсэгт мөргөлдөөнд зовсон Гватемала юм.¹ Тус улсын Үнэнийг тогтоох хороо нь олон мянган хүний эрхийн зөрчилд мөрдөн байцаалт, шүүх хурал хийгдээгүй, хууль ёсны шийтгэл үгүй гэдгийг баталсанаар, эргэлзээгүй тодорхой болсон. Шүүхийн системийн сул дорой байдал нь шүүхийн ажиллагаанд бүхэлд нь сөрөг нөлөө үзүүлж байна. Авлигын хэргийг шийдвэрлэсэн нэг ч жишээ үгүй бөгөөд улс төрийн зүгээс авлигатай холбоотой хэргүүдийг буруушаасан нэг ч мэдэгдэл үгүй байна. Шүүхийн энэхүү асуудал нь зэвсэгт мөргөлдөөний цаг үед эхэлсэн бөгөөд энхтайвны гэрээнд шүүхийн тогтолцооны нэгдсэн шинэчлэлийг хийх талаар тусгасан. 1985 онд ардчилал ялснаас хойш олон нийтийн ухамсар шүүх, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа сул бөгөөд эрх мэдэлтэйд нь үйлчилдэг гэдэгт итгэсэн хэвээр үлдсэн. Дэлхийн банкны саяханы судалгаанд 70 хувь нь шүүхэд итгэхгүй байгаагаа илэрхийлж, шүүх нь зөвхөн ядуу хэсэгт хууль хэрэгжүүлж, “хоёр өөр байдлаар эрх мэдлийг” хэрэгжүүлдэгийг илрүүлжээ.²

- 1 Зэвсэгт мөргөлдөөний талаарх шинжилгээг Түүхийн шинжилгээний хорооны тайлангаас үзнэ үү (ТШХ), Гватемала: Чимээгүйн дурьдатгал (1999), shr.aaas.org/guatemala/ceh/mds/spanish/ вэб хуудаснаас үзнэ үү.
- 2 Гватемалагийн засгийн газрын хүсэлтээр, Дэлхийн банкнаас хийж, 2004, 2005 онуудад танилцуулсан “Гватемалагийн удирдлага, авлига, ил тод байдлын дүгнэлт”. Энэ нь хувийн компани, нийтийн албан хаагчид, өрхийн тэргүүн, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, ойлголтын талаарх үндэсний санал асуулгад тулгуурласан. www.comisionados.gob.gt/archivos/1138896134.doc

Шүүх сул байгаагийн нэгэн илрэл бол өнгөрсөн 10 жилд иргэдийн шүүх олноороо байгуулагдсан явдал юм. Зэвсэгт мөргөлдөөн илүү уршиг тарьсан бүс нутгуудад иргэд шүүхийн үйлчилгээг авахад хүндрэл учрах, процессын ажиллагаа сунжрах, ял шийтгэл оноохгүй байх зэргээс шалтгаалан шүүх эрх мэдлийг өөрсдийн аргаар хэрэгжүүлж байна. НҮБ-ын шалгалтанд дурьдсанаар, 1996-2002 онд 480, 2006 оны эхний 5 сард 32 линчийн шүүх ажиллагаа³ буюу гэм буруутай гэж үзсэн этгээдийг хохирогч өөрсдөө шийтгэж, дүүжлэх аргаар цээрлүүлсэн тохиолдол гарчээ.⁴ Цаазаар авах ял гүйцэтгэхийг уриалж байгаа тэдгээр хүмүүсийг энэ үйлдэлд нь мөрдөн шалгаж, гэм буруутайг нь тогтоосон жишээ байхгүй. Тухайн нутгийн уугуул хүмүүс болон бусад иргэдийн хоорондын хууль зүйн болон зан заншлын ялгаа маш их. Түүнчлэн “хууль зүйн” болон “хууль ёсны” гэсэн хоёр ойлголтын хооронд асар их зөрүү байх бөгөөд хууль ёс нь холимог эрх зүйн системийг (түүний дотор уламжлалт эрх зүйг) хүлээн зөвшөөрүүлэхээр оролдож, мөн зөрчлийг шийдвэрлэх шүүхийн бус, өөр арга замыг ашиглахыг чармайж байдаг.

Шүүхийн тогтолцоо нь Дээд шүүх (12 шүүгч), давж заалдах шатны шүүх (72 орон тооны, 48 орлогч шүүгч), анхан шатны (шүүх хуралдаан удирдан явуулах) болон ял оноох шүүгч нар (170), шударга ёсны (мөн л анхан шатны) шүүгчид (369). Дээд шатны шүүгчдийг Конгрессоос томилдог боловч, нэр дэвшүүлэх, чөлөөлөх асуудлыг зөвхөн шүүгч, шүүхийн ажилтнуудаас бүрдэх Шүүхийн мэргэжлийн зөвлөл эрхэлнэ.

Шүүхийн авлигын үр дагаварууд

Ардчилсан нийгэм дэх иргэний эрх, армийн чиг үүргийг бэхжүүлэхийн тулд шүүхийн авлигыг таслан зогсоох, түүнд нөлөөлөх бүтцийн хүчин зүйлүүдийг арилгахад чиглэсэн шүүхийн шинэтгэл нэн тэргүүний асуудал хэмээн Энхтайвны гэрээнд тусгасан. Холбогдох яамдын төлөөлөгчид, хууль зүйн мэдлэгтэй нийгмийн болон хувийн байгууллагуудын төлөөгчдөөс бүрдсэн үндэсний шударга ёсны хороо 1997 онд байгуулагдаж, шүүхийн шинэтгэлийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж байна. “Энхийн төлөөх шинэ шударга ёс” хэмээх сүүлийн тайландаа, шүүхийн бүтцэд багтах байгууллагуудыг бэхжүүлэх ба тэдгээрийн авлигын талаар онцлон тэмдэглэсэн.

Тайланд дурдсанаар шүүхийн авлигын дараах үндсэн шинжүүд байна:

- Шүүгч хэргийн оролцогчдод дарамт үзүүлэн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж, албан тушаалаа урвуулан ашиглах
- Хууль бусаар мөнгө шаардах

3 Эдгээр тоо баримтыг www.nd.edu/_cmendoz1/datos/ вэб хуудаснаас үзнэ үү.

4 Линчийн шүүхийн талаарх мэдээг 2006 онд www.prensalibre.com/pl/2006/mayo/08/141075.html сайтанд нэгтгэсэн.

- Хэрэг шийдвэрлэх ажиллагааг түргэвчлэх, процессын зарим арга хэмжээг авахын төлөө шан харамж, мөнгөн шагнал авах
- Процессын заавал хийгдэх ёстой арга хэмжээг хийхгүй алгасахын тулд төлбөр авах
- Хууль бусаар албан тушаалд томилох, хөндлөнгөөс нөлөөлөх
- Хэргийн баримт бичиг, материалуудыг үрэгдүүлэх
- Нотлох баримтыг үрэгдүүлэх буюу хуурамчаар үйлдэх, өөрчлөх, хураагдсан эд хөрөнгийг завших

Эдгээрээс олон нийтийн анхаарлыг татсан саяханы 2 тохиолдол буй. Нэг дахь нь шүүхийн ажилтан Мануэль Висент Монрой шүүгч Виктор Херрера Риосийн нэрийг барьж, хэрэгтэнийг суллана хэмээн хээл хахууль өгөхийг шаардсан хэргээр шүүхэд дуудагдсан.⁵ Дараах нь байнга тохиолддог жишээ болох хэргийн баримт бичиг үрэгдүүлсэн явдал байлаа. 2005 онд Ерөнхий прокурор асан Карлос дэ Леон Аргуэтагийн эсрэг хэргийг хянан шийдвэрлэж байх үеэр хавтаст хэрэг алга болсон, энэ мэт нь шүүхийн талаарх үнэлэмжийг бууруулдаг.

Авлигатай холбоотой хэргүүдийг шүүхийн сахилгын зөвлөл шалгах бөгөөд 3 гишүүний бүрэлдэхүүнтэй комиссоос гомдол гаргагчийн мэдүүлгийг авч, хуралдаанаар хэлэлцэж, хариуцлага ногдуулах эсэхийг шийдвэрлэнэ.⁶ Үүний гол дутагдал нь шүүхийн магистратууд, шүүгчид уг процессын ажиллагааг эрхлэн явуулж, ажил мэргэжил нэгтэндээ шийтгэл ногдуулах эсэхийг шийдвэрлэж байгаа нь хараат бусаар ажиллаж байгаа эсэхэд нь томоохон эргэлзээ төрүүлдэг. Байгуулагдсанаасаа хойш 2005 он хүртэл дээрх зөвлөл шүүгч, магистратуудын захиргааны шинжтэй үйл ажиллагаанаас үүдсэн авлигын тухай 3000 орчим гомдлыг хүлээн авсан.⁷ Албан ёсны мэдээгээр, дээд шатны шүүгчдээс илүүтэй шударга ёсны шүүгчид болон анхан шатны шүүгчидтэй холбоотой гомдлууд зонхилж байна.

Шударга ёсыг ганхуулагч өөр 2 байгууллага бол гүйцэтгэх эрх мэдлийн үүрэг хариуцлага хүлээж, авлигын нөхцөлийг бүрдүүлдэг, ял эдлүүлэх болон цагдаагийн байгууллага юм. Олон шоронгууд ялтануудын (зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүд, хар тамхины наймаачид, залуучуудын мара гэмт бүлэглэлийнхэн) хяналтанд байдаг. Конгресс чухал шаардлагатай байгаа, Шоронгийн тухай хуулийг 2 жилийн турш хэлэлцсэн боловч батлаж чадалгүй хойшлуулсан. Үндэсний цагдаагийн авлигын асуудал болон үйл ажиллагааны сул байдал нь мөн сэтгэл түгшээж байна. Сүүлийн 2 жилийн турш авлигад холбогдсон ажилтнуудыг өөрчлөх, тоног төхөөрөмж сайжруулах, хяналтын шинэ

5 Pensa Libre (Гватемала), 2006 оны 5 сарын 5.

6 Уг тоо баримтыг үндэсний шүүхийн шинжилгээ, баримт бичиг боловсруулах төвөөс үзэж болно./ҮШШБББТ/.www.oj.gob.gt

7 Pensa Libre (Гватемала), 2005оны 10 сарын 1.

систем, цалин хөлсийг нэмэгдүүлэх зэрэг эрчимтэй шинэчлэл эхэлсэн боловч өдийг хүртэл тодорхой үр дүнд хүрсэнгүй.

Шүүх ажиллагааг улс төржүүлэх нь

Олон улсын хуульчдын хорооны 2005 онд хийсэн судалгаагаар улс төржсөн шүүх нь сэтгэл түгшээсэн асуудлын нэг гэж тодорхойлсон. Дээд болон доод шатны шүүгчдийг сонгох механизмд уг асуудал илэрнэ. Үндсэн хуульд, шүүхийн нэр дэвшүүлэх хорооноос санал болгосон нэр дэвшигчдээс Конгресс нь Дээд шүүх болон давж заалдах шатны шүүгчдийг томилно гэж заасан боловч практикт томилгооны процесс бүхэлдээ улс төржсөн байдаг.⁸ Хэдийгээр нэр дэвшигчдийн жагсаалт олон нийтэд ил байдаг боловч, нэр дэвшигчдийн авсан саналын тоо, комиссын гишүүдийн өгсөн санал, саналууд үндэслэлтэй эсэх, олон нийтийн санал бодлыг тооцож үзсэн эсэх зэрэг нь тодорхойгүй байдаг.

Нэгэн онцлон тэмдэглэх асуудал бол нэр дэвшүүлэх хороо хуралдахад, гишүүд нь нэр дэвшигчдэд үнэлгээ өгөх арга зүйн стандарт байдаггүй явдал юм. Өмнөх туршлагыг тусгаагүй, олон нийтийг оролцуулаагүй, нэр дэвшигчийг сонгох талаарх мэргэжлийн зөвлөгөөг авалгүйгээр шинэ журмын төсөл боловсруулав.

Энэ нь, НҮБ-ын шүүхийн хараат бус байдлын үндсэн зарчимд тусгасан шаардлагууд болох “хөндлөнгийн оролцоо, дарамт, шахалт, сүрдүүлэг болон хэн нэгнээс, ямар нэг шалтгаанаар шууд болон шууд бусаар нөлөөлөх” явдлаас ангид байж хэргийг шийдвэрлэх баталгаа үгүй болохыг харуулна. Зарим шүүгч нар, түүний дотор Дээд шүүхийн шүүгчид хэрвээ тэд нар албан тушаалдаа үлдэхийг хүсвэл, зарим нэг хэргүүдийг хэрхэн шийдвэрлэх “заавар” авах болдог тухай ярьсан байна.⁹

Мирна Макын хэрэг

2002 онд Хууль зүйн салбарын авлигатай тэмцэх хороо нь ил тод байдлыг нэмэгдүүлэх, шүүхийн авлигатай тэмцэх стратеги, бодлогыг боловсруулах чиг үүрэгтэйгээр байгуулагдав. Тус хороо нь авлигыг бууруулах, албан тушаалтнуудад авлигын хор уршигийг таниулах байгууллага хоорондын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулсан боловч олон нийтийг татан оролцуулах ажлыг муу зохион байгуулж, үр дүн нь зөвхөн тодорхой хүрээнд л илэрсэн. Иргэний нийгмийн зүгээс бусад оролдлогуудыг хийж байна.

8 Хамгийн сүүлийн Дээд шүүхийн шүүгчийг сонгосон талаар www.elperiodico.com.gt/look/article.tpl?IdLanguage_13&IdPublication_1&NrIssue_89&NrSection_1&NrArticle_3463 www.elperiodico.com.gt/look/article.tpl?IdLanguage_13&IdPublication_1&NrIssue_95&NrSection_1&NrArticle_3707; вэб хуудас болонс Prensa Libre (Гватемала), 2004 оны 9 сарын 29. сэтгүүлээс тус тус үзнэ үү.

9 Гватемала дахь шударга ёс,

Шүүхэд тулгараад буй бэрхшээлийг арилгах ажлыг орчин үеийн төвшинд хүргэх шинэ сонирхол бий болов. Конгресст нэгэн хуулийн төслийг хэлэлцүүлэхээр оруулсан бөгөөд түүнд, шүүхийн ажиллагааны явцад олонтаа тохиолдох шүүгчийн эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах, үндсэн хууль зөрчсөн үйлдлүүд болон шүүгдэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэн тусгасан.¹⁰ 1990 оны 9 сард хүн судлаач Мирна Макийг хөнөөсөн хэрэгт сэжиглэгдээд буй цэргийн тусгай тасгийг шүүх ажиллагааг 3 жилийн турш ямар нэгэн байдлаар саатуулсан 12-оос доошгүй шийдвэрүүд гаргаж, тэднийг хаацайлсан хэмээн үзэж Интер Америкийн хүний эрхийн шүүхээс шударга, хараат бус, хууль ёсоор ажиллах шүүхээр шүүлгэх ёстой хэмээн шахалт үзүүлсэн.

Өнгөрсөн хэдэн жилүүдэд авлигыг бууруулж, ил тод байдлыг дээшлүүлэхэд анхаарч, шүүх илүү нээлттэй болж байна. Мөн зарим нэгэн дэвшил гарсан боловч авлига нь албан тушаалтантай холбоотой, цалингийн төвшин, дотоод хяналт, хариуцлага сул, ашиг сонирхлын зөрчилтэй, өргөн тархсан шинжтэй байгаа тохиолдолд шинэчлэл хийгдэх боломж муутай.

Шударга ёсны хорооноос гаргасан зөвлөмжүүд нь үйл ажиллагааны чиглэл болох боловч Гватемала нь олон улсын авлигын эсрэг конвенцид нэгдсэний дараа тэдгээр зөвлөмжүүдийг өөрийн нөхцөлд тохируулан боловсруулах нь зүйтэй. Авлигын төвшинг бууруулах гол зөвлөмжүүд бол:

- Орчин үеийн шаардлагад нийцүүлэх: Санхүүгийн нөөцийг зөв хуваарилах, авлига үйлдсэн, эрх мэдлээ хэтрүүлэн сүрдүүлсэн хэргүүдийг зөв шийдвэрлэх
- Мэргэшүүлэх: Шүүхийн сургалтыг боловсронгуй болгох, албан тушаал дэвших зөв тогтолцоог бүрдүүлэх
- Хууль зүйн үйлчилгээний хүртээмж: Зөрчлийг шийдвэрлэх шүүхийн бус, өөр арга механизмыг хөгжүүлэх, маргааныг шийдвэрлэх өөр хэлбэрийг хүлээн зөвшөөрөх
- Үр дүн: Шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрх, шүүх хуралдааныг мэтгэлцээний үндсэн дээр амаар явуулдаг болгох

*Карлос Мэлгар Пенья
(Акция Чигуададана, Гватемала хот)*

10 www.congreso.gob.gt/archivos/iniciativas/registro3319.pdf.

Энэтхэгийн шүүхийн хойрго байдал

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, мэтгэлцэх болон холимог зарчим, холбооны улс

100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 1.3¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 3,996 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 7,992 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 720 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 45.3 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 125.3 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.04

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Бүрэн бие даасан

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Эрүүгийн шүүхийн тогтолцоог шинэчлэх хорооны тайлан (2003 оны 3 сар)

2. indiabudget.nic.in/ub2006-07/bag/bog4-2pdf 3. Мөн тэнд. 4. Дэлхийн банкны хөгжлийн үзүүлэлт (2005)

5. indiabudget.nic.in/ub2006-07/bag/bog4-2pdf 6. Мөн тэнд

Хэдийгээр Энэтхэгийн Үндсэн хуулинд шүүхийн хараат бус байдал, хариуцлагатай байдлын талаар зохицуулсан байдаг боловч авлига байсаар байна. Саяханы 2 шийдвэр үүний баталгаа болно. Нэг дахь нь 2002 оны Гужарат хотын нийтийг хамарсан үймээнтэй холбоотой хэргийн Дээд шүүхийн шийдвэр бөгөөд энэ нь засгийн эрхэнд буй намтай холбоотой хүний хэргийг шүүх шийдвэрлэхээс зайлсхийдэг болохыг харуулсан.¹ 2 дахь нь, 1999 онд залуу бүсгүй Жессика Лалыг хөнөөсөн 9 хүний хэрэг бөгөөд, хэдийгээр энэ гэмт хэрэг нь олон гэрчийн нүдний өмнө үйлдэгдсэн ч 2006 онд шийдвэрлэхээс татгалзсан. Хэрэгт сэжиглэгдэж буй хүний нэг нь улс төрчийн хүү байв.

Энэтхэгийн шүүхийн тогтолцоо нь Дээд шүүх, мужийн төвшин дэхь дээд шатны шүүх, түүнд харьяалагдах дүүргийн болон орон нутгийн шүүхээс бүрдэнэ. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, 25 шүүгчид нь Ерөнхийлөгчөөс томилогддог. Дээд шүүх нь шаардлагатай тохиолдолд Ерөнхийлөгчийн хүсэлтээр зөвлөх үүрэгтэй ажиллана. Дээд шатны шүүхүүд харьяалах доод шатны шүүхүүдийн албан тушаалд томилох, дэвшүүлэх болон захиргааны асуудлыг хариуцна. Дээд шүүх болон дээд шатны шүүхийн шүүгчид зөвхөн импичментийн журмаар парламентаар

1 Захира Хабибула Шейх Гужарат мужийн эсрэг, 2004 AIR SCW 2325; 2004 (4) SCC 158. www.frontlineonnet.com/fl2111/stories/20040604003029700.htm

хэлэлцүүлж огцорно. Бүх шатны шүүхийн шийдвэрийг Дээд шүүх хүртэл шатанд нь давж заалдаж болно.

“Мөнгөний эрх мэдэл”

Авлига нь 2 төвшинд илэрдэг. Нэг нь шүүхийн ажилтнуудтай холбоотой, нөгөө нь хууль зүйн бүхэл тогтолцоон дахь авлига юм. Хэдийгээр тодорхой тохиолдол гардаг нь ойлгомжтой боловч Энэтхэгийн дээд шатны шүүхүүдийг харьцангуй цэвэрт тооцож болно. Шүүх ажиллагаа нь нээлттэй бөгөөд бичиг баримтуудын үнийг төлж хуулбар авах боломжтой. Сэжигтэн нь холбогдох баримт бичгийн бүх хуулбарыг үнэ төлбөргүй авах эрхтэй. Захирамжуудыг эх хувиас нь хуулбарлан хадгалах ёстой. Давж заалдах, хяналтын тогтолцоогоор аливаа алдааг залруулах үр дүнтэй системтэй.

Хууль зүйн нийт байгууллагуудын авлига нь тогтолцооны шинжтэй. Шүүхийн туслах ажилтнууд, прокурор, мөрдөн байцаагчид шүүхийн ажиллагааны явцад бичиг баримт боловсруулахад албан тушаалаа урвуулан ашиглах магадлал өндөр. Энэ нь хууль, шүүхийн тогтолцоон дахь олон чиг үүргийг хэрэгжүүлэх ажилд сөрөг нөлөө үзүүлж байна. “Эрүүгийн шүүх мөнгөний хүчинд захирагдаж байна” хэмээн Дээд шүүхийн шүүгч асан В.Р. Кришна өгүүлсэн байдаг.

Хэвлэл, мэдээллийн судалгааны төвөөс олон нийтийн дунд доод шатны шүүхүүдийн авлигын талаарх ойлголт, тохиолдлын талаар 2005 онд хийсэн судалгаанаас үзэхэд, ажил бүтээлгэхийн төлөө хээл хахууль өгөх шаардлагатай гэжээ.² 12 сарын хугацаанд ойролцоогоор P26,300,000 (580 сая орчим ам.доллар) хээл хахуульд өгсөн гэсэн тооцоо буй. Мөнгийг дараах хувиар тооцож өгсөн. Үүнд: 61 хувийг өмгөөлөгчид, 29 хувийг шүүхийн ажилтнуудад, 5 хувийг шүүгчдэд, 5 хувийг зуучлагч нарт тус тус өгсөн.

Итгэл буурсан нь

Авлигаас үүддэг үндсэн хор уршиг бол хэргийг шийдвэрлэхээс татгалзан хойшлуулах, шүүгчид дутагдалтай, процессын нарийн түвэгтэй, ойлгомжгүй байдал зэрэг бүгд шинээр маш олон хууль гардагаас шалтгаалсан асуудлууд байдаг.

2006 оны 2 сарын байдлаар Дээд шүүхийн 26 шүүгчид 33,635 хэрэг, дээд шатны 670 шүүгчид 3,341,040 хэрэг, 13,204 анхан шатны шүүхүүдэд 25,306,458 хэрэг тус тус шийдвэрлэгдээгүй байна. Эдгээр хуримтлагдсан хэргүүдийн ачаалал, хэргийг шийдвэрлэх ажиллагааг урт хугацаагаар сунжруулж, ажиллагааг түргэвчлэхийн тулд хэргийн оролцогчид мөнгө өгөхөд хүргэдэг.³ “Хэрэг шийдвэрлэх өнөөгийн

2 Энэтхэгийн ТИ нь мэдээллийн хэрэгслийн судалгааны төвд судалгаа хийх ажил даалгасан (2005).

3 Хиндустриан Таймс (Энэтхэг), 2006 оны 3 сарын 19

хурдаар бол, дахин хэрэг нэмэгдэхгүй тохиолдолд 350 жилийн дараа хуримтлагдсан хэргүүдийг шийдвэрлэж дуусна”⁴ гэсэн тооцоо 1999 онд гаргасан байна.

1 сая хүнд 12-13 шүүгч ногдож байгаа нь, АНУ-д 107, Канадад 75, Их Британид 51 шүүгч 1 сая хүнд ногдож байгаатай харьцуулахад маш доогуур байна.⁵ Хуримтлагдсан хэргүүдийг шүүгчдийн тоонд хуваан үзвэл, Дээд шүүхийн шүүгч тус бүрт 1,294, дээд шатны шүүгч тус бүрт 4,987, доод шатны шүүгч тус бүрт 1,916 хэрэг тус тус ногдоно. Сул орон тоо энэхүү хүндрэлтэй байдлын нэгэн шалтгаан мөн. 2006 оны 3 сард Дээд шүүхэд 3, дээд шатны шүүхэд 131, доод шатны шүүхэд 634 орон тоо тус тус эзэнгүй байв.⁶ Шүүгчид энэ их тооны шийдвэрлээгүй хэрэгтэй байтлаа хэргийг хойшлуулах шийдвэр гаргасаар байгаа бөгөөд хүмүүс “үйлчилгээ түргэвчлэх мөнгө”-ийг өгөхөд хүргэнэ.

Хэргийн шийдвэрлэлт удаашрах болон авлигын төвшин нь шүүхийн системд хардалтыг үүсгэсэн. Энэ үл итгэх байдал нь холбогдох хуулийн нөлөөг бууруулах сөрөг үр дагаварыг бий болгоно. Хүмүүс дөт арга замыг эрэлхийлж хээл хахууль, шан харамж, шагнал өгөх, дайлах зэргээр хууль бус үйлдэл хийхэд хүрдэг. Нэгэн энгийн жишээ бол Энэтхэгийн хотууд дахь хууль бус, зөвшөөрөлгүй барилгууд юм. Барилгын болон аюулгүй ажиллагааны тухай хуулийг эрх мэдэлтнүүд үл тоомсорлоно. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч асан Ж.С Анандын өгүүлсэнээр: “Хэргийг хойшлуулах нь хуулийн хүчийг сулруулж, нийгэмд гэмт хэрэг үйлдэж шүүхийн бус замаар асуудлыг шийдвэрлэдэг, нийгмийг бүхэлд нь гэмт явдалд татан оруулах явдлыг өөгшүүлж байна... Шуурхай шүүх бол энэхүү өвчний цорын ганц эмчилгээ мөн.”⁷

Шинэтгэл хэрэгжүүлэх зөвлөмжүүд

Шүүхийн авлигатай тэмцэх шинэтгэлийг хэрэгжүүлэхийн тулд, түүнд нөлөөлөх хууль зүйн болон шүүхийн үйл ажиллагааны харилцаан дахь бүх хүчин зүйлс, түүний дотор мөрдөн байцаах агентлагууд, прокурорын газар, шүүх, өмгөөлөгчид, шоронгийн захиргаа, нотлох баримт, нотолгоотой холбогдох хуулиудыг тооцон үзэх нь чухал. Эдгээр асуудлын талаар Эрүүгийн шүүхийн тогтолцоог шинэчлэх хороо буюу Малиматын хорооны 2003 оны тайланд тусгасан бөгөөд түүнээс гаргасан зөвлөмжүүд нь өдгөө хүртэл үнэ цэнээ алдаагүй байна. Зарим арга

- 4 Энэтхэгийн ТИ болон Лок Севак Сангхийн, Нью Делид 1999 оны 12 сарын 18-19 нд зохион байгуулсан “Энэтхэгийн шүүхийн тогтолцоон дахь авилга, хэрэг хойшлуулах явдал ба Шүүхийн шинэчлэлтэй холбоотой асуудлууд” гэсэн сэдвээр хийсэн конференци, хурлын тайлангаас.
- 5 Эрүүгийн шүүхийн тогтолцоон дахь шинэчлэлийн хороо (‘Малиматийн хорооны тайлан’) (Банглогор:Дотоод хэргийн яам,2003 оны 3 сар).
- 6 Хиндустириан Таймс (Энэтхэг), 2006 оны 3 сарын 19
- 7 Letter to the Prime Minister of India on 7 April 2005 Энэтхэгийн Ерөнхий сайдад 2005 оны 4 сарын 7 нд бичсэн захидал, Өмнөд Азийн улс төр, цуврал. 5, дугаар. 1 (2006)

хэмжээ нь шүүхийг шинэчлэхэд голлох нөлөөг үзүүлсэн бол зарим нь шүүхийн тогтолцоог бүхэлд нь шинэчлэхэд дам нөлөө үзүүлсэн.

- Шүүгчдийн тоог нэмэгдүүлэх: Шүүхийн албан тушаалтнуудын тоог нэмэгдүүлээд зогсохгүй, өнөөгийн сул орон тоог яаралтай нөхөж, хэрэг нэмэж хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх ёстой. Дээд шүүхээс, одоогийн 1 сая хүнд 12 шүүгч ногдож буй төвшнөөс ирэх 5 жилийн дотор 1 сая хүнд 50 шүүгч ногдох хэмжээнд хүргэх нь зүйтэй гэсэн санал оруулсан.⁸ Мөн тус шүүх нь холбооны болон мужийн төвшинд дээд шатны болон харьяалах шүүхүүдийн сул орон тоонд шүүгчдийг гүйцээн томилоход үйл ажиллагаагаа чиглүүлж байна.⁹
- Шүүхийн хариуцлага: Шүүхийн хариуцлагын талаар хоосон ярианууд буй боловч түүнийг хангах үр дүнтэй механизм бүрдээгүй. 2003 оны Үндсэн хуулийн нэмэлтийн дагуу, Шүүгчдийг томилох 2006 оны хуульд, алдаа гаргасан шүүгчид бага хэмжээний шийтгэл ногдуулах эрх үндэсний шүүхийн хороонд олгогдсон байхаар тусгасан.¹⁰
- Шүүгчийн ёс зүйн дүрэм: 1999 онд Энэтхэгт болсон шүүхийн Ерөнхий шүүгч нарын бага хурал дээр “Шүүгчийн зан үйлийн үнэт зүйлсийн товчоон” нэртэй шүүгчийн ёс зүйн дүрмийг дээд шатны шүүхээс санал болгосон.¹¹ Уг бичиг баримтанд гэр бүлийн гишүүд оролцвол сонирхлын зөрчлийг хэрхэн шийдвэрлэх тухай, бэлэг өгөх, дайлах, хөрөнгө босгох, хандив цуглуулах үед хэрхэн ажиллах талаар тусгасан. Бангалорын зарчмыг 2002 онд баталсан боловч шүүх үүнийг эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болгоход дэмжлэг үзүүлээгүй, санаачлага гаргаагүй байна.
- Шүүхийн хэргийн бүртгэлийн удирдлага: Шүүхийн бүртгэлд шинэ технологийг танилцуулан зарим амжилт олж байгаа бөгөөд Дээд шүүх 1998 оноос хойшхи хэргүүдийг төрөлжүүлж, ижил тайлбар шаардлагатайг нь эмхтгэсэн. Засгийн газраас 2005 оны 10 сард Дээд шүүхийн шүүгч Ж. С. Барукагийн удирдлагад ажиллах Электрон-Хороог байгуулж өгсөн бөгөөд энэ нь шүүхийн мэдээлэл түгээх системийг компьютержуулах 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Мөн уг хороо нь 2,500 шүүхийн цогцолборуудыг компьютержуулан, 15,000 орчим шүүхийн ажилтнуудыг зөөврийн компьютерээр хангаж, шүүхийн ажилтнуудад шинэ технологийн сургалт явуулах болно. Түүнчлэн шинэ болон шийдвэрлэж буй хэргүүдийн өгөгдлийн санг байгуулж, автомат бүртгэлтэй болгож, хуулийн номын сан, шүүхийн архивыг тоон системд шилжүүлнэ. Уг хороо нь Дээд болон дээд шатны шүүхүүдэд видео-конференци хийж, шүүгдэгчийн бүртгэлийг

8 Бүх Энэтхэгийн шүүгч нарын холбоо ба зарим хүмүүс Энэтхэгийн холбооны эсрэг, 2002 (4) SCC 247.

9 Трибун (Энэтхэг), 2006 оны 4 сарын 6.

10 Энэтхэгийн мэдээ (Энэтхэг), 2006 оны 3 сарын 7

11 Шүүгч Р. С. Лахоти, ‘Шүүгчийн ёс зүйн дүрэм’, Үндэсний шүүхийн академи, дугаар. 5 (2005). nja.nic.in

тоон системд шилжүүлэх тул түүнийг мөрдөх ажиллагааг сунгахад шүүх дээр дуудах шаардлагагүй болно. Видео-конференцоор дамжуулан гэрчийг зайнаас шалгах ажиллагааг гүйцэтгэнэ.¹²

- Шинээр томилох: Одоогийн байдлаар нийтийн үйлчилгээний хороо нь мужуудын хувьд доод шатны шүүхийн албан тушаалд томилох ажлыг хариуцаж байна. Нийт улсын төвшинд, сонгох шалгуур өндөртэй “Бүх Энэтхэгийн шүүхийн үйлчилгээ”-ний байгууллагыг бий болгох нь зүйтэй.¹³ Энэ талаар 1992 онд Дээд шүүхийн тогтоолд тусгаж байсан боловч доод шатны шүүхийн чанарыг сайжруулах талаар дорвитой алхам хийгдээгүй.¹⁴
- Санхүүгийн болон захиргааны эрх хэмжээ: Шүүхийн наад захын хэвийн үйл ажиллагааг хангах санхүүгийн боломжгүй, төсвийн дутагдал их. Шүүхийн барилга, түр саатуулах байр, хуралдааны танхим, гэрчийг тусгаарлах өрөө, бүртгэлийг компьютерт оруулах, бичиг баримтаар хангах гэх мэт олон зүйл нь зохистой бус санхүүгийн нөөцөөс шалтгаалан шаардлага хангахгүй байна. Шүүх нь маш чухал чиг үүрэгтэй субъект боловч төсөв, санхүүг нь хууль тогтоох байгууллага хянаж, гүйцэтгэх эрх мэдэл зарцуулж байдаг юм. Шүүх төсөв, хөрөнгөө зарцуулах ямарч эрх хэмжээгүй. Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн бичсэнээр “Дээд шатны шүүхүүд нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрхтэй боловч санхүүгийн эрх үгүй, цаашлаад анхан шатандаа нэг ч шүүгчийн эсхүл туслахын орон тоо бий болгох захиргааны эрх үгүй, түүнчлэн шүүхийн барилга барих газар хүсэх, худалдан авах, шүүхийн үйл ажиллагааг шинэчлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх эрхгүй байдаг.”¹⁵

Энэтхэгийн ТИ, Шинэ Дели

-
- 12 Шүүгч Ж. С. Барука ‘Энэтхэгийн шүүхэд мэдээлэл, харилцааны технологийг нэвтрүүлэх нь’, Үндэсний шүүхийн академийн сонин, цуврал. 2, дугаар. 2 (2005).
 - 13 Хэдийгээр энэхүү заалт нь Үндсэн хуулийн 42 дахь нэмэлтээр /312 –р зүйл/ 1977 онд орсон боловч, харахан хэрэгжээгүй байна.
 - 14 Бүх Энэтхэгийн шүүгчдийн хэрэг AIR 1992 SC 165.
 - 15 Үндэсний шүүхийн академийн сонин

Израилийн Дээд шүүх: өөрсдийн санаагаа хэрэгжүүлсээр л

Эрх зүйн тогтолцоо: Эрх газрын болон заншлын эрх зүй хосолсон, мэтгэлцэх болон олон талт зарчим

100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 9.01¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 4,155 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 6,612 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 18,620 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 45.1 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 62.1 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.07

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шат хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүгчид сахилгын хариуцлага ногдуулах байгууллага: Бүрэн хараат бус

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм (Батлах ажиллагааны эцсийн шатанд буй)

1. Статистикийн төв газар /2005/ 2. Хууль зүйн яам /2006/ 3. Мөн тэнд
4. Дэлхийн банкны хөгжлийн үзүүлэлт (2005) 5. Санхүүгийн яам /2006/ 6. Мөн тэнд

Израилийн шүүхийн тогтолцоонд системчлэгдсэн шинжтэй авлига байхгүй боловч, зарим хэргүүдийг зөв шийдвэрлэхгүй байх, улс төрийн зүгээс чухал хэргийн шийдвэрүүдэд нөлөөлөх нь шүүхэд итгэх итгэлийг сулруулж байна.¹

2005 онд, Шүүгчдийн омбудсманаас шүүхийн ажилтнуудын авлигатай холбоотой нэг ч гомдол хүлээн аваагүй гэж мэдэгдсэн.² Хээл хахууль өгөх нь ховор, шүүхийг улс төрөөс тусгаарлах механизм ажилладаг. Хэдий тийм боловч, шүүхийн хараат бус байдалд нөлөөлөх цөөн хэдэн хязгаарлалт бий. Нэгд, Шүүгчийг сонгох хорооны 9 гишүүний 4 нь улс төрчид байдаг. Хоёрдугаарт, сүүлийн 10 жилийн хугацаанд, Дээд шүүх рүү дайралт хийх, түүний маргаан бүхий хэргүүдийн шийдвэрийг шүүмжлэх улс төрчид нэмэгдэж байгаа.

Дээд шүүхийн тэргүүн асан Ахарон Баракийн үед дээд шүүхийн эрх мэдэл нэлээд өссөн.³

1 Израилд шүүхийн авлигын талаар хэлэлцсэн цөөн тохиолдол байдаг.

2 Ха'арез (Израил), 2005 он 11 сарын 20

3 Сайжруулалт, жишээг Ривка Амадогийн 'Нийтийн үйлчилгээний томилгоо, хяналт шалгалт, тэнцвэрт байдал: Чиг хандлагын харьцуулалтанд Израилийн туршлага', Нийтийн захиргааны мэдээ, цуврал. 61 (5) (2001); ба Дапни Барак Эрез, 'Улс төрийн талаарх шүүхийн шүүмжлэл: Израилийн асуудал', Эрх зүй болон нийгмийн сэтгүүл, цуврал. 29 (4) (2002).

Баракийн үед Дээд шүүхээс, жагсал цуглааныг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх ямарч хязгаарлалтгүй байсан цагдаагийн эрх хэмжээг хязгаарлаж, алан хядах үйл ажиллагаанд оролцогчдыг мөрдөн байцаахад бие махбодийн дарамт үзүүлэхийг хориглож, “нууц хадгалах” гэдэг ойголтын эрх зүйн үндэслэлийг шалгасан. Тэрээр, Палестинаас “тусгаарлах хана”-ны хэрэг хэмээн нэрлэгдэх болсон хэрэгт хамгаалалтын бүсийг нийгмийн олон янзын ашиг, сонирхол бүхий хэсгүүдэд оршин суух хүмүүст хор уршиг учруулахгүй байхаар өөрчлөн тогтоохыг засгийн газарт үүрэг болгосон. Мөн түүнчлэн, армиас хөршөөр нь дамжуулан орон гэрийг нь сүйтгэх гэж байгаа тухай мэдээлдэг “хөршийн ажиллагааг” хүчингүй болгосон. Барак нь өндөр албан тушаалтнуудтай холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй хэргийг мөрдөн шалгах, яллах ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.⁴

Энэхүү бие даасан байдал нь эсэргүүцэлтэй тулгарч байлаа. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд засгийн газар шүүхийн байгууллагуудыг улс төржүүлэхийг оролдож байсан бөгөөд нэгэн дуулиантай хэрэг бол Ерөнхийлөгч асан Беньямин Нетаньяху, Рони Бар Онийг Ерөнхий прокуророор⁵ томилох оролдлого хийсэн нь гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс шүүхийн хараат бус байдалд нөлөөлөх гэсэн мөн шүүгчдийн ёс зүйн алдаа гаргаж байгаа зэргийг ашиглан Дээд шүүхэд итгэх итгэлийг унагах гэсэн оролдлого байв. Харин Дээд шүүх хатуу чанд ёс зүйн дүрэм шинэчлэн баталж хариу барьжээ.

Шүүхийн сахилга батыг улам бүр сайжруулах нь

Шүүхийн шийдвэрийг өөрчилсөн авлигын хэргийн нотлох баримт олоход хэцүү ч гэсэн хувь хүмүүсийн мэдээлж буйгаар шүүхэд үл итгэх байдлыг төрүүлэх тохиолдлууд байдаг. Зарим шүүгч нар өөрсдийн ургийн хүнээ туслахаараа томилох, дээд шатны шүүгчид болон өмгөөлөгчдийн хоорондын гэр бүлүүдийн холбоо, шүүхийн системд ажиллах гэр бүлийн хос, засгийн газрын хууль зүйн зөвлөлийн гишүүдийн төрөл садны хүмүүс Барын холбоо (хуульчдын)-нд ажиллах зэрэг ураг төрлийн хэлхээ холбоо, цус ойртолт нь анхаарал татсан нэгэн асуудал мөн.⁶

Ёс зүйтэй холбоотой зарим асуудал бий. 2005 оны 8 сард Шүүгчдийн сахилгын трибун нь, магистрат Хила Кохенийг шүүх хуралдааны тэмдэглэлийг буруу үйлдэж, шүүхийн бичиг баримт устгасан хэмээн буруутгасан. Дээд шүүхийн 3 шүүгчийн 2 нь, ажлаас нь чөлөөлөх сануулга өгөх нь зүйтэй гэж үзэв. Дээд шүүхийн дарга Ахарон Барак, түүнийг ажлаасаа өөрийн санаачлагаар чөлөөлөгдөх ёстой хэмээсэн санал дэвшүүлсэнийг Кохен эсэргүүцсэн бөгөөд энэ нь олон нийтийн хүчтэй

4 Баракийн шүүхийн талаарх санаачлагууд ба баримтуудын талаар Ха'арез (Израил), 2006 оны 9 сарын 1; ба Едиот Ашаронот (Израил, 2006 оны 9 сарын 1)-оос үзнэ үү

5 Дэлгэрэнгүй мэдээллийг Amadogoос үзнэ үү.

6 Ха'арез (Израил), 2005 он 10 сарын 10

эсэргүүцэлтэй тулгарсан.⁷ 2005 оны 12 сард Шүүгчдийн сонгох хороо түүнийг санал нэгтгэйгээр огцруулав.⁸ 2005 оны 8 сард Ерөнхий прокуророос шүүгч Оснат Алон-Лоферийг нөхрөө өөртөө үнэнч эсэхийг тодруулахын тулд хувийн мөрдөгч хөлсөлсөний төлөө шүүхэд хэргийг нь шилжүүлсэн. Уг хэрэгтэй холбогдуулан Алон-Лоферийг утасны ярианы бичлэгийг хууль бус аргаар олж авсан хэмээн хариуцлага ногдуулжээ.⁹

Алон-Лофер хууль зөрчсөн байж болох ч, бичлэгийг хууль бусаар олж авсан гэдгийг нотлох баримт үгүй. Иймэрхүү тохиолдлууд нь шүүхэд итгэх итгэлийг сулруулах бөгөөд шүүгчид олон нийтийн итгэлийг хүлээхийн тулд илүү нарийвчилсан зохицуулалт хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч 2004 онд шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсруулсан. Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн мэдэгдсэнээр, шүүгчийн зан үйлийн горим нь өнгөрсөн хугацаанд заншил, ерөнхий үнэлэмж, уламжлал, туршлага дээр тулгуурлаж байсан бөгөөд албан ёсны буюу бичмэл хэм хэмжээнүүд үгүй байв. Харин одоо тэдгээр зан үйлийн горимуудыг албан ёсоор бичиж, цогц ёс зүйн дүрмийг батлах нь зүйтэй.

Шүүгчийг татгалзан гаргах асуудлыг илүү боловсронгуй, нарийн шалгууртай болгох хэрэгтэй

Ялангуяа өмнө нь холбоо бүхий хууль зүйн товчоо хэргийн нэг тал болж оролцсон тохиолдолд, Дээд шүүхээс 2005 оны 11 сарын 24-нд илүү боловсронгуй мэргэжлийн шалгуурын талаарх бодлогыг танилцуулсан.¹⁰ Дээрх шийдвэрийг гаргахад хүргэсэн хэрэг бол, Сломо Наркис болон Изайх Волдхорн нарын хоорондох 500,000 орчим ам.долларын төлбөрийн асуудал бөгөөд саяхан дүүргийн шүүх шийдвэр гаргасан. Наркис давж заалдсан бөгөөд тус шүүхээс шийдвэрийг хэрэгжүүлэхийг хойшлуулах тухай захирамжласан. 2005 оны 6 сард Волдхорн тус шүүхийн шийдвэр нь хууль бус, нөгөө талд үйлчилсэн хэмээн гомдол гаргасан. Волдхорны өмгөөлөгч нь шүүгч Сара Дотан өмнө нь хэрэг хэлэлцэх үеэр уг төлбөр нь маргаангүй гэж мэдэгдэж, нөгөө талд үйлчилж байгаагаа харуулсан хэмээжээ (Энэ нь шүүгч аль хэдийн Наркисийн талд орсон гэсэн утгатай). Волдхорны мэдэгдэж буйгаар, шүүгч Дотан ба Наркисын өмгөөлөгч Ишай Бэт-Он нарын хооронд төрөл садангийн холбоо байгаа бөгөөд Бэт-Он нь олон хэрэгт Дотаны хүүг өмгөөлөн оролцож байжээ.

Дээд шүүхээс шүүгчийн татгалзан гаргахад хангалттай сонирхлын зөрчилтэй байсан байна гэж шийдвэрлэсэн. Бэт-Оны тухайн хэргийн хууль бус оролцоо

7 Ха'арез (Израил), 2005 он 12 сарын 12

8 Иерусалим Пост (Израил), 2005 оны 12 сарын 2

9 Ха'арез (Израил), 2005 он 8 сарын 30

10 Изайх Волдхорн, Сломо Наркисийн эсрэг, CP 6332/05, 2005 оны 11 сарын 24 (хэвлэгдээгүй).

дэндүү их байсан ч шүүхэд дуудагдаагүй. Тэрээр Наркисыг төлөөлөн хэрэгт оролцож давж заалдахад хүргэсэн бөгөөд давж заалдах өргөдлийг Бэт-Он бичсэн гэж үзэж болно. Уг хууль зүйн товчооны нэгэн ахмад хуульч Наркисыг мөн төлөөлж байсан бөгөөд түүний мэдээлснээр, Бэт-Он нь мэргэжлийн үйлчилгээний төлбөр хэмээн 100,000 гаруй ам.доллар авчээ. Эдгээр нөхцөлийн үндсэн дээр Дээд шүүх нь, шүүгч Дотаныг нэг талд илүү үйлчилж, хөндлөнгийн байх шаардлагыг биелүүлээгүй гэсэн хардлага бий болгосон хэмээн тодорхойлжээ. Дээд шүүхээс уг шийдвэр нь нэг талд үйлчилсэнийг нотлохгүй бөгөөд харин мэргэжлийн шаардлагад харшлах хангалттай сонирхлын зөрчил буйг онцлон тэмдэглэсэн.¹¹

Бичмэл ёс зүйн дүрэм

2006 оны 7 сард Кнессет (парламент)-ээс Шүүхийн тухай хуулинд нэмэлт оруулсан бөгөөд уг хуулиар Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид шүүгчийн ёс зүйн багц дүрмийг тодорхойлох, тэдгээр дүрмийг үүрэг болгох, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлэх эрх мэдлийг олгосон.¹²

Дүрмийн төслийг Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Барадын томилсон тусгай хороо боловсруулсан бөгөөд шүүгчдийн мэргэжлийн болон хувийн амьдралын хэм хэмжээг тусгасан. 3 дахь бүлэгт нь, мэргэжлийн шаардлагад тавигдах сонирхлын зөрчлийг зохицуулсан. Дараах 15 үндэслэл байвал шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцохыг хориглохоор тусгажээ. Үүнд:

- Хэргийн оролцогчдын аль нэг тал буюу тэдгээрийн төлөөлөгч, эсвэл хэргийн чухал гэрч нь шүүгчийн гэр бүлийн гишүүн бол,
- Хэргийн оролцогчидтой ураг төрлийн холбоотой байж болох бусад бүх тохиолдолд,
- Шүүгч болон түүний гэр бүлийн гишүүд хэргийн ажиллагаа, түүний үр дүнд санхүүгийн сонирхол буй бол,
- Шүүхэд томилогдохоос өмнө тухайн хэргийн төлөөлөгч, арбитр, туслалцаа үзүүлэгч, гэрч, зөвлөгч, шинжээчээр оролцож байсан бол,
- Шүүхэд томилогдохоос өмнөх тухайн хэргийн аль нэг тал буюу чухал гэрч нь шүүгчийн үйлчлүүлэгч байсан бол,
- Тухайн хэрэгт оролцсоноос хойш, 5—аас дээш жилийн хугацаа өнгөрөөгүй бол,
- Хамт ажиллаж байсан шүүгч нь 5 жилийн дотор тухайн хэргийн аль нэг талын өмгөөлөгчөөр оролцохоор бол,

11 Мөн тэнд

12 news.walla.co.il/?w_/942842

- Хэргийн аль нэг талыг төлөөлж буй өмгөөлөгч нь, шүүгчийн ажил хэрэг болон шүүгчийн гэр бүлийн аль нэг гишүүдийг төлөөлж, өмгөөлж байсан бол,
- Шүүгчийн төрөл садны хүн нь уг хэрэгт оролцож буй хууль зүйн товчооны өмгөөлөгч, ажилтан, эсхүл хувь нийлүүлэгч (partner) бол

Уг ёс зүйн дүрэм нь шүүгч, хэвлэл мэдээллийн хоорондын харилцааг тусгайлан зохицуулсан. Үүнд шүүгч нь, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөхөөс илүүтэйгээр гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг сайтар боловсруулж, тайлбарлахыг зөвлөмж болгосон. Түүнчлэн, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарах тохиолдолд Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс зөвшөөрөл авч байхыг шаарддаг болсон.

*Дорон Навот
(Израилийн ТИ, Тель Авив)*

Кенийн шүүх дахь “эрс шинэчлэл”

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, мэтгэлцээний болон олон талт зарчим (Исламын эрх зүйн элементүүд бүхий)

100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 0.2¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: Мэдээлэл авагдаагүй

Дээд шүүхийн шүүгчийн цалин: Мэдээлэл авагдаагүй

Нэг хүнд ногдох ҮНБ: 530 ам.доллар²

Шүүхийн жилийн төсөв: 26.8 сая ам.доллар³

Жилийн нийт төсөв: 7.0 тэрбум ам.доллар⁴

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.4

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1 Кения таймс (Кения) 2006 оны 8 сарын 29 2 Дэлхийн банкны хөгжлийн үзүүлэлт (2005)
3 2005 -2006 оны төсөв. 4 Мөн тэнд

Шүүх нь авлигад идэгдэж, гүйцэтгэх эрх мэдлээс үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцож байх үед, 2002 онд Ерөнхийлөгч Мвай Кибаккийн тэргүүлсэн Үндэсний Солонго эвсэл (ҮСЭ) засгийн эрхэнд гарсан. Кенид ардчиллыг бэхжүүлэх өргөн хүрээтэй ажиллагааны нэгэн хэсэг болсон шүүхийн шинэчлэл хэрэгтэй байгаа бөгөөд засгийн газар уг арга хэмжээг авах болно хэмээн амлаж ялалт байгуулсан билээ. Гэвч хэлэх, хийхийн хооронд нилээдгүй зөрүү гарсан. Гэсэн хэдий ч олон нийт авлигын төвшин буурсан гэж үздэг, харин хуульчид уг асуудал оршсоор байна гэж үздэг.¹

Судалгаа, санал асуулгууд олон нийтийн итгэлийг алдруулж буй шүүхийн тогтолцоон дахь хүчин зүйлсийг тэмдэглэсэн. Тэдгээр мэдээллийн дагуу, тус улсын хамгийн их хээл хахуульд идэгдсэн 10 байгууллагын 6 дугаарт хээл хахууль дэлгэрсэн шүүх байгууллага жагсжээ. Цагдаагийн байгууллагийн үйл ажиллагаа нь хээл хахууль дэлгэрэх шимтэй хөрс болж байна.²

1 Уг үнэлэмжийн талаар Кени дахь Олон улсын хуульчдын нийгэмлэгийн хийсэн судалгаанаас. ‘Шүүхийн шинэтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үзүүлэлтүүд: Кенийн шүүхийн талаарх олон нийтийн үнэлэмж’ (Найроби: ОХН (Кения), 2001).

2 www.tkenya.org/documents/Kenya%20Bribery%20Index%202006.pdf

“Эрс шинэчлэл” нь шүүхийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлнө

1998 онд Квочийн хороо³ гэгдэх Шүүхийн хороо шүүгчийн ёс зүйн дүрэм болон олон чухал арга хэмжээнүүдийг санаачилсан боловч тэдгээрийн олонхи нь хэрэгжээгүй. 2002 онд Кени дахь Олон улсын хуульчдын нийгэмлэг (ОХН) нь Хамтын нөхөрлөлийн орнуудын хуульчдаас баг бүрдүүлж шүүхийн хараат бус байдлын талаар шалгалт хийхийг хүссэн бөгөөд шалгалтын тайланд шүүгчийн ёс зүйтэй холбоотой хэргийг шалгах ажиллагааны шуурхай, үр дүнтэй механизмыг санал болгосон.⁴

ҮСЭ нь “эрс шинэчлэл” гэж нэрлэгдэх шинэчлэлийн хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн нь, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч асан Бернард Чунгаг огцроход, 23 шүүгч, 82 магистратын эрхийг түдгэлзүүлж, авлигатай холбогдуулан шалгахад хүргэсэн байна. Энэхүү үйлдэл нь олон нийтийн дэмжлэгийг хүлээж, шүүхийн авлигыг таслан зогсоох нэгэн нотолгоог харуулж чадсан юм. Гэвч “эрс шинэчлэл” нь зарим шалтгааны улмаас шүүмжлэлд өртсөн.

Нэгд, үндсэн хуулийн баталгаа болох шүүгчид насан туршдаа томилогдох, мөн олон улсын шүүхийн хараат бус байдлын зарчим болох шүүгчийг хэрэгт холбогдуулан шалгах эхний шатанд, эсвэл түүний хүсэлт гаргаснаар уг хэргийг нууцлах ёстой гэсэн зүйл, зарчмуудыг зөрчсөн.⁵ Зарим шүүгч тэдний эсрэг үйл ажиллагаа явуулсан гэдгийг мэдээгүй, тэдэнд өөрсдөд нь мэдэгдээгүй. Сэжигтэн дээд шатны шүүхийн шүүгч Даниэль Анганияаа сахилгын асуудал хэлэлцсэн хуралдаанд (трибуналд) мэдүүлэхдээ, зөвхөн сонины мэдээн дээрх жагсаалтанд түүний нэр байгааг л охиноосоо сонсжээ.⁶

Шүүгчдийг түдгэлзүүлэх ажиллагаа дэндүү богино хугацаанд, зохих зөвшөөрөлгүйгээр явагджээ. Уг ажиллагаанд олон улсын шүүгчдийг албан тушаалаас нь огцруулахад хэрэглэгддэг хүлээн зөвшөөрөгдсөн туршлагыг ашиглаагүй байна. Хоёрт, сэжигтнээр татагдсан шүүгчдийн оронд одоо ажиллаж буй, эсвэл гэрээгээр ажиллах шүүгчдийг томилж байгаа нь шүүхийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлнө. Гуравт, шүүхийн ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, шүүхийн албаны зөвлөлийн хараат бус байдлыг дээшлүүлэх зэрэг шүүхийн шинэчлэлийн онц чухал хэсгүүдийг анхааралгүй орхигдуулсан.

3 Шүүхийн захиргааны хороог тэргүүлэх давж заалдах шатны шүүгч Ричард Квоч (өдгөө чөлөөнд гарсан)

4 www.icj.org вэб хуудаснаас уг тайланг үзэж болно.

5 НҮБ-ын шүүхийн хараат бус байдлын талаарх үндсэн зарчмууд, www.unhchr.ch/html/menu3/b/h_comp50.htm

6 Дэйли Нэйшн (Кения), 2006 оны 8 сарын 18.

Шүүхийн томилгоо

Хэдийгээр шүүгчдийг томилох эрхийг Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгосон байдаг ч Шүүхийн албаны зөвлөлтэй зөвшилцөх шаардлагатай. Харин шүүхийн албаны зөвлөл нь Ерөнхийлөгчөөс томилогддог Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор, Давж заалдах шатны нэг шүүгч, нийтийн албаны зөвлөлийн дарга зэрэг албан тушаалтнуудаас бүрдэнэ. Нэгэнт шүүгчид болон зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгч томилох болсноос хойш гүйцэтгэх эрх мэдлээс, шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох боломж бий болсон.

Квочийн хороо, гагцхүү мерит (нэр дэвшигчийн ур чадвараар өрсөлдүүлэх) тогтолцоон дээр суурилсан илүү нарийн, боловсронгуй томилох ажиллагааны журмыг санал болгосон. Засгийн газраас шүүгчдийн томилгооны механизмд Кенийн хууль зүйн нийгэмлэг (КХН)—ийн хяналт болон зарим гадны этгээдийн зөвшилцөх эрх бүхий оролцоог хангахаар оролдсон. Гэвч, уг оролцоо нь Дээд шүүхийн болон КХН—ний дарга нарын хоорондын хувийн харилцааны асуудал байх болно. Тэдгээрийн хоорондын зөвлөгөөн, уулзалт, тэндээс гарсан шийдвэрүүд нь нийтэд мэдээлэгдэхгүй. Хохирогчдыг хамгаалах хороо⁷ нь нэр дэвшигчдийг нягтлан шалгаад, тэдгээрийг олон нийтэд танилцуулаагүй болохыг тогтоосон. Зарим хүмүүс томилгоог “сайн хийгдсэн бөгөөд урьдынхаасаа илүү нээлттэй байдлаар явагдсан” гэж байхад зарим нь парламентын оролцоог хангаагүй нь илүү нээлттэй хянан шалгах боломжгүй болгосон гэж үзэж байна.

Томилгооны процесс нь “эрс шинэчлэлийн” нэгэн хэсэг байлаа. 2002 оны сонгуулийн дараа шүүхийн шинэчлэлийн төлөөх улс төрийн шахалт эрчимжсэн бөгөөд засгийн газарт, шүүхийг шуурхай цэвэрлэх шаардлага байгааг харуулах шаардлагагүй болсон байна. Энэ үйл ажиллагаа нь шүүхийн хараат бус байдлын баталгааг алдагдуулж, гүйцэтгэх эрх мэдлийн нөлөөнөөс ангид байх зарчмыг анхааралгүйгээр явагдсан. Шинэ шүүгчдийг үүрэг гүйцэтгэгчээр томилсны дараа шүүгчийг бүх насаар нь томилж баталгаажуулах болон шүүхийн тогтолцооны хараат бус байдал бүхэлдээ анхаарал шаардсан асуудал болон босч ирэв.

Хяналт, сахилгын хариуцлага тооцох механизм

Магистратуудын сахилгын болон ёс зүйн хэм хэмжээг сахиулах сахилгын хариуцлага тооцох гол механизмыг Шүүхийн албаны зөвлөл хэрэгжүүлэх боловч, шүүгчдийн сахилгын асуудлыг хариуцахгүй. Үндсэн хуульд зааснаар, шүүгчийн чадвартай холбоотой асуудал илэрсэн тохиолдолд, шүүгч албан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх бөгөөд, Ерөнхийлөгчөөс томилсон трибунал (маргаан шийдвэрлэх зөвлөл) нь уг хэргийг хянан шалгана. Иймэрхүү ад хок (ad hoc) буюу зөвхөн тухайн асуудлыг шийдвэрлэхээр байгуулагдсан трибунал нь “эрс

7 Хохирогчдыг хамгаалах хороо нь засгийн газрын агентлаг бөгөөд сахилгын хороонд шилжүүлэхээс өмнө өмгөөлөгчдөд гаргасан гомдлыг шалгах эрх бүхий байгууллага юм.

шинэчлэл” бодлогын хүрээнд, дээд шатны болон давж заалдах шатны шүүгчдийн авлига, зохисгүй үйлдэлтэй холбоотой хэргийг шалгах аар томилогдож байсан ажээ.

2005 онд ард нийтийн санал асуулгаар олонхийн дэмжлэг авч чадаагүй Үндсэн хуулийн төсөлд, шүүгчтэй холбоотой хэргийг шүүн таслах эрхийг шүүхийн албаны зөвлөлд өгсөн. Гэвч, нэгд, зөвлөлийн гишүүдийн ихэнхи нь шүүгч нар байх, хоёрт, байнгын ажиллагаатай ажлын албагүйгээс шалтгаалан уг онц эрхийг хэрэгжүүлж чадахгүй байна.⁸

Шүүхийн албаны зөвлөлийг гүйцэтгэх эрх мэдэл,⁹ Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс¹⁰ хараат бус байлгаж, зөвлөлийн даргын албан тушаалд хараат бус хүнийг томилох ёстой. Түүнд шүүгчийн ёс зүйг сахиулах эрхийг олгох нь шаардлагатай. Түүнчлэн, хуульчдаас шүүгчийн зохисгүй үйлдэлтэй холбоотой гомдлыг олон нийтээс хүлээн авах, хэлэлцэх, албан үүргээ хэрэгжүүлэх хугацааг тодорхойлох, зөвлөх эрхийг олгох нь зүйтэй хэмээжээ.¹¹

Кенийн Авлигатай тэмцэх хороо (КАТХ) байгуулагдсан явдал нь шүүхээр зогсохгүй бусад байгуулагуудын гадаад хяналтын механизмыг хөгжүүлэхэд нэгэн алхам болсон. КАТХ-д авлигын хэргийг шалгах өргөн эрх мэдэл олгогдсон. Гэхдээ яллах эрх мэдлийг нь Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхий прокурор эдэлнэ. Шүүхийн авлигатай тэмцэх КАТХ-ны стратеги тодорхойгүй. Энэ нь шүүхийн бүртгэлийн ажилтантай холбоотой авлигын хэрэг дээр илэрсэн. Засгийн газрын байгуулсан шүүх цөөн хэдэн хэрэг дээр ажилласан нь, хэдийгээр засгийн газрын мэдэж байгаагаар өөрийнх нь байгууллагууд авлигад идэгдсэн байгааг ч, энэ хэргийг шуурхай шийдвэрлэх үүднээс тодорхой санаачлага байгааг харуулж байна.

2003 онд батлагдсан Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмээр шүүгчийн ёс зүйн асуудлыг зохицуулдаг бөгөөд төрийн албан хаагчид нь хөрөнгө, орлогоо мэдүүлж байх ёстой боловч шүүгч, сайд, парламентын гишүүд бусад албан тушаалтнууд хөрөнгө, орлогоо нийтэд мэдээлээгүй.

8 Дээд шүүхийн дарга шүүхийн албаны зөвлөлийг тэргүүлнэ.

9 Кенийн Үндсэн хуулийг хянан хэлэлцэх хорооноос үүрэг болгосны дагуу Кени дахь ОХН нь хараат бус шүүхийн албаны зөвлөлийг санал болгож, түүний гишүүдийн талаар шинэ Үндсэн хуульд, 5 жилийн хугацаагаар томилогдон, нэг удаа улиран ажиллахаар тусгасан.

10 Уг үндэслэлийн талаар Альберт Камунде, ‘Шүүхийн албаны зөвлөлийг бэхжүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх нь’ бүтээлдээ тодорхой тусгасан, Кенийн шүүхийн шинэчлэл 1998–2003, Мбака (2004)

11 Уг байр суурийн талаар Кени дахь ОХХ –ны “Шүүхийн хараат бус байдал, авилга ба шинэчлэл” (Женев: ОХХ, 2005) –д тусгагдсан.

Шүүгчдийн хэргийг мөрдөн шалгах трибунал

2003 оны 2 сард Ерөнхийлөгч Кобаки, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Бернард Чунгаг авлигатай холбогдуулан шалгах зөвлөл (трибунал) томилогдсон. Чунга албан тушаалаасаа татгалзаж, Ерөнхийлөгч Эванс Гичеруг түүний оронд томилсон. Дараагийн сард нь шинэ Дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүхийн захиргааны асуудлыг шийдвэрлэх хороо байгуулж, түүний бүрэлдэхүүнд шүүгч Аарон Рингерагаар тэргүүлүүлж, авлигын талаар мэдээлэл цуглуулах, шалгах дэд хороог байгуулсан. Мөн тус дэд хороо нь шүүхийн авлигын шалтгаан, нөхцөлийг тодруулах, авлигыг илрүүлэх стратегийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх, сахилгын зөрчлүүдийг илрүүлэн шалгах үүрэгтэй. Рингерагийн тайлан хэмээн нэрлэгдэх хорооны дүгнэлтэнд, Давж заалдах шатны 9 шүүгчийн 5 нь, 36 дээд шатны шүүгчийн 18 нь, 254 магистратын 82 нь тус тус авлигад холбогдсон гэж мэдээлжээ.¹² Олон шүүгч, магистратууд албан тушаалаасаа татгалзаж, “тэтгэвэртээ гарсан” байна. Үлдсэнд нь, Ерөнхийлөгч Кобаки 2 трибунал томилж, нэг нь дээд шатны нөгөө нь давж заалдах шатны шүүхийн авлигын хэргийг хариуцан шалгах болжээ. Засгийн газар, нэг трибуналаар олон шүүгчийн хэргийг шалгуулсан, үүнд нь прокурорын газарт буюу гүйцэтгэх эрх мэдлийн албан тушаалтан уг трибуналд нь голлох чиг үүрэгтэй оролцсон зэргээр шүүмжлэлд өртөж, засгийн газрыг өөртэйгээ эн “тэнцүү эрх мэдлийг шалгасан” гэж буруутгасан байна.

Шүүхийн шинэчлэл дахь улс төрийн нөхцөл

Шүүхийн бүртгэл дахь хээл хахуулийн тухай мэдээ нь, шүүхийн тогтолцоонд авлигыг дахин сэргэж байгааг харуулж байна. Гол асуудал нь засгийн газраас үүнтэй тэмцэх алхам хийгээгүйд оршино. 2003 оны 10 сард КХН нь, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн удирдлагад ажиллах, шүүхийн авлигыг шалгах хороог байгуулсан бөгөөд уг хорооны бичиг баримтад цаашид шалгах ёстой шүүгч нарын нэрсийг жагсаасан.

2005 онд Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ёс зүй, удирдлагын зөвлөлийг томилсон. Уг зөвлөлийг Давж заалдах шатны шүүгч Волтер Онянго Отиено тэргүүлж шүүхийн авлигатай холбоотой хэргүүдийг шалгаж эхлээд, иргэдийн гомдлыг хүлээн авч, 2005 оны 9 сард ажлаа дуусгаад, олон нийтэд ажлын үр дүнгээ хараахан танилцуулж амжаагүй байна.

Трибуналы ажиллагаа үр дүнгүй болов. 4 жилийн дараа ганц хэрэг шийдвэрлэсэн нь шүүгчийг цагаатгах шийдвэр байв. Улс төрийн дэмжлэг замхран алга болж, трибуналын байх эсэхийг хариуцах хүнгүй болжээ. Шүүгчийг огцруулах ажиллагааг хурдасгах тэрэг мэт санаж байсан тэдний ажил 4 жил хүртэл сунжрав. Трибуналын зарим гишүүд нь үүргээ гүйцэтгэж байсан шүүгчид байсан бөгөөд тэд эхэн үедээ зорилгодоо анхаарлаа дээд зэргээр хандуулж байсан. Үүний дараа

12 Жишээг news.bbc.co.uk/1/hi/world/africa/3195702.stm вэб хуудаснаас үзнэ үү.

анх хийж байсан ажилдаа (шүүгчийнхээ) буцаж томилогджээ. Энэ нь трибуналын цаашдын ажиллагаа нэгэнт үгүй болсоныг илтгэн харуулж байна.

Урагшлах арга замын талаарх зөвлөмжүүд

- 2003 оноос эхэлсэн “эрс шинэчлэл” ямар нөлөө үзүүлсэн болохыг шинжлэн үзэх шаардлагатай. Зарим хүмүүс уг ажиллагаа нь, шүүгчдийн тогтвортой ажиллах баталгааг алдагдуулж, зөвхөн сөрөг нөлөө үзүүлсэн гэдэг. Шүүхийн ажилтнуудыг зөвхөн үндсэн хуулинд заасны дагуу, шударга, зохистой ажиллагааны дараа огцруулж болно. Сэжигтнээр татагдсан шүүгчийн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх ёстой бөгөөд ямар нэгэн байдлаар хойшлуулж үл болно.
- Ёс зүйн дүрэмд, авлига болон ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдлийг хянах, үр дүнтэй ажиллах дотоод механизмыг тогтоож өгдөг. Гэвч шүүхийн ажилтнуудын ёс зүйн асуудлыг шийдвэрлэхэд томоохон хүчин зүйл болох уг дүрмийн хэрэгжилт муу байв. Бусад төрийн байгууллагуудын адил, шүүхэд ч мөн уг дүрмийг хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа хөрөнгө, орлогын мэдүүлгээ өгөх үүргийг заавал биелүүлэх ёстой.
- Шүүхийн шинэчлэлд сөргөөр нөлөөлж буй Үндсэн хуулийг боловсруулах ажил удааширсан байдлыг шуурхайлах нь зүйтэй. Үндсэн хуулийн төсөл, өнгөрсөн жилийн ард нийтийн санал асуулгаар олонхийн санал авч чадаагүй тул хүчингүй болсон. Кени дахь ОХХ нь, Үндсэн хуулийн төсөл хойшилсон тул, Шүүхийн болон хууль зүйн тогтолцооны талаарх 13-р бүлгийг тусад нь салган авч хуулийн төсөл болгон парламентаар яаралтай хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн.
- Шүүгчийг сонгон шалгаруулах ажилд дорвитой хувь нэмэр оруулахын тулд шүүхийн албаны зөвлөлийн бүтцэд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Барын холбооноос чухал арга хэмжээнүүдийг санал болгосон бөгөөд, тэдгээрт шүүхийн ажилтнуудын ёс зүйн асуудалтай холбоотой иргэдийн гомдлыг хүлээн авах, шүүгчдийн эсрэг хэргийг хэлэлцэх, шүүгчийн албан үүргээ гүйцэтгэх хугацааны баталгааг хангах, уг хугацааны талаар санал оруулах эрхүүдийг зөвлөлд олгоно.¹³ Зөвлөлд шүүгч нарын эсрэг хэргийг шийдвэрлэх, сахилгын хэм хэмжээг сахиулах эрхийг олгох нь зайлшгүй.
- Магистрат болон бусад доод тушаалын шүүхийн ажилтнуудын ажлын нөхцөлийг сайжруулах ажлыг тэргүүн ээлжинд хийх ёстой. Цалин, хөлсийг нэмэгдүүлэх, орон сууцны нөхцөл болон аюулгүй байдал (ялангуяа ахмад магистратуудад)-ыг сайжруулах нь нэн тэргүүний асуудал мөн.

Кенийн ТИ, Найроби

Монголын хуульчдын хүрэн дэх авлига

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, мөрдөн шалгах болон мэтгэлцэх зарчим
100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 13.3¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 2,412 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: мэдээлэл байхгүй байна.

Нэг хүнд ногдох УНБ: 690 ам.доллар³

Шүүхийн жилийн төсөв: 3.7 сая ам.доллар⁴

Жилийн нийт төсөв: 1.1 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.3

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Бие даасан

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Шүүхийн Ерөнхий Зөвлөл (2006)

2. Мөн тэнд

3. Дэлхийн Банкны Хөгжлийн Үзүүлэлтүүд (2005)

4. Шүүхийн Ерөнхий Зөвлөл (2006)

5. Мөн тэнд

6. Мөн тэнд

Монголын шүүхийн тогтолцоон дахь олон асуудлууд төр шүүхийг хяналтандаа авсан үеийн үр дагавраас үүдсэн юм. 15 жилийн тэртээд Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш шүүгч, хуульчид ёс зүй болон хараат бус шүүхийн тогтолцооны талаар зах зухаас нь суралцах шаардлагатай болсон юм.

Олон нийтийн дундах авлигын төсөөллийн төвшинг тодорхойлохыг оролдсон олон судалгаанууд байдаг. 2006 онд 1,030 хүний дунд явуулсан санал асуулгаар ард иргэд авлигыг улс орны өмнө тулгараад буй хоёр дахь хамгийн чухал асуудал бөгөөд шүүхийг гааль, газрын алба, мөн уул уурхайн лицензийн дараа орох дөрөв дэхь авлигад хамгийн ихээр автсан салбар гэж үзжээ.¹ Өөр нэгэн санал асуулгаар ард иргэдийн 39 хувь нь шүүхийн салбарыг авлигад их өртсөн гэж хариулсан бол энэ тоо 2005 онд 18 хувь болж бууран ахиц гарсан байна. Гэсэн хэдий ч 2005 онд судалгаанд оролцогчдын 93 хувь нь улс төрийн нөлөө бүхий хүмүүст, харин 90 хувь нь баян хүмүүст шүүх давуу эрхтэй ханддаг гэжээ.²

1 АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлаг, Азийн сан, Муж улсын шүүхүүдийн үндэсний төв, Авлигын жишиг: Монгол улс дахь авлигын цар хүрээ болон тохиолдлын талаарх ойлголт, 2006 оны 4 сар, www.asiafoundation.org/pdf/MG_Benchmarking.pdf

2 Сант Марал, Улсын шүүхүүдийн үндэсний төв, Монголын шүүхийн шинэчлэлийн төслийн Монгол дахь шүүх тогтолцооны талаарх ойлголт 2001, 2003 ба 2005 он. www.owc.org.mn/santmaral/page3.html

Гуравдахь судалгааны³ дүнгээр, шүүхийн тогтолцоонд авлига гарахад “бага цалин, ил тод байдал дутагдалтай” зэрэг ердийн хүчин зүйлүүдээс эхлээд эрх зүйн салбарт түгээмэл гардаг авлигын олон талт асуудлууд нөлөөлж байна. Бусад нөлөөлж буй хүчин зүйлүүдэд доорх асуудлууд багтаж байна. Үүнд:

- Төр, хувийн хэвшил хоорондын зааг, ялгаа байхгүй болсон
- Ил тод бус байдал, төрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл хүртээмжгүй байх
- Төрийн албаны үйлчилгээ шаардлага хангахгүй байх
- Авлигатай тэмцэх улс төрийн эрмэлзэл байхгүй байх
- Хяналтын байгууллагын ажиллагаа сул байх зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Авлигын цар хүрээ

2002 оноос өмнөх хоёр жилийн хугацаанд шүүгч болон цагдаагийн ажилтнуудын эрх мэдлээ урвуулан ашигласан 456 эрүүгийн гэмт хэрэг шалгагдаж байсны 250 хэргийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд үлдсэн хэргүүдийг нь хэрэгсэхгүй болгосон байна.⁴ 2002 онд байгуулагдсан шүүгч, прокурор болон цагдаагийн ажилтнуудын үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулагдсан цагаасаа шүүгч нарын эсрэг дөрвөн авлигын хэрэг илрүүлсэн ч, эдгээрийг эцсийн шатанд нь хэрэгсэхгүй болгожээ.⁵ Энэхүү албаны дарга прокурорын албаны, шүүхийн сахилгын хороонд хэргийн мөрдөлтийг дахин эхлүүлэхээр хүсэлт гаргасан ч, “дээрээс хэргийг шалгахгүй байлгахгаар дарамт шахалт үзүүлэх болсон” гэсэн мэдээлэл авчээ.⁶ Албаны өөр нэгэн гишүүний мэдээлснээр шүүгчид, цагдаагийн албан хаагч эсхүл шүүгчдийн эсрэг авлигын гэмт хэргийг хуулийн хүрээнд арай хор хохирол багатайд тооцогдох жижиг сажиг хөрөнгө шамшигдуулсан хэрэг болгож, зүйлчлэлийг байнга өөрчилдөг гэжээ.⁷

3 АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлаг, “Монгол улс дахь авлигын үнэлгээ”, 2005 оны 8 сар. Үз: www.usaid.gov/mn/library/documents/MongoliaCorruptionAssessmentFinalReport.pdf

4 Роберт Ла Монт, Монгол дахь шүүхийн авлигатай тэмцэх зарим аргууд, 2002 оны 8 сарын 1. Үз: pdc.ceu.hu/archive/00002274/01/Judicial_Corruption_in_Mongolia.pdf

5 УЕПГ-ын хяналтын прокурор Батчимэгтэй хийсэн ярилцлага, 2006 оны 5 сарын 16. Өөр нэг эх сурвалжийн мэдээлснээр тус алба 2004 онд шүүгч, прокурор болон цагдаа нарын оролцсон авлигатай холбоотой 6 хэргийг мөрдөн шалгажээ. Үз: oloo.mn/modules.php?name=News&file=article&sid=25715

6 УЕПГ, мөрдөн байцаах албаны орлогч дарга Т.Ганболд. Үз: Тэргүүн (Монгол), 2006 оны 5 сарын 8.

7 УЕПГ, мөрдөн байцаах албаны ахлах мөрдөгч Т.Жаргалбаатар. Үз: Ардын эрх (Монгол), 2006 оны 5 сарын 3.

Шүүх тогтолцоонд авлигын үр дүнд гарсан байж болохуйц хуульд нийцээгүй шийдвэрүүдэд “ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн”, “мэргэжлийн алдаа гаргасан” гэсэн шалтгаанаар шүүгч нарт сахилгын арга хэмжээ авах шийдвэр гаргадаг.⁸ 2000-2001 онд 37 шүүгчид сахилгын арга хэмжээ авсан бөгөөд 9 шүүгчийн цалинг хасч, 20-д нь албан ёсны сануулга өгч, харин найман шүүгчийг албан тушаалаас нь огцруулжээ.⁹ 2003 онд шүүхийн сахилгын хороо шүүгч нарын эсрэг 25 хэрэг шийдвэрлэснийг 2004 онтой харьцуулбал 21, 2005 онд 19, 2006 оны 5 сар гэхэд 6 хэрэг гэсэн дүн гарчээ.¹⁰

Шүүгч нарын сарын цалин ойролцоогоор 200 ам.доллартай тэмцэж байгаа нь бусад төрийн албан хаагчдын цалинтай харьцуулбал хамгийн өндөр цалин боловч энэ нь хувийн хэвшилд ажиллагсдын цалингийн дундаж цалингийн 50 хувьтай тэнцэж байна. Бага цалин, амьдралын төвшин доогуур байх нь шүүхийн хараат бус, шударга байдалд аюул занал учруулж байна. Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэрийн өгүүлсэнээр шүүгч нарын 70 хувь нь өөрийн гэсэн орон байргүй, байр түрээслэж амьдардаг ажээ.¹¹

Засгийн газар шүүхийн ажлыг цалгардуулж байна

Монгол улсын Үндсэн хуульд шүүх засаглал хараат бус байна гэж заасан байдаг ч энэ нь бодит ажил хэрэг болохын тулд эхлэл үедээ л явж байна. Дөрвөн жилийн өмнөхөн Хууль зүйн сайд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын албыг давхар хашиж, 12 хүний бүрэлдэхүүнтэй уг зөвлөл шүүхийн хараат бус байдлыг хангах үүрэг хүлээж байсан юм. Үндсэн хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосноор Ерөнхийлөгч шүүгч нарыг бүх насаар нь тус албан тушаалд томилдог.

Засгийн газрын гишүүд авлигын гэмт хэрэгт холбогдвол, Ерөнхийлөгчөөс ажил нь хамааралтай байдаг шүүгчийн хувьд үүнийг хараат бусаар шийдвэрлэнэ гэдэг хүнд асуудал байх нь ойлгомжтой. Сүүлийн үеийн жишээ дурдвал, төрийн сангаас 2.9 сая ам.долларыг завшсан хэргээр мөрдөн байцаалт явуулахыг шаардсан жагсагчдын шаардлагын улмаас сонгуулийн кампанит ажил нь бүтэлгүйтсэн Ерөнхийлөгч Намбарын Энхбаярын хэрэг юм. Саяхны мэдээгээр Ерөнхийлөгч Н. Энхбаяр түүнийг албан тушаалаа урвуулан мөнгө, хөрөнгө завшсан хэмээн буруутгасан бие даасан судлаачийг нэр төрийг нь гутаасан хэмээн давж заалдах шатны шүүхэд хууль бусаар нөлөөлж анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулсан гэх мэдээлэл гарсан ажээ. Тэрхүү судлаачийн хэргийг анхан шатны шүүхээр хэрэгсэхгүй болгосон байсан юм.¹²

8 Роберт Ла Монт (2002)

9 Мөн тэнд

10 хяналтын прокурор Батчимэгтэй хийсэн ярилцлага. 2006 оны 5 сарын 15.

11 Өдрийн сонин (Монгол), 2005 оны 12 сарын 8

12 Дээдсийн хүрээлэн (Монгол), 2006 оны 4 сарын 1

Сахилгын сул механизм

Шүүгч, прокурор, өмгөөлөгч — зэрэг хууль, эрх зүйн мэргэжил тус бүрт ёс зүйн дүрэм болон түүнийг сахиулах байгууллага байдаг. Хэдийгээр эдгээр дүрмүүд нь ерөнхийдөө хангалттай зохицуулалттай ч хэргийн оролцогч тал болон гэрчтэй “дангаараа” уулзалт хийхийг хориглоогүй байдаг нь учир дутагдалтай. Шүүгчийн ёс зүй зөрчсөн үйлдэлтэй тэмцэх Сахилгын хороо нь маш сайн санхүүгийн болон хүний нөөцтэй байх шаардлагатай бөгөөд тэдний гарыг Ерөнхийлөгч шүүгчдийг шууд томилдог явдал мөн хүлдэг юм. Шүүх эрх мэдэл үйл ажиллагаагаа ил тод бусаар явуулдаг учир нь шүүх шийдвэрээ нууцаар гаргадаг (зөвлөлдөх тасалгааны нууц) энэ нь шүүгчдэд өөрсдийн гаргасан шийдвэрийг үндэслэх нотлох баримт дутагдаж буйг нуух боломжийг өгдөг.

2002 онд хуулийн салбарын ажилтнуудын холбогдсон эрүүгийн гэмт хэргийг мөрдөн байцаах тусгай албыг прокурорын байгууллагын дэргэд байгуулсан юм. Хуульчдад холбогдох хэргүүдийн дийлэнх нь эцсийн дүнд улс төрийн нөлөөлөл эсхүл шаардлагатай нотлох баримтыг зүй ёсоор цуглуулах чадвар дутагдсан зэргээс шүүхээс буцаагдах эсхүл шүүхээс гадуур тохиролцох байдлаар шийдвэрлэгдэх явдал гардаг.¹³

Өмгөөлөгчдийн хээл хахуулийн суваг

Өмгөөлөгчид шүүгч нарт шууд хээл хахууль өгөх, хэргийг “нөлөөлж болохуйц” эсхүл “дуулгавартай” шүүгчээр шийдвэрлүүлэхээр хуваарилуулах оролдлого хийх, мөн прокурорын ажиллагаанд нөлөөлөх зэрэг авлигын хэрэг үйлдэж байна. Зарим өмгөөлөгч нар танил харах эсхүл томилогдсон шүүгч, мөрдөн байцаагчтай сайн харьцаатай эсэхээс хамаарч хэрэг өмгөөлөхөөр авдаг. Үүний зэрэгцээ, тэд хөлс өндөр өмгөөллийн хэрэг авах¹⁴ бөгөөд зарим тохиолдолд шийдвэрийг өөрт ашигтайгаар гаргуулахын тулд шүүгчид “бэлэг” өгөхийг үйлчлүүлэгчиддээ зөвлөдөг.¹⁵

Зарим өмгөөлөгчид хэргийн эсрэг талын өмгөөлөгчид хээл хахууль өгч хэргийг нь санаатайгаар ялагдуулах арга хэмжээ авдаг байна. Үгсэн хуйвалдах эдгээр хэргийг нотлох амаргүй бөгөөд учруулсан хор хохирлыг нь засч залруулах боломжгүй байдаг. Учир нь нэхэмжлэгч болон хариуцагчийн өмгөөлөгчдийн авлигач “баг” хэргийг давж заалдах боломжгүй байдал оруулдаг.

13 АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлаг (2005)

14 Ардын эрх (Монгол), 2006 оны 5 сарын 10.

15 Хүний эрх, Хөгжлийн төв, “Үндэсний Хүний Эрхийн Тайлан 2000: Монгол”, www.chrd.org.mn

Хариуцагч тал болох ганц бие эмэгтэй өөрийн гурван хүүхэд болон өвөг эцгийн хамт, түүний эзэмшлийн байранд амьдардаг байжээ. 1999 онд байрны эзэн өнгөрөхөд, түүний ач охин байрны хууль ёсны эзэмшигч болжээ. Эмэгтэйн аваг ах буюу талийгаачийн хүү болох өөрийн гэсэн байшинтай чинээлэг эр мөн уг байрыг эзэмших эрхтэй гэж зарга үүсгэсэн байна.

Заргалдаж байх хугацаанд эмэгтэйд хэд хэдэн өмгөөлөгч шүүхэд нөлөөтэй хэн нэгнийг олохыг зөвлөжээ. “Хуулийн дагуу та заргаа авах ёстой хэдий ч, юу ч тохиолдож болно шүү дээ. Та тэгэхээр шударга шийдвэр гаргуулахын тулд хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг таних хүнийг олж, түүнд мөнгө төл” гэжээ. Байраа алдахаас өөр сонголтгүй болсон эмэгтэйд өөр ямар ч боломж байсангүй. Түүний өмгөөлөгч Дээд шүүхийн шүүгчтэй найз нэг хүнийг олсон байна. Эмэгтэй гэр бүлийн хамтаар заргаа авч чаджээ.¹⁶

Цусан төрлийн холбоо

Монголын шүүхийн салбарт байдаг нэг онцлог зүйл, мөн уг салбарт авлига гарахад нөлөөлдөг хүчин зүйл нь олон өмгөөлөгчид хувиараа өмгөөлөл хийхийн өмнө шүүх эсхүл хууль хэрэгжүүлэгч бусад байгууллагад ажиллаж байсан явдал юм. Цаашлаад, өнөр өтгөн гэр бүлийн гишүүдийн дотроос эрх зүйн олон салбарт ажилладаг цусан төрлийн холбоотой мэргэжилтнийг олох энүүхэнд байдаг. Монголын хоорондоо нягт холбоотой, сүлжээ үүсгэсэн, жижигхэн эрх зүйн салбарынханд байдаг иймэрхүү цусан төрлийн холбоо шүүхийн ил тод байдал, шударга, бие даасан байдалд том саад учруулж байна.

Асуудлыг хүндрүүлдэг бас нэг зүйл нь Монголын хуулиуд ихэнхдээ салаа утгатай, тэр бүү хэл хоорондоо зөрчилтэй байдаг учир шүүгч, өмгөөлөгч нар өөрсөддөө санхүүгийн давуу тал олж авахын тулд хуулийг өөрөөр тайлбарлах үндэс болдог. Олон нийтийн хууль, эрх зүйн хангалтгүй мэдлэг, боловсролтой нийлээд энэ тодорхой бус байдал нь хуульчид албан тушаалаа урвуулан ашиглах таатай нөхцөл бололцоог бүрдүүлж өгдөг байна.

Шинэчлэлийн үр дүн

2000 онд Монгол улсад Монголын Шүүх эрх мэдлийн Стратеги төлөвлөгөөг баталсан бөгөөд дараа жил нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, GTZ, Mercy Corps, РАСТ зэрэг байгууллагуудтай хамтран таван жилийн хугацаатай Шүүхийн Шинэтгэлийн Төсөл (ШШТ)-ийг боловсруулжээ. ШШТ нь 5 салбарт гол анхаарлаа хандуулжээ. Үүнд:

- Шүүхийн захиргааны удирдлага болон хэргийн хөдөлгөөний менежмент
- Эрх зүйн үргэлжилсэн сургалт

- Хуульчдын мэргэжлийн шалгалт авдаг системийг үүсгэн бий болох
- Эрх зүйн мэргэжилтнүүдийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх
- Шүүх ажиллагааны талаарх нийт олны мэдлэгийг дээшлүүлэх ажил

Төслийн гол ололтуудаас дурдвал: Монголын бүх 61 шүүхийг бүрэн автоматжуулсан; хэргийг тохиолдлын журмаар хуваарилдаг болсон; өмгөөлөгчид болон олон нийтийг хэргийн талаар мэдээлэл авах, танилцах боломжийг хангах үүднээс шүүхүүдэд Мэдээлэл, лавлагааны төвүүдийг бий болгосон; мөн 2005 оноос хойш сүлжээнд холбогдсон хэргийн мэдээллийн төвлөрсөн санг бүрдүүлсэн ажлууд байгаа ажээ. Боловсролын асуудлаар, ШШТ нь бүх эрх зүйн мэргэжилтнүүдийг давтан сургалтанд хамруулах эрх бүхий шинээр байгуулагдсан Хууль зүйн үндэсний төвд ажиллах сургагчдын баг бүрдүүлсэн; хөдөө орон нутгийн шүүгчдэд ёс зүйн болон бусад сургалт явуулсан; ХЗДХЯ-тай хамтран Монголд анх удаагаа эрх зүйн мэргэжилтнүүдээс авах албан ёсны шалгалтыг боловсруулсан; мөн олон нийтэд эрх зүйн тогтолцоонд гарч буй өөрчлөлтүүдийг тайлбарлах зорилгоор зурагт хуудас, ном, өгүүллэг болон радио, телевизийн хөтөлбөрүүд гаргажээ. ШШТ-өөс мөн шүүгч нарын шинэ ёс зүйн дүрмийн төслийг боловсруулахад зөвлөгөө өгсөн бөгөөд компьютерийн тоног төхөөрөмжөөр хангах, мөрдөн байцаах арга техникийн талаар сургалт явуулах зэргээр шүүхийн сахилгын хороо, прокурорын мөрдөн байцаах тусгай нэгж гэсэн гол хоёр мониторингийн албаны чадавхийг бэхжүүлсэн ажээ.

Монголын шүүх байгууллага шүүх үйл ажиллагаа явуулах ил тод, эрх тэгш үйлчлэх наад захын шаардлагыг хангах шаардлага байсаар байгааг харгалзан, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагаас ШШТ-ийг 2008 он хүртэл 3 жилээр сунгажээ. 2005 оны эцсээр гаргасан 18 шинэ зорилтууд дунд шүүхийн захиргаа, удирдлага, төсөв, гүйцэтгэл, “харилцааны хэм хэмжээ” болон эрх зүйн салбаруудаар мэргэшүүлэх (үнэт цаас, татвар, олон улсын худалдаа гэх мэт) зэрэг дийлэнх нь шүүх байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зорилтууд байжээ. Хэдийгээр цахим болон хэргийн менежмент зэрэг шүүх тогтолцоог сайжруулах цэвэр механик ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай ч шинэтгэлд хүний оролцоо, хүсэл чармайлт дутагдсан хэвээр байна. Дэлхийн хүндрэлтэй хэсэгт Монголын хамгийн үнэнч донорын (USAID) явуулсан ШШТ хэрэгжиж эхэлснээс хойш 5 жилийн дараа АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг шүүгчийн ёс зүйн дүрмийг сайжруулах, шүүгч нарыг хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзахыг хориглох, төрийн хөрөнгийн мэдүүлэг эсхүл “мэргэжлийн алдааны тодорхойлолт” зэрэгт хууль тогтоох байгууллагын зөвшөөрлийг авч чадаагүй байгаа юм. 2006 оны 7 сард батлагдсан Авлигын эсрэг хуулиар хараат бус Авлигатай тэмцэх газар байгуулж, шүүгч, прокурор зэрэг төрийн албан хаагчдаас хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргуулахыг шаардах болсон байна.

*ТИ Монгол,
Улаанбаатар*

Мароккогийн язгууртан дээдсийн эрх мэдэл ба шүүхийн хараат бус байдал

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, мэтгэлцэх болон олон талт зарчим, прокурор нь шүүх эрх мэдэлдээ хамаардаг

100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 20.7¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: Мэдээлэл байхгүй байна

Дээд шүүхийн шүүгчийн цалин: Мэдээлэл байхгүй байна

Нэг хүнд ногдох ҮНБ: 1,730 ам.доллар²

Шүүхийн жилийн төсөв: 290.7 сая ам.доллар³

Жилийн нийт төсөв: 16.8 тэрбум ам.доллар⁴

Жилийн төсөвт эзлэх хувь: 1.7

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тодбайдаг: Үгүй

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Үгүй

1. Дэлхийн банк (2000)

2. Дэлхийн Банкны Хөгжлийн Үзүүлэлтүүд (2005)

3. Төсвийн тухай хууль, Албан ёсны хэвлэл дугаар 5382 (2005 оны 12 сарын 25)

4. АНУ ын ТЕГ Дэлхий баримт ном (2005)

Credit Immobilier et Hotelier (СИН)-ийн хэрэг нь Марокко улсад мөрдөн байцаах, яллах болон хэрэг хянан шийдвэрлэх эрх мэдэл бүгд засгийн газрын хяналтад байдаг бөгөөд энэ нь авлигын эсрэг хийх шүүх тогтолцооны тэмцэлд саад учруулж байдагийг нотлон харуулсан юм.

Үндсэн хуульд шүүх тогтолцоо нь гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат бус байна гэж заасан байдаг. ¹ Энэ зарчмыг иргэний болон эрүүгийн хуульд баталгаажуулсан байдаг бөгөөд магистратын дээд зөвлөлөөс (МДЗ) хэрэгжүүлэх Шүүгчийн ажил мэргэжлийн байдлын тухай хуульд ч энэ тухай тодорхой тусгасан байдаг. МДЗ нь хамгийн дээд тушаалын шүүгч нараас бүрддэг ба тэдгээрийн олонхийг мэргэжил нэгтнүүд нь сонгодог юм. Тус зөвлөл шүүгчдийг сонгон шалгаруулах, албан тушаал дэвшүүлэх, шилжүүлэх болон хариуцлага хүлээлгэх асуудлыг хариуцдаг. Ингэхдээ шүүгчийн сэтгэлд нийцэх албан тушаалын бүрэн эрхийн хугацаа олгодог, харин прокуроруудад харьцангуй муу нөхцөл олгодог байна. Энэ хязгаарлалтуудыг заримдаа “si la plume est serve, la parole est libre” гэсэн үг өгүүлбэрээр илэрхийлдэг ба энэ нь өргөн утгаар прокурор бичихээс илүүтэй ярихдаа хамгийн их эрх чөлөөг эдэлдэг гэсэн санааг агуулдаг.

1 82 дугаар зүйл.

Хаан тушааж, хууль “хөсөр хаягддаг”

Гэхдээ дээр үг нь МДЗ-ийг тэргүүлж, эцсийн шийдвэрийг гаргадаг Мароккын хаан Мухамед VI-д хамааралтай үг юм.² Учир нь тэр бүх шүүгч, прокурор, төрийн албаны дээд албан тушаалтан болон засгийн газрын гишүүдийг томилдог. Бодит, өдөр тутмын ажлыг дэд дарга буюу Хууль зүйн сайд өөрийн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэдэг. Тэрээр МДЗ-ийн байнгын тамгын газрыг тэргүүлж, хэлэлцэх асуудлыг бэлтгэн, хурал зохион байгуулж, мөн зөвлөлийн хэлэлцсэн асуудлыг батлуулахаар Хаанд илгээдэг ажээ. Мөн тус сайд нь шүүхийн ерөнхий удирдлага, шүүхийн төсөв, түүнчлэн яаманд удирдах алба нэгэн зэрэг хашдаг шүүгчид болон хүний нөөцийн менежментийг тэргүүн ээлжинд хариуцан ажилладаг. Сайд нь МДЗ-өөс батлаагүй хүлээгдэж байгаа албан тушаалд шүүгч нарын нэрийг дэвшүүлэх, шүүгчийг шилжүүлэн ажиллуулах эрх мэдэлтэй байна.

Гүйцэтгэх засаглалаас шүүхийн захиргаанд үзүүлэх нөлөө өдөр тутмын амьдралд төдийлөн илэрхий ажиглагдаад байдаггүй. Харин шүүхээс нийгэмд дээгүүр байр суурь эзэлдэг хэн нэгний хууль бус хөрөнгөтэй холбоотой хэргийг хэлэлцэх үед зүй бус нөлөө үзүүлэх оролдлого хийгдэнэ. СИН-ийн хэрэг бол үүний нэг жишээ юм.

Уг хэрэг авлига болон төрийн хөрөнгө шамшигдуулах эсхүл төрийн албан тушаалтнуудтай холбоотой бусад албан тушаалын хэргийг яллах үүрэг бүхий тусгай шүүхийн харьяалалд багтана. Шүүхийн тухай хуульд яллах ажиллагааг зөвхөн Хууль зүйн сайдын гарын үсэг бүхий тогтоол, шийдвэр гарсан тохиолдолд эхлүүлэх хязгаарлалт хийж өгсөн байдаг.³

СИН: Хэдэн арван жилийн хэрэгцээг хангах бэлэн мөнгөний “саалийн үнээ”

СИН байгууллагыг анх газар эзэмшүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор байгуулжээ. Төд удалгүй 1956 онд Марокко тусгаар тогтнолоо олоход энэ нь орон сууцны болон аялал жуулчлалын салбарыг хариуцсан зээл олгох байгууллага болон хувиржээ. Төрөөс түүний үйл ажиллагаанд хяналт тавьж, хааны томилсон дарга үйл ажиллагааг нь удирдан явуулж байв. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд 1970-аад оноос эхлэн хөрөнгө оруулалтын маргаантай асуудалд нэр холбогдсон СИН-ийн тухай мэдээлэл цацах болсон юм. СИН нь олон нэр хүнд бүхий хүмүүсийн санхүүгийн эх үүсвэр болж байсан бөгөөд өнөөгийн энэ хэрэг мандахад хүргэсэн санхүүгийн найдваргүй хэлэлцээрүүдийг гүйцэлдүүлэх “тусч” санхүүжүүлэгч нь байжээ. Үүнээс урьдчилан сэргийлэх зорилготойгоор ажиллуулж байсан гадаадын

2 32 дугаар зүйл. 1999 онд хаан ширээнд заларсан тус улсын өнөөгийн хаан Мухаммед Бен Аль-Хассан.

3 Төрийн албан хаагч хөрөнгө хувьдаа завьших, авлига, төрийн албан тушаалтнууд худалдаанд нөлөөлөх, хөрөнгө шамшигдуулсан хэргийг яллах тусгай шүүх байгуулах тухай 1972 оны 10 сарын 1-72-157 дугаар Хуулийн дахир (тогтоол).

ба дотоодын хяналтын механизмын аль альных нь ажиллагаа саармагжсан байна. Хожим гүйцэтгэх засаглал нь өөрийн гаргасан маргаантай шийдвэрүүдийг хаацайлах, улмаар хэргийн оролцогч тал буюу үүнээс ашиг хүртэж байсан этгээдүүдийг яллах шийдвэрээс зайлсхийлгэхийн тулд шүүхэд хэрхэн нөлөөлж байсныг харуулсан юм.

Хэдэн арван жил үргэлжилсэн муу менежментийн уршгаар олгосон зээлүүд нь эргэн төлөгдөхгүй байгаа нь СИН-ийг 1998 онд дампуурлын байдалд оруулж болзошгүйг мөрдөн байцаагчид олж илрүүлсэн байна. Тэдний тооцоолсоноор 9 тэрбум ДН-ийн (1 тэрбум ам. доллар) өр эргэн төлөгдөх ёстой байжээ.⁴ Хэдийгээр энэ бүгдийг тухайн үед илрүүлж, түүнд анхаарлыг хандуулж байсан боловч прокурорын алба болон шүүх тодорхой арга хэмжээ аваагүй байна. Харин парламентаас санхүүгийн дэмжлэг хүссэнээс хойш энэ хэргийн тухай мэдээлэл ил тод болж, хянан шалгах ажлыг 2000 онд эхлүүлсэн байна.⁵

Үндсэн хуульд зааснаар парламентын хянан шалгах хороо нь “хэргийн талаар мэдээлэл цуглуулж, хуралд өөрсдийн гаргасан дүгнэлтийг өргөн барих” үүрэгтэй ажээ. Уг хороог “хэрэг шүүхэд шилжих, шүүх ажиллагаа явагдаж байхад” байгуулдаггүй юм байна. Хэдийгээр төрийн тэргүүн нь энэ жигшүүрт хэргийн талаар анхааруулж байсан ч СИН-ийн хэргийг шүүхэд шилжүүлээгүй учир парламент хороо байгуулж хянан шалгах ажиллагаа явуулжээ.

Хянан шалгах ажлыг засгийн газрын шийдвэрээр гүйцэтгэж байгаа боловч засгийн газрын зарим сайдуудын буруу үйл ажилаагаанаас болж уг хэрэг дэгдсэн юм, тухайлбал Хууль зүйн сайд тухайн үед мөрдөн байцаах ажил эхлүүлэхгүй байсан нь уг хэргийг даймжруулсан байна. Хуулиараа бол парламентын хороо нь парламентын гишүүдэд танилцуулах тайланг бэлтгэнэ. Харин хуулийн дагуу арга хэмжээ авах эрх мэдэл гагцхүү гүйцэтгэх засаглалын гарт л байдаг ажээ.

Шүүхээс томилогдсон цагдаагийн ажилтнууд⁶ 2001 оны 1 дүгээр сард мөрдөн байцаалт явуулж эхэлсэн нь засгийн газар тусгай шүүхэд шилжихээс өмнө эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа явуулах эрмэлзэлтэй байгааг харуулжээ. Олон нийтийн анхаарлыг уг хэрэгт хандуулах ажилд Le Journal Hebdomadaire, мөн L'economiste, Al Ahdath Al Maghribia зэрэг өдөр тутмын сонинууд чухал үүрэг гүйцэтгэсэн гэдэг. Эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг Транспэрэнси Марок, Төрийн өмчийн хөрөнгийг хамгаалах сүлжээ зэрэг иргэний нийгмийн байгууллагууд семинар зохион байгуулах, иргэдийн дунд судалгаа, асуулга явуулах, сонин хэвлэлээр мэдээлэл цацах зэрэг үйл ажиллагаагаар дэмжсэн байна.

4 Энэ мэдээлэл, мөн парламентын мөрдөн байцаалтын үйл явцын тухай мэдээлэл өдөр тутмын L'Economiste, мөн долоо хоног тутмын Хебдомадэйр ба Марок Хебдо сэтгүүлд гарсан.

5 Үз: Аль Шарк Авсат (Их Британи), 2001 оны 2 сарын 2

6 Brigade Nationale de la Police Judiciare бол мөрдөн шалгах эрх бүхий шүүхийн цагдаа юм.

Авлигыг мөрдөн шалгах алтан боломж алдагдсан байна

2002 оны 10 дугаар сард Хууль зүйн сайд он олон жил нийт олны анхаарлын төвд байсан уг хэргийг шийдвэрлэх тусгай шүүхэд шилжүүлэхийн тулд мөрдөн байцаалт эхлүүлэх тушаал гаргажээ. Ажиллагаанд олон хүн хамрагдаж байснаас зарим нь шүүх хурлаа хүлээж байжээ. Хэдийгээр хуульд⁷ тусгай шүүхэд шүүх хуралдаануудыг түргэн шуурхай явуулах ба хамгийн ихдээ 6 долоо хоногийн дотор хэргийг шилжүүлнэ гэж заасан авч шинжээчдийн дүгнэлтийг шалгах зэрэг цаг авах ажиллагааны улмаас мөрдөн байцаалт 2004 оны 1 дүгээр сар хүртэл үргэлжилжээ. Эцэст нь 20 хүрэхгүй хүнийг төрийн хөрөнгө завшсан, худалдааны шийдвэрүүдэд урьдаас нөлөөлсөн, мөн хамтын буюу нийгмийн аюулгүй байдалд төсөвлөсөн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан хэрэгт хэргийн гол эзэд, хамсаатны аль алинд нь ял оноожээ. Шүүх хурлыг 2004 оны 1 дүгээр сарын 19-нд хийхээр товлосон хэдий ч зарим яллагдагч нар хуралд ирээгүй гэсэн шалтгаанаар хурал хойшилсоор гурван сар хүрч дуусч байжээ. Цагдан хорих хуульд заасан хугацаа хэтэрмэгц яллагдагч нарыг шүүх хурал хүртэл сулласан байна.

2004 оны 4 дүгээр сард СИН-ийн 2003 он тайлан тэнцлийг хэвлүүлсэн бөгөөд эндээс 5 тэрбум ДН (550 сая ам.доллар)-ыг нөхцөл байдлыг залруулах гэсэн амжилтгүй оролдлогуудыг санхүүжүүлэхэд зарцуулсныг харж болно. Маргаантай зээлийн хэмжээ 9.5 тэрбум ДН (1 тэрбум ам.доллар)-д хүрчээ. Тухайн жилд тусгай шүүхийн үйл ажиллагааг зогсоож, СИН-ийн хэргийг дахин мөрдөн байцаалт явуулахаар Касабланкагийн давж заалдах шатны шүүхийн эрүүгийн гэмт хэргийн тасаг руу шилжүүлсэн байна. Энэ нам гүм хугацаанд гадаад руу зугатаад байсан СИН-ийн дарга асан Мүлэй Зин Захидитай хийсэн хоёр шуугиан тарьсан ярилцлага хэвлэлд нийтлэгдсэнээс өөр онц зүйл болоогүй байна.⁸ Тэрээр эрэн сурвалжилж байсан гол хүн бөгөөд түүнийг эзгүйд нь хэргийг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Өмч хувьчлалын сайдын алба зэрэг хэд хэдэн сайдын албан тушаалд томилогдон ажиллаж байсан Захидигаас илгээсэн зурвас олон юмыг тодорхой болгож өгсөн юм. Парламентын хянан шалгах ажиллагаа, шүүн таслах ажиллагааны баримт бичгүүдийн аль нь ч хэргийн үнэн дүр зураг, нотлох баримтан дээр тулгуурлаагүй байжээ. Хамгийн сэжигтэй зээл, хууль бус шилжүүлгүүдийг тэрээр төрийн дээд албан тушаал хашдаг хэн нэгний заавраар хийж гүйцэлдүүлдэг байсан тухай ярьжээ. Түүний эдгээр хэрэг явдлын талаар сүүлийн хаан Хассан II болон Мохаммед IV-т хэлэх оролдлого хийдэг байсан ч “улирсныг март” гэсэн анхааруулгатай тулгардаг байсан байна.

7 1972 оны 10 сарын 6-ны өдрийн 1-72-157 тоот дахир (тогтоол)

8 Анхны ярилцлага *Nouvel Hebdomadaire* дээр 2003 оны 10 сарын 19-нд, хоёр дахь нь *Le Journal Hebdomadaire* дээр 2006 оны 5 сарын 20-нд тус тус нийтлэгдсэн.

2006 оны 9 дүгээр сарын байдлаар СИН-ийн зарим удирдлагыг үл тооцвол, хэнд ч улс төрийн болоод захиргааны хариуцлага ногдуулах боломжгүй болох нь тодорхой болжээ. Шүүх ажиллагаанд зөвхөн шуналдаа хөтлөгдсөн төдийгүй захирах захирагдах, хувийн үйл ажиллагааны нууцлалын удирдамж, албан тушаал өсөх боломж зэрэг төрийн албанд байдаг айдсаас болж уг хэргийг үйлдсэн байж болох доод тушаалын албан хаагчид тунаж үлджээ.

Энэ хэрэг шүүхийн шинэтгэл хийхэд ямар нэг хувь нэмэр оруулсан уу? Үүнийг тодорхойлоход хүндрэлтэй юм. Авлигатай тэмцэх зорилго бүхий тодорхой шинэчлэлүүдийн дунд тусгай шүүхийн ажиллагааг зогсоосон явдал багтаж байна. Ингэснээр Транспэрэнси Марок болон бусад ТББ-уудын удаан хугацаанд хүсч хүлээж байсанчлан Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эхлэн явуулахад Хууль зүйн сайдын бичгээр гаргасан тушаал шаардлагагүй болсон юм. Гэхдээ түүний хэрэгт саад учруулдаг эрх мэдлийг нь багасгаагүй байна. Тэр прокурорын байгууллагыг удирдсан хэвээр бөгөөд тэд үйл ажиллагаа явуулахдаа түүний зааврыг мөрддөг. Мөн түүнчлэн шүүхийн албаны зөвлөлөөр дамжуулан харьцангуй давуу эрх эдэлдэг. Энэ байдал нь шүүх тогтолцоог авлигын эсрэг тэмцэх жинхэнэ үүрэг хүлээхээс зайлсхийлгэдэг байна.

СИН-ийн хэрэг шиг шүүх хуралдаан ил тод бус явагдах, шийдвэр гаргахад засгийн газар хөндлөнгөөс эрээ цээргүй оролцох нь шүүхийн тогтолцоо хараат бус байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байгаа юм. Иймд шүүхийн тогтолцоонд шинэтгэл хийх нь иргэний нийгмийн байгууллагын нэн тэргүүний асуудал болж байна. Үүнд өөр бусад дэмжлэг туслалцаа шаардлагатай. Тухайлбал, шүүгчийн бүрэн эрхийн хугацааг баталгаажуулснаар засгийн газрын зүгээс үзүүлэх дарамт шахалтаас хамгаалж чадна. Одоо энэ асуудал хойш тавигдаад байгаа юм.

*Транспэрэнси Марок,
Касабланка*

Балбын “доголдолтой” шүүхийн байгууллагад өөрчлөлт хийгдэх боломж тохиож байна

Эрх зүйн тогтолцоо: Эрх газрын эрх зүй, мөрдөн шалгах болон олон талт зарчим
100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 1.0¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 3,300 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 4,800 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 270 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 13.0 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 2.0 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.7

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Үгүй

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Дээд Шүүхийн ажилтан (2006)

2. Мөн тэнд

3. Мөн тэнд

4. Дэлхийн банкны хөгжлийн үзүүлэлтүүд (2005)

5. Дээд Шүүхийн ажилтан (2006)

6. Сангийн Яам

Балбын шүүх байгууллага улсдаа авлигад хамгийн их автсан салбаруудын нэгд тооцогддог.¹ Авлига засаглалын бүхий л салбарт нүүрлэсэн байдаг хэдий ч шүүх байгууллага дахь авлига жирийн иргэдэд² аюул заналхийлэл учруулж, тэдний амьдрал, өмч хөрөнгө болон эрх чөлөөнд шууд нөлөөлдөг. Энэ нь эрх зүйт төрийг баталгаажуулахад (эсхүл оршин тогтноход) томоохон саад тотгор болж байгаа юм.

1990 оны Үндсэн хуульд Балбын шүүх байгууллага нь гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын шийдвэрт хяналт тавих төрийн хараат бус байгууллага болно гэж заажээ. Энэ заалт бүрэн утгаараа хэрэгждэггүй боловч авлигад хяналт тавих дорвитой арга хэмжээнүүдийг авч эхлэн, авлига үйлдсэн байж болзошгүй шүүгч болон шүүхийн ажилтнуудын эсрэг мөн арга хэмжээ авч байгаа ажээ.³

Дээд шүүх өөрийн дуу хоолойгоо идэвхжүүлсэн нь

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд болж өнгөрсөн 10 жил үргэлжилсэн Маоист бослогын үймээн самуун, улс төрийн намуудын хувийн эрх ашиг хөөсөн үйл

1 Бабурам Дакал, Адалатма Бастачар (Шүүхүүд дэх авлига), өөрөө хэвлүүлсэн (2006), мөн ТИ-ийн Өмнөд Азийн Авлигын талаарх Өрхийн судалгаа (2002)

2 “Авлигыг Хянах Зөвлөмжийн Хорооны Тайлан”, 1999 онд Балбын Засгийн газарт өргөн барьсан.

3 Ананта Раж Луител, “Шүүгчдийг томилох ажиллагаа ба түүнтэй холбоотой маргаанууд”, Авлигын эсрэг Судалгаа болон Хэвлэл мэдээллийн Төвийн Сайн засаглалын мэдээнд гарсан, Балба, 2006 оны 2-3 сар.

ажиллагаанууд болон Гианэндра хааны улс төрийн санаархал бүгд нийлээд ял завших, цээрлэл үл хүлээх байдал, мөн авлигыг хөхиүлэн дэмжсэн улс төрийн тогтворгүй байдал үүсэхэд хүргэжээ. Үндсэн хууль болон бусад эрх зүйн баримт бичигт авлига үйлдэхийг хориглосон авч хуулийн хэрэгжилт муу, улс төрийн эрмэлзэл дутагдалтай байх, мөн 2005 оны 2 дугаар сарын 1-нд Хаан төрийн эрхийг булаан авсан явдал авлигач этгээдүүдэд зэмлэл хүлээлгэлгүй өнгөрөх бололцоог бүрдүүлжээ.

Хаан Гианэндрагийн парламентыг тарааж, Авлигыг хянах хааны ажлын комиссыг (АХХАК) байгуулсан явдал үндсэн хуулиар томилогдсон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахтай тэмцэх алба болох төр засгийн байгууллагын эрх мэдлээ урвуулан ашиглах хэргийг мөрдөн шалгах комиссын эрх хэмжээнд хөндлөнгөөс нөлөөлж, тус байгууллагын үйл ажиллагааг сулруулж байгаа нь авлигын эсрэг хөдөлгөөнийг түгжигдмэл байдалд оруулсан байна.

Түүнээс 1 жилийн дараа буюу 2006 оны 2 дугаар сарын 13-нд Дээд шүүхээс АХХАК-ыг үндсэн хууль зөрчсөн гэж үзэн үйл ажиллагааг нь нэн даруй зогсоох шийдвэр гаргажээ. Ингэснээр авлигын хэргээр саатуулагдаад байсан, шахан зайлуулагдсан Ерөнхий сайд Шер Бохадур Деубаг чөлөөлөх замыг нээж өгчээ. 4 дүгээр сард өрнөсөн олон нийтийн эсэргүүцэл хааныг парламентыг дахин сэргээж, эцэст нь өөрийн эрх мэдлээс татгалзахад хүргэсэн юм. Дээд шүүхийн шийдвэр Балбад хараат бус шүүх жинхэнэ утгаар оршин тогтнох нөхцөлийг хангаж өгсөн алхам болсон ч өнгөрсөн жилүүдэд хааны талыг баримтлагч шүүгч нарыг томилож байсан үйлдлийнхээ төлөө ихээхэн шүүмжлэгдэж, буруушаагдаж байсан юм.⁴ Идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг Балбын өмгөөлөгч нарын нийгэмлэг захиргаадалтын засаглалын үед шүүхээс гаргасан “үлбэгэр” шийдвэрүүдийнх нь төлөө шүүхийг байнга буруушааж байсан бөгөөд эцэст нь Балбын хааны арми болон цагдаад саатуулагдаад буй идэвхитнүүдийн өмнөөс гаргасан олон habeas corpus өргөдлүүдийг нааштай шийдвэрлүүлж чадсан юм.

Шүүгчид хамт ажиллагсад, мэргэжил нэгтнүүд болон тэтгэвэр тэтгэмжээ хамгаалдаг

1990 оны Үндсэн хуульд парламент нь Дээд шүүхийн шүүгчийг авлигын хэрэгт холбогдсон нь тогтоогдсон тохиолдолд импичментын журмаар албан тушаалаас нь огцруулах заалт байдаг ч энэ эрх мэдлээ 15 жилийн туршид огт хэрэгжүүлээгүй байна. Үндсэн хуульд дийлэнх олонхийн 2/3-ийн саналаар импичмент явуулна гэж тусгасан нь уг заалтыг парламентын санал хуваагдсан тохиолдолд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг бөгөөд парламентыг тараах тохиолдолд бүр ч бүтэмжгүй асуудал болох юм. Өөрөөр хэлбэл бие даасан авлигын эсрэг алба болох Төр засгийн байгууллагын эрх мэдлээ урвуулан ашигласан хэргийг мөрдөн шалгах комисс шүүгч нарын эсрэг ямар ч арга хэмжээ авах эрхгүй гэсэн үг юм.

4 Азийн Хүний Эрхийн Комисс, хэвлэлийн мэдээ, 2006 оны 2 сарын 15

Тиймээс шүүгч нар Үндсэн хуулийн хөдөлбөргүй заалтын дагуу халдашгүй эрх ямба эдэлдэг байна.

Давж заалдах болон дүүргийн шүүхүүдийн шүүгчдийн хууль бус үйл ажиллагаатай холбоотой хэргүүдийг Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн зөвлөл боломжтой бүх арга хэмжээг аван шийдвэрлэх үүрэгтэй. Шүүхийн зөвлөлийг Ерөнхий шүүгч тэргүүлдэг бөгөөд бүрэлдэхүүнд нь Дээд шүүхийн дээд тушаалын 2 шүүгч, Хууль зүйн сайд болон Хааны төлөөлөл багтдаг. Эрх мэдэл бүхий энэ Шүүхийн зөвлөл доод шатны шүүхийн олон шүүгчдийн талаар ирсэн гомдлын мөрөөр шийдвэртэй арга хэмжээ авахгүй байснаараа тэдгээр шүүгч нарыг илчлэгдэхээс хамгаалсан байна. Доод шатны шүүхийн шүүгчдийн талаар ирсэн олон гомдлууд шийдвэрлэгдээгүй байсаар байна.

Кришна Кумар Верма, Бали Рам Кумар хэмээх Дээд шүүхийн 2 шүүгч Интерполоор эрэн сурвалжилж буй мансууруулах бодисны хууль бус наймаачин Гордон Уильям Робинсонд холбогдох хэргийг цагаатган хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүмжлүүлсний дараа 2004 онд албан тушаалаасаа буусан байна. Робинсоныг Катмандугийн онгоцны буудал дээрээс цүнхэндээ 2.3 кг герион авч явахад нь баривчилжээ. Тэрээр 17 жилийн хорих ял авч, 1.7 сая Rs (24125 ам.доллар)-ын торгууль төлөх болсон ч Дээд шүүхээс баримт нотолгоо хангалтгүй гэсэн үндэслэлээр цагаатгасан байна.⁵ Түүнээс гадна шүүхийн зөвлөл мөрдөн байцаах, шийтгэл ногдуулах арга хэмжээ авалгүй шүүгч нарыг чимээгүйхэн тэтгэвэрт нь гаргасан байна.

Ерөнхий шүүгч асан Бисва Нат Упадхая олон нийтэд хийсэн мэдэгдэлдээ зүй бус үйлдлүүд гол төлөв авлигач шүүгч болон өмгөөлөгчид үгсэн ажиллах үед гардаг гэжээ.⁶ 1990 оны Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссын тэргүүлэгч асан Упадхая Шүүхийн зөвлөлийг шүүх байгууллага дахь авлигыг зогсоогоогүй, “албан ёсоор хуваарилсан тоо, хэмжээ”-ний дагуу доод тушаалын шүүгчдийг томилоогүй төдийгүй тушаал дэвшүүлээгүй хэмээн буруутгаж байжээ.⁷

Энэ нь шүүх байгууллагыг удаан хугацаанд улс төржүүлсэн уламжлалыг бий болгоход нөлөөлсөн юм. 1990 онд ардчиллыг сэргээн тогтоосны дараагаар шүүгчээр томилогдсон шинэ шүүгчдийн дийлэнх нь эрх баригч Балбын Конгресс нам болон түүний удирдлагуудтай холбоо сүлбээтэй байсан бөгөөд энэ явдал Балбын Коммунист нам, мөн Растрия Пражатаантра нам засгийн эрхэнд гарахад мөн давтагджээ. Гианэндра хааны засаглалын үед хаан өөрийн хүрээний хуульчдыг шүүгчээр томилж Паван Кумар Ожа гэгчийг Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурор, дараагаар нь Дээд шүүхэд ажиллуулахаар тушаал гаргасан нь Балбын Өмгөөлөгчдийн нийгэмлэгийн зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч

5 Өгүүллэгийг nepalnews.com-оос үз, 2005 оны 1 сарын 4, мөн www.nepalnews.com.np/contents/nepaliweekly/nispakshya/2005/jan/jan04/thisweek.htm-ээс үзэх боломжтой.

6 Spacetime (Балба), 2003 оны 12 сарын 13

7 2006 онд Балбын Өмгөөлөгчдийн Холбооны Алтан ойн дурсгалд өгсөн ярилцлага

байжээ. Улс төртэй холбогдоогүй шударга хуульчид томилгооны ажиллагаанаас хол хоцордог байна.

Албан ёсны шүүн таслах ажиллагаа дийлэнх олонхи хүмүүст хэт өндөр үнэтэй тусаж байна

Шүүхэд хууль бус үйлдэл хийх явдал цөөнгүй гардаг бөгөөд хэрэг үйлдэгч этгээдүүд нь ихэнхдээ шүүхийн ажилтнууд байх ба тэд гол төлөв өмгөөлөгчидтэй хуйвалддаг байна. 2002 оны ТИ-ийн Авлигын судалгаа нь Балбын ард иргэд шүүхийн ажилтнууд болон өмгөөлөгчид албан ёсны шүүх ажиллагааг ямарч үр дүнгүй үргэлжилсэн үйл явц болгож, завхруулах гэж хуйвалддаг гэж үздэг болохыг харуулж байна.⁸ 1990 оны үндсэн хуулийн төслийг санаачилсан, олны хүндэтгэлийг хүлээсэн Ерөнхий сайд асан Кришна Прасад Бхаттарай нэг удаа үндэсний телевизээр “өчүүхэн бага цалин авдаг албан тушаалтнууд өөрсдийн зардлыг нөхөх өөр хувилбарууд хайхаас аргагүй байдалд ордог. Иймд үйлчилгээ үзүүлсний төлөө төлөх “ex gratia” төлбөрийг олон нийт ч үүнийг шаардвал төлөх ёстой мэтээр ойлгодог” гэж мэдэгджээ.⁹

Аллага, орон байрны хулгай, мансууруулах бодисын худалдаа, авлигын хэрэг зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үед хээл хахууль илүүтэйгээр өгдөг.¹⁰ 2003 оны ТИ-ийн Рупандехи дүүрэг дэх авлигыг тодорхойлох судалгаа шүүхийн ажилтан, өмгөөлөгч, шүүгч, яллагдагчийн зуучлагч нар бүгд төлбөрийн зохих хэмжээг тогтоосны үндсэн дээр яллагдагчийг суллуулахаар ажилладаг болохыг харуулж байна.¹¹ Балбын Өмгөөлөгчдийн нийгэмлэг, иргэний нийгмийн байгууллага болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Робинсоны хэрэг шиг хэрэг үйлдсэн гэмт этгээдүүдийг цагаатгасан шүүхийн шийдвэрүүдийг хүчтэй шүүмжилдэг байна. Улс төрийн оролцоо, Үндсэн хууль болон бусад хуулиудын заалтыг үндэслэлгүйгээр тайлбарлах, хэрэглэх, олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн заргуудыг шийдвэрлэхэд алгуур хандах, шийдвэр гаргах процессыг удаашруулах зэрэг нь авлигыг цэцэглүүлдэг. Мөн шүүх тогтолцоо үр ашиггүй, нэг талыг барьсан, өртөг зардал ихтэй байна гэсэн шүүмжлэлүүд гарчээ.¹²

Олон нийтийн дундах эрх мэдлээ урвуулан ашиглах явдал газар авсан гэсэн ойлголт албан ёсны шүүх тогтолцоонд итгэх итгэлийг алдагдуулж байгаа юм. Тиймээс дээрх байдлаас улбаалан ядуу иргэд Маоист шүүхүүдэд хандах, зарга үүсгэх явдал ихэсжээ. Засгийн газрын зүгээс “шүүх нэртэй хэлбэр төдий” зүйл (kangaroo court) гэж гутаан нэрлэдэг эдгээр шүүхүүд мэргэшсэн өмгөөлөгчийн оролцоогүйгээр гэмт хэргийн сэдэлтэй үйлдлээс эхлээд малын хулгай хүртэл

8 ТИ-ийн Авлигын талаарх Өрхийн судалгаа (2002)

9 Балбын Хуулийн Нийгэмлэг, “Балбын шүүх тогтолцоо: Олон нийтийн санаа бодлын талаарх Үндэсний судалгаа”, 2002 оны 11 сар

10 Авлигыг Хянах Зөвлөмжийн Хорооны Тайлан (1999)

11 ТИ-Балба, “Рупандехи дүүрэг дэх Авлигын хэмжээ” (2003)

12 ТИ-Балба, “Балба: Үндэсний шударга байдлын тогтолцоо” (2004)

жижиг сажиг хэргүүдийг шуурхай шүүн тасалдаг ажээ. “Эрүүгийн хэргийг шүүх системд шүүх баячуудын талд үйлчилдэг, харин ядуус шударга явдлыг хайх нь зэрэглээ хөөхтэй адил” гэж бослого гарсан тосгоны эмэгтэй ярьж байна.¹³ Хүчингийн хэрэг гэх мэт хүчирхийллийн гэмт хэрэгт хатуу ял шийтгэл оноон нэр хүнд олж авсан шүүхүүд олон эхнэртэй байх явдлыг хянахад үр дүнтэй ажилладаг байна. Маоист шүүхийн ажиллагааг 2006 оны 7 дугаар сард шинэ засгийн газартай хийсэн эвлэрлийн хэлэлцээрээр зогсоосон ажээ.

Шинэтгэл хийх алтан боломж

2006 онд гаргасан Балбын үндсэн хуулийн санал болгож буй төсөлд анх удаа дүүргийн шүүхийн шүүгчийн ажилд нэр дэвшиж буй нэр дэвшигчийг шалгалтанд оруулж шалгах төсөл оруулжээ. Дээд шатны шүүхийн шүүгчдийг шууд эсхүл доод шатны шүүгчдээс тушаал дэвшүүлэн томилно гэжээ. Эдгээр арга хэмжээ нь шүүгчийг томилох ажиллагаанд давуу тал олгох байдлыг хязгаарлах бөгөөд шүүх байгууллагад ур чадвар болон итгэл үнэмшил төрүүлэхүйц байдлыг бий болгох зорилготой юм. Түүнчлэн Шүүхийн зөвлөлийн гишүүнээр Балбын Өмгөөлөгчдийн нийгэмлэгээс зөвлөмж болгосны дагуу ахлах өмгөөлөгч нараас томилно гэсэн заалтыг тусгажээ. Ингэснээр өмгөөлөгчид шүүх байгууллагад иргэний нийгмийн “ажиглагч”-ийн үүрэг гүйцэтгэхэд тус дөхөм болно гэж найдаж байгаа юм.

Шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс Дээд шүүх НҮБХХ болон АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар шүүхээс гадуур буюу харилцан хялбарчилсан журмаар хэрэг шийдвэрлэхийг дэмжих, шүүгчдийг чадавхижуулах, хэрэг шийдвэрлэх явцыг түргэсгэхэд чиглэсэн хэд хэдэн хөтөлбөрүүдийг саяхнаас хэрэгжүүлж эхлээд байгаа ажээ. Гэсэн хэдий ч шүүгч нарын ур чадвар, ёс зүйн суурь мэдлэгийг сайжруулах, шүүхийн салбарын нэр хүндийг өсгөх, шүүхийн шударга байдлыг бий болгох хөтөлбөрүүдийг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай юм. Парламент болон шинэ засгийн газар авлигын гэмт хэрэгт холбогдсон шүүгчийг мөрдөн шалгах, баривчлах болон эд хөрөнгийг нь хураах эрх мэдэл бүхий өндөр төвшний хараат бус байгууллагыг маш хурдан байгуулах ёстой. Үүний тулд Шүүхийн зөвлөлийн зохион байгуулалтыг өөрчлөх замаар шинээр байгуулах, эрх мэдэл болон чадварыг нэмэгдүүлэхээс эхлэх хэрэгтэй.

Ардын хөдөлгөөний дэмжлэгийг авсаар байгаа долоон намын эвсэл шүүх байгууллага дахь авлига, хууль бус явдлыг бодитойгоор багасгах шинэ бодлогыг боловсруулах чадавхитай гэдгээ харуулах ёстой юм. Одоогийн шүүх эрх мэдлийн тогтолцоо нь үйл ажиллагаагаа үр нөлөөтэй хэрэгжүүлэх чадваргүй гэдэгт эргэлзэх зүйлгүй болсон тул олон нийт хараат бус, үр дүнтэй, шударга шүүхийг хүссэн хэвээр байгаа билээ.

*Кришна Прасад Бхандар
(Ахлах зөвлөх, Балбын дээд шүүх, Катманду)*

13 Inter Press Service (Итали), 2004 оны 7 сарын 29, southasia.oneworld.net/article/view/90875/1/-ээс үзэх боломжтой.

Нигер дэх эрх мэдлийн хуваарилалт

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, олон талт зарчим(Исламын хуулийн элемент бүхий), прокурор нь шүүх эрх мэдэлдээ хамаардаг

100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 1.3¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 6,096 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 13,188 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 240 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 5.4 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 415.4 сая ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 1.3

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага:

Мэдээлэл байхгүй байна

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Төслийн шатанд явж байгаа

1. Шүүхийн шинэчлэлийн хөтөлбөрийн тайлан (2003)

2. Дөнгөж томилогдсон хоёр шүүгчийн төлбөрийн баримт (2006 оны 1 дүгээр сард томилогдсон)

3. Хууль зүйн яам (2006)

4. Дэлхийн банкны хөгжлийн үзүүлэлтүүд (2005)

5. Бүгд Найрамдах Нигер улсын албан ёсны хэвлэл, 2005 оны 12 сарын 6-ны өдөр

Нигерийн түүхэн дэх зургаа дахь үндсэн хууль болох одоо мөрдөж буй Үндсэн хуулийн 98-р зүйлд “шүүх нь гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагаас хараат бус байна” гэж заажээ. 100-р зүйлд “Шүүгчид өөрийн үүргээ гүйцэтгэхдээ хараат бус бие даан ажиллах ба зөвхөн хуульд захирагдах бөгөөд Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч шүүгчдийн хараат бус байдлыг баталгаажуулна” гэжээ. Гэвч энэхүү зохицуулалт нь “прокуроруудын үйл ажиллагааг албан ёсны удирдлага ба Хууль зүйн сайд хянан удирдана” гэж шүүгч болон хуульчид (гол төлөв прокурор болон шүүхийн бусад албан тушаалтнууд)-ын статусыг тодорхойлсон 1988 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 88-01 тоот тушаалын 4-р заалттай зөрчилдөж байгаа юм. Мөн тус хуулийн 5-р зүйлд “Төрийн тэргүүн нь шүүхийн ажилтнуудыг Хууль зүйн сайдын саналыг үндэслэн томилох ба шүүгчдийг Шүүхийн албаны хороотой зөвшилцөсний үндсэн дээр томилоно” гэж заажээ.

Шүүх эрх мэдлийг Үндсэн хуулийн шүүх, cour de cassation (давж заалдах хамгийн дээд шатны шүүх), төрийн зөвлөл¹, аудитын алба, мөн дээд болон доод шатны шүүхүүд тус тус хэрэгжүүлнэ.

1 Төрийн зөвлөл (conseil d'etat) нь хамгийн дээд шатны захиргааны шүүх бөгөөд хууль тогтоомжоос үүдэн гарсан асуудлуудад засгийн газрын зөвлөхийн үүрэг гүйцэтгэдэг.

Прокурорууд: “гүйцэтгэх засаглалын зэвсэглэсэн жигүүр мөн үү”?

Прокурорууд Хууль зүйн сайдаас хараат байдаг нь гүйцэтгэх засаглалыг амаар эсхүл бичгээр өгсөн удирдамжуудын аль альнаар нь дамжуулан шүүх байгууллагын хэрэгт хөндлөнгөөс оролцох явдлыг дэмжиж байгаа бөгөөд ингэснээр “прокурорын алба шүүх эрх мэдлийн байгууллага доторх гүйцэтгэх засаглалын зэвсэглэсэн жигүүр мөн” гэсэн яриа гарах сэжүүр болж байгаа юм. Улсын прокурорын албаны доод тушаалын албан хаагчдыг Хууль зүйн сайд томилдог нь Нигерийнх шиг Ромын загварт тулгуурласан бүхий л шүүх тогтолцоонд байдаг ерөнхий зарчим боловч Нигерийн бусад төрийн байгууллагуудын сул тал цаашид үүнд таагүй үр нөлөө үзүүлнэ.

Үндсэн хуулиар шүүгчийн бүрэн эрхийн хугацааны баталгаат байдлыг хамгаалж өгсөн ч үүнийг төдийлөн хэрэгжүүлдэггүй байна. Ерөнхийлөгч тусгай албан тушаалын баталгаагүйгээр шүүгчийг томилох, мөн шүүгчдийг прокурорын алба руу шилжүүлэх учраас тэдний хараат бус байдал угтаа тун эргэлзээтэй байдалд ордог. 5-р зүйлд заасанчлан төрийн тэргүүн Шүүх албаны хороотой зөвшилцөлгүйгээр прокуроруудыг томилдог ажээ.

Онолын хувьд шүүгчдийн хараат бус байдлыг хамгааллах ёстой уг хороог төрийн тэргүүн даргалж, Хууль зүйн сайдын өргөн барьсан бодлогыг дэмждэг байна. Үүний дүнд “зөв газарт нь зөв хүнийг тавих” зарчмыг мөрдөх нь ховор. Жишээлбэл нийслэл Ниамей дахь бүсийн шүүхэд эгзэгтэй хэргүүд дээр (тухайлбал сэтгүүлчид болон сөрөг хүчний удирдагчдыг яллах, зэвсэгт хүчин эсэргүүцлийн жагсаал болон иргэний нийгмийн байгууллагын тэргүүнүүдийг баривчлахад гарсан үймээн самуунтай холбоотой хэргүүд дээр) ямагт нэг л шүүгчийг Хууль зүйн сайдын тушаалаар уг хэргүүдийг хянан шийдвэрлүүлэхээр томилдог байна. Энэ нь Шүүхийн албаны хорооны хэмжээнд ч шүүгчдийг томилохоос өмнө ёс зүйн хэм хэмжээ баримталдаг эсэх болон албаны чиг үүргээ хэрхэн хангаж ирсэнийг шалгуур болгож үздэггүй болохыг харуулж байна. Энэ нь үнэн хэрэгтээ түүний санаачилгаар шүүгч болон өмгөөлөгчийн нэгэн бүлгийг байгуулж, эрх мэдэл бүхий албан тушаалын хүмүүстэй “бөмбөг” тоглох хуульчдыг нэг дор цуглуулсан хэрэг юм.²

Шүүх засаглалд итгэх олон нийтийн итгэл бага байгаа нь Үндсэн хуулиар тогтоосон хараат бус байдлын зарчмыг баримтлахгүй байгаатай шууд холбоотой юм.

Анхан шатны шүүхэд эрх барих намын дэмжлэтэйгээр томилогдсон ахлах тушаалын төрийн албан хаагчдын асуудлыг хөндсөн 61 хэргээс зөвхөн хоёр хувийг нь л шүүх хуралдаанаар хэлэлцжээ.³

2 Le Sahel (Нигер), 2005 оны 7 сарын 4

3 Le Sahel (Нигер), 2006 оны 9 сарын 2

Авлигын гэмт хэрэгт холбогдоод цээрлэл үл хүлээдэг, ял завшдаг байдал дан ганц шүүгчдийн ажиллагаанаас хамаардаггүй байна. Ямар ч шүүх хэн нэгэн гомдол мэдүүлээгүй эсхүл ял төлөвлөж ирүүлээгүй хэргийг шүүн таслах эрхгүй байдаг. Улсын прокурорын албанаас хүсэлт гаргасан эсхүл хохирол учруулсан гэж гомдол гаргасан тохиолдолд процесс явагдаж эхэлдэг байна. Төрийн хөрөнгийг хувьдаа завшихтай холбоотой хэргүүдэд төр засгийн байгууллагууд шүүхэд гомдол гаргах ёстой ажээ. Хэрэв хэргийг шүүхэд шилжүүлж ирүүлэхгүй л бол шүүгч шүүн таслах ажиллагааг гардаж хийх боломжгүй.

Дээд албан тушаалтны авлигын гэмт хэргийн жишээ болсон Боловсролын яамнаас хөрөнгө завшсан гэх саяхан үйлдэгдсэн нэгэн хэрэг аажмаар ил гарсан байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тус хэргийг олон нийтэд цацсанаас хойш⁴ цагдаагийн газраас урьдчилсан мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхэлжээ. Шүүхийн хараат бус байдал хангагдахгүй учир төрийн өмчийн хөрөнгөөс олон сая доллар завшсан хэрэг ч хэрэгсэхгүй болгох вий, Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд хоёул ял завших вий гэсэн сэжиг, айдас их байжээ. Хэдийгээр хэрэг шийдвэрлэх процесс дуусаагүй ч хэргийн явцаас авлигатай хийх тэмцэлд иргэний нийгмийн байгууллагууд маш их үүрэг гүйцэтгэж болохыг харж болно.

Авлигын бүтэц

Орон бүрт байдагчлан Нигерийн шүүх төрийн бусад байгууллагуудын (цагдаа, хорих газар) туслалцаатайгаар хууль зүйн үйлчилгээг хүргэдэг. Гэмт хэрэг гарахад цагдаа шууд мөрдлөг явуулдаг. Улмаар тэд хавтаст хэргийг шүүхэд шилжүүлж, хэргийг шийдвэрлэх шүүгчид шилжүүлдэг. Өмгөөлөгч нар доод шатны шүүхэд яллагдагчийг өмгөөлдөг бол шийдвэр гүйцэтгэгчид (huissiers de justice гэж нэрлэгддэг мэргэшсэн хуульчид) иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлдэг. Энэ сүлжээний хаана нь ч авлига үйлдэгдэх боломжтой.

- **Цагдаагийн байгууллагын хүрээнд:**

Яллагдагчийн төрөл төрөгсөд мөрдөн шалгах ажил явуулж буй ажилтантай холбогдон, төлбөр өгч зөвшилцөх эсхүл гомдол гаргаж буй этгээдийг (айлган сүрдүүлэх болон бусад хэлбэрээр) нэхэмжлэлийг нь эргүүлж авахуулах ажлыг даатгадаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 12 болон 13 дугаар зүйлд цагдаа нь прокурорын, харин улсын прокурор шүүхийн хорооны хяналтанд байна гэж заасан байдаг ч дээрх тохиолдол түгээмэл гардаг. Хээл хахуульд өгсөн төлбөр нь шүүх ажиллагаанаас мултрах, яллагдагчийг цагдан хорихоос зайлсхийлгэх улмаар үнэн илчлэгдэхээс сэргийлнэ.

4 Le Republican (Нигер), 2006 оны 6 сарын 22 болон 2006 оны 7 сарын 13

- **Өмгөөлөгчдийн хүрээнд:**

Нэр алдартай болох, мөнгө түргэн олох хүсэл нь өмгөөлөгчдийг үйлчлүүлэгчээсээ төлбөр авч өөрт нь талтай шийдвэр гаргуулахаар хөөцөлдөхөд хүргэдэг. Нэгэн хэрэг дээр өмгөөлөгчийн хавтаст материал дотроос үйлчлүүлэгчээсээ өөрт нь төлөх төлбөрт шүүгчид өгөх хувийг багтаасан байхыг хүссэн тэмдэглэл олджээ.⁵ Нөгөөтэйгүүр, өмгөөлөгч өөрийн эсрэг талын өмгөөлөгчийг худалдан авч, үйлчлүүлэгчийнх нь хэргийг хэрэгсэхгүй болгоход хүргэдэг байна.⁶

- **Шүүгч болон шүүхийн ажилтнуудын хүрээнд:**

Нигерийн 11 сая оршин суугчдад 200 хүрэхгүй шүүгч болон шүүхийн албан хаагчид ногддог. Доод шатны шүүхүүдийн ажлын хэт ачаалал шүүх ажиллагааг удаашруулах, авлига үйлдэх нөхцлийг бүрдүүлэн, авлига газар авахад нөлөөлдөг байна.⁷ Бэлэн мөнгө өгөх болон бусад төрлийн авлигын хэрэг үйлдэх явдал их газар авсан ажээ.

Шүүгчийг хэргийн оролцогчтой шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нар эсхүл шүүхийн бусад ажилтнууд болох жижүүр зэрэг ажилтнууд холбож өгдөг байна. Ингэх хоёр хувилбар байдаг.

Нэгдүгээрт, яллагдагч нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгуулах, барьцаагаар суллагдах, гэм буруугүйд тооцогдох эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэтгэх зорилгоор шүүхийн ажилтантай өөрийн санаачилгаар холбоо тогтоодог.

Энэхүү тохиролцоог хийх этгээд нь өмгөөлөгч байж болох бөгөөд яг л “нэг хэсэг нь хууль мэддэг өмгөөлөгчид, харин нөгөө хэсэг нь шүүгчийг мэддэг өмгөөлөгчид” байдаг гэдэг олны дунд ам дамжин яригддаг алдартай зүйр үг байдаг шиг.⁸ Хэргийн шийдвэрлэлтээс хамаарч үйлчлүүлэгчид олгогдох нөхөн төлбөрийн хэмжээнээс өөрийнх нь орлого хамаарч буй өмгөөлөгч шүүгчтэй урьдчилан тохиролцож болно.

Хоёрдугаарт, шүүхийн ажилтан өөрөө эхэлж яллагдагчийг ээрч хоргоох нь бий. Дээгүүр алба хашиж, өндөр цалин авдаг байсан ч Нигерийн шүүхийн ажилтнуудын ажлын аюулгүй байдал Сенегал, Кот-Дивуар болон Буркина-

5 1998 онд Ниамейд болсон давж заалдах шүүхийн иргэний танхимын хуралдааны өмнөх шүүх хуралдааны урьдчилсан бэлтгэл хурал

6 Махаман Тиджани Алу, La corruption dans la justice au Benin, Niger et Senegal (Нигер болон Сенегал, Бениний шүүх тогтолцоон дахь авлига), Laboratoire d'études et de recherches sur les dynamiques sociales et le développement local, Etudes et Travaux дугаар 39 (2005)

7 Programme d'appui a la reforme judiciare (Шүүхийн шинэчлэлийг дэмжих хөтөлбөр), эцсийн тайлан, 2003 оны 2 сар

8 Мөн тэнд

Фасогийнхтай харьцуулбал хангалтгүй байдаг. Тиймээс олон албан хаагчид ажилтай байгаа дээрээ аль болох их мөнгө олохоор улайрдаг.

Нигерт шүүхийн ажилтнууд ажлын гараагаа сарын 75,000 CFA (138 ам.доллар) цалинтайгаар эхэлдэг. Цалингийн бусад нэмэгдлийг нь хашиж буй албан тушаалаас нь хамаарч өөр өөр хэмжээтэй байхаар тогтоодог. Харин Ниамейд шүүхийн ажилтнуудын татварын өмнөх цалин 205,000 CFA (375 ам.доллар) байдаг. Сарын түрээс болон холбогдох зардлуудыг суутгасны дараа тэдэнд хоол хүнс, тээвэр, түүнчлэн гэр бүлийнхэндээ (аав, ээж, эхнэр, ах, эгч, хүүхдүүд) зарцуулах 140,000 CFA (260 ам.доллар) үлддэг. Нигерт цалин хөлсийг сүүлийн 20 орчим жил нэмэгдүүлээгүй ажээ.⁹ Энэ нь “хоол залгуулах авлига” гаарахад хүргэжээ. Шүүгч, өмгөөлөгч, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга болон зуучлагч нар¹⁰ бүгд “жижиг” авлига үйлдэхэд оролцдог байж болзошгүй юм.

Зөвлөмжүүд

Улс төрийн хөндлөнгийн оролцоо болон сүрдүүлэгт автсан сул, авлигад идэгдсэн тогтолцоо нийгмийг бүхэлд нь хамарч байгаа тул эдгээр асуудлыг нухацтай авч үзэх шаардлагатай. Төрийн гол гол үйлчилгээнүүдийг сайжруулах зорилготойгоор хуваарилсан хэдэн сая ам.долларыг улс төрийн эсхүл хувийн ашиг хонжоо хайгчид завшсан гэж олон нийт үзэж байгаа юм. Шүүх засаглал ихээхэн хараат байгаа нь эдийн засгийн өртгийг нэмэгдүүлж, хүний эрхэд халдан, шүүхийн өмнө бүгд эрх тэгш байх эрхийг мөн хөсөрдүүлж байна. Улс төрчдийн эрх мэдлийг хуваарилах жигшүүрт зарчим, түүнчлэн ял завших явдал нь хууль эрх зүйн болон шүүх байгууллагад тогтворгүй байдал үүсэх суурийг тавьж байна.

Нигер улс саяхнаас ардчиллын замаар замнах болжээ. Хараат бус, ил тод, төвийг сахих заншил нь шүүгч, шүүхийн ажилтнууд болон иргэний нийгмийн байгууллагууд найдвартай, шударга бөгөөд авлигад автаагүй шүүхийн ач холбогдлыг ойлгосон цагт оршин тогтнох болно. Иргэний нийгмийн байгууллага, шүүгч болон шүүхийн ажилтнуудын мэргэжлийн холбоодыг хөгжүүлэх нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх шаардлага байгаагийн дохио боловч санхүүгийн эх үүсвэр бололцоо дутагдах, улс төрийн тогтворгүй байдал зэрэг нь энэ зорилгыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байдаг. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

- Шүүх тогтолцоог хангалттай нөөцөөр хангах (Нигер улс 1960 онд тусгаар тогтнолоо олсноос хойш Хууль зүйн яамны төсөв нийт төсвийн 1%-аас хэзээ ч давж байгаагүй)

- 9 2006 оны 5 сарын 1-ний өдрийн баярын үеэр гаргасан үйлдвэрчний эвлэлүүдийн мэдэгдэл
- 10 Хожим явуулах ажиллагаанд удирдамж өгдөг хуульч болон зарга үүсгэгч нарын хоорондын зуучлагч. Зарим нэг нь өөрсдийгөө шүүгчийн найз гэж итгүүлэн, өөрийн нэрээр хээл хахууль авч, өгч буй этгээдэд тухайн мөнгийг шүүгчид дамжуулна гэж үнэмшүүлдэг. Үз: Tidjani Alou.

- Шүүгч, хуульчид болон засгийн газрын албан тушаалтнууд өөрсдийн хөрөнгө орлогоо мэдүүлдэг байх шаардлагатай. Ингэхийн тулд үр нөлөө бүхий мониторинг хийх, залилан мэхлэх үйлдэл хийсэн нь нотлогдох аваас ял шийтгэл ногдуулах
- Шүүгч, хуульчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх
- Шүүгч, хуульчдыг томилох ил тод шалгуур, дүрэм журам боловсруулах
- Шүүгч сонгон шалгаруулах шалгалтыг чангатгах
- Шударга бус хэрэг үйлдсэн нь нотлогдох тохиолдолд зохих ял шийтгэл ногдуулж байх
- Давж заалдах шатны шүүх ажиллагаа нэг бус харин гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байхаар зохицуулах

Эрх мэдэл бүхий өндөр албан тушаалын ажилтнууд 2002 онд хэвлэмэл мэдээн дээр гарсан шүүх байгууллагад гардаг асуудлуудыг ухамсарлан ойлгодог байх хэрэгтэй. Шүүх тогтолцоонд ард иргэд төдийлөн итгэдэггүй, тэр бүү хэл шүүх тогтолцооны журам, албан хаагчдын зан байдалд урам хугарсан олон нийт үүнийг жигшдэг. Тэд шүүх ажиллагааг бүгд найрамдах улсын хуулийг хатуу мөрдсөний үндсэн дээр шийдвэрлэгддэггүй, харин мөнгө, улс төрийн хэлхээ холбоо гэх мэтийн эрх мэдлийн хоорондох тэмцлийг илүүтэй тусган шүүгч, хуульчдаар өөрсдийн анд найз нөхдийн хэргийг хялбар шийдвэрлүүлдэг гэж үздэг.¹¹

2005 онд эрх баригчид 2003 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор гаргасан Авлигатай тэмцэх стратегийг хэрэгжүүлэх Үндэсний хороо байгуулжээ. Хууль зүйн сайд шүүгч болон хуульчдын ёс зүйд хяналт тавих үүрэгтэй хороог байгуулах арга замыг олжээ.¹² 1974 оноос 1999 оны хооронд засгийн газруудын авлигатай тэмцэх янз бүрийн аргууд хэрэглэж байснаас амжилттай болсоныг нь дурдвал Үндэсний хянан шалгах алба, санхүүгийн хянан шалгах алба, төрийн хөрөнгө завших хэргийг шийдвэрлэх тусгай шүүх, гэмт хэрэг болон шударга бус явдлыг хянан шалгах комисс, мөн 1996 оны төрийн эргэлтийн дараа байгуулагдсан ёс зүйн хэм хэмжээг хянан шалгах комисс зэрэг болно.

Хууль эрх зүйн орчин нэгэнт бүрдсэн энэ үед авлигын гэмт хэрэг үйлдэх тохиолдолд эдгээр хуулийг хэрэгжүүлэх, хууль хяналтын байгууллагад үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах боломж олгох цаг нэгэнт болжээ.

*Шүүгч Жибо Абдулае
(Нигерийн авлигатай тэмцэх нийгэмлэг, Ниамей)*

-
- 11 2006 оны 8 сарын 24-нд Le Republician (Нигер)-т өгсөн өмгөөлөгч Маман Абу, Умару Кэйта нарын ярилцлаганд орсон Maitre Couliba Moussa-аас иш татсан. Хоёр сэтгүүлч худал, нэр хүндэд халдсан мэдээ дамжуулах гэж оролджээ.
 - 12 Комисс байгуулах 2003 оны 10 сарын 17-ны өдрийн 2003-256/PRN/PM тогтоол, уг тогтоолд бүрэлдэхүүн болон үүрэгт ажлыг тодорхойлсон байна.

Пакистан: Шүүх дэх хүлцэнгүй байдлын тогтсон “дэг”

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, мэтгэлцэх болон олон талт зарчим (Исламын хуулийн элементүүдийг багтаасан), холбооны улс
100000 хүнд ногдох шүүгчийн тоо: 1.1¹
Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 1,195 ам.доллар²
Дээд шүүхийн шүүгчийн цалин: 12,432 ам.доллар³
Нэг хүнд ногдох ҮНБ: 690 ам.доллар⁴
Шүүхийн жилийн төсөв: Мэдээлэл байхгүй байна
Жилийн нийт төсөв: 21.8 тэрбум ам.доллар⁶
Жилийн төсөвт эзлэх хувь: Мэдээлэл байхгүй байна
Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм
Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат
Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Үгүй
Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Дэлхийн банк (2000) 2. ТИ-ийн Үндэсний Шударга Тогтолцоог үнэлэх Тайлан (2003)
 3. Dawn (Пакистан), 2003 оны 12 сарын 23-ны өдөр

Пакистаны шүүх дэх авлигын асуудлыг тус байгууллагын түүхийг судлахгүйгээр ойлгох аргагүй юм. Шүүх тогтолцоог Британий колончлогчдоос тэр чигт нь хуулбарлан авчээ. Өнөөг хүртэл шүүхийн албан ёсны хэл нь нийт ард иргэдийн 98% нь ойлгодоггүй Англи хэл байсаар байгаа. Шүүхийг хууль бусаар хөрөнгөжих, эрх мэдэл авах тулааны газар гэж үздэг байсан ойлголт одоо ч хэвээр байна. Дийлэнх олонх, нэн ялангуяа хөдөөд жирга, панчаят гэх мэт албан бус маргаан шийдвэрлэх механизмыг ашигладаг.

ТИ-Пакистанаас хийж, 2006 оны 8 дугаар сард хэвлүүлсэн Үндэсний авлигын судалгаа шүүхийг авлигад автсан байдлаар 2002 онд дөрөвдүгээрт байсан бол 2006 онд гуравдугаар байранд орж улам дордсон болохыг харуулж байна.¹ 4,000 оролцогчдоос 3,568 нь өгсөн хээл хахуулийн дундаж хэмжээ төрийн бүх салбаруудад 38 ам.доллар байсан бол шүүхийнх 93 ам.доллар байжээ. Бусад анхаарал татсан зарим үзүүлэлтүүдийг дор жагсаав. Үүнд:

1 www.transparency.org.pk

Авлигын хэлбэрүүд	Гүйлгээнд шууд эсхүл шууд бусаар оролцогчид							
	Шүүгч	Шүүхийн ажилтнууд	прокурорууд	Нэхэмжлэгчийн өмгөөлөгч	Гэрч	Бусад	Нийт	Хувь
Шүүхийн ажилтанд төлөхийг шаардсан нэмэгдэл мөнгө	2	117	3	5	21	3	151	41.71
прокурорт төлөхийг шаардсан нэмэгдэл мөнгө	23	9	19	4			55	15.19
Гэрчид төлөхийг шаардсан нэмэгдэл мөнгө	17	9	13		8		47	12.98
Нэхэмжлэгчийн өмгөөлөгчид төлөхийг шаардсан нэмэгдэл мөнгө	3	15	2	18			38	10.50
Магистрат шүүгчид төлөхийг шаардсан нэмэгдэл мөнгө	3	27				2	32	8.84
Шүүгчид төлөхийг шаардсан нэмэгдэл мөнгө	11		5				16	4.42
Бусад (тодорхой заах)	2	11	1			9	23	6.35
	61	188	43	27	29	14	362	100.00

Оролцогч (үйлчилгээ үзүүлж буй этгээд) шууд мөнгө шаардсан	224	61.88
Оролцогч гуравдагч этгээдээр дамжуулан мөнгө шаардсан	107	29.56
Оролцогч (үйлчилгээ үзүүлж буй этгээд) шууд мөнгө санал болгосон	23	6.35
Үйлчлүүлж буй этгээдээс гуравдагч этгээдээр дамжуулан мөнгө санал болгосон	8	2.21
НИЙТ	362	100.00

Шүүх гүйцэтгэх засаглалд “үнэнч” ажиллахаа амлажээ

1947 онд тусгаар тогтнолоо олж, шинэ Пакистаны Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг бүрдүүлэн хуралдуулсан байна. Гишүүд үүнийг долоон жилийн турш хэлэлцсэн бөгөөд яг дуусах дөхөж байтал Захирагч Генерал Гулам Мухаммад сайд нарыг халах өөрийн эрх мэдлийг нь өөрчлөх оролдлого хийсний хариуд ажлын хэсгийг тараажээ. Анхны ажлын хэсгийн дарга Маулви Тамизуддин энэ шийдвэрийг эсэргүүцсэн байна. Захирагч генералын талд шийдвэр гаргасан дээд шүүхийн шийдвэрт ихэд почирдсон бөгөөд энэ үеэс шүүх байгууллага эрх барих хүчнийхэнд хүлцэнгүй хандах эхлэл тавигджээ.

1950-аад оноос Пакистаны түүх дангаар ноёрхсон цэргийн дэглэм болон иргэний засгийн газрын түр засаглал ээлжилсэн үеүдэд хуваагдсан байна. Бараг нэг дэглэм гарах бүрт шүүх болон гүйцэтгэх засаглалын хоорондын харилцаа, онц байдлын тухай заалт, мөн Ерөнхийлөгчийн эрх мэдлийн хугацааг тодорхойлж, үндсэн хуулийг шинэчилж байв. Мөн тухайн дэглэм бүр шүүх байгууллагыг эрх барих junta буюу цэргийн дэглэмд Үндсэн хуулиас илүү үнэнч байх “амлалт дахин өгөх”-ийг тулгаж байжээ. Энэ нь институциудыг сүйрүүлж, шүүгчдийн ёс суртахууныг доройтуулан, тэднийг хууль бус нөлөөнд амархан автахад хүргэсэн байна. Беназир Бхутто (1988-90 болон 1993-96) болон Наваз Шарифын (1990-93 болон 1997-99) иргэний засгийн газрууд тэдний өөрсдийнх нь эрх мэдэл армийн дэмжлэгээс хамаарч байсан тул цэргийн болон шашны тэргүүнүүд, мөн цэргийн дэмжлэгтэй улс төрчдийн хоорондын холбоог тасалж чадаагүй байна.

Эрх мэдлийг барьж буй өнөөгийн төрийн тэргүүн Генерал Первез Мушараф шүүгчдийг “Гүйцэтгэх засаглалын тэргүүн эсхүл өөрийнх нь удирдлага дор шийдвэр гаргах эрх мэдлийг хэрэгжүүлж буй хэн нэг этгээд”-ийн шийдвэр, эрх хэмжээг хориглохгүй, эсэргүүцэхгүй байхыг шаардсан 1999 оны Түр Үндсэн хуулийн тогтоолоор баталсан Шүүгч нарын тангарагт амлалт өгч, тангараг өргөхийг хүчээр шахах зэргээр шүүх байгууллагийг үндсэнд нь татан буулгах ажиллагааг хийжээ. 2000 оны 1 дүгээр сард Ерөнхий шүүгч Саидузаман Сиддики болон Дээд шүүхийн бусад таван шүүгч нар уг шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж, албан тушаалаасаа огцоржээ. 2003 онд Ерөнхийлөгч Мушараф Үндсэн хуулийн 17-р нэмэлт өөрчлөлтийн 2003 оны хууль гэж албан ёсоор нэрлэгдсэн Эрх зүйн ерөнхий тогтоолыг батлуулахыг тохиролцож чадсанаар Ерөнхий сайдыг халах, үндэсний чуулганыг тараах, мөн зэвсэгт хүчний дарга нар болон мужийн захирагчдыг томилох эрх мэдлээ эргүүлэн авчээ. Энэ тогтоолоор тэрээр мөн 2004 онд цэргийн албан тушаалаа хадгалах, 2007 оныг хүртэл Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах бүх нөхцөлийг бүрдүүлж авсан байна.

Засгийн газар нь ялангуяа дээд шүүхийн хэмжээнд шүүгч, шүүхийн ажилтнуудыг томилох, шилжүүлэх болон огцруулах ажиллагаанд хатуу хяналт тавьж байгаа.² Шүүгчдийн бүрэн эрхийн хугацааны аюулгүй байдал дутагдалтай байгаа нь тэднийг улс төрийн нөлөөнд амархан автахад хүргэдэг байна. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүгчид нэр дэвшиж буй нэр дэшигчийг, Хууль зүйн сайд,

2 Энэ ялгаа нь мужийн нийслэлүүдэд байрладаг 4 дээд шүүхүүд болон хамтдаа “дээд шүүх гэж нэрлэгдэх” Дээд шүүхийн 17 шүүгчийн хооронд гол төлөв гардаг ба бусад шүүхүүдийг нийтэд нь “доод шүүх” гэж үздэг ажээ. Үүнээс гадна Ерөнхийлөгчийн томилсон Ерөнхий шүүгчийг оруулаад 8 Лалын шашинт шүүгч нараас бүрдэх холбооны шариат шүүх гэж байдаг. Тус шүүх нь аливаа хуулийг Исламын хуультай харшилж байгаа эсэхийг шийдвэрлэдэг. Түүнчлэн мансуурах, хулгай, бэлгийн харилцаа зэрэг гэмт хэрэгт холбогдох худоод хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэрүүд дээр эрүүгийн шүүхүүдээс давж заалдах хурал явуулдаг. Вафаки Мохтасиб буюу Омбудсманы алба нь мөрдөн байцаах болон холбооны алба эсхүл албан тушаалтнуудын буруутай ажиллагаанаас хор хохирол амссан хүнд нөхөн төлбөр өгөх эрхтэй ажээ. Омбудсманыг мөн Ерөнхийлөгч томилдог.

парламент эцэст нь Ерөнхийлөгчид санал болгодог. Нэр дэвшигчийн жагсаалтыг Алба хоорондын тагнуулын газар гэдэг нөлөө бүхий байгууллага шалгадаг. Нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт шат тутамд өөрчлөгдсөөр шүүгчийг тэтгэвэрт гаргах, огцруулах эсхүл нас барснаас хойш сул орон тоог нөхөх 30 хоногийн хугацаанаас хэтэрдэг.

Дээд шүүх шүүгчдэд хэрэг хуваарилах болон шүүгчдийг мужийн шүүхүүдэд томилох захиргааны эрх мэдлийг хэрэгжүүлдэг тул гүйцэтгэх засаглал дээд албан тушаалын дуулгавартай шүүгч нарын тусламжтайгаар шат шатанд хяналтаа тавьдаг.³ Гүйцэтгэх засаглал мөн Ерөнхий шүүгч нарын сонгуулийн ажиллагаанд зүй бусаар нөлөөлдөг. Учир нь тэд доод шатны шүүх байгууллагуудын сонгуульт албан тушаалтнуудыг томилдог ажээ.

1999 оны 10 дугаар сард болсон цэргийн эргэлтийн дараагаар нэмэлт өөрчлөлт оруулсан Үндэсний хариуцлагын албаны (ҮХА) тогтоолын дагуу шүүн таслах ажиллагаа эрхлэх “хариуцлагатай хэргийн шүүхүүд” (1994 оноос хойш үйл ажиллагаа нь сулраад байсан) дахин сэргэж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Эдгээр шүүхүүд авлига, авлигын гэмт үйлдлүүд, хөрөнгө завшсан, хувь хүртэх, шан харамж авах авлигын үйлдлүүд болон эрх мэдлээ урвуулан ашигласан зэрэг гэмт хэргүүдийг түргэн шуурхай шийдвэрлэхээр байгуулагдсан ажээ. ҮХА улс төрчид, төрийн албан хаагчид болон бизнес эрхлэгчдийн эсрэг их хэмжээний авлигын зуу зуун гэмт хэргүүдийг амжилттай ялласан хэдий ч шүүгчид болон цэргийн албан тушаалтнууд олон тоогоор ялаас чөлөөлөгджээ. Уг тогтоолоор яллагдагчтай холбоотой хэргийг нотлох үүрэг хүлээлгэсэн ажээ.

Шүүх байгууллага дахь авлига өнөөдрийн байдлаар

Дээд шатны шүүхтэй холбоотой авлигын хэргийн талаар гомдол гарах байдал харьцангуй бага байгаа ч энэ нь авлига байхгүй байна гэсэн үг биш юм. Пакистаны Өмгөөлөгчдийн зөвлөлийн 2003 онд гаргасан шүүх байгууллагын талаарх анхны тайланд цэргийн дэглэм авлигыг тэвчих үзлийг бий болгож байгаа бөгөөд үүний шалтгаан нь “нөлөөнд автсан шударга бус” шүүгч нар засгийн газартай холбоотой хэргийг төдийлөн авч хэлэлцдэггүйтэй холбоотой юм гэжээ.⁴ Шүүхийн авлигын эсрэг гомдол ирүүлсэн тохиолдол бага байгаа өөр нэг шалтгаан нь 2003 оны 7 дугаар сард гаргасан зөрчсөн этгээдийг 6 сар шоронд хорих эсхүл 1,700 хүртэлх ам.доллараар торгох шийтгэл оногдуулах зэрэг хүчтэй дарамттай Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэхийн эсрэг тогтоол юм.⁵ Түүнчлэн парламент дахь шүүхийн үйл ажиллагааны тухай шүүмжлэл ч ял шийтгэл ногдуулах гэмт

3 Олон улсын Хямралын Групп, “Пакистанд Шүүхийн хараат бус байдлыг бий болгох”, Азийн тайлан дугаар 86 (2004). www.crisisgroup.org/home/index.cfm?l=1&id=3100-ээс үзэх боломжтой.

4 Daily times (Пакистан), 2003 оны 11 сарын 25

5 Unpan1.un.org/intradoc/groups/public/documents/NISPAcee/UNPAN016204.pdf

хэрэгт тооцогдох болсон.

Доод шатны шүүхүүд дэх авлига маш ноцтой байгаа бөгөөд шүүхийн үйл ажиллагааны дийлэнхийг хээл хахууль эзэлж, шүүх ажиллагааны шат тутамд мөнгө төлөхийг шаарддаг байна.⁶ 2002 онд бүс нутаг бүрээс 3,000 хүн хамруулан ТИ-Пакистанаас явуулсан судалгаа доод шатны шүүхүүдтэй харьцсан оролцогчдын 96 хувь нь шүүхийн ажилтан, гэхдээ ихэнхдээ шүүгч нарын зүгээс авлигатай тулгарсан болохыг харуулж байна.⁷

Хэдийгээр доод шатны шүүхүүдэд шүүх хуралдааны дийлэнхийг нутгийн хэл дээр явуулдаг боловч Англи хэл дээрх хууль, дүрэм нь авлига гарах нөхцөлийг бүрдүүлж байгаа ажээ. ҮХА-ын 2002 оны Үндэсний Авлигын эсрэг стратегиар “Шүүх ажиллагаанд иргэд хамгийн анх хуульчдын зүгээс авлигатай тулгардаг. Үйлчлүүлэгч өмгөөлөгчтэй уулзаж мэргэжлийн зөвлөгөөг ховорхон авдаг бөгөөд тэд ихэнхдээ заргатай нь холбоотой худал найдвар төрүүлдэг. Улмаар тэр хэрэгт бэлтгэх нэрийдлээр их хэмжээний мөнгө шаарддаг ч энэ нь хууль бус гэдгийг үйлчлүүлэгчид төдийлөн мэддэггүй” гэж нотолсончлон өмгөөлөгчид зарга үүсгэгчийг будилуулдаг байна.⁸ Үүнээс хамгийн ихээр хохирдог нь өмгөөлөгчид хээл хахуульд өгөх мөнгөгүй эсхүл барьцаа төлж дийлэхгүй эмэгтэйчүүд, хүүхдүүд л байдаг. Үүнийг бичиж байх үед, Худодын тогтоолоор 4,000 орчим эмэгтэйчүүд шоронд хоригдож байгаа гэжээ.⁹

Муу нэр хүнд ба сул хариуцлага

Шүүхийн хамгийн дээд сахилгын байгууллага нь гурав буюу түүнээс дээш тооны Дээд шүүхийн шүүгчид болон Ерөнхий шүүгчээс бүрдсэн Дээд шүүхийн зөвлөл байдаг. Шүүгчдийн эсрэг гаргасан гомдлын дагуу мөрдөн шалгах, холбогдох арга хэмжээ авахаар 2005 оны 11 дүгээр сард тус зөвлөл хуралдсан ч нэг ч шүүгчид сахилгын арга хэмжээ аваагүй байна.¹⁰ Зөвлөл хэдийгээр цагдаа, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс шүүгч нарын үйлдсэн авлигын талаар “мэдээлэл” хүлээн авч байсан ч тухайн гомдлыг “худал, яльгүй эсхүл санаанаасаа зохиосон” нь тогтоогдвол гомдол гаргасан эх сурвалжийн эсрэг “шууд арга хэмжээ” авах эрхтэй байна.

6 ТИ-Пакистан, “Үндэсний Шударга Байдлын Тогтолцооны Судалгаа” (Карачи: Транспэрэнси Интернэшнл, 2003). Үз: www.transparency.org.pk

7 “Өмнөд Ази дахь Авлига: Өмнөд Азийн 5 оронд явуулсан иргэдийн ойлголтыг тандсан судалгаанууд” (Берлин: ТИ, 2003)

8 www.transparency.org.pk-ээс үзэх боломжтой.

9 Худоод Тогтоол нь үүнийг шариат хуульд оруулсан Генерал Зибул Хакын гоц санаа байсан юм. Бусад зүйлүүдээс гадна үүнд хүчиндүүлсэн эмэгтэйчүүд өөрсдөө гэр бүлээс гадуур бэлгийн харьцаа тогтоосонд буруутгагдаж, дөрвөн гэрчтэй байхаас нааш хэргийг амжилттай яллуулж чадахгүй байдалд хүрэх болзол байдаг.

10 The Nation (Пакистан), 2005 оны 11 сарын 20

Шүүхийн авлига бол мэргэжлийн ур чадварын талаарх хэтэрхий сул, доогуур стандарт болон иргэний үүргээ биелүүлэх хэм хэмжээ дутагдалтай байгаа зэрэг ихээхэн гүн үндэс, язгуураас үүдэн гарсан шинж тэмдэг юм. Өндөр албан тушаалтнуудыг засгийн газартай холбоо сүлбээтэй зүгээр л “том хиймэл ус”-н голнууд гэж үздэг. Доод шатны шүүхийн бага цалин хөлс шүүгч болон шүүхийн ажилтнуудыг нэр хүнд муутай, нийгмийн давхаргад хамааруулж тэдний зүгээс ирээдүйдээ найдлага тавьдаггүй болоход хүргэж байгаагийн зэрэгцээ эрх зүйн мэргэжилтэнг хувийн хуулийн сургуулиуд хялбар аргаар тоо томшгүй олноор нь төгөсгөж байна.

Эдгээр асуудлууд дээр нэмэгдэх нэг зүйл бол бүх доод шатны шүүхүүд дээр овоорсон иргэний болон эрүүгийн үлдэгдэл шийдвэрлэгдээгүй хэргүүд юм. Дан ганц Пунжабт л гэхэд, энэ өгүүллийг бичиж байхад 111,839 хэрэг, 343,732 эрүүгийн хэрэг болон 439,460 иргэний хэрэг тус тус шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байлаа. Энэ мэт ужгирсан, хойшлуулах асуудлын шалтгаан нь мэтгэлцэгч талууд шийдвэрийг удаашруулахаар хээл хахууль өгсөнтэй холбоотой юм.

Хөдөө орон нутгийн шүүхүүд

2003 онд хөдөөгийн шүүхүүдийн талаар гаргасан НҮБХХ-ийн судалгаа¹¹ нь ядуу тосгоны ард иргэд цагдаа, шүүхийг баячуудад зориулсан тансаг зэрэглэлийн үйлчилгээ гэж үздэгээс албан ёсны эрх зүйн системтэй харьцах дургүй болохыг харуулж байна. Түүнээс гарах үр өгөөж нь эрх зүйн маргаанд оролцох зардлаас хэтэрдэггүй. Үүний оронд тэд орон нутгийн панчаяатаар маргаанаа шийдвэрлүүлдэг.¹²

НҮБХХ-ийн судалгаанд 207 оролцогч, мөн 64 бусад оролцогчдоос бүрдэх хяналтын баг хамрагджээ. Цагдаад гомдол гаргасан 56 оролцогчийн 54 хувь нь хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай Анхдагч мэдээллийн өргөдөл (АМӨ)-г гаргахыг хүндрэлтэй гэж үзэж байгаа ажээ. Дийлэнх олонх нь АМӨ гаргахад цагдаа нар хээл хахууль шаарддаг гэжээ. 84 оролцогчийн мэдээлснээр тэд дунджаар 19 удаа цагдаа дээр очсон байна (хамгийн ихдээ 300 удаа очсон тохиолдол байгаа). Цагдаагийн газар орох дундаж зай 10 км байдаг гэвэл энэ нь дэндүү цаг үрсэн ажил болохыг харуулж байна. Хураамж, баримт бичиг, тээвэр, хээл хахуульд төлөх бусад зардлууд мөн өндөр байдаг. 64 оролцогч дунджаар 95,000R (1,577 ам.доллар), 10 оролцогч дунджаар 40,000R зарцуулсан гэж мэдээлсэн нь харьцангуй ядуу өрхийн хувьд асар их мөнгө юм.

11 Фокиа Садик Хан ба Шахрух Рафи Хан, “Хууль ёс, дэг журмын талаар судалгаа, Эрх мэдлийг шилжүүлэх асуудал дахь Шүүхийн хэрэгжилт” (Нью-Йорк, НҮБХХ, 2003)

12 Панчаяат гэж шүүхийн удаашралаас үүдсэн харилцан буулт хийлгүүлэх зорилготой хоёрдогч маргаан таслах байгууллагыг хэлдэг. Гэсэн хэдий ч панчаяат нь газар болон гэр бүлийн маргаануудад анхдагч зарга шүүх байгууллагаар ажилладаг ба хэрэв хэрэг шийдвэрлэгдээгүй бол маргалдагчид албан ёсны шүүх тогтолцоонд ханддаг. Бодит байдал дээр, албан ёсны ба албан ёсны бус шүүх тогтолцоонууд аль аль нь нэг нэгийгээ орлож байдаг.

Үйлчлэгч-үйлчлүүлэгчийн систем маргаан шийдвэрлэхэд тусламж үзүүлдэг бөгөөд оролцогчдын гуравны хоёр нь хуулийн эсхүл цагдаагийн асуудлууддаа туслалцаа авахаар нөлөө бүхий найз, овгийн удирдагчид ханддаг байна. Феодалын систем шиг тусгай үйлчлэгчээс хамаарах энэхүү систем нь ядуу иргэдэд хүртээмжтэй, түргэн шуурхай шүүх бий болох хүртэл оршоор байх болно.

Шинэчлэл бүтэлгүйтсэн нь

Шүүх засаглал зохих ёсоор үйл ажиллагаагаа явуулахгүй байх нь эдийн засгийн хөгжилд саад учруулдагийг ойлгосон Азийн хөгжлийн банк 1998 онд Шүүхийн Хөтөлбөр (ШХ) хэрэгжүүлэх зорилгоор Пакистан улсад 350 сая ам.долларын зээл олгожээ. 2001-2004 онд хэрэгжсэн тус хөтөлбөр нөөцийнхөө дийлэнхийг шүүхийн захиргааг сайжруулах, тухайлбал шүүгч болон шүүхийн ажилтнуудад давтан сургалт явуулах; хэдэн зуун шүүхүүдийн барилга угсралт, сэргээн засварлалтын ажил; хэргийн ачааллыг зохицуулах системийг компьютержүүлэх; 100 шүүхийн ачааллыг багасгах хөтөлбөр хэрэгжүүлэх; эрх зүйн туслалцаа үзүүлэх туршилтын систем боловсруулах; мөн цагдаа, прокурор, өмгөөлөгч болон дээд шүүхүүдийн шүүгчдийн үйл ажиллагааг хянах, тэдний эсрэг гомдлыг мөрдөн шалгах зорилгоор байгуулагдсан “гишүүнийг хянах баг” зэрэг холбогдох институциудыг бэхжүүлэхэд тус тус зарцуулжээ. Түүнээс гадна уг төслийн хүрээнд үл хүндлэх, нэр хүндэд халдах, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиудын нилээд хэмжээний төсөл, Эрх зүйн комиссын тогтоол, дүрэм журам, мөн Хуулийн тайлангийн акт зэргийг гаргажээ. Төслийн зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд уг хөтөлбөрийг дахин 5 жилээр сунгах шаардлагатай байна гэдэг нь 2003 оны эцэст тодорхой болжээ.¹³

Шүүгчдийг томилох процесс бүрхэг байх, зэрэг дэв дэвшүүлэх ажиллагаа ил тод бус байх, цалин хөлс нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах ажилд санхүүжилт хуваарилахгүй байх зэрэг хүчин зүйлс хөтөлбөрийн үр нөлөө буурахад нөлөөлсөн.¹⁴ Мөн хариуцлага тооцох үр нөлөө бүхий механизм хэрэгжүүлэх шаардлагатай байна. Шүүхийн дээд зөвлөл гүйцэтгэх засаглалаас хараат, сул байдаг бөгөөд шүүгчид цагдаа нараас хамааралтай байдаг. Шүүхийн ур чадвар дорой, амархан худалдагдах байдал нь Пакистанчуудын шүүхэд итгэх итгэлийг алдагдуулдаг тул шүүхийн захиргааны шинэ механизм нэвтрүүлэх шаардлагатай. Ингэхийн тулд шүүх ажиллагааны шударга бус байдал, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг хэтрүүлэх, шүүхийн шийдвэрийг үл гүйцэтгэх зэрэг дутагдлыг арилгах улс төрийн жинхэнэ эрмэлзэл өгүүлэгдэж байна.¹⁵

Жавайд А.Сиддики

(Дээд шүүхийн өмгөөлөгч бөгөөд хуулийн зөвлөх ТИ Пакистан, Карачи)

13 Ливингстоун Армитаж, “Пакистаны Хууль болон Шүүхийн салбарын Шинэчлэлийн туршлага: Зарим хичээлүүд”, Law, Social Justice & Global Development Journal 2 (2003). www2.warwick.ac.uk/fac/soc/law/elj/lgd/2003_2/armytage/-аас үзэх боломжтой.

14 Мөн тэнд

15 Мөн тэнд

Туйлдуулсан дайн тулаан Палестины шүүх засаглалыг дордуулж байна

Эрх зүйн тогтолцоо: Эрх газрын эрх зүй, олон талт зарчим (Исламын хуулийн элементүүдийг багтаасан)

100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 4.0¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 18000 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 33600 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: Мэдээлэл байхгүй байна

Шүүхийн жилийн төсөв: 8.6 сая ам.доллар⁴

Жилийн нийт төсөв: 2.0 тэрбум ам.доллар⁵

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.4

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Ихээхэн хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Үгүй

1. Палестины Шүүх эрх мэдлийн тухай хууль (2002)

2. Мөн тэнд

3. Мөн тэнд

4. Мөнп тэнд

5. Жилийн төсвийн тухай хууль 2005 он

Палестины шүүх ихэд улстөржсөн орчинд үйл ажиллагаа явуулдаг. Израилын зэвсэгт хүчний бараг өдөр бүр явуулдаг аюулаас хамгаалах болон цэргийн ажиллагаа Палестины шүүхийн статус, мөн шүүхийн үүргээ хэрэгжүүлэх чадамжинд нөлөөлдөг. Зөрчил мөргөлдөөн шүүхийн нөлөөллийн ертөнцөд бүтцийн доголдол бий болгож, авлига зэрэг гэмт хэргийг шийтгэлгүй өнгөрөөх нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн шийдвэр дэх улс төрийн оролцоо нэмэгдэхэд хүргэж байна. Иргэд уламжлалт маргаан шийдвэрлэх арга, системээр¹ зөрчлөө шийдвэрлүүлэх эсхүл бүр хуулийг өөрсдөө хэрэгжүүлэх гэж оролдох зэрэг маргаан шийдвэрлэх бүх оролдлогууд нь бүтэлгүйтсэний дараа шүүхэд ханддаг.

Шүүхийг сулруулж байгаа зөрчилтэй холбоотой нөхцөл байдлууд:

- Израилын хүчний хяналтанд байдаг нутаг дэвсгэр дэх Палестины шүүхээс эрүүгийн ноцтой хэрэг үйлдсэнийг нь тогтоосон яллагдагчийг цагдаа нар баривчилж, ялыг эдлүүлж чаддаггүй.²

1 Иргэний болон эрүүгийн хэрэг шийдвэрлэх шүүх тогтолцооноос гадна шариатын тогтолцоо болон хувийн асуудлуудыг шийдвэрлэх бусад шашны шүүхүүд байдаг.

2 Эзлэгдсэн нутаг дэвсгэрүүдийг гурван хэсэгт хуваадаг. Тэдгээр нь: Палестины Үндэсний Эрх баригчдын гарт бүрэн аюулгүй байдлыг хангадаг А хэсэг, Израил аюулгүй байдалд бүрэн хариуцлага хүлээдэг Б ба С хэсэг.

- Израил иргэдийн эсрэг Палестины шүүхийн шийдвэрүүдийг хэрэгжүүлж чаддаггүй.
- Шүүгч, мэтгэлцэгч талууд болон өмгөөлөгчдийг шүүхэд тогтоосон цагтаа очиход нь Палестинчуудад тогтоосон хөдөлгөөний хязгаарлалт нь саад болдог.
- Баруун Эрэгт шорон хомсдолтой байдгаас шоронд хорих ялыг төдийлөн эдлүүлдэггүй.

Шүүхийн эрх мэдлийг сулруулж байгаа өөр нэг хүчин зүйл нь Палестины Үндэсний байгууллагын институциуд Палестины зэвсэгт бүлэглэлийн эрх мэдлийг давахаар өрсөлддөг явдал юм. Сүүлийн үед Израилтай хамтран ажилласан гэж сэжиглэгдэж буй иргэдийн эсрэг хуулиас гадуур залхаан шүүх эсхүл хувийн давуу тал олгох зорилгоор хэрэг шийдвэрлэж шүүхээс зайлсхийх болсон байна. Сүүлийн саруудад зэвсэглэсэн бүлэглэлүүд шүүгч, хуульчдад заналхийлэх, барьцаалах оролдлогууд хийх болжээ. 2006 оны 5 сард Аль Акса Мартирын Бригадтай нэгдсэн нэгэн бүлэглэл Наблус дахь шүүхэд цөмрөн орж, барилгаас албан хаагчдыг хүчээр гаргаж, хэдэн цагийн туршид хаалгыг нь барьсан ажээ.

Эцэст нь, шүүх засаглалд хуваарилсан хязгаарлагдмал төсөв Палестины шүүхийг хөгжүүлж, шинэчлэх үйл ажиллагааг боогдуулж байна. Эрхзүйн/ шүүхийн тогтолцоо хоёр талын болон олон талт хэлэлцээрийн дагуу доноруудаас их хэмжээний туслалцаа авч, хөрөнгө оруулах шийдвэр өөрчлөгдөхөд хүнд байдалд ордог бөгөөд 2006 оны 1 сард хууль тогтоох байгууллагын тэргүүний сонгуульд Хамас ялалт байгуулсны дараагаар донорууд шүүхэд олгож байсан санхүүжилтээ эрс зогсоосон байна.

Давуу тал олгох авлигын хэлбэр бусад авлигын хэргээс илүү түгээмэл байна

Эдгээр нөхцөл байдал шүүхийг авлигын хэрэгт хариуцлага хүлээхээс хэлтрүүлэхгүй юм. Палестин дахь шүүхийн авлигын гол шалтгаан нь гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын хөндлөнгийн оролцоо бөгөөд үүний дүнд нөлөөнд автсан шийдвэр болон гүйцэтгэх засаглалд түшиглэсэн шүүхийн бодлогууд явагдах болжээ. Мэтгэлцэгч талууд шүүхийн албан хаагчдад хээл хахууль өгөх явдал цэргийн ажиллагаа явагдаагүй Ойрхи Дорнодын орнуудад мөн түгээмэл байна.

Шүүх ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл дутагдалтай байгаагаас шүүгчдийн дундахь авлигад үнэлгээ хийхэд түвэгтэй болж байгаа юм. 1998 онд Палестины хууль тогтоох зөвлөлийн тухай хуулийн хүрээнд шүүх байгууллагад хяналт тавих, түүний бүтэц, үүрэгтэй холбоотой бодлогод мөн хяналт тавих, шүүгч нарыг томилох, тушаал дэвшүүлэх болон шилжүүлэх үүрэгтэйгээр байгуулагдсан дээд шүүхийн зөвлөлийн даргын гаргасан саяхны хэвлэмэл мэдээнд иргэний нийгмийн байгууллагаас зохион байгуулсан шүүхтэй холбоотой үйл ажиллагаанд шүүгчдийг оролцохыг хориглох, мэдээлэл өгөхгүй байх хандлага байдаг тухай

өгүүлжээ. Энэ нь мониторингийн үүргээ биелүүлэх чадамжийг багасгаж байгаа юм.

Шүүгч болон шүүхийн албан хаагчдын оролцсон цөөн тооны баримтжуулсан хээл хахуулийн хэргүүд байдаг ч энэ асуудал шүүхийн шинэтгэлийн талаар хэлэлцэхэд хүргэдэг. Хамгийн нийтлэг тохиолддог асуудал нь шүүгчдийн зүгээс давуу тал олгох, хамаатан саднаа харж үзэх, мөн гүйцэтгэх засаглалын зүгээс шүүгчдэд үзүүлдэг өөрсдөд нь давуу тал олгохыг шаарддаг дарамт, шахалт байдаг. Өмгөөлөгчид шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн баримт бичиг болон тогтоолыг гардуулахаар томилогдсон албадуудад хээл хахууль байдаг гэж үзэж байгаа ажээ.³ Тэд зарим өмгөөлөгчид болон тэдний үйлчлүүлэгчид үйлчилгээний явцыг түргэтгэх, удаашруулах эсхүл албаны хүнээр хэрэгт холбогдох хэн нэг этгээдэд шүүхийн зарлан дуудах хуудас хүлээлгэж өгч чадаагүй гэж мэдүүлэх зэрэгт их хэмжээний мөнгө төлдөг гэсэн байна.

Улс төрийн давуу тал олгох байдал давж заалдах болон Дээд шүүхүүдийн ажилд авах, тушаал дэвшүүлэх ажиллагаанд илт ажиглагддаг. Дээд шүүхийн зөвлөл 2006 оны 3 болон 5 дугаар сард явагдсан шүүгчийг сонгон шалгаруулах журмын талаар мэдээлэл өгөхөөс татгалзжээ. Дээд шүүхийн шүүгчдийн ажилд хуульчдыг сонгон шалгаруулж авах шалгуурыг нийтлээгүй төдийгүй “эвлэрлийн” шүүхүүдэд шинээр авах шүүгчдийг шалгаруулах шалгаруулалтын дүн, түүнчлэн тэнцсэн оролцогчдын тодорхойлолт, нэрсийг ч нийтлээгүй байна. Олон тооны хуульчид Ерөнхийлөгч Махмуд Аббасын хуулийн зөвлөх Дээд шүүх, дээд шатны шүүх болон сонгуулийн шүүхийн шүүгчдийн сонгон шалгаруулалтанд хөндлөнгөөс нөлөөлсөн гэж үзэж байгаа ажээ.⁴

Хүнд суртлын нөлөөгөөр шүүхийн эрх мэдэл суларсан нь

2006 оны 3 сард Рамалад Мусави ТББ-аас зохион байгуулсан семинарын хэлэлцүүлэгт шүүгчид шүүх засаглал Ерөнхийлөгчийн эрх мэдлийн нөлөөнд байдаг гэж үздэгээ илэрхийлжээ. Шүүхийн дээд зөвлөлийг тушаал дэвшүүлснийх нь хариуд Ерөнхийлөгчийн “балмад явдлыг” дэмждэг эсхүл зөвлөлийн гишүүнд нэр дэвшихэд нь тусалдаг гэж шүүмжилжээ. Зөвлөлийн дуулгавартай байдаг нэг жишээг дурдвал Ерөнхийлөгч 2006 оны эхээр шүүх ажиллагааг зохицуулдаг хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад, энэ нь шүүхийн хараат бус байдлыг алдагдуулсан өөрчлөлт байсаар атал зөвлөл эсэргүүцэл илэрхийлээгүй байна.

Улс төрийн оролцоо нь мөн ёс төдий шүүхийн эрх мэдлийн хүрээнд явагддаг гүйцэтгэх байгууллагуудын оролцоотой асуудлууд дээр илэрдэг. Баруун Эргийн бүх амбан захирагчийн албаны хуулийн хэлтсийн ажилтнууд, иргэн хоорондын эрх зүйн эсхүл эрүүгийн нэмэмжлэл болон заргыг шалгах үүрэг хүлээсэн байдаг.

3 Зохиогчийн 2006 онд хийсэн ярилцлага

4 Зохиогчийн 2006 онд хийсэн ярилцлага

Гүйцэтгэх засаглалын нэг хэсэг болох эдгээр хэлтсүүд шүүх хурал явуулдаггүй ч маргааныг зохицуулах эсхүл шахалт үзүүлэх замаар талуудыг хооронд нь эвлэрүүлэх зэргээр нэхэмжлэлийг шийдвэрлэдэг.

Хөндлөнгийн оролцооны өөр нэг хэлбэр нь зарим яамдууд болон аюулгүйн албадууд ахлах албан тушаалтны ашиг сонирхолтой зөрчилдсөн шүүхийн шийдвэрүүдийг хэрэгжүүлэхээс зайлсхийдэг явдал юм. Энэ талаар шүүхийн дээд зөвлөлийн дэд дарга, Дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн орлогч Сами Сарсураас тодруулахад тэрээр гүйцэтгэх институциуд тэдний эсхүл ахлах албан тушаалтнуудад шүүхийн зарлан дуудах хуудас өгөхөд ихэнхдээ ирдэггүй гэжээ.

Зарим улс төрийн эсхүл цэргийн дээд албан тушаалтнууд байгууллага нь, өөрсдөд нь эсхүл гэр бүлийн гишүүдийнх нь эсрэг нэхэмжлэл эсхүл шүүхийн зарлан дуудах хуудсанд хариу өгөхөөс мөн татгалздаг. Энэ нь шүүхийн эрх хэмжээг алдагдуулж, авлига болон нөлөө бүхий хүрээнд эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг нэмэгдүүлж байна.

Шинэтгэл нэрээр шүүх засаглалыг улам сулруулж мэдэх маргаантай зүйлүүдийн талаар

2005 оны эхээр явагдсан сонгуулиар Ерөнхийлөгч Аббас 2002 оны Шүүх эрх мэдлийн тухай хуулийн хяналт зэргийг багтааж шүүх тогтолцоог цомхотгох стратеги боловсруулах удирдлагын хороог хуралдуулжээ. Олны хүндэтгэл хүлээсэн доктор Камил Мансур Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргаар томилогдсон бөгөөд тус хороо нь 2005 оны 4 сард Шүүхийн тухай шинэ хуулийн төслийг боловсруулж, улмаар хууль тогтоох зөвлөлд өргөн барьжээ.

Гэвч Парламент шүүхийн хараат бус байдлын талаарх хорооны анхны саналуудыг засаж өөрчилжээ. Анхны саналд шүүхийн дээд зөвлөл, Хууль зүйн яам болон иргэний нийгмийн байгууллага, засгийн газар зэрэг бусад оролцогчдын ашиг сонирхлыг маш болгоомжтой тэнцвэржүүлэхийг зорьсон байжээ. Парламентаас баталсан хувилбар тэнцвэрийг аддагдуулж, эрх мэдлийг Хууль зүйн сайдын талд хазайлгасан байна. Энэ хууль Үндсэн хуультай зөрчилдөж байсан тул 2005 оны 11 сард Газагийн дээд шатны шүүхээс үүнийг Үндсэн хуульд нийцээгүй гэж мэдэгджээ.⁵

2006 оны 2 сард Ерөнхийлөгч Аббас одоо Хамасын давамгайлж буй шинэ хууль тогтоох чуулганыг хуралдахаас өмнө 2002 оны Шүүхийн тухай хуульд нэмэлт,

5 100 дугаар зүйлд “Дээд шүүхийн зөвлөлийг байгуулах шаардлагатай. Хуулиар бүтэц, эрх мэдлийн хүрээ болон үйл ажиллагааны зарчмыг тодорхой зааж өгөх ёстой. Зөвлөл нь төрийн яллах ажиллагаа явуулдаг шүүхийн салбарын аливаа ажиллагааг зохицуулах хуулийн төслүүдийн талаар зөвлөгөө авах шаардлагатай” гэжээ.

өөрчлөлт оруулах тогтоол гаргажээ. Шинэ хувилбар хэдийгээр доктор Мансурын хорооны бүрдүүлсэн тэнцвэртэй гишүүнчлэлийг эвдэж байсан ч тэнцвэрийг дээд шүүхийн талд болгон өөрчилсөн байна.

Нэмэлт, өөрчлөлт сахилгын арга хэмжээний эсрэг шүүгчдийн давж заалдах эрхийг сэргээж, зөвлөлд хагас цалинтай, тэтгэвэрт гарсан гэх мэт ямар ч шүүгчийг шийтгэх эрх олгожээ. Гэхдээ зөвлөлийн гишүүний ашиг сонирхлын эсрэг зүйл хийсэн шүүгчдийн эсрэг эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг хязгаарласан ямар ч механизм оруулаагүй байна.

Нэмэлт өөрчлөлт оруулсан хуулиар мөн Ерөнхийлөгчид шүүхийн мөрдөн байцаах хэлтсийн даргыг томилох эрх олгожээ. Дээд шүүхийн зөвлөл, Хууль зүйн яам гэсэн хоёр сөрөг байгууллагын нөлөөнд байсанаар уг хоёр байгууллага аль аль нь шүүхийн хараат бус байдлыг алдагдуулж мэдэхээр бөгөөд энэ салбарыг дордуулж байгаа юм. Түүнээс гадна, өнөөгийн хуулийн хүрээнд давж заалдаж чадах боломжгүй байдаг Дээд шүүхийн шийдвэрүүдийг мөрдөн шалгах эрх мэдэл дутагдалтай байна. Үүнээс үүдсэн Дээд шүүхийн шүүгчдийг мөрдөн байцаах халдашгүй байдал нь дээд шатны шүүхийн шүүгчдийг арбитрын арга хэмжээ авч, шударга, ил тод байдлын зарчмуудыг үл ойшоох явдал нэмэгдэх орчин нөхцөлийг бий болгох болно.

Тангараг өргөснөөс хойшх анхны хуралдаанаар шинэ парламент 2006 оны 3 сард Шүүх эрх мэдлийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгосноор шинэтгэлийн байдлыг тодорхой бус болгож орхисон.

Уг баримт бичигт эвлэрлийн шүүхийн шүүгчдээс бусад шүүхийн албан тушаалд томилоход зөвлөлийн зүгээс тавих ямар нэг тодорхой шалгуурын талаар дурдаагүй байна. Шүүгчийн ёс зүй болон үүргийг зохицуулах ямар ч ёс зүйн дүрэм гаргаагүй, техникийн алба байгуулаагүй мөн шүүхийн мөрдөн шалгах хэлтсийн ажлыг идэвхижүүлээгүй байна. Шинэ хууль тогтоох зөвлөлийн дэргэд зарим улс төрийн эвслүүд шүүхийн авлига болон шинэчлэл хийх хэрэгцээ шаардлагыг хэлэлцэх жинхэнэ эрмэлзэл гаргаж байгаа ажээ.

Нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх ажлууд:

- Ил тод байдлаар тодорхой шалгуурын дагуу албан тушаалд томилох болон шилжүүлэх
- Мөрдөн шалгах, сахилгын арга хэмжээ авах системийг бий болгох
- Хөрөнгө орлогын мэдүүлэг авах нэг удаагийн бус байнгын давтамжтай систем бий болгох шаардлагатай
- Шүүгч нарын ёс зүйн дүрэм боловсруулан мөрдүүлэх

АМАН
(Палестины хариуцлагатай, шударга байдлын
төлөөх эвсэл), Иерусалим

Шүүхийг хянаж буй байдал нь Панамын элитүүдэд ял завших боломжийг хангаж байна

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, мөрдөн шалгах болон олон талт зарчим
100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 8.4¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 1,130 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 6,000 ам.доллар³

Нэг хүнд ногдох УНБ: 4,630 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 46 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 6.7 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.7

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэрүүд нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1 Америкийн хууль зүйн сургалтын төв (2004–5)

2 www.organojudicial.gob.pa/contenido/planilla/planilla.html 3 Мөн тэнд

4 Дэлхийн банкны хөгжлийн түвшинг тодорхойлогч (2005)

5 www.asamblea.gob.pa/25434_2005.pdf 6 Мөн тэнд

ТИ–ийн 2005 оны Дэлхий Нийтийн Авлигын Хэмжүүрт тусгаснаар, ял завшуулах болон шүүгчийн ёс зүйн байдал нь Панамд олон нийтийг түгшээж байгаа хоёр томоохон асуудал мөн. Уг судалгааг 1-5 оноогоор дүгнэхэд, шүүх нь 4.5 оноо авчээ (5 нь хамгийн их авлигатай гэж үзнэ). Зөвхөн улс төрийн нам, парламент нь л бага оноогоор дүгнэгджээ. Хариуцлага тооцох зөв механизм байдаггүй нь, шүүх авлигад өртөх боломж олгох нэгэн шалтгаан юм. Удаах нь, шүүгчдийг сонгон шалгаруулахад улс төрөөс нөлөөлөх явдал юм.

Улс төрийн нөлөө

Дээд шүүх туршлагатай улс төрчдөд ээлтэй бөгөөд авлигатай холбоотой хэргээр шалгагдах үед нь ашигтай хэрэгсэл болдог. Одоогийн Дээд шүүхийн 2 шүүгчийг, Ерөнхийлөгч асан Эрнесто Перез Балладарз (1994–1999), 4–ийг нь Ерөнхийлөгч асан Мирэяа Москосо (1999–2004) нар тус тус томилсон бөгөөд дээрх 2 Ерөнхийлөгч нь Арнулфиста намын гишүүд юм. Дээд шүүхийн Ерөнхийлөгч асан Адан Арнулфо Аржона, түүний танхимийн бүрэлдэхүүнд багтах 2 гишүүн болох Уинстон Спадафора, Анибал Салас, Конгрессын гишүүн Алберто Сигаруиста нар нь дотнын найзууд. Одоогийн Ерөнхийлөгч Мартин Торрихос дараах 3 хүнийг сонгосон. Үүнд: Хүүхэд, өсвөр насныхны дээд шатны шүүгч асан Эсмералда Аросэмэна дэ Тройтино, Конгрессын зөвлөх асан Харли Митчел, прокурорын байгууллагад олон жил ажилласан Виктор Бехавидес нар юм.

Саяхан Дээд шүүх 28.4 сая ам.долларыг Арнулфиста намын гишүүн, бизнес эрхлэгч Августо Оназис Гарсиа болон Улсын банкны Ерөнхийлөгч асан Жозе Перез Саламеро нараас улсын орлогод хураахтай холбоотой хэргийг шийдвэрлэж, 5 саналаас 4 нь тэдгээрийн талд гарчээ. Мөн тэдгээр шүүгчид нь Гектор Ортегагийн хөрөнгийг хураах хэргийг сэжигтэй байдлаар шийдвэрлэсний дараа, хэргийг мөрдөн шалгаад, төрийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаанд ялагч болсон Порт Инженеринг ба Консалт корпорацийн¹ авлигатай холбоотой нь тогтоогджээ. Эдгээр хэргүүдэд холбогдогчдод өөрийг нь буруутгаж байгааг мэдэгдээгүй, процессын эрхийг хангаагүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоосон гэсэн үндэслэл хэлдэг. Эсрэг санал гаргасан 4 шүүгч өгүүлэхдээ, үнэндээ эрх нь хангагдсан байсан бөгөөд уг шийдвэр нь “нийтийн захиргааны актын ил тод, хариуцлагатай байх зарчимд харшилсан”² хэмээжээ.

Авлигыг хэлэлцэх нь

Панам дахь шүүхийн авлигын үндсэн үр дагавар нь, гол улс төрийн намууд, албан тушаалтнууд асан, бусад нөлөө бүхий хүмүүстэй холбогдсон тэдгээрийн үйлчлүүлэгчид ял завших явдал юм. Улс, хулгайлагдсан мөнгийг арай ядан буцаан цуглуулдаг учир энэ төрлийн авлига эдийн засгийн өндөр алдагдал дагуулдаг.

2005 оны 11 сард өөр нэгэн шуугиан дэгдсэн нь Америкийн нэгдсэн улсын засгийн газар шүүгч Уинстон Спадафорагийн визийг, авлигатай холбогдуулан хүчингүй болгож, хураан авсан явдал байлаа.³ Америкийн нэгдсэн улсын элчин сайдын яамны төлөөний хүн, хээл хахууль авсан тухайг нь нотлох баримт байгаа бөгөөд Панамын засгийн газар хүсэлт гаргавал шилжүүлэн өгч болох талаар мэдээлсэн. Панамын иргэний нийгмийн байгууллагууд, түүний дотор Панам дахь ТИ-ийн салбар, тухайн хоригт хүргэх болсон нотлох баримтыг гаргуулан авч, тэдгээрийг Спадафорагийн эсрэг зохих арга хэмжээг авахад тооцон үзнэ үү, хэмээн эрх мэдэлтнүүдэд хүсэлт гаргасан. Өнөөдрийг хүртэл, Конгресс, шүүхийн аль нь ч нотлох баримтыг хамгаалах талаар зохих арга хэмжээ аваагүй.⁴

- 1 Перез Балладарзын захиргаанд байсан үндэсний боомтын удирдлагууд Порт Инженерийн ба Консалт корпорацид (РЕСС) концесс баталж өгсөнтэй холбогдогдуулан, Санхүүгийн байцаагч асан Алвин Вийдн “улсын хөрөнгийг ашиглан шамшигдуулах” гэмт хэргийг шалгаж, хөрөнгийг хураах тушаал гаргасан.
- 2 Эл Панама Америка (Панам), 2006.6.15.
- 3 Ла Пренса (Панам)–г үзнэ үү. 2005.12.1 Америкийн Нэгдсэн Улсын гаалийн тухай хуулиар, албан үүргээ биелүүлж явахдаа, “авлигын гэмт хэрэг үйлдсэн, оролцсон, түүнийг үйлдэхэд боломж олгосон бөгөөд тэр нь АНУ –ын гадаад харилцаа, тусламж, олон улсын гэмт хэрэг, терроризмтой тэмцэхэд, үндэсний болон нийгмийн аюулгүй байдалд, ноцтой хор уршиг учруулахаар байвал” АНУ –д орохыг хориглоно гэсэн байдаг.
- 4 Авлигын эсрэг ил тод байдлын Үндэсний зөвлөлийн гүйцэтгэх захирал Алма Монтенегро дэ Флэчэр нотлох баримт санал болгох нь “Панамын дотоод улс төрийн асуудалд хөндлөнгөөс оролцож буйтай ижил” хэмээн шүүмжилсэн.

2005 оны 8 сард шүүгч Спадафора “Эдитория Панама Америка” сэтгүүл болон сэтгүүлч Густаво Апарико, Жин Марсел Черигийн эсрэг “сэтгэл санааны хор хохирол учруулсан” хэмээн зарга үүсгэсэн. Тэд, 2001 оны 3 сард Матео Итюралдад 4.5 км зам тавих тухай нэгэн нийтлэл бичсэн. Тэдний бичсэнээр, замыг Нийгмийн хөрөнгө оруулалтын сангаас санхүүжүүлсэн боловч, хөрөнгө нь бараг бүхэлдээ Спадафорагийн хувийн эдлэнд хүрэх зам тавихад зарцуулагдсан.⁵ Сэтгүүлчдийн холбооны Ерөнхийлөгч Луис Поло Роа нь Спадафораг буруушааж, сэтгүүлчдийг хэвлэлийн эрх чөлөөний эсрэг энэхүү үйлдэлтэй тэмцэхийг уриалсан.⁶

Маргаан дагуулсан өөр нэгэн шийдвэр бол, Адан Арнулфо Аржона (Дээд шүүхэд цөөнхийн бүлэгт багтдаг) энэ шийдвэрийг шүүмжлэн үздэг, хар тамхины наймаатай холбоотой хэргийн шийдвэр юм. Тэрээр 2005 оны 3 сард хэвлэлийн бага хурал дээр хэлсэн үгэндээ: “Надаас эсрэг санал гаргасан шүүгч Хойс, Салас нар нь 2004 оны 4 сарын 30-нд Лорена Хэнао Монтояагийн 28 хавтаст хэргийг үл хэрэгсэн, мансууруулах бодисны наймаа, мөнгө угаах гэмт хэрэгт оролцсоныг нотлох баримт үгүй хэмээн сулласан. Миний үзэхэд, түүнд хорих ял оноох нь зүйтэй юм” гэжээ. Хэнао Монтояа нь Панамд ял шийтгэлгүй өнгөрсөн энэхүү гэмт хэргийн төлөө, төрсөн газар болох Колумби улсад гэм буруутай нь тогтоогдсон.⁷

Адан Арнулфо Аржона нь, 15 ТББ, эрдэмтэд, судлаачид, үйлдвэрчний эвлэл, сэтгүүлчдийн бүрэлдэхүүнтэй Шударга иргэдийн төлөөлөгчдийн санаачилсан хэвлэлийн бага хурал дээр, энэ болон бусад 5 хэргийн нотлох баримтад задлан шинжилгээ хийлгүүлэхээр хуульч ажиллуулахыг мэдэгдсэн. Тэд: “Хар тамхины наймаатай холбоотой хэргүүд (зургаан)”-ийн шийдвэр сэжигтэй байгаа бөгөөд холбогдогчид, зүгээр л сонгогдсон бус харин тэднийг буруутай гэж үзэж болохоор байна. Дээд шатны шүүгчдийн үйлдэл нь сэжигтнүүдэд боломж олгосон шинжтэй байгаа тул хэргүүдийг мөрдөн шалгах ёстой”⁸ гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Прокурорын байгууллагыг үгүй хийх

Прокурорын байгууллага нь шүүхийн ялзарсан тогтолцоонд сөргөөр нөлөөлж, улам дордуулдагийг Ла Пренса өдөр тутмын хэвлэлд нийтэлсэн үндэсний судалгаа харуулсан. “Ерөнхий прокурорын байгууллагын үйл ажиллагааны талаар сэтгэгдэлээ хэлнэ үү” гэсэн сурвалжлагчийн асуултанд 2 хүний нэг нь “муу”, “маш муу” гэж хариулжээ. Уг үнэлгээ Жозе А. Соссаг Ерөнхий прокурорын албан тушаалыг хашиж байх хугацаанд (1994-2004) хэвээр үлдсэн.

5 “Панамын мэдээ”-г үзнэ үү. Цуврал 12, дугаар 6, 2006 оны 3.19 – 4.8.

6 Эл Панама Америка (Панам), 2005.8.18.

7 Ла Пренса (Панам)–г үзнэ үү. 2006.3.6

8 Шүүхийн мэргэжилтэн Альянза Сюдандана, ‘2005 оны гэмт хэргийг шүүн таслах ажиллагааны иргэдийн хяналт’. www.alianzaprojusticia.org.pa/resumen_ejecutivo_seis_casos.doc сайтаас үзэх боломжтой.

Судлаачид прокурорын байгууллагын нэр хүнд муу байгаагийн нэг шалтгаан бол прокурор яллах сонирхолгүй байдаг оршино гэжээ. “Ла Пренса” сэтгүүлийн үндэслэгч, сэтгүүлч И.Роберто Айзанман 7 хоногийн буландаа “прокурорын үүрэг бол гэмт хэрэгтнүүдийг хамгаалж, сэтгүүлчид, хохирогчидтой заргалдах бус харин гэмт хэрэгтэй тэмцэх юм”⁹ гэж бичсэнийхээ төлөө гүтгэн доромжилсон хэргээр шүүхэд дуудагдсан. Хорьж, мөрдөхөд нь, Олон улсын байгууллагууд түүнийг хамгаалахаар нэгджээ. Авлигын эсрэг нэгдсэн сэтгүүлчид прокурорын үйл ажиллагааг “үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдсан явдал” хэмээгээд хилийн чанад дахь сэтгүүлчид “Панамд хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гол аюул бол шүүхийн дарамт” гэжээ.¹⁰

2005 оны 1 сард Ана Матильда Гомез, Соссагийн албан тушаалыг аваад, цуврал мөрдөн шалгах ажиллагаануудыг явуулсан нь олон прокурорыг огцроход хүргэсэн. Хамгийн их дуулиан дэгдээсэн нь, Архимеди Саиз Кастилотой холбоотой хэрэг бөгөөд Ла Корерагийн тойргийн прокурор асан 2005 оны 7 сард таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөхийн төлөө хээл хахууль авч байгаад нотлох баримттайгаар баригджээ.¹¹ 13 прокурор, бусад доогуур албан тушаалтнууд ажлын байран дээр хээл хахууль авахаар оролдсоны төлөө ажлаасаа чөлөөлөгджээ.¹²

Шударга ёсны гэрээний зөрчил

Дээрх хэргүүдээс, улс төрийн нөлөө, бизнес, ургийн хэлхээ холбоо нь хэрхэн Дээд шүүхийг хянаж, шүүхийн хараат бус байдлыг сулруулдагийг үзэж болно. Шүүхийн албан тушаалтнууд сахилгын шийтгэл хүлээх нь маш ховор. Цөөн тохиолдолын нэг нь дээд шатны шүүхийн шүүгч Дулио Аррачо 2005 онд гаргасан сахилгын зөрчлийнхөө төлөө 2006 оны 5 сард огцорсон хэрэг юм. Шүүгч нэгэн хэргийг шийдвэрлэх ажиллагааны үеэр намаас мөнгө авахыг хүссэн, туслах ажилтнаа өөртөө зээл авч өгөхийг шаардсан.

Энриката Дэвис¹³ үүнийг шинэ үзэгдэл хэмээгээд, дэлгэрэнгүй тайлбар хийжээ. Тэрээр шүүгчид, өмгөөлөгчид, прокурорууд, орон нутгийн омбудсмэн, хуульчдын дунд хийсэн судалгаанаас, Панамын ял ногдуулах үйл ажиллагаа нь “хааяа” эсвэл “байнга” хараат байдалтай байдаг гэж оролцогчдын 70 хувь нь үзсэн гэжээ. Шударга ёсны төлөөх Иргэдийн холбооноос зохион байгуулсан шүүхийн шинэтгэлийн хурал дээр, хуульч Дамарис Кабалеро дэ Алменгор ба Айдо Журадо нар шүүхийн авлига ба хараат байдлын шалтгаануудыг тодорхойлсон нь:¹⁴

9 Ла Пренса (Панам). 2004.2.11

10 Панамын мэдээ, цуврал 10, дугаар 7, 2004 оны 4 сарын 17

11 Ла Пренса (Панам). 2005.12.7

12 Эл Панама Америка (Панам), 2006.1.2.

13 Энриката Дэвис: Панамын шүүхийн захиргааны бодит байдал; Шүүхийн мөрдөн шалгах төв, Улс төр, хууль зүйн факультет (Панамын их сургууль: Панам хот, 1993).

14 Диаро Панама Америка (Панам), 2000.8.14

- Шүүгчид, улс төрийн намуудын хоорондын хэлхээ холбоо
- Шүүгчид нэр дэвшүүлэх асуудлыг гүйцэтгэх засаглалаас хянадаг
- Дээд шүүхийн шүүгч нар шүүхийн албан тушаал дэвшүүлэх журамд хамаардаггүй
- Шүүхийн хараат бус байдлыг хүндэтгэх улс төрийн болон нийгмийн соёл дутмаг

Панамын шүүхийн тогтолцооны хямралын дараа, Ерөнхийлөгч Торрижос, шүүгчдийн төлөөлөл, Үндэсний прокурорын байгууллага, Конгресс, Омбудсман, Шударга ёсны төлөөх Иргэдийн холбоо¹⁵, Сүмүүдийн нийгэмлэгийг урьж 2005 оны 3 сард Шударга ёсны гэрээг байгуулсан. 27 төслийн санал батлагдсан байна.¹⁶

Түүний дараа хэдэн дэвшилттэй зүйл хийгдсэний нэг нь, Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх хороо байгуулагдсан явдал байлаа. Гэвч нэр дэвшигчийг тэнцэхгүй гэж шийдвэрлэх эрх мэдэл дутаж, зөвхөн Үндсэн хуулийн шаардлагын хүрээнд л шалгаж байна. Зөвхөн хоёрхон шүүгчийг л уг ажиллагааны дагуу шалгажээ.

Энэ нь санасан төвшингөөс хэт доогуур байв. Гэрээ нь шүүхийн шинэтгэлийн бүхий л хүрээг хамарсан. Үүнд: Шүүхийн дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх, прокурорын байгууллагад хяналтын субьектийг бий болгох, авлигатай холбоотой хэргүүдийн мөрдөн шалгах ажиллагааг сайжруулах механизмыг бий болгох, шүүхийн ил тод байдал, яллах ажиллагааг дэмжих харилцааны шинэ хэрэгслийг хөгжүүлэх зэрэг болно. Энэхүү өгүүллийг бичиж байх үед гэрээг байгуулсан хүмүүс 8 сарын дараа цугларч, 27 бүлэг гэрээнийхээ үр дүнг тооцох болно. Эдгээр нь тус бүрдээ хэрэгжих тодорхой хугацаатай бөгөөд зохицуулагч нэг бүрчлэн баталсан.¹⁷

Шударга ёсны төлөөх иргэдийн холбооноос шүүгч, прокурорын сахилгын хэргийг хянан шийдвэрлэх процесс өөрчлөгдвөл, сахилгын хэм хэмжээний хэрэгжилт сайжирч, хэргийг шударгаар шүүх баталгаа нэмэгдэх болно гэсэн саналыг дэвшүүлсэн. Шалгах ажиллагаа, шинжилгээний үр дүнд илэрсэн үр дүнг олон нийтэд ил тод болгохыг хүссэн. Өөр нэгэн санал нь шүүхийн албан тушаал дэвшүүлэх болон сургалтын тогтолцоог шинэчлэвэл, шүүгчид нэр дэвшигчийг хүлээн зөвшөөрөх, албан тушаал дэвшүүлэх нь гагцхүү ур чадварт суурилах болно.

*Анжелика Мейтин Юстиниани
(Иргэдийн эрх чөлөөний төлөөх сан – ТИ Панам, Панам хот)*

15 Шударга ёсны төлөөх иргэдийн холбоо. www.alianzaprojusticia.org.pa/ Сайтаас үзнэ үү.

16 2006 оны Дэлхийн нийтийн авилгын тайлан-г үзнэ үү.

17 www.alianzaprojusticia.org.pa/

Парагвайн шүүх дэх улс төр, ураг төрлийн хор уршиг

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, мэтгэлцэх зарчим

100,000 хүн тутамд ногдох шүүгчийн тоо: 10.5¹

Шүүгчийн цалигийн эхлэх хэмжээ: 15,600 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 33,600 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 1,280 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 68.2 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 1.4 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 4.9

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх түртэл давж заалдах боломжтой эсэх: Үгүй

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэрүүд нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Америкийн хууль зүйн сургалтын төв (2001)

2. Шүүх эрх мэдэл (2006)

3. Мөн тэнд

4. Дэлхийн банкны хөгжлийн түвшинг тодорхойлогч (2005)

5. Шүүх эрх мэдэл

6. CIA Дэлхийн үйл явдалын товчоон (2005)

Олон жилийн турш авлигын эсрэг тэмцэгчдэд, шүүхийн авлига нь шинэтгэлийн нэн тэргүүний зорилт байсаар байна. Магистратуудын хүнд суртал нь шүүхийн захиргааны үйл ажиллагааг сулруулж, үүний дүнд шүүн таслах ажиллагааг шуурхайлах, эсвэл удаашруулахын тулд хээл хахууль өгөх болдог. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг онлайнаар дамжуулах нь хэргийн материалтай танилцаж, зөвлөгөө авахад хялбар болсон боловч шүүхээс хэргийг шуурхай шийдвэрлэхэд бага нөлөө үзүүлсэн.

Тэр бүү хэл, бүр 1989 онд засгийн газар, өмнөх цэргийн дэглэмийн үед тогтсон үйл ажиллагааг бүрэн өөрчлөхийн тулд хараат бус шүүхийг бий болгох хэрэгтэйг мэдэрсэн. Засгийн газрын хийх гэж оролдсон зарим үйл ажиллагаанууд нь хараат бус шүүхтэй байж чадаагүйгээс хэрэгжиж чадаагүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. 1992 оны Үндсэн хуулиар эрх мэдлийн хуваарилалтыг баталгаажуулж, хараат бус шүүхийн тухай 248-р зүйлд тунхагласан. Үндсэн хуульд заасны дагуу, магистратуудын зөвлөл нь шүүхийн хараат бус байдлыг хангах зорилготойгоор байгуулагдсан боловч, үйл ажиллагаа нь зорилгоосоо дэндүү хол зөрүүтэй байлаа. (Доор өгүүлсэн)

Шүүгчээр ажиллах эсэхийг нэр дэвшигчийн намын гишүүнчлэл тодорхойлно

Колорадо болон Либерал намуудын хооронд зөрчлийн үр дүнд Үндэсний чуулганы Шүүхийн байгууллагын байнгийн хороо нь магистратуудын зөвлөлийн эрх

хэмжээнд нэлээд хязгаарлалт хийсэн. Уг хязгаарлалтыг Колорадо нам болон түүнтэй хэлхээ холбоотой зарим шүүгч нар хийсэн бөгөөд генерал Лино Овиедо 1996 оны 4 сард төрийн эргэлт хийхэд оролцсоны төлөө, хорих ял шийтгүүлсэнээ эсэргүүцэж мөн онд гомдол бичихэд, уг хязгаарлалт тодорсон байна. Шүүгч Бланка Флорентин, Антонио Рукс Варгас нар генералын өргөдлийн шаардлагыг яаран биелүүлэхэд, ажиглагчид тэднийг *oviedistas*¹ хэмээн нэрлэдэг этгээдийн бэлдсэн бичиг баримтуудыг зөвхөн тамгалсан гэж үздэг. Энэхүү мөрөөдлийн хараат бус байдлыг эс тооцвол шүүх нь улс төрийн олон янзын нөлөөнд байдаг. Жишээ нь, Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалын орон тоо гарахад түүний намын гишүүн томилгоонд тэнцдэг.

Шүүхийн тогтолцоо нь Дээд шүүх, давж заалдах шатны шүүх, анхан шатны, иргэний, хөдөлмөрийн, хүүхдийн, эвлэрлийн шүүхүүдээс бүрддэг. Дээд шүүхээс бусад нь бүс нутгийн хэмжээнд шүүхийн ажиллагааг явуулах эрхтэй. Шүүхийн төсөв нь Үндсэн хуульд зааснаар улсын төсвийн 3 хувийг эзэлдэг.

Шүүгч бэлтгэх сургууль магистратуудын зөвлөлийн ивээлд, ирээдүйд тэдгээрийг чанаржуулахын тулд байгуулагдсан. Мэргэшүүлэх үүрэг хүлээхгүй, сургуульд элсэн ороход хувийн байгууллагад ажилд орох ярилцлагаас дор. Сүүлийн үед сонгон шалгаруулалтаар, албан тушаалаа хашихаар дахин хүсэлт гаргасан магистратууд жагсаалтын эхэнд бичигдэх бөгөөд албан тушаалаа хадгалж үлдэх маш давуу боломжтой. Магистратууд 5 жилээр томилогддог бөгөөд 65 хүртлээ уг албан тушаалыг хаших боломжтой. Зөвхөн гэмт хэрэг үйлдсэн эсхүл удаан хугацаагаар ажил үүргээ зохих төвшинд гүйцэтгэж чадаагүй гэсэн 2 нөхцөлөөр магистрат шүүгчийг огцруулна.

Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн шалгуур илүү нарийн байдаг. Докторын зэрэгтэй, шүүгч эсхүл профессор, эсхүл өмгөөлөгчөөр 10-аас доошгүй жил ажилласан байхыг шаарддаг.

2003 онд Ерөнхийлөгч Никанор Дуартэ Фрутос албан тушаалаа авсаны дараа авлигатай тэмцэхээ мэдэгдсэн. Эхний жилд Дээд шүүхийн 6 шүүгчийг импичментын журмаар² албан тушаалаас нь чөлөөлж, өмнөх Ерөнхийлөгч Луис Гонзалес Макчиг 16 сая ам.долларыг Парагвайн төв банкнаас Нью-Йоркийн Сити банкинд хууль бусаар шилжүүлсэн хэмээн буруутгасан.³

1 Дэлгэрэнгүйг www.coha.org/Press%20Release%20Archives/1998/98.10_Paraguay's_Endemic_Corruption.htm сайтаас үзнэ үү.

2 Дэлгэрэнгүйг www.usaid.gov/policy/budget/cbj2006/lac/py.html сайтаас үзнэ үү.

3 Давж заалдах шатны шүүх Гонзалес Макчиг 2006 оны 9 сард цагаатгасан. Гэвч Ерөнхийлөгч асан тэрбээр 2004 онд Швейцарийн нууц дансандаа 1 сая гаруй ам.доллар нууж байсан нь илэрч, ял шийтгүүлсэн байна. edition.cnn.com/2006/WORLD/americas/11/09/paraguay.trial.ap/index.html сайтаас үзнэ үү.

Авлига ба ивээлдээ авдаг уламжлал

Шүүгч, магистратууд шударга, хараат бусаар үйл ажиллагаа явуулах ёстой боловч магистратуудыг сонгох журмыг улс төржүүлэн, шүүх эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдэлд үйлчлүүлж, авлигад өртөх боломжтой болгосон. Магистратын зөвлөл нь, Дээд шүүхийн шүүгчид, гүйцэтгэх эрх мэдлийн төлөөлөл, конгрессын гишүүн, Сенатор, 2 хуульч, 2 академичаас бүрдэж байгаа нь онолын хувьд бие даасан юм. Энэхүү бүрдэл нь олон ургальч үзлийг тусгасан мэт харагдаж байгаа боловч, гишүүдийг сонгоход улс төрийн шалгуур нөлөөлдөг. Жишээ нь: Конгрессын гишүүд, сенат нь, тухайн бүлгийнхээ улс төрийн нөлөөгөөр тодорхойлогддог.

Гүйцэтгэх эрх мэдлээс Ерөнхий прокурор, Дээд шүүхийн шүүгчийг сенатад батлуулахаар оруулж байгаа нь хөндлөнгөөс нөлөөлж буй хэлбэр юм. Сүүлийн жилүүдэд Ерөнхий прокурор, Дээд шүүхийн шүүгчид, Санхүүгийн ерөнхий байцаагчийн томилгоо, улс төрийн хэлэлцээрийн үр дүнд хийгдэх болжээ.

Магистратын зөвлөл нь намуудын нөлөөллийн үр дүнд цөөн нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг хийдэг. Магистратууд, прокурорууд, шүүгчдийн томилгоонд төрийн өөр эрх мэдэл нөлөөлөн, татгалзах явдал бий. Үүнд: Сенат, Ерөнхийлөгч, Дээд шүүхийн шүүгчдийн шийдвэр. Энэ нь, Ерөнхийлөгчийн сонгуультай давхцуулан, гүйцэтгэх засаглалаас 5 жилийн хугацаатайгаар томилдог байсан өмнөх тогтолцооны шинэчлэл юм. Магистратуудыг хянах субъект тодорхойгүй, сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд Дээд шүүхийн шүүгч 2, магистратуудын зөвлөлөөс 2 гишүүн, 2 Сенатор, 2 конгрессын гишүүн орох бөгөөд тэднийг намууд хэлэлцэн нэр дэвшүүлдэг. Уг бүрэлдэхүүн магистратуудыг огцруулах шийдвэр гаргах нь ховор.

Шүүх нь аль нэг намын мэдэлд, ихэвчлэн засгийн эрхийг барьж буй намын мэдэлд байгаа одоогийн энэ таагүй байдлын үндсэн шалтгаан нь шүүгчдийг сонгоход улс төрөөс нөлөөлж байгаа явдал юм. Тэр ч байтугай, шүүгчийг сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнээс буруутай гэж тодорхойлсон ч, улс төрийн намын зүгээс мөн л хаацайлдаг. Ийм байдлаар нөлөөлөх нь, шүүгчийг холбоо бүхий намын ашиг сонирхлын эсрэг, түүнчлэн, засгийн эрхийг баригчдын эсрэг шийдвэр гаргавал, албан тушаалаа алдах эрсдэлд хүргэдэг.

Шүүхийн хээл хахууль түгээмэл үзэгдэл

Парагвай дахь ТИ–ийн 2005 онд авлигын талаарх хийсэн үндэсний хэмжээний судалгаа хийсэн бөгөөд оролцогчдын 18.7 хувь нь, шүүхийн үйлчилгээг авахын тулд, дунджаар 680,000–ийг (130 ам.доллар) хээл хахуульд өгдөг гэжээ. 62 хувь нь нааштай шийдвэр гаргуулахын тулд шүүгчид хээл хахууль өгөх янз бүрийн арга замууд байдаг гэсэн ба зөвхөн 7 хувь нь, энэ нь боломжгүй буюу хэцүү гэж хариулжээ.

Энэхүү шүүхэд итгэлгүй байдал нь, иргэдийн эрх зөрчигдсөн ч шүүхэд хандахгүй байх нэгэн шалтгаан болдог. Хэрэв тэдгээрийн эсрэг тал нь улс төрийн, магистратын, эсвэл шүүгчтэй холбоотой, мөн илүү баян бол шүүхэд хандахаас зайлсхийдэг. Парагвайн ТИ–д нэгэн төрийн банкны ажилтан асан хүн авлигын хэргийн талаар мэдээлэл ирүүлсэн. Энэ нь үндэслэлгүй олгогдсон зээлийг шударга бусаар чөлөөлсөн тухай байв. Тэрээр энэ хэргээр шүүхэд хандаж, өөрийнх нь талд шийдвэр гарсан боловч түүний удирдлага асан хохирлыг нөхөн төлөх хүтэл 7 жил болжээ. Гэвч үнэндээ тэрээр уг хөрөнгийг гаргуулахын тулд ч хээл хахууль өгсөн байв.

Ураг төрлийн холбоо ба падриназго (ивээлдээ багтаах) нь авлигын өргөн зам болдог. Магистратуудын төрөл садан, улс төрийн холбоотноос “гуйсан, ярьсан” хэрэг хугацаандаа шуурхай шийдвэрлэгддэг. Нэгэн жишээ бол Манди Рэсэпсионезийн, эрчим хүчний Итайпу компанийн эсрэг хэрэг юм. Тэрээр 500,000 ам. долларын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг 2 жилийн хугацаатай хийсэн бөгөөд энэ нь цаашид сунгагдах нөхцөлтэй байв. Энэхүү гэрээний “зохицуулалт” болгож 5 сая ам.долларыг уг компаниас нэхэмжилсэн.⁴ Түүний ах болох дээд шүүхийн шүүгч Антонио Фернандез Гадеа, Манди Рэсэпсионезийн ялсан уг хэргийн материалыг сайтар бүрдүүлэв.

Шүүхийн нэр хүндэд муугаар нөлөөлсөн нэгэн хэрэг бол, Ерөнхийлөгч Дуартэ Фрутосыг, Колорадо намын даргын албан тушаалыг хавсран гүйцэтгэх нь Үндсэн хуульд нийцэхгүй хэмээн шийдвэрлэсэн Сонгуулийн шүүхийн шийдвэртэй холбоотой байлаа. Ерөнхийлөгч Дээд шүүхэд давж заалдахад, Колорадо намтай холбоо бүхий 5-н шүүгч уг шийдвэрийг судлаж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг шийдвэрийг түдгэлзүүлэхийг дэмжиж санал өгсөн. Энэ нь намын Дэд Ерөнхийлөгчдөө, намын даргын албан тушаалаа шилжүүлэхэд хангалттай хугацаа байв.

Сөрөг хүчнийхэн, хэвлэл, мэдээллийн ажилтнууд, иргэний нийгмийн байгууллагууд үүнийг эсэргүүцэж, шүүгчдийг албан тушаал бууруулах, эсвэл импичмент журмаар огцруулахыг шаарджээ. Гэвч үүний оронд, эсрэг санал өгсөн 4 шүүгчийн нэг “хүмүүсийг өдөөн турхирсан ” хэрэгт холбогдсон.

Энэ болон энэ мэт хэргүүд нь шүүх хэрхэн улс төрийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөн, тэдний талд шийдвэр гаргадгийг харуулж байна. Магистратын зөвлөлийн энэхүү гажиг тогтолцоо нь, өөрийг нь улс төрийн арилжааны газар болгож хувиргажээ. Улс төрийн нөлөөг арилгахын тулд нарийн нягт хяналт шалгалт хэрэгтэй. Гэвч үүний тулд Парагвайн засагт үгүйлэгдэж буй ёс суртахууныг төлөвшүүлэх нь чухал юм.

*Парагвайн Транспэрэнси,
Асуньсон хот*

4 www.abc.com.py/inventario/articulos.php?pid_62345&sec_30

Филиппин: Шүүхийн дорвитой шинэчлэлийн хандлага

Эрх зүйн тогтолцоо: Эрх газрын эрх зүй, мөрдөн шалгах, олон талт зарчим / исламын эрх зүйн элемент/

100,000 хүн тутамд ногдох шүүгчийн тоо: 2.7¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 5,996 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 32,545 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 1,300 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 146 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 24.5 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 0.6

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэр нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1 jbc.supremecourt.gov.ph/news/best_brightest.php.

2 Дээд шүүхийн санхүүгийн газар /2005/.

3. Мөн тэнд. 4 Дэлхийн банкны хөгжлийн түвшинг тодорхойлогч (2005)

5 Төсвийн ерөнхий хууль 2005.

6 Мөн тэнд

Филиппинд шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулахад хэд хэдэн бэрхшээл тулгардаг ба тэдгээрийг дурдвал: Шүүхийн ил тод бус байдал, хэргийн ачаалал, шүүхийн ажилтан, шүүгч, өмгөөлөгчдийн эсрэг хэргийг шийдвэрлэхгүй удаашруулах явдал, мөн цалин, хангамжийн хүрэлцээгүй байдал юм.

Нийгмийн төлөвийг судлах газар (НТСГ)¹-аас 2003 онд хийсэн судалгаанд оролцогчдын 30 хувь нь авлига дээд шатны шүүхэд, 35 хувь нь бусад шүүхүүдэд мөн оршдог гэж хариулсан. 2005 онд Дээд шүүхийн шүүгч Рэйнато С. Пуно, олон улсын хурал дээр хэлсэн үгэндээ, 2004 онд дээд шатны 2 шүүгчид сануулга авч, 4 шүүгч арга хэмжээ авахуулж, 45 нь огцорсон, 5 нь ёс зүйн зөрчил гаргасны төлөө торгууль хүлээсэн. 2005 онд дээд шатны 27 шүүгч огцорч, 15 нь сахилгын арга хэмжээ авахуулсан гэжээ.² Прокурорын байгууллагын авлигын талаарх нэгдсэн дүн байхгүй боловч, НТСГ-ын судалгааны Пангасинан, Себу, Давао хотын оролцогчдын 58 хувь прокурорын байгууллага, 81 нь хувь цагдаагийн байгууллага авлига үйлддэг гэжээ.

1 Нийгмийн уур амьсгалыг судлах газар, “Төрийн шүүх ба хуулийн мэргэжлийн мониторинг”, 2003. 4 сар www.sws.org.ph/ үзэх боломжтой.

2 “Филиппин улсын Шүүгчийн ёс зүйн шинэ дүрэм” Олон улсын шүүхийн шинэтгэлийн хурал дээр тараагдсан. Манила, 2005 оны 11 сарын 28-30.

Шүүхийн авлигын мөн чанар, цар хүрээ

Шүүхийн авлигын талаар албан ёсны судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй боловч дараах хүчин зүйлүүд оршдог. Үүнд:

- Улс төрийн нөлөө
- Төсөв, цалин бага
- Шинэтгэл доноруудын төсвийн дэмжлэгээс хараат байдал
- Процедурын хэм хэмжээг өөр хоорондоо зөрчилтэй байдлаар хэрэглэдэг
- Мониторинг дутмаг
- Боловсролын тогтолцоонд ёс суртахууны үнэ цэнийн тухай ойлголтыг төлөвшүүлэх ажил дутмаг
- Хэргийн ачаалал, шийдвэрлэх ажиллагааны удаашрал, хойшлуулах явдал

Дээд шүүх Үндсэн хуулийн манаач

Шүүх эрх мэдлийг тэргүүлэгч Дээд шүүх нь Ерөнхий шүүгч, 14 шүүгчээс бүрддэг. Шүүхийн тогтолцоо нь 4 шатлал бүхий тогтолцоотой. Үүнд: анхан шатны, хоёр дахь шатны, давж заалдах болон сандиганбаян шүүх (өндөр албан тушаалтантай холбоотой авлигын хэргийн) -ээс бүрдэнэ.

Хэд хэдэн хэргүүд нь, дээд шатны шүүхүүд дэхь улс төрийн нөлөө (Хууль зүйн яам, шүүхийн хоорондын зөрчилдөөн үүссэн тохиолдолд) нь доод шатны шүүхүүдэд муугаар нөлөөлдгийг харуулна. 2004–2006 оны үйл явдлууд нь гүйцэтгэх эрх мэдлээс шүүхэд улс төрийн зорилгоор халдах нь, мөнгө авдагаас илүү уршигтай гэдгийг үзүүлж байна. 2004 онд болсон сонгуулийн булхайтай холбоотой цэргийн албан тушаалтнуудыг мөрдөн шалгахад хэцүү. Ерөнхийлөгч Глориа Макапагал Аройяа, сенатын зөвлөл шалгахаас өмнө, сонгуулийн хорооны гишүүн Виржилио Гарсилланотой, Ерөнхийлөгчийн ярьсан утасны яриаг шалгахыг хориглосон шийдвэр гаргасан. Ерөнхийлөгч сонгуульд ялахын тулд сая гаруй саналыг луйвардаж, өөрийн талд өгүүлэх зааварчилгааг өгсөн юм.

Ерөнхийлөгчийн хоёр дахь шийдвэр бол “хариуг урьдчилан тохируулах” (ХУТ) гэж нэрлэгддэг, Ерөнхийлөгч Макапагал Аройяагийн 2004 онд гаргасан тушаал юм. Тэрээр эсрэг талуудын зөрчилдөөнийг арилгахын тулд хэмээн нэрийдэж, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, уучлал хүсэх, төрийн байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхийг хязгаарласан байна. 2006 оны 4 сард Дээд шүүх санал нэгтгэйгээр уг тушаалыг Үндсэн хуульд харшилсан гэж зарласан боловч, Эвлэлдэн нэгдэх тухай хуулийн олон нийтийн газар, жагсаал цуглаан зохион байгуулахын тулд, аюулгүй байдлыг хангах үүднээс зөвшөөрөл авах ёстой гэсэн заалтыг хэвээр үлдээжээ.³

3 Дээд шүүхийн шийдвэр. 2006.4.25

Ерөнхийлөгчийн гурав дахь шийдвэр бол, цэрэг, цагдаагийнханд эрх олгосон 1017-ийн тунхаг юм. Уг тунхагт цэрэг, цагдаагийн байгууллага нь, засгийн эсрэг үзэл бодолтой хүмүүсийг баривчлах, төрийн дэглэмд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бизнесийн болон үйлдвэрийн газрын үйл ажиллагааг зогсоож, хаах эрхтэй болох тухай заасан.⁴ Дээрх гурван тохиолдолд Дээд шүүх тушаалуудыг бүгдийг Үндсэн хуулийн бус хэмээн зарлаж хараат бус байдлаа батлан харуулсан.

Ядмаг санхүүжилтийн урхаг

Шүүх нь жилийн улсын төсвийн өчүүхэн хэсэг буюу 0.6 хувьтай тэнцэх санхүүжилт авдаг. Дээд шатны шүүгчид нь жилийн 8,987 ам.доллар авдаг нь Америкийн ижил төрлийн шүүгчдийн жилийн цалингийн дөрөвний нэгээс ч бага байна. 2003 оны 10 дугаар сард⁵ авсан арга хэмжээний дүнд шүүхэд ажиллагсдын цалинг 2 дахин нэмэгдүүлэхээр тогтсон боловч хөрөнгө хүрэлцээгүй шалтгаанаар 4 жилийн дараа хэрэгжсэн. 2006 оны 10 сараас зорилт хэрэгжиж эхэлсэн. Шүүгчийн цалин ингэж нэмэгдсэний дараа ч, сонирхол татагдахаар байж чадаагүй. Олон чадварлаг хуульчид шүүгчээр ажиллахыг хүсдэггүй. Шүүгчид хувийн салбарт ажиллахаар ажлаасаа гарах нь элбэг тохиолдоно. 2005 онд шүүхийн байгууллагын сул орон тоо, бүс нутгийн болон захиргааны төвшинд 17-52 хувьтай байсан.⁶

Хангалттай тооны шүүгчид үгүйгээс хэргийн шийдвэрлэлтийн хугацаа сунаж, хойшилдаг. Ердийн хэргийг шийдвэрлэхэд дунджаар 5-6 жил шаардагдана. Хэрэв давж заалдвал, эцсийн шийдвэр гаргал дахин 6-н жил болно. 2005 онд Дээд шүүх, Филиппин улсын хэмжээнд нийт 800,000 гаруй хэрэг шийдвэрлэгдээгүй байгааг тогтоосон байна.⁷

Процедурын хэм хэмжээний зөрчилтэй хэрэглээ

Шүүхийн тогтолцоонд ажиллагсад харилцан холбоотой ажиллах явдал эрс үгүйлэгддэг. Үүнээс шалтгаалан авлигад хөтлөх олон процедурын хэм хэмжээг бий болгогч тохиолдолууд байдаг. Эдгээрт:

- Зөвшөөрөлгүй баривчлах
- Эрүүгийн хэрэг шийдвэрлэх үед, хувийн прокурор (private prosecutor) ирсэн байхад ч, төрийн прокурор ирэхгүй байх

4 Дээд шүүхийн шийдвэр. 2006.5.3 Sun Star онлайн сүлжээ, www.sunstar.com.ph/static/net/2006/02/24/.state.of.emergency.allows.arroyo.to.tap.military.html сайтаас үзнэ үү.

5 Төсвийн тухай хууль. 9227

6 “Хамгийн сайн, ил тодыг дэвшүүлэх нь” Шүүхийн дарга Артемиол Панганибан. 2006.2.23 jbc.supremecourt.gov.ph/news/best_brightest.php сайтаас үзэх боломжтой.

7 Шүүхийн шинэчлэлийн олон улсын хурлын үеэр, Дээд шүүхийн тавьсан илтгэл. Манила. 2005 оны 11 сарын 28-30

- Төрийн эрх зүйн туслалцааны хуульчид дутагдалтайгаас ядуу хэргийн оролцогчдын хэрэг шалтгаангүй хойшлох
- Хууль хэрэгжүүлэх ажилтнуудын хууль, процессын хэм хэмжээний талаар мэдлэг дутмагаас шалтгаалан хууль бус ял оноох
- Мэдээллийн хэрэгслээр мэдэгдсэн хэргийг далд шалтгааны улмаас, мөн хээл хахууль аван хууль бусаар хянан хэлэлцэх

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар зөвхөн прокурор нь урьдчилсан мөрдөн байцаалт явуулах эрхтэй гэсэн байдаг боловч энэ нь хэрэгждэггүй. Зарим прокурорууд өөрсдийн эрх мэдлээ, хэргийг хууль бусаар хаахад ашиглах бөгөөд хэргийн оролцогчид, хэдийгээр авлигын талаар тодорхой мэдсэн ч хууль зүйн туслалцаа авах боломжгүй байдаг. Заримдаа анхан шатны шүүгч, прокурортой үгсэх, цагдаагийн ажилтан хээл хахууль авахаар сүрдүүлэхийн тулд хэргийн материалыг хуурамчаар бүрдүүлэх тохиолдол бий.

Хэдийгээр хуулиар хориглодог ч гэсэн батлан даалтанд гаргахын тулд, төлбөр болон бусад нөхцлийг өөрчлүүлэхээр хууль бус орлогыг байршуулдаг. 2005 оны 8 сард Дээд шүүх урьдчилсан мөрдөн байцаалт явуулах, батлан даалтанд гаргах хуулийн хэм хэмжээнд өөрчлөлт оруулж, тодруулсан.⁸ Энэхүү нэмэлтээр анхан шатны шүүгчдийн урьдчилсан мөрдөн байцаалт явуулах эрхийг хүчингүй болгов. Батлан даалтын хөрөнгийг зөвхөн шүүхээс өмнөх шатанд, хэргийг мөрдөж байх хугацаанд гаргаж, энэ талаар хэргийн материалд хавсаргах ёстой. Шүүгч байхгүй үед, тухайн хэргийг шийдвэрлэж буй өөр нэгэн шүүгч хойшлогдсон батлан даалтын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх эрхтэй.

Шүүхийн тогтолцоог шинэчлэх оролдлого

2000 оны 11 сард, 2001-2006 онуудад хэрэгжүүлэх Шүүхийн шинэтгэлийн хөтөлбөр (ШШХ) боловсруулсан.⁹ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол хүн нь Дээд шүүхийн Ерөнхий шүүгч асан Хиларио Давид байлаа. ШШХ нь, шүүхэд хандах эрх, авлига, албан тушаалдаа тэнцэхгүй байх байдал, хэрэг шийдвэрлэх ажиллагааны удаашрал зэрэг үндсэн асуудлуудад чиглэсэн. Шинэтгэлийн нэгээхэн хэсэг бол цахим системийг нэвтрүүлэх замаар зардлыг бууруулах явдал байв. Үүний тусламжтайгаар төлбөрийг шүүхийн тамгийн хэлтсийн дансанд бус, Дээд шүүхийн санд төвлөрүүлэх юм. Цахим хэрэг-мэдээллийн системийн захиргаа нь нийт нутгийн 28,000 шүүгчид, шүүхийн албан хаагчдын компьютерийн сургалтыг зохион байгуулах ажлаа танилцуулсан. Энэ нь цахим номын сан, шүүгчдийн эрдэм шинжилгээний ажил бичих, ял шийтгэлийн оновчтой байдлын талаар туслах цахим номуудтайгаар бүтээгдсэн. Шүүхийн тэмдэглэл болон бусад процессыг автоматжуулахад учирсан нэгэн бэрхшээл бол телефон утасны шугам

8 Дээд шүүхийн захиргааны ажил. 2005.8.26. дугаар 05-8-26

9 www.apjr_sc_phil.org сайтаас үзнэ үү.

хүрэлцээгүй юм. Энэ нь Дээд шүүх байрлах Манила хотоос 17 км зайд орших Кавите-д хүртэл асуудал болж байлаа.

ШШХ нь шүүгчид нэр дэвшигчийг зөв шалгаруулахын тулд Барын системийг шүүхийн практикт хэрэгжүүлэхээр санаачилсан. 21-р зууны шаардлагад нийцсэн, хариуцлагатай хуульч бэлдүүлэхийн тулд, хууль зүйн коллежийн үйл ажиллагааг хянах, шалгах Боловсролын газрыг 2004 оны 5 сард байгуулсан. Шүүхийн дагалдах ажилтныг сургах хөтөлбөр нь, 3, 4-р курсын оюутнуудыг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай танилцуулж, хууль зүйн судалгаа, шүүхийн шийдвэр бичих дадлага хийлгэхэд чиглэж байна. Заавал суралцах Хууль зүйн Үргэлжилсэн Сургалт (ЗХҮС) хөтөлбөр нь Барын гишүүдийг хууль, эрх зүйн шинжлэх ухаантай байнга холбож сургах, тасралтгүй хөгжүүлэх, хуульчийн тангарагыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхэд чиглэнэ.¹⁰ Дээд шүүх нь Банглорын зарчмыг үлгэрлэн, Шүүгчийн болон шүүхийн ажилтны ёс зүйн дүрмийг 2004 онд баталсан. Эдгээр шинэ дүрмийг хэрэгжүүлэхийн тулд доноруудын тусламжтайгаар тусгай сургалтыг өргөн хэмжээгээр зохион байгуулсан.

Хэн нэгний ивээлээр бус мерит тогтолцоонд (нэр дэвшигчийн ур чадварт) суурилсан албан тушаал дэвшүүлэх, томилох тогтолцоог бий болгож шинэчлэх шаардлагатай байна. ШШХХ -ийн зорилтуудын нэг нь боловсон хүчнийг сонгон шалгаруулах байнгын, үр дүнтэй тогтолцоог бий болгох, алдаа гаргасан шүүгчид хатуу хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх юм. Энэхүү процесс нь, шүүхийн болон Барын зөвлөл нь шүүгчид нэр дэвшигчийг сонгож олоод, тэдгээртэй ярилцлага хийнэ. Тэнцсэн хүмүүс нь нэрээ нийтэд мэдээлэх бөгөөд, олон нийтээс уригдсан хүмүүс, нэр дэвшигчидтэй ярилцан, тодорхойлолт гаргана. Муу үзүүлэлттэй гарвал үл тэнцэнэ. Үлдсэн нэр дэвшигчдээс 3-ийг нь сонгож, орон нутгийн шүүгчийн орон тоонд өрсөлдүүлэхээр Ерөнхийлөгчид өргөн барих бөгөөд тэрээр эцсийн сонголтыг хийнэ. Шүүгчийн томилгооны процесс дахь иргэдийн төлөөлөгчдийг сонгож олох, шүүхийн болон Барын зөвлөлд орон тооны 4-н гишүүн ажиллах бөгөөд тэдгээрт Барын гишүүн, Хууль зүйн шинжлэх ухааны профессор, Дээд шүүхээс тэтгэвэртээ гарсан шүүгч, хувийн салбарын төлөөлөгч нар орно. Харин Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчдийг томилоход иргэний нийгмийн оролцоо хангалтгүй байдаг.¹¹

6 жилийн шинэтгэлийн туршид олон үйл ажиллагааг явуулсан боловч, үр дүн, түүнчлэн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд тулгарсан асуудлуудыг үнэлэх ажил дутагдалтай байв. Мөн олон шинэчлэлүүд хэрэгжиж чадаагүй. Санхүүгийн нөөц хязгаарлагдмал байсаар байгаа нь хэргийг шийдвэрлэх, төлбөр хураах, хэргийн ачаалалтай холбоотой хэрэгжих электрон тогтолцоо зохих ёсоор хэрэгжээгүйг илтгэнэ. Прокурорын сургалтын хөтөлбөр хэрэгжээгүй, хойшлогдсон хэргийн

10 Дээд шүүхийн шийдвэр, www.supremecourt.gov.ph/rulesofcourt/2003/administer_113_03.htm сайтаас үзэх боломжтой.

11 Дэлгэрэнгүй мэдээллийг www.tan.org.ph/files/proj_scaw сайтаас үзнэ үү.

талаарх судалгааны материал хүлээн авах боломж муу, ядмаг удирдлага зохион байгуулалт, мэдээлэл солилцох хамтын ажиллагаа дутмаг зэрэг нь санаа зовох олон асуудлын шалтгаан болж байна.¹²

Шүүхийн авлигатай хийх тэмцэлд иргэний нийгмийн оролцоо

Филиппинд 30 гаруй ТББ авлигатай тэмцэхээ мэдэгдэж, мөн зарим нь Филиппиний ТИ-ийг өөртөө нэгтгэсэн Ил тод байдал, Хариуцлагын Сүлжээнд (ИХС) нэгдэн орсон. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, омбудсман, сонгуулийн хорооны ажилтнуудыг сонгоход хяналт тавих ажиглагч бүлгүүд бий болсон. ИХС нь шүүхийн болон Барын зөвлөлийг хянах, мөн олон нийтийн төлөөллөөр тодорхойлолт гаргуулах, мэргэшсэн нэр дэвшигчийн жагсаалтыг хэрэгжүүлэхийн тулд хороо байгуулсан.

Ашгийн бус мэдээллийн агентлаг, холбоо, тухайлбал, Филиппиний Сэтгүүл зүйн Эрэн сурвалжлах Төв (ФСЭТ), Мэдээллийн Эрх чөлөө, Хариуцлагын Төв зэрэг нь шүүхийн хариуцлагыг дээшлүүлэх, судлах талаар чухал үүрэг гүйцэтгэж байна. ФСЭТ нь 2001 онд, Аргентиний фирм болох ИМПСА-гийн эрчим хүчний станц байгуулах талаарх зөрчилтэй гэрээнд засгийн газраас зөвшөөрөл олгосон болохыг эрэн сурвалжилж илрүүлсэн. Энэхүү мэдээлэл нь, уг шийдвэрийн талаарх шударга бус асуудлуудыг дэвшүүлэн гаргаж, 2003 оны 1 сард болсон Сенатын мөрдөн шалгах ажиллагааны эх сурвалж болж чадсан.¹³

*Шүүгч Долорес Эспанол
(Филиппины ТИ, Манила)*

12 pdf.ph/downloads/governance/Judicial%20reform%2019%20July%20Presentation.pdf

13 www.pcij.org

ПШГ (Папуа Шинэ Гвиней) –ийн шүүхийг шинэчлэхэд улс төрийн дэмжлэг чухал

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, мэтгэлцэх болон олон талт зарчим
100,000 хүн тутамд ногдох шүүгчийн тоо: 2.6¹
Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 9,945 ам.доллар²
Дээд шүүхийн шүүгчийн цалин: 111,082 ам.доллар³
Нэг хүнд ногдох УНБ: 660 ам.доллар⁴
Шүүхийн жилийн төсөв: 11.6 сая ам.доллар⁵
Жилийн нийт төсөв: 1.5 тэрбум ам.доллар⁶
Жилийн төсөвт эзлэх хувь: 0.7
Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм
Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Мэдээлэл байхгүй
Шүүхээс гаргасан бүх шийдвэрүүд нийтэд ил тод байдаг: Тийм
Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Төслийн шатанд

1. Дэлхийн банк (2000) 2. Шүүхийн үйлчилгээ (2006) 3. ПШГ–ийн Цалин, хангамжийн хороо.
 4. Дэлхийн банкны хөгжлийн түвшинг тодорхойлогч (2005)
 5. www.treasury.gov.pg/files/budget2006/detail.223.2006.1.pdf. 6 Мөн тэнд

Сүүлийн 20 жилийн дотор Папуа Шинэ Гвиней (ПШГ) дэх төрийн удирдлага, зохицуулалт суларсан.¹ Олонхи хуулийн болон захиргааны байгууллагууд үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгаа боловч, бусдаасаа илүү сайн ажиллаж буй нь бас бий. Судалгаа нь төрийн гол байгууллагын нэг болох шүүх, хэдийгээр хоорондоо асар их ялгаатай ажиллаж байгаа ч, үүргээ биелүүлдэг гэж үзсэн.² Шүүхийн ажлын ачаалал их байгаа нь, шан харамж горилон, үүргээ зохих ёсоор биелүүлэхгүйд хүргэдэг. Шүүхийн авлигын асуудал нь ПШГ–ийн хатуу уламжлалт нийгэм дэх, шүүхийн тогтолцооны уналтын эхлэл үү, эсвэл нэгэнт тогтсон гажуудал уу гэдэг нь тодорхой бус байна.

Шинэтгэлийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, хамгийн том хандивлагч бол Хууль, Шүүхийн салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Олон улсын хөгжлийн төлөөх Австралийн агентлаг (Ausaid) юм. Олон жилийн дэмжлэг, гадаадын шүүхийн зөвлөхүүдийн туслалцааг эс тооцвол, шүүхийн салбарын үйл ажиллагаанд гойд сайжирсан зүйл үгүй. Ausaid нь үйл ажиллагааны сүүлийн үеийн дэвшлийг тэмдэглэсэн бөгөөд энэхүү ололтыг зогсоолгүй цааш үргэлжлүүлэх нь чухал юм.

1 Шүүхийн зөвлөх байгууллагын тайлан, “ПШГ-д Авлигатай тэмцэх, Албан тушаал дэвшүүлэхэд шударга хандах нь”, 2005.2.20
 2 ПШГ –ийн үндэсний шударга ёсны тогтолцооны тайлан, 2003 www.transparency.org/policy_research/nis/regional/asia_pacific

Австралийн Хамтын ажиллагааг сайжруулах хөтөлбөр (ХСХ) нь авлигын асуудалд төвлөрч ажилладаг бөгөөд Австралийн шүүх, прокурорын байгууллагын³ ажилтнуудыг ажиллуулдаг бөгөөд тэдгээр нь зөвлөгчөөр бус орон тооны ажилтанаар ажилладаг. Австралийн мэргэжилтнүүдийн халдашгүй дархан эрхийг ПШГ-ийн хуулиар хамгаалдаг ч, ХСХ-г хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байдаг. Мороби мужийн захирагч зарим албан тушаалтнуудыг (ихэвчлэн цагдаагийн) эгүүлэн татах талаар ХСХ-ийн эсрэг Дээд шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн. ХСХ-ийн прокурор шүүх ажиллагаанд оролцох эрхтэй.

ПШГ дэх шүүхийн үйл ажиллагааны доголдлын үндсэн шалтгаан бол улс төрийн зүгээс анхаарал, хайхрамжгүй хандах явдал юм. Хандивлагчдын шинэтгэлийн төлөөх оролдлого нь, улс төрд нэмэлт ачаалал өгч магадгүй боловч, улс төрийн хайхрамжгүй байдал, эсэргүүцэлтэй тулгарвал шинэтгэлийг хийж чадахгүйд хүргэнэ. 2006 онд Хууль зүйн яамны сайдаар томилогдсон Бире Кимисопа, шүүхийн тогтолцоог шинэчилж, авлигыг таслан зогсоохоо мэдэгдсэн. Түүний тэргүүлсэн байгууллага, хууль, шүүхийн салбарын авлига, шударга бус байдлаас урьдчилан сэргийлэх талаар онцгойлон авч үзсэн нэгэн актын төслийг боловсруулжээ.

Шүүх бол “итгэлийн гэрэлт цамхаг”

Үндэсний шүүхийн тогтолцоо нь 4-н шатлал бүхий шүүхээс бүрдэнэ. Үүнд: 5-н танхим бүхий Дээд шүүх, давж заалдах шүүхийн үүргийг гүйцэтгэх үндэсний шүүхүүд, дүүргийн болон тосгоны шүүхүүд тус тус хамаарна. Голлох хуулийн түшмэдүүд нь, захиргааны сайд, Ерөнхий прокурор (хэрэв Хууль зүйн сайд нь хуульч биш бол 1986 оны хуульчдын актын дагуу томилогдно), төрийн прокурор, төрийн өмгөөлөгч нар юм. Шүүх нь эрх мэдэл, чиг үүргээ бүрэн хараат бусаар хэрэгжүүлнэ.

Майкл Сомарийн 2002 оны сонгуулийн амлалтанд тусгагдсанаар, засгийн газрын кабинет бүрдсэний дараа 2003 онд Шүүхийн эрх зүй, хууль зүйн салбарын хороог шинээр байгуулсан. Уг хороо нь хууль зүйн салбарт хяналт, шалгалт хийх чиг үүрэгтэй. Уг өгүүллийг бичиж байх үед, тус хороо хуралдаанаа хийгээгүй байсан.

Шүүх нь ПШГ-ийн хувьд итгэлийн гэрэлт цамхагт тооцогдсоор ирсэн. Дээд шатандаа шударга шийдвэр гаргадаг боловч ажиглагчдын үзэж буйгаар доод шатанд шударга шийдвэр гаргах явдал суларсан. Үйл ажиллагааны менежмент сул, бараг байдаггүй.⁴

Тосгоны шүүхүүд нь, ПШГ-н алслагдсан бүсүүдэд шүүхийн үйлчилгээг хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь зохион байгуулалт сайтай байгаагийнх гэхээсээ

3 Үндэсний (ПШГ), 2006.1.19

4 Шүүхийн зөвлөх байгууллагын тайлан

илүү тосгоны шүүхийн ажилтнуудын ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг байдал болон сайхан сэтгэлтэйгх байдаг. Тосгоны шүүгчид мужийн засаг захиргааны өмнө хариуцлага хүлээдэг. Санхүүгийн өөр эх сурвалж, хяналтаас шалтгаалан шүүхүүд хуваагдах явдал өсөж байна. 2006 онд засгийн газар нь, магистратуудад хойшлогдсон мөнгөн тэтгэлгийг олгох, мужуудад төлбөрийн сайжруулсан тогтолцоог хэрэгжүүлэхээ мэдэгдсэн.⁵ Тэр хүртэл олон магистратууд цалин хөлсөө аваагүй байсан бөгөөд торгуулийн мөнгөөр амьдралаа залгуулж байсан гэж үзэж болохоор байна. Уг мөнгө нь ямар нэгэн тооцоогүй, аудитаар шалгагддаггүй бөгөөд авлигын нөхцөлийг бүрдүүлж байжээ.

Тосгоны шүүхүүдэд саарын зэрэгцээ сайн зүйлүүд ч байдаг. Зүүн Шинэ Британи мужид шүүхийн захиргаа маш сайн ажилладаг, Зүүн Хайландын тосгоны шүүхүүд сайн удирдлага, зохион байгуулалттай, мужийн болон нутгийн захиргаа нь магистратын үйлчилгээг үргэлжлүүлэн хүргэдэг. Хандивлагчдын, голдуу Ausaid-н тусламжтайгаар, улсын болон мужийн хяналтын тогтолцоог сайжруулах замаар, тосгоны шүүхийн захиргааг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулж байна.

Ерөнхий прокурорын газар дахь улс төрийн тушаа

Шүүгчид бол шүүхийн тогтолцоон дахь олон эд эсийн зөвхөн нэг хэсэг нь юм. ПШГ-н шүүгчид нь хэдийгээр тэд шударга, сайн ажиллаж байгаа ч авлига өмгөөлөгч, прокурор, цагдаа зэрэг бусад оролцогч этгээдүүдээр дамжуулан шударга ёсыг алдагдуулж, шүүн таслах үйл ажиллагаанд орж ирж байна хэмээн буруушаадаг.⁶

Шүүхийн тогтолцоонд авлигын талаар худал мэдүүлдэг нэгэн субъект бол Ерөнхий прокурорын газар юм. Уг албан тушаалаас, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн олз олж болох нь мэдэгдсэн үеэс, энэхүү албан тушаалын төлөө хүчтэй өрсөлдөөн бий болсон. Тус өгүүллийг бичиж байх үед өрсөлдөгч улс төрийн хүчний эрх ашгийг хязгаарлах, өөрийн хүний нэр дэвшүүлэх, эсвэл зөвшилцөж томилохын тулд уг албан тушаал нь 2 жилийн турш эзэнгүй байсан. Ерөнхий прокурорын газрын цалин хөлс, түүнтэй ижил хувийн байгууллагын цалин хөлснөөс маш доогуур, ёс зүйн сургалт тааруу байдаг.

Хэргүүдийн хяналт сул, яллах ажиллагаа гүйцэд бус, түүнчлэн өмгөөлөгч, хуульчдын үйл ажиллагааны идэвхгүй байдал зэргээс шалтгаалан, хэргүүд шийдэгдэхгүй орхигдох, процессын ажиллагаа хийгддэггүй. Шүүхэд шилжүүлэх хэргийн материалын бүртгэлийг дутуу хийж байгаа нь дээрх нөхцөлийг бүрдүүлдэг. Магадгүй энэ нь тэдэнд ашиг, унцаа болдог байж болох тухай зарим нотлох баримтууд байдаг. Агентлагууд нь эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагаанд Шүүхэд шилжүүлэх Хэргийн өгөгдлийн санг ашиглаж байна. Уг

5 “Папуа Шинэ Гвинейн тосгоны шүүхийн тогтолцоо”, ПШГ Шүүхийн зөвлөх байгууллага, 2004.3.21. www.lawandjustice.gov.pg/www/html/7-home-page.asp

6 Жишээг Үндэсний (ПШГ), 2006.6.14 -7.26 хэвлэлээс үзнэ үү.

системд бүх хэргийн мэдээллүүд цуглардаг. Энэ болон сайжруулсан хэргийн бүртгэлийн систем нь хэрэг шийдвэрлэх ажиллагаа удаашрах, эрүү, иргэний хэргийн сэжиг бүхий авлигын үндэс болсон хэргийн материал үрэгдэх явдлыг 30 хувиар бууруулсан.

Шүүхээс гадуур тохиролцох нь унац ихтэй бизнес бөгөөд авлигын эх сурвалж болдог. Санхүүгийн албан хаагчид нь шүүх, хувийн хууль зүйн товчоо үгсэн хуйвалдаж төрийн эсрэг залилан хийдэг.⁷ 1995 оноос хойш төрийн эсрэг гаргасан нэхэмжлэлийн үнийн дүн 500 саяд (175 сая ам.доллар) хүрсэн. Одоогоор Өмгөөлөгчдийг удирдах байгууллагын 11 хуульчид 8,905 хэрэг дээр ажиллаж байгаа бөгөөд нэхэмжлэгчид нь хэргээ эвлэрлийн аргаар шийдвэрлүүл гэсэн хатуу шаардлаган дор байгаа. Энэхүү шаардлага нь шинэ төвшинд хүрсэн бөгөөд саяхан нэхэмжлэлийг эвлэрлийн журмаар шийдвэрлүүлэх ажиллагааг хойшлуулсан нэгэн ахмад хуульчийг алахаар сүрдүүлжээ.⁸ 2006 оны Дэлхий нийтийн авлигын тайланд дурьдсанаар, ихэнхи нэхэмжлэлүүд цагдаагийн байгууллагын эсрэг байх боловч нийтийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хууль бус үйл ажиллагааны эсрэг нэхэмжлэл гаргах нь ихсэж байна.

Яллах ажиллагааг хэсэгчлэн хувьчлах нь

2005 онд хийгдсэн хууль зүйн өөрчлөлтийн дүнд шүүхийн нарийн бичгийн даргын зөвшөөрөлтэйгээр шүүхээс гадуур тохиролцох боломжтой болсон. Уг зохицуулалт нь ихээхэн хэмжээгээр урвуулан ашиглагдсан боловч парламентын үнэлгээний олон нийтийн хороо нь дэмжиж буйгаа илэрхийлсэн. 2006 онд засгийн газар, өнгөрсөн 10 жилд томоохон авлигын хэрэгтэй холбоотой асуудалд хуурамч мэдэгдэл хийсэн санхүүгийн байгууллагуудыг шалган байцаах ажлыг эхлүүлсэн. 2006 оны эхэнд парламентын гишүүн Жэмми Макстон Грахам парламентаар зарим хэргүүдийг хэлэлцүүлэхээр гаргасан боловч тэдгээр нь түүнээс дор хаяж 6 сарын өмнө хууль хэрэгжүүлэх агентлагуудад тарсан байжээ.

Нэмж хэлэхэд, Нийтийн үнэлгээний хороо нь төрийн нэрийн өмнөөс маргаан шийдвэрлүүлэхэд зориулж нэгэн хууль зүйн товчоонд зардал болгон шилжүүлсэн 28 сая (10 сая ам.доллар)-ыг шалгаж байна.⁹ Энэ нь Улсын өмгөөлөгч, Ерөнхий өмгөөлөгчийн 2.24 сая, улсын прокурор, өмгөөлөгчдийн 5.3 саяаас тус тус бүрдсэн 2006 оны төрийн хуулийн хэлтсийн төсөв болох 20.8 сая (7.3 сая ам.доллар)-аас илүү байна¹⁰. Дээрх мөнгийг шилжүүлж, төрийн хөрөнгөөр худалдан авалт хийхэд

7 Үндэсний (ПШГ), 2006.6.14

8 2006.5.14-16 нд болсон Австралийн Кайрнд болсон, Австрали, Папуа Шинэ Гвинейн 22 дахь удаагын бизнесийн чуулган дээр Хууль зүйн сайд Бирэ Кимисопагийн хэлсэн үгээс

9 Үндэсний (ПШГ), 2006.1.19

10 2006 оны төсвийн тухай бичиг баримтаас. www.treasury.gov.pg/html/budget_2006.html сайтаас үзэх боломжтой

сангийн яамаар дамжуулан олон хамгаалалтыг нэвтрэх шаардлагатай байдаг. Гэтэл дээрх хууль зүйн товчоо нь, төрийн мөнгөн хөрөнгө болох 1.3 тэрбум (54.5 сая ам.доллар)-ыг¹¹ буцаан төлүүлэхийн төлөө тэдний мэргэжилтнүүд ажиллаж, уг мөнгө тэдгээрийн зардалд зориулагдсан хэмээжээ.

Шүүхийн тогтолцооны өөр нэгэн элемент бол цагдаагийн байгууллага дахь авлигын илрэл юм. 2005 онд хийсэн захиргааны нарийвчилсан шалгалт явуулж, санхүүгийн нөөцийг зохисгүй ашиглах, сахилгын хариуцлага тооцох механизм бараг үгүй болсоныг илрүүлсэн (Дэлхий нийтийн авлигын тайлан 2006). Мэдээлэл батлагдсаны дараа, Дотоодын аюулгүй байдлын сайд (өдгөө Хууль зүйн сайд) нэг жилийн дараа л хөгжлийн явц удаан байгаад итгэсэн. Иргэний нийгмийн байгууллагууд илүү шүүмжлэлтэй хандсан бөгөөд тэд тэр ч байтугай хамгийн амархан хамгаалалт болох, таних тэмдэгээ байнга зүүж явах тухай арга хэмжээ ч хэрэгждэггүй хэмээн мэдэгдсэн.

Өмгөөлөгчид ч мөн шүүхийн авлигад оролцдог боловч, энэ талаар хангалттай бус мэдээлэл нь, асуудлыг бүрэн хэмжээгээр хөндөхөд бэрхшээл учруулдаг. Өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэгтэй Хууль зүйн нийгэмлэг нь үүргээ чадан ядан биелүүлнэ. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явц удаан хугацаагаар хойшлогдож, ноцтой гомдол дээр өмгөөлөгчид хэрэг шийдэгдэх хүртэл олон жил ажиллаж болно.

Шүүхээр үйлчлүүлэгчдийн нийгэмлэг шийдвэрлэгдээгүй хэргийн тоог бууруулдаг

Омбудсмэны хороо бол ПШГ-н төрийн удирдлагуудын нууцад халдаж мөрдлөг явуулах эрх бүхий, шүүхийн тогтолцоон дахь чухал субъект юм. Авлигын эсрэг үйл ажиллагаа нь талархал хүлээдэг хэдий ч, 2006 онд Трибуналын удирдлагууд болох парламентын гишүүд, сайд нар олноороо шалгагдсан тул, уг байгууллага хурц шүүмжлэлд өртсөн. 2005 онд Омбудсмэны хорооны эрх мэдэл, чиг үүргийг хянаж, тодорхойлохоор парламентаас сонгогдсон хороо байгуулагдан 2006 оны сүүлээр дүгнэлт гаргасан. 2006 оны дундуур Омбудсмэны хорооны ачаалал нэмэгдсэнтэй холбогдуулан 2.8 сая (980,000 ам.доллар)-ыг төсвийн нэмэлт болгож засгийн газраас баталсан.

Эцэст нь 2005 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн зарим зүйл заалтыг баталгаажуулан, ПШГ-н залилан мэхлэх гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дотор Санхүүгийн мэргэжлийн шалгалтын тусгай тасгийг байгуулсан. Энэ нь төрийн эсрэг хэрэг үйлдсэн цагаан захтануудтай тэмцэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх болно. Хэрвээ энэ тасаг төрийн албан дахь

11 Үндэсний (ПШГ), 2006.7.25

гүнзгий бэхжсэн авлигатай тэмцэж эхлэвэл, илүү өндөр хэмжээний эсэргүүцэлтэй тулгарч болзошгүй.

Зөвхөн авлигатай бус, харин шүүхийн тогтолцоог бүхэлд нь хамарсан хэд хэдэн ажил санаачлагдсан нь авлигыг бүрдүүлэгч орчинг үгүй болгоход нөлөөтэй юм. Эрүүгийн шүүхийн бодлого хэрэгжүүлэгч хорооны дарга, шүүгч Могиш, эрүүгийн хэргийг мөрдөх ажиллагааг баривчлахаас, шүүн таслах хүртэл шинэчлэхийн төлөө ажиллаж байна. Хэргийг мөрдөн шалгах ажиллагааг маш удаан хугацаагаар хойшлуулдаг, хорих тогтолцоонд шинэчлэл хийх шаардлагатай нь тогтоогдсон.

Үндэсний шүүхийн шүүгчдийн тэргүүлсэн Шүүхээр үйлчлүүлэгчдийн нийгэмлэг нь 20 муж, 7 тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд шүүхийн үйлчилгээг иргэдэд хүргэх, чанарыг сайжруулахыг зорьж байна. 2003-2004 онд Порт Моресби дахь Вайгани үндэсний шүүхийн шийдвэрлэгдээгүй хэргийн тоо 67 хувиар буурсан нь, АОХА, Хууль, Шүүхийн салбарын хөтөлбөрийн дэмжлэгтэй, Шүүхээр үйлчлүүлэгчдийн нийгэмлэгийн ажлын үр дүн юм.

ПШГ-н шүүхийн үйл ажиллагаа нь хангалттай дээд төвшинд арай хүрэхгүй байгаа нь тодорхой. Авлигад өртөөгүй, маш сайн ажиллаж байгаа шүүхийн үйл ажиллагааг яаралтай дэмжих арга хэмжээ авч баталгаажуулах нь зүйтэй. Зарим хүмүүс, эрх зүйн тогтолцоо нь, өөрийн бүтцэд гарсан ан цаваас болж эрсдэлд хүрч байгаа тухай, хэсэг зарим нь дараагийн зорилтод ажлууд нь системийг бүхэлд нь харж чадахгүй зөвхөн бүрэн бус шинэчлэлд зориулагдах тул сайн болж чадахгүй гэдэг. Хэдийгээр найдлага муутай байгаа ч, шүүхийн тогтолцоонд улс төрийн дэмжлэг маш чухал. Хэрэв сайд нар, парламентын гишүүд, төрийн албан хаагчид, хуульчид, цагдаагийн ажилтнууд өөр өөрийн эрх ашгаас өмнө, шүүх эрх мэдлийн тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулахад нэгдсэн байдлаар дэмжлэг үзүүлвэл, өөрчлөлт бодитой хэрэгжих болно.

*Папуа Шинэ Гвиней дэхь ТИ
Порт Моресби*

Румыны шүүхийн үйл ажиллагааны авлига ба дутагдал

Эрх зүйн тогтолцоо: Эх газрын эрх зүй, мэтгэлцэх зарчим, прокурор эь шүүх эрх мэдэлдээ хамаардаг

100,000 хүн тутамд ногдох шүүгчийн тоо: 18.0¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 7,861 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 25,828 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 3,830 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 651.7 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 15.6 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 4.2

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Бүрэн бие даасан

Шүүхээс гаргасан бүх шийдвэрүүд нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Consiliu Superior de Magistratura (2006) ба Institutul National de Statistica (2003)

2. Ordonanta de Urgenta. Дугаар 27. 2006 оны 3 сар 3. Мөн тэнд 4. Дэлхийн банкны хөгжлийн төвшинг тодорхойлогч (2005)

5. Хууль 379/2005

6. Мөн тэнд

Үндэсний шударга ёсны талаарх Румыны судалгаанаас¹ үзэхэд, коммунизмаас шилжин гарах явцад шударга ёсны тулгуур зарчмууд алдагдсан. Шүүх нь Дээд шүүх, прокурор бүхий 3-н шатлалт тогтолцоотой. Магистратын дээд зөвлөл нь шүүхийн албан хаагчдыг төрийн бусад албан тушаалтантай харилцахад төлөөлөх, мөн хараат бус байдлын баталгаа болдог. Уг байгууллага нь шүүхийн ажилтнуудад шударга ёсыг сахиулж, шүүхийн дотоод бүтцийг зохион байгуулдаг.

Европын Холбооны (ЕХ) шүүхийн стандарттай нийцүүлэх нь

Шилжилтийн үеэр шүүхийн шинэтгэл хийгдэхэд хэцүү буюу бараг хийгдээгүй юм. ЕХ-нд элсэн орсоноор сүүлийн жилүүдэд шүүхийн шинэтгэлийн хурд, чанар өссөн. ЕХ-ноос 2006 оны 5 сард, Румыны талаарх тайланд тэмдэглэсэнээр, шүүхийн шинэтгэлд “дэвшил” мэдэгдсэн боловч ёс зүйн асуудалд анхаарах нь зүйтэй гэжээ.² Олонх шинэчлэлүүд онолын төвшинд нарийвчлан боловсруулагдсан боловч практикт хэрэгжээгүй хэвээр байна. 2004-2005 онд шүүхийн чухал шинэчлэлүүд хийгдсэн нь шинээр төсөл санаачилж, хууль баталсан явдал байв.

1 2005 оны 12 сард Транспэрэнси Интернэшнл баталгаажуулсны дараа санаачилсан.. Дэлгэрэнгүй мэдээллийг www.transparency.org.ro – оос үзнэ үү.

2 Румыны үнэлгээний тайлан. 2006 оны 5 сар. ec.europa.eu/enlargement/key_documents/pdf/2006/monitoring_report_ro_en.pdf

Тэдгээрийн дотор Магистратын статутын, шүүхийн байгууллагын, магистратын дээд зөвлөлийн онцлогын талаарх хуулиуд багтана.

Румын дахь ТИ нь эдгээр арга хэмжээнүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж, 2005 оны 10 сараас 2006 оны 10 сар хүртэл, шүүхийн авлигатай холбоотой иргэдийн гомдолд, зөвлөгөө өгөх төвийг байгуулан ажиллуулсан. Тус төв нь иргэдийн 1,600 орчим өргөдөл, гомдлыг хүлээн авч 600 орчимд нь туслалцаа үзүүлсэн бөгөөд 40 хувь нь тус төвийн эрх хэмжээний хүрээнд ажиллах боломжтой асуудал байсан. Эдгээрээс 30 хувийг, магистратын дээд зөвлөлд, магистратууд асуудалд хариуцлага хүлээх эсэхийг тодруулахаар илгээсэн. Румыны ТИ–н шинжилгээ хийж үзээд, шинэтгэлийг хэрэгжүүлэхэд шүүхийн удирдлага, захиргааны чадвар сул, прокурорын байгууллагын дэмжлэг дутмаг байна гэсэн дүгнэлт хийжээ.

Төвийн үйл ажиллагааны эхний шатны талаарх товч дүгнэлтэнд³ шүүх, бүртгэлийн болон архивын тасгийн болон нарийн бичгийн дарга нарын ажилд шударга ёс алдагдсан, захиргааны чанар сул, үйлчилгээний хурд удаан байгааг илрүүлэн тэмдэглэсэн. Энэ нь, шинэтгэлийн нөлөө бага, шүүхтэй харилцах иргэдэд хүрэхгүй байгааг илтгэнэ.

Шийдвэр гаргахад нөлөөлөх дарамт

Өнгөрсөн 3 жилийн хууль зүйн шинэтгэл нь, 1989 оны хувьсгалаас хойш шүүмжлэлд өртөөд байгаа шүүхийн хараат бус байдалд анхаарлаа чиглүүлэхийг хичээсэн. Тухайлбал, 2005 онд хууль тогтоох байгууллага, хүний нөөцийн асуудал, үйл ажиллагааг нь зөв зохицуулахын тулд шүүхийн төсвийн удирдлагыг Хууль зүйн яамнаас Магистратын дээд зөвлөлд шилжүүлсэн бөгөөд энэ нь 2008 оноос хүчин төгөлдөр үйлчилнэ. Энэ хүртэл хугацаанд яамны мэдэлд байх болно.

Зөвлөл нь шүүгч, прокурорын дундаас сонгогдсон 9 шүүгч, 5 прокуророос бүрдэх боловч хуульд зааснаар, тэдгээрийн дээр Хууль зүйн сайд, Дээд шүүхийн Еөнхийлөгч, Ерөнхий прокурор, сенатаас сонгогдсон 2 иргэний нийгмийн төлөөлөгч багтдаг. Энэхүү бүтэц нь, шүүхийн хараат бус байдлыг хангаж, шинэтгэлийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.⁴ Румыны ТИ–ийн 2005 оны 9 сард хийсэн судалгаанаас⁵ үзэхэд, магистратуудын 78 хувь нь шүүх хараат бус гэхдээ “туйлын хараат бус” байж чадахгүй гэжээ. Шүүгчид шийдвэр гаргахдаа, мэдээллийн хэрэгсэл, парламентын гишүүд, засгийн албан тушаалтнуудын болон

3 “2006 оны 1 сараас 6 сар хүртэлх хугацааны Авилгын эсрэг хууль зүйн төв дэх хэргүүдийн мониторингын дүн” www.transparency.org.ro

4 Румыны ТИ, 2005 оны Үндэсний шударга байдлын судалгаа, www.transparency.org.ro/doc/NCR%202006%20eng.pdf

5 Румыны ТИ, 2004 оны 8 сараас 2005 оны 9 сар хүртэлх хугацаанд хамаарах ‘Шүүхийн хараат бус байдлын судалгааны талаарх ухамсар’ Румын даяарх 418 магистратын төлөөл асуулгад оролцож, алдаа 4.8 хувьтай гарсан. www.transparency.org

эдийн засгийн дарамтыг мэдэрдэг гэсэн байхад прокурорууд нь, дээд шатны прокурор буюу прокурорын даргын дарамтыг мэдэрдэгээ илэрхийлжээ.

Дээд зөвлөлд шүүхийн удирдлагыг хэрэгжүүлдэг тул аливаа асуудал энэхүү зөвлөлөөр заавал хэлэлцэгдэж, зөвшөөрөгдсөн байх болдог нь шүүхийн албан хаагчдын чадваргүй байдал, магистратын доод төвшний стандарт зэрэг бүтцийн доройтолтой хавсардаг. Шударга ёсны талаарх нэгэн зүйл нь Румын нь 2001 оноос хойш шүүхийн ёс зүйн дүрэмтэй байсан явдал бөгөөд 2005 онд шүүхийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталсан нь бүс нутагтаа анхдагчид тооцогдож байна. Харин үүнийг хянах, хэрэгжүүлэх механизмыг сайжруулах шаардлагатай бөгөөд сургалт явуулах нь зүйтэй.

Шүүхийн хариуцлага

Шүүхээр үйлчлүүлэгчид болон шүүхийн ажилтнуудын хоорондын харилцаанд гардаг ил тод бус байдал, авлигын асуудал нь системийн шинжтэй болсон байна. Авлига үйлдсэн шүүгч, прокурорт хариуцлага тооцох хууль тогтоомж хангалттай буй боловч хэрэгжилт муу. Румыны ТИ иргэдийн гомдолд шинжилгээ хийж үзээд, зарим тохиолдолд зөвлөл нь авлигатай холбоотой хэргийг шүүх, прокурорт шилжүүлэх бус, харин тухайн хэрэг шийдвэрлэгдэж дуустал хадгалдаг. Хууль хэрэглэх мэргэжлийн зөрчлөөс ч илүүтэй, ноцтой сахилгын зөрчлийн талаар мэдүүлсэн байсан ч дээрх байдал давтагдана. Хэрэв гомдол гаргагч нь үндэслэлээ сайн гаргаагүй бол, зөвлөл нь магистратын тухайн үйлдэлд хариуцлага хүлээхгүй тухай тодорхой тайлбар бүхий захидлыг явуулдаг.

Хүний эрхийн Европын конвенцийн 6.1, Үндсэн хуулийн 20.3—г шүүхээс тайлбар хийх ажил удаашралтай байна. Эдгээр нь Румыны эрх зүйн тогтолцоонд ач холбогдолтойд тооцогддоггүй боловч, хэргийг бүрэн дүүрэн, зөв шийдвэрлэхэд чухал нөхцөл болдог. Румыны ТИ—ээр үйлчлүүлэгчид олон жил өнгөрсөн ч шийдвэрлэгдэхгүй байгаа давж заалдах болон сахилгын гомдлын талаар олон жишээг өгүүлжээ. Өөр нэгэн бэрхшээл бол хуульд богино хугацаанд өөрчлөлт оруулах явдал юм. Шүүхийн ажлыг дээрх асуудал ихээхэн хүндрүүлдэг, учир нь шийдвэр гаргах үед уг шийдвэр нь шинэ хуульд нийцэхгүй байдлаар гарах болдог тул удалгүй хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нийцээгүй гэдэг үндэслэлээр дахин давж заалдах ажиллагаа явагддаг. Хууль зүйн тайлбарыг стандартчилах хэдэн оролдлогыг эс тооцвол, Румыны шүүх нь тогтворгүй хэвээр бөгөөд шүүхүүдийн хууль зүйн тайлбарууд хоорондоо зөрчилтэй, тэр ч байтугай нэг шүүхийнх ч бас дотроо зөрчилтэй байна. Эрх зүйн тогтолцооны нэгдмэл байдлыг бэхжүүлэх, шүүгчдийн шийдвэр гаргахад хараат бус байдлыг жигд хангах, шийдвэр гаргахдаа ижил нөхцөлтэй байх тухай нэгэн хууль хэлэлцэгдэж байна.

ТИ-ийн хууль зүйн зөвлөгөө, нөлөөллийн төвөөр үйлчлүүлэгчид нь, шүүхийн ажилтан, албан хаагчид тэдэнтэй уулзах, мэдээллээр хангах хүсэлтийг нь хүлээн авахаас татгалздаг тухай гомдол мэдүүлсэн. Шүүхийн бүртгэлийн болон архивын

ажилтнууд иргэдэд өөрийн материалтай танилцахыг зөвшөөрдөггүй. Румыны ТИ нь Бухарест хотод иргэн-шүүхийн харилцаанд зохих өөрчлөлтийг хийж чадсан боловч, орон нутгийн шүүхүүдэд асуудал өргөн тархсан байна гэж мэдэгдэжээ. Иргэд Үндсэн хуульд заасан эрхээ (Жишээ нь: Мэдээлэл авах, хэргийн процессын ажиллагаа шударга байх, тогтоосон хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх) үл ойшоодогоос энэхүү муу нөхцөл нь улам даймжирч байна.

Ашиг сонирхлын зөрчил

Магистратуудыг тухайн хэрэгт өөрийнх нь төрөл садан (өөрийнх нь 4 үеийн дотор) оролцогч байвал уг хэргийг шийдвэрлэхэд оролцохыг хориглох зэргээр илүү хатуу ашиг сонирхлын зөрчлийг хянах нөхцөлүүдийг 2003 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Төвөөр үйлчлүүлэгчид ашиг сонирхлын зөрчил бүхий эрүүгийн хэргийн актын олон жишээ хэлсэн. Жишээлбэл, төрөл садны холбоотой эсвэл өөр байдлаар холбоотой хүмүүс, хэргийн шийдвэрт хууль бусаар нөлөөлж, магистратуудыг тэдэнд зориулсан шийдвэр гаргахад хүргэдэг. Төвд ирүүлсэн 60 орчим хэргүүдээс 190-ийг нь хууль зүйн дагуу зайлшгүй шалгуулах үндэслэлтэй байсан. Хамгийн их давтагдсан нь “нотлох баримтыг харгалзаж үзээгүй”, “хэрэг мөрдөх ажиллагааны процедур зөрчсөн” гэх 2 үндэслэл байх бөгөөд олон үйлчлүүлэгчид эдгээр үйлдлийг ашиг сонирхлын зөрчлөөс үүдсэн хэмээнэ.

Ашиг сонирхлын зөрчил болон бусад алдаанууд нь ихэнх тохиолдолд, ажилдаа үл тэнцэх олон тооны магистрат, прокуророос үүдэлтэй. 2006 оны 6 сард Магистратын дээд зөвлөлийн тооцоолон гаргаснаар, шүүхийн тогтолцоонд 7,253 магистрат байх ёстой. Гэвч үүнээс, шүүгчийн албан тушаалын 89 хувь, прокурорын албан тушаалын 78 хувь нь эзэнтэй байна. Харин 22,408,393 хэрэг шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байна.

Шүүгчид сахилгын хариуцлага ногдуулах процедур

Магистратын шударга ёсыг төлөвшүүлэх систем нь, авлигатай тэмцэхэд бас нэгэн асуудал мөн. Сахилгын хариуцлага тооцох эрх мэдэл Хууль зүйн яам, Магистратын Дээд зөвлөлийн хамтарсан үйл ажиллагааны дүнд хэрэгждэг байсан бол 2004 онд уг эрх мэдэл нь Дээд зөвлөлд албан ёсоор шилжсэн. Хэдийгээр сахилгын хариуцлагыг өндөржүүлж, шударга ёсыг хангах шаардлагатай байгаа ч, хянах, хэрэгжүүлэх чадамжийг мөн дээшлүүлэх нь зүйтэй.

Зөвлөл нь 2 хорооноос бүрдэх бөгөөд нэг нь шүүгчийн, нөгөө нь прокурорын үйлдсэн хэрэг, зөрчлийг шалгах үүрэгтэй. Шүүх нь нийгмийн итгэлийг хүлээсэн тохиолдолд, зөвлөл нь магистратын шударга ёсыг хангах үйл ажиллагааг саадгүй явуулах ёстой. Тус улс нь Европын Хүний эрхийн шүүхэд давж заалдан ялагдсаны дараа, магистратуудаас иргэнд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хэм хэмжээ хэрэгжиж эхэлсэн. Нилээдгүй тохиолдолд тэдэнд ногдуулах шийтгэлийг хөнгөрүүлдэг юм. Учир нь, нөхөн төлөх зардал нь Сангийн яамнаас гарах бөгөөд,

энэ нь татвар төлөгчдийн мөнгийг үргүй зарцуулах алдагдал болно. Ийнхүү төсвөөс төлөгдөх нөхөн төлбөрийн байдлыг харгалзан магистратуудад ногдуулбал зохих шийтгэлийг хүлээлгэж чадахгүй байгаа нь тэднийг эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх Зөвлөлийн чадварыг сулруулж байгаа юм.

Магистратын хууль⁶ нь, магистратын шударга бус, алдаатай шийдвэрийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, сахилгын хариуцлага тооцох талаарх харилцааг зохицуулна. Магистратууд санхүүгийн хариуцлага хүлээдэг байлгахын тулд тус хуульд магистратууд нь алдаатай шийдвэр гаргах аваас, түүнээс үүдэн гарах хохирлыг нөхөн төлөх тухай өнгөц зохицуулалтыг оруулсан. Үүний адилаар, хуучин эрүүгийн байцаан шийтгэх хуулинд, Сангийн яам нь, магистратын төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байсан. 2006 оны 6 сард Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гаргасан алдааны төлөө магистратын эсрэг заавал сахилгын хэрэг үүсгэн шалгах тухай заалт нэмэгдсэн.⁷ Энэ нь магистратуудын шийдвэр гаргах хариуцлагыг өндөржүүлэх, шүүхийн тогтолцоонд бүхэлд нь шударга ёсыг сахиулахад нааштай хандлага болсон.

Румыныг ЕХ-нд элсүүлэх судалгааны ажлын хүрээнд, ЕХ-ны шүүхийн стандартад нийцүүлэн хууль тогтоох үйл ажиллагааны загварыг боловсруулах, шүүхийн болон бусад хууль тогтоомжийг шуурхай хянан үзэх шаардлагатай. 2004 онд Румын нь, ЕХ-ний гишүүн элсүүлэх протоколын, Шүүх болон Дотоод хэргийн бүлэгт заасан шаардлагыг гүйцэлдүүлэхийн тулд ажиллаж байх үед шүүхийн шинэчлэлийн явц хурдассан. Гэхдээ ЕХ-ны мониторингын дүн, шүүхийн салбарын хүндрэлтэй асуудлуудыг тусгасан, илүү нарийвчилсан, байнгын шинжтэй шинэтгэл чухал гэдгийг харуулсан.

Хууль зүйн яамнаас авсан олон арга хэмжээний дараа, ЕХ-ны техникийн зөвлөл, авлига буурах хандлагатай болсныг тэмдэглэсэн. Дараагийн хийгдэх ёстой ажил нь тэдгээр арга хэмжээнүүдийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх явдал юм. Румын ЕХ-нд элсэн орвол, авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх, нийтийн дунд шударга ёсыг бэхжүүлэх шаардлагыг засгийн газарт хүргэнэ.

*Виктор Алистар
(Румын дахь ТИ, Бухарест хот)*

6 Эрх зүй. дугаар. 303/2004.

7 Эрх зүй. дугаар. 356/2004.

Зүй бус үйлдлүүд Өмнөд Африкийн шүүхийг сүйтгэн сүйрүүлж байна

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, мэтгэлцэх зарчим, прокурор нь шүүх эрх мэдэлдээ хамаардаг

100,000 хүн тутамд ногдох шүүгчийн тоо: 1.1¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 38,454 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 89,134 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 4,960 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 881.7 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 66.3 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 1.3

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Бүрэн бие даасан

Шүүхээс гаргасан бүх шийдвэрүүд нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Үгүй

- | | |
|------------------------|---|
| 1. Дэлхийн банк (2000) | 2. Линда Ван Дэр Вижвэр, Өмнөд Африкийн шүүх байгууллага. Шүүхийн түгээмэл эрх зүйн харьцуулсан судалгаа (Кэйп хот, Сайбер Инк, 2006) |
| 3. Мөн тэнд | 4. Дэлхийн банкны хөгжлийн түвшинг тодорхойлогч (2005) |
| 5. Төсвийн тойм | 6. Мөн тэнд. |

Өмнөд Африк нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд шинэ Үндсэн хуулийн шаардлагад нийцүүлэн, төрийн байгууллагуудаа өөрчлөх зорилго тавин ажилласан. Энэ нь шүүхүүд, шүүхийн захиргаа болон ШҮХГ (Хууль зүйн яам болон Үндсэн хуулийн хөгжлийн газар)—т хариуцлагатай, шударга, хараат бус байдлын онолын үзэл баримтлалыг хэрэгжүүлж, өргөн хүрээтэй бүтцийн өөрчлөлт хийнэ гэсэн үг юм. Эдгээр элементүүд нь, Үндсэн хуулийн эрх мэдэл хуваарилах зарчмын нэгээхэн хэсэг болно.

Өмнөд Африкийн шүүхийн тогтолцоо нь, Үндсэн хуулийн шүүх, Давж заалдах дээд шүүх, дээд шатны шүүх, бүс нутгийн болон дүүргийн магистратын шүүхээс бүрдэнэ. Үндсэн хуулинд шүүх хараат бус байх тухай заахдаа “нөлөөнд үл автан, аливаа дарамтгүйгээр, гагцхүү Үндсэн хууль болон бусад хуулинд захирагдан шударгаар үйл ажиллагаа явуулах ёстой”¹ гэжээ. 165—р зүйлд зааснаар, “төрийн байгууллага, албан тушаалтан шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож болохгүй, төрийн байгууллага шүүхийг хамгаалж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх ёстой, шүүхийн шийдвэрийг бүх хүн түүнчлэн төрийн байгууллага заавал биелүүлэх ёстой”, 173-р зүйлд Дээд шүүх нь өөрийн үйл ажиллагааны журмыг тогтоох, хамгаалах онцгой эрхтэй гэж заажээ.

1 VIII бүлэг, 165—р зүйл.

Шинэтгэлийн хүрээнд хууль тогтоох болон захиргааны зарим арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Шүүхийн томилгоо, ажиллах нөхцөл, баталгаа, шагнал урамшил, болон шүүхийн албаны зөвлөлийг байгуулах талаар олон эрх зүйн актууд батлагдан гарсан. Эдгээр нь, шүүхийн чиг үүргийг сайжруулж, хараат бус байдалд нь тус болсон. Гэвч зарим ажиглагчид, шинэчлэл удаан бөгөөд алаг цоог, хэсэгчилсэн байдлаар хийгдэж байна гэж шүүмжилсэн. Нээлттэй нийгэм байгууллагын шүүхийн салбарт хийсэн дүгнэлтэд дурдснаар ШҮХГ энэхүү процесс удаан байгаа шалтгааныг тайлбарлахдаа, цаашид шаардлагатай чухал өөрчлөлтүүдийг хийхээс өмнө, харилцан ойлголцож, зөвшилцөх нь чухал гэж үзжээ.²

Өөр нэг төсөл бол НҮБ-ын мансууруулах бодис, эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын санаачилсан шүүхийн чадварыг дээшлүүлэх, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Шүүхийн шударга байдлын төсөл юм. Төслийн хүрээнд шүүхийн байгууллагад зориулсан Үндэсний Авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. Уг төлөвлөгөө нь 2006 оны эхээр эхлэх ёстой байсан боловч хугацаа давчуугаас хойшлогдсон.³

Эдгээр арга хэмжээнүүд нь бүхэлдээ, эрх мэдлийг хуваарилах зарчмыг хамгаалах, дэмжихэд чиглэсэн. Ерөнхий шүүгч асан Артур Часкалсон, “өнгөрсөн 10 жилийн ардчилсан тогтолцоонд засгийн газар шүүхийн хараат бус байдлыг дордуулах эсхүл түүнд сөргөөр нөлөөлөх ямар ч алхам хийгээгүй”⁴ хэмээн мэдэгдэв. Иймэрхүү эерэг хандлагуудын хажуугаар, шүүхийн зохисгүй үйл ажиллагаа, хараат бус байдал алдагдсан, хариуцлага сул зэргийг парламентад шүүн хэлэлцэж, олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.

Шүүхийн авлига ядууст хамгийн их хохирол учруулдаг

Шүүхийн Шударга байдал төслийн бүрэлдэхүүний нэг хэсэг бол хуулийн байгууллагын ажилтнуудын талаарх судалгаа юм. Доод шатны шүүхийн судалгаанаас үзэхэд, 400 хүн шүүхээр үйлчлүүлсэн бөгөөд тэдгээрийн 52 хувь нь шүүхэд итгэх итгэлийг алдагдуулах үндсэн шалтгаан бол авлига хэмээгээд, 7 хувь нь прокурорт, 11 хувь нь шүүхийн албан хаагчид хэргийг шуурхай шийдвэрлүүлэхийн тулд хээл хахууль өгсөн гэдгээ тэмдэглэн хэлсэн. Уг судалгаа нь, шүүхийн үйл ажиллагааг сулруулагч гол хүчин зүйлүүд болох, санхүүгийн нөөц, чадамж болон менежмент, ажиллах сонирхол сул байгаа зэргийг илрүүлсэн.⁵

2 Өмнөд Африкийн Шүүхийн салбар ба Хууль дээдлэх ёс , Эргэцүүлэл (2005), Өмнөд Африкийн АфриМАП ба Нээлттэй Нийгэм Хүрээлэн. www.soros.org/resources/articles_publications/publications/sajustice_20060223/afri-map-report_20060223.pdf; ШҮХГ жилийн тайлан, 2003-2004 , www.doj.gov.za/

3 Сандэй Таймс (Өмнөд Африк), 2006.5.21

4 Бизнесийн өдөр (Өмнөд Африк), 2006.5.11

5 Сандэй Таймс (Өмнөд Африк), 2006.5.21

Магистратуудын 70 орчим хувь нь ажлын нөхцөлд сэтгэл хангалуун бус байгаа нь судалгаагаар тогтоогджээ.

Засгийн газар болон магистратуудын хоорондох унааны тоог олшруулах зөвшөөрлийн талаарх зөрчил нь дээрх байдлын нэгэн илрэл юм. 2006 оны эхээр Ерөнхийлөгчөөс магистратуудын унааны тоог олшруулахаар шийдвэр гаргасан боловч санхүүгийн хороо холбогдох зардлыг гаргах боломжгүй хэмээснээс, магистратуудыг ажил хаяхад хүргэсэн. Тэд одоогоор мэргэжлийн нэр хүндийг унагаасан хэрэгт шалгагдаж байна.⁶ Хүнд болон шийдвэрлэгдээгүй хэргийн ачаалал шүүхийн албан хаагчид мөн иргэдийг ч бухимдахад хүргэж байна. 2006 оны 3 сард Шүүхийн бичиг хэргийн хорооны товч тэмдэглэлд дүүргийн шүүхэд 157,932, бүс нутгийн шүүхүүдэд 47,112 хэрэг шийдвэрлэгдээгүй байгаа тухай тэмдэглэжээ.⁷

Санхүүгийн удирдлага, зохион байгуулалт дулимаг байгаа нь авлигатай тууштай тэмцэхэд бэрхшээл учруулдаг. Шүүхийн бичиг хэргийн хорооны дарга, шүүгч Дэ Ланж (2004 оны сонгуулийн дараа Хууль зүйн яамны орлогч сайдаар томилогдсон) “ШҮХГ нь 1959 оноос хойш бичиг баримтаа бүрэн хэмжээгээр эмхтгэж, цэгцлээгүй... 518 шүүхийн албаны дөнгөж 30 нь компьютержсэн бөгөөд олон ажил хэргүүд гүйцэд бүртгэгдээгүй”⁸ гэж мэдэгдсэн.

Үүний хариуд ШҮХГ–аас, Ерөнхий аудиторыг, магистрат болон мастерын байгууллагад томилон ажиллуулахаар хүсэлт гаргасны дагуу 2001-2002 онд дээрх байгууллагуудад аудит хийсэн бөгөөд энэ нь Өмнөд Африкийн түүхэн дэхь томоохон аудитын шалгалтын нэг байлаа. ШҮХГ-н санхүүгийн байцаагч Алан Маккензи: “Авлигын хамгийн гол эмгэнэл бол хүмүүс шүүхэд мөнгө өгч шийдвэр гаргуулан, хүн амын ядуу хэсэг хохирогч болох явдал юм”⁹ гэжээ. Аудитаар зарим байгууллагад эд хөрөнгө, барьцааны болон урьдчилгааны мөнгийг ашиглан шамшигдуулсан зэрэг ихээхэн хэмжээний хууль бус үйлдийг илрүүлсэн талаар Хууль зүйн сайд парламентын асуулгын хариуд хүргүүлсэн мэдээлэлдээ дурджээ. Аудитын үр дүнд, 2,000 гаруй сахилгын, 162 эрүүгийн хэргийг үүсгэн шалгаж байна.

Түүнээс хойш ШҮХГ нь, залилангийн хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдлийн санг бүрдүүлэх зэрэг санхүүгийн нөөцийг зохицуулах, мэдээлэх шаардлагыг тусгасан 1999 оны Нийтийн санхүүгийн менежментийн актыг хэрэгжүүлж эхэлсэн. Хэдийгээр санхүүгийн удирдлага сайжирсан ч, Ерөнхий аудиторын сүүлийн 2

6 Стар (Өмнөд Африк) 2006.6.19

7 Парламентын Мониторингийн хэсэг, “Шүүх, үндсэн хуулийн хөгжлийн газрын Бичиг хэргийн хорооны тэмдэглэл: Шүүх ба Үндсэн хуулийн хөгжлийн газрын тухай товч өгүүлэх нь”, 2006.2.1

8 Транспэрэнси Интернэшнл, “2005 оны Үндэсний шударга байдлын талаарх тайлан” www.transparency.org/policy_research/nis/regional/africa_middle_east

9 Бизнесийн өдөр (Өмнөд Африк), 2003.7.21

жил гаруй хугацаанд хийсэн аудитын үйл ажиллагааны үр дүнд мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих чанар алдагдсан зэрэг санхүү, захиргааны хяналтын ноцтой зөрчлүүдийг илрүүлсэн. Ерөнхий аудитор нь 134 сая (19.4 сая ам.доллар)-ын тайлан тэнцлийн зөрүү, 44 сая (6.4 сая ам.доллар)-ын дутагдал, 108 шүүхийн тайлан тэнцлийн зөрүү, 41 шүүхийн санхүүгийн бичиг баримт дутуу буюу байхгүй, 120 шүүх банкны дансгүй байгааг тус тус илрүүлсэн байна.¹⁰

Төрийн бусад албан тушаалтнуудтай харьцуулахад, шүүгчид жил бүр хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргаж өгөх шаардлага тавигддаггүй байсан нь тухайн харилцаанд ашиг сонирхлын зөрчил үүсэх бололцоог бий болгодог. Хэдийгээр шүүхийн түшмэдүүд шударга, хараат бус гэж тооцогдож, иргэдийн 62 хувь нь “ихэнхи” буюу “бүх” шүүхийн ажилтнууд итгэл хүлээж чадахуйц хэмээн үнэлж байгаа ч, ил тод байлгах механизмгүйгээр олон нийтийн итгэл алдагдах нь хялбар байх болно.¹¹ Саяхан Баруун Кэйпийн Ерөнхий шүүгч Жон Глоф, 2002 оны 4 сараас 2003 оны 3 сар хүртэл сар бүр 10,000-ыг хувийн нэгэн компаниас хүлээн авч байсан тухай хэрэгт буруутгагдсан. Түүний асуудлыг шалгаж дуустал албан тушаалаас нь түдгэлзүүлээд байгаа билээ.¹² Дараагийн нэг тохиолдол нь газрын хэргийн шүүхийн шүүгч Фикайл Бам өөрийн албан тушаалаа хувийн бизнест ашигласан талаарх мэдээлэл юм.¹³

Одоогоор шүүгчдэд нэр төрөө хамгаалахын тулд гадаад ашиг сонирхлоос ангид байлгах албан ёсны бус ёс зүйн дүрэм хэрэгждэг. Шүүгчид нь сайдын зөвшөөрөлгүйгээр гадны байгуулагаас ямар нэг шагнал, урамшил авахыг хориглох бөгөөд онцгой тохиолдолд ихэнхдээ зөвхөн тэтгэвэрт гарахыг нь тохиолдуулан зөвшөөрдөг. Мөн шүүгчид нь prima facie буюу тухайн асуудалд аль нэг талыг дэмжиж буй нь илэрхий болсон, ямарч тайлбар шаардаагүй нөхцөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас шүүгчид өөрсдөө татгалзан гарч байх практик үйлчилдэг. Саяхан Дэд ерөнхийлөгч асан Жакоб Зумагийн холбогдсон хүчингийн хэргийг таслан шийдвэрлэх шүүх хуралдааны үеэр 2 шүүгч хэргийг шийдвэрлэхээс өөрсдөө татгалзсан. Шүүгч Нгоэпэ Зумаг баримчлах зөвшөөрлийг өгсөн,¹⁴ харин шүүгч Шонгвигийн үеэлийн хүүхдийг Зума загалмайджээ.¹⁵

10 Ерөнхий Аудиторийн 2005-2006 онд ШҮХГ-т хийсэн аудитийн тайлан. www.doj.gov.za

11 Афробарометр, Ажлын бичиг баримтууд 61 (Зүүн Лансинг: Мичиганы Их сургууль, 2006). 18 оронд явуулсан судалгаанаас үзэхэд Өмнөд Африкийн шүүхийн түшмэдүүдийн нэр хүнд бүс нуггийн дунджаас харьцангуй өндөр байсан. www.af-robarometer.org

12 Бизнесийн өдөр (Өмнөд Африк), 2006.4.19

13 Сандэй Таймс (Өмнөд Африк), 2006.5.21

14 Мэйл ба Гардиан (Өмнөд Африк), 2006.3.21

15 Кэйп Таймс (Өмнөд Африк), 2006.2.15

Эрх мэдэл хуваарилах болон хариуцлагатай байх зарчмуудыг маш нарийн зурвас тусгаарлаж байна

Шүүхийн үйл ажиллагааг дордуулж буй нэгэн зүйл бол илт сул хариуцлагын тогтолцоо юм. Засгийн газраас ёс зүйн дүрэм, гомдол гаргах болон сахилгын хариуцлагын шинэ механизм, санхүүгийн орлогоо бүртгүүлэх шаардлагын талаарх харилцааг зохицуулсан хуулийн¹⁶ төслийг санаачилсан. Шүүхийн албаны зөвлөл (ШАЗ)¹⁷ эдгээр чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ. Уг хуулийг дэмжигчид, Үндсэн хуулиар шүүхэд ард олноос сонгогдсон төлөөлөгчдийн шийдвэрийг хүчингүй болгох бүрэн эрх олгосон байдаг тул илүү өндөр хариуцлагатай байх ёстой хэмээжээ. Шүүгчийн ёс зүйн дүрмийн нарийвчилсан стандарт, авлигыг зогсоох сахилгын процедурыг боловсруулснаар шүүх болон шүүгчдийн нэр хүнд олон нийтийн дунд өсөх болно. Гэвч хэсэг зүйл заалтууд нь эрх мэдэл хуваарилах зарчим болон шүүхийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлж, хуулийн хэрэгжилтэнд саад болно гэж нөгөө хэсэг нь үзжээ. Сахилгын хариуцлага нь, улс төрчид, эсвэл ялагдсан талын зүгээс шүүхийн шийдвэрт нөлөөлөх боломжийг олгоно гэж хуулийн төслийг шүүмжлэгчид нотолж байна.¹⁸

Дараагийн нэгэн асуудал бол шүүхийн томилгоо, хараат бус байдлын тухай юм. Үндсэн хуулинд тусгайлан зааснаар, ШАЗ–ны санал болгосноор Ерөнхийлөгч бүх шатны шүүгчийг томилох хэдий ч, албан тушаалаасаа шалтгаалан журам нь өөр байна. Жишээ нь, Ерөнхийлөгч, Дээд шүүх, давж заалдах дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон орлогчийг, ШАЗ–ны болон Үндэсний чуулганд суудалтай намын дарга нарын санал болгосноор тус тус томилно. ШАЗ нь дээд шатны шүүхийн сул орон тоонд өрсөлдүүлэхээр ярилцлага хийж, Ерөнхийлөгчид нэр дэвшүүлнэ. Хэрэв Ерөнхийлөгч татгалзвал ШАЗ нэр дэвшүүлэх ажиллагааг дахин эхэлнэ. 11 шүүгчээс бүрдэх Үндсэн хуулийн шүүхийн орон тоонд томилогдох магадлал бүхий 4 хүнийг ШАЗ Ерөнхийлөгчид санал болгоно, тэрээр улс төрийн намуудын дарга нарын зөвшилцсөнөөр шийдвэрлэнэ. Бусад шүүгчид парламентийн баталсан тусгай актад заасан журмын дагуу томилогдно. Жишээ нь, Магистратын хуулийн дагуу байгуулагдсан магистратын хороо нь сул орон тоонд авах, шилжүүлэх, дэвшүүлэх, ёс зүйн болон албан тушаалаас огцоруулахтай холбоотой асуудлыг хариуцна.¹⁹

16 Энэхүү багц нь, Шүүхийн үйлчилгээний нэмэлт хууль, Шүүгчийн ёс зүйн асуудлыг шийдвэрлэх хууль, Дээд шүүхийн хууль, Шүүгчдийг бэлтгэх Үндэсний коллежийн хуулиадаас бүрдэнэ.

17 Уг байгууллага нь 1994 оны Үндсэн хуулийн болон Шүүхийн албаны зөвлөлийн актад заасны дагуу байгуулагдсан бөгөөд шүүх, түүний захиргаатай холбоотой асуудалд засгийн газарт зөвлөгөө өгөх үүрэгтэй.

18 Шамила Сидат ба Жонатан Фаул, Шүүхийн шинэчлэлийн талаар хэлэлцэх нь: Илтгэл ба Үндсэн санаа (Кэйп Таун: Идаса, 2005)

19 Жишээ нь, магистратууд нь 1993 оны Магистратын акт, журмын дагуу томилогдно. 1944 оны Магистратын шүүхийн актыг үзнэ үү.

ШАЗ болон магистратын хорооны бүрэлдэхүүн нь дараагийн хэлэлцэх сэдэв юм. Кэйп Таун их сургуулийн, Өмнөд Африкийн шүүхийн байгууллагын талаар хийсэн судалгаанаас үзэхэд,²⁰ 23-25 гишүүдээс бүрдэх ШАЗ ны 11 гишүүн нь улс төрчид байгаа нь санаа зовох асуудлын нэг болж байна. Магистратын хорооны хараат бус байдалд мөн зарим асуудал бий. Ван Рүүний²¹ хэрэг шүүх дээр маргаан дэгдээсэн бөгөөд нарийвчлан хэлэлцсэний дараа, магистратын хороо нь бүрэн хараат бус (гэхдээ бүрэлдэхүүний хувьд) хэмээн тогтоосон.²²

Өмнөд Африкийн шүүхүүд нь хүний эрх, сайн засаглалыг тодорхойлоход нэлээд үүрэг гүйцэтгэж байгаа нь хүлээн зөвшөөрөгдсөн. Гэвч үүнээс гадна, хараат бус байдлыг хангах, авлигатай тэмцэх, шүүхийн шударга байдлыг дэмжих, боловсронгуй болгох нь нэн тэргүүний хэлэлцэгдэх асуудал мөн. Шүүхийн салбарт шинэчлэл хийх эрх хэмжээ бүхий этгээдүүдийг шаардлагатай мэдээллээр хангах, мэдээллийн бодитой, хангалттай байдлыг нэмэгдүүлэх нь нэн чухал. ШҮХГ нь мэдээллийн удирдлагыг сайжруулахын тулд Шударга шүүх төсөл, Электрон-Шүүх хөтөлбөрийг эхлүүлсэн боловч, үр дүнтэй хяналт, шаардлагатай мэдээлэл дутагдалтай байгаа нь шүүхийг бэхжүүлэх, хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэхэд саад учруулж байна.

Жүдит Фебруари
(Өмнөд Африкийн Ардчилалын хүрээлэн
Кэйд Таун)

-
- 20 Линда Ван Дэр Вижвэр, Өмнөд Африкийн шүүх байгууллага. Шүүхийн түгээмэл эрх зүйн харьцуулсан судалгаа/Кэйп хот, Сайбер Инк, 2006/
- 21 Дэлгэрэнгүй мэдээллийг Ван Рүүнийхэн Төрийн тэмцэл , Өмнөд Африкийн Барын Ерөнхий зөвлөлийн оролцоо, 2002 он (5) SA 246 (CC), www.supremecourtofappeal.gov.za/judgments/sca_judg/sca_2004/64002.pdf
- 23 South Africa Justice Sector Өмнөд Африкийн Шүүхийн салбар (2005)

Шри Ланкийн шүүх дэх авлига

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, мэтгэлцэх болон олон талт зарчим (исламын эрх зүйн элементүүдтэй)

100,000 хүн тутамд ногдох шүүгчийн тоо: 1,4¹

Шүүгчийн цалингий эхлэх хэмжээ: 4,038 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 7,644 ам.доллар³

Нэг хүнд ногдох ҮНБ: 1,160 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 21.0 сая ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 8.2 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 2.6

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм

Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэрүүд нийтэд ил тод байдаг: Тийм

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Үгүй

1. Зохиогчийн тооцсоноор

2. Шүүхийн түшмэдүүдээс авсан мэдээлэл

3. Албан ёсны үзүүлэлт

4. Дэлхийн банкны хөгжлийн төвшинг тодорхойлогч (2005)

5. 2005-2006 оны төсөв

6. Мөн тэнд

Шри Ланкад шүүхийн хараат бус, бие даасан байдалд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс нөлөөлөхөөс хамгаалах эрх зүйн хэм хэмжээ хангалттай буй. Гэвч практикаас ажиглахад мэргэжилтэн, эрдэмтэдийн дэмжлэггүйгээр мөн олон нийт хүлээн зөвшөөрөхгүйгээр, Үндсэн хуулийн зүйл, заалтууд дангаараа шүүхийн хараат бус байдлыг хангаж үл чадна. Шри Ланкийн шүүх нөлөөнд автсаны нэгэн үр дагавар бол авлига мөн. 1999 онд үндэсний болон олон улсын шүүхийн байгууллагуудын эсэргүүцлийг үл хэрэгсэн Сарат Дэ Силвиаг Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээр томилсоны дараа байдал бүр дордсон бөгөөд түүнийг 2 ч парламент эрх мэдлээ урвуулан ашигласан, авлига үйлдсэн хэрэгт буруутгаж, импичментын журмаар огцруулахыг оролдсон.

Шүүхийн бүтэц, тогтолцоо

Дээд шүүх нь тус улсын хамгийн дээд шатны шүүх бөгөөд 6-10 шүүгчээс бүрдэх бөгөөд түүнийг Ерөнхий шүүгч тэргүүлнэ. Дээд шүүх нь ихэвчлэн, Үндсэн хууль болон суурь эрх зөрчсөнтэй холбоотой мөн давж заалдсан хэргүүдийг хянан хэлэлцдэг. Дээд шүүхийн доор давж заалдах, мужийн дээд шатны шүүх, дүүргийн шүүх, магистратын болон анхан шатны шүүхүүд байна. Дээд шүүх нь бүх шатны шүүхийн хэргийг хяналтын журмаар хэлэлцэх эрхтэй. Дээд шүүхийн шүүгч 65, давж заалдах шатны шүүгчид 63, дээд шатны шүүгчид 61 насандаа тус тус тэтгэвэрт гарна. Цалин хөлс тодорхой хугацаанд үе шаттайгаар нэмэгдсээр байгаа бөгөөд хувийн салбарын хуульчидтай харьцуулахад цалин, хөлс доогуур

ч гэсэн, хүрэлцээтэй гэж үздэг. Зөвхөн, зохистой буюу чадварлагаар үүргээ гүйцэтгэж чадахгүйг нь, парламентаас нотолсны дараа л, Ерөнхийлөгчийн тушаалаар албан тушаалаас нь чөлөөлж болно. Доод шатны шүүгчид нь бусад төрийн байгууллагын албан хаагчдын адилаар 55 насандаа, жилийн нэмэгдэл хугацааг тооцвол 60 насандаа тэтгэврээ тогтоолгоно.

2001 он хүртэл Ерөнхийлөгч нь Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, дээд шатны шүүхийн шүүгчид, шүүхийн албаны зөвлөлийг тус тус томилдог байсан. Энэхүү зөвлөл нь Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, дээд шүүхийн 2 шүүгчээс бүрдэх бөгөөд доод шатны шүүхүүдийн шүүгчийн албан тушаалд томилох, дэвшүүлэх, огцруулах асуудлыг шийдвэрлэнэ. 2001 онд шүүхийн чухал албан тушаалтныг томилоход улс төрийн нөлөө оруулахгүй байлгах зорилгоор, Үндсэн хуулийн нэмэлтийг хэлэлцсэн. Уг нэмэлтийн дагуу Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлсэн дээд шатны шүүгчдийг танилцуулах, батлах Үндсэн хуулийн зөвлөл байгуулагдсан. Шүүхийн албаны зөвлөлийн гишүүдийг томилох журам мөн өөрчлөгдөж, тэднийг томилохоос өмнө Үндсэн хуулийн зөвлөл батлах шаардлагатай болсон. Энэхүү өөрчлөлт нь улс төрийн зүгээс дэмжлэг үгүйгээс шалтгаалан, санасан үр дүнд хүргээгүй.

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч шударга байж чадах эсэх нь 2001 оноос хойш маргаантай асуудал болсон

1999 онд Ерөнхийлөгч асан Чандрика Кумаратунга Ерөнхий прокурор Сарат Дэ Силвиаг Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээр томилсон. Энэ нь ер бусын томилгоо болсон юм. Тогтсон заншлаар бол хамгийн ахмад, туршлагатайг нь томилно. Тухайн тохиолдолд шүүгч М.Д.Х Фернандо энэ шаардлагыг хангаж байсан бөгөөд олон улсын төвшинд нэр хүндтэй байсан. Гэтэл тэрээр хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн албан тушаалтнуудын эсрэг шийдвэр гаргаж байсан нь Ерөнхийлөгч Кумаратунгагын сэтгэлийг гонсойлгож байв.

Түүнийг томилох үед Дэ Силвиагийн нэр хүнд ихээхэн асуудалтай байсан. Түүний прокуророор ажиллаж байх үедээ албан тушаалаа урвуулан ашигласан, ёс зүйн зөрчил гаргасантай холбоотой 2 хэрэг Дээд шүүхийн өмнө шийдвэрээ хүлээж байлаа. Нэг нь, Синхалагын 7 хоног тутмын хэвлэлийн эрхлэгч Виктор Иваны өргөдлөөр үүссэн хэрэг юм. Тэрээр, Дэ Силвиаг өөрийн хамаатан болох магистрат Ленин Ратнаякийн хүчингийн болон хөрөнгө ашиглан шамшигдуулсан хэргийг баримт бичгийг нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх замаар хаацайлан, шийдвэрлээгүй хэмээн буруутгасан.¹ Шинжээчид, түүний дотор НҮБ-ын Хуульч, шүүгчдийн хараат бус байдлын Мэдээлэгч, түүний томилгоонд сэтгэл зовниж буйгаа илэрхийлсэн бөгөөд Дэ Силвиагийн хэргийг шийдвэрлэж дуустал томилох ажиллагааг түдгэлзүүлэхийг зөвлөсөн. Гэвч Кумаратунга зөвлөгөөг хүлээж аваагүй.

1 Олон улсын хуульчдийн хороо. www.icj.org/news.php3?id_article_2591&lang_en

Тэрхүү томилгоог зогсоох олон арга хэмжээнүүд авагдсан. 2001, 2003 онуудад парламент 2 ч удаа албаны эрх мэдлээ урвуулан ашигласан, улс төрийн ашиг сонирхолд нийцүүлэн хэргийн материалыг засаж өөрчилсөн, авлигад холбогдсон, харьяалагдах шүүгч, албан тушаалтнуудыг хаацайлсан хэргээр шинэ Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг импичментын журмаар огцруулах санал оруулсан. Гэвч 2 тохиолдолд, хоёуланд нь, Кумаратунга парламентын санал шалгагдахаас өмнө парламентыг өөрийг нь тараасан. Шүүх эрх мэдлийг тэргүүлэгчийн зохисгүй үйлдэл нь олон нийтийн дургүйцлийг төрүүлж, шүүх эрх мэдэлд итгэх итгэлийг алдагдуулжээ.

Дээд албан тушаалын шүүгчдийн томилгоонд шинэ журмыг зөрчсөн олон тохиолдлыг илрүүлсэн. 1999 оны нэмэлт ёсоор, Дээд болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг томилуулахаар Ерөнхийлөгчид санал болгохдоо, Үндсэн хуулийн зөвлөлөөр батлуулах ёстой. Уг байгууллага нь парламентаас томилогдсон 6 гишүүдээс бүрдэх бөгөөд 4 нь ex officio (орон тооны бус) гишүүд байна. 2005 оны 11 сараас хойш, Кумаратунгагийн залгамжлагчаас шалтгаалан уг байгууллагын үйл ажиллагаа зогссон. Ерөнхийлөгч Махинда Ражапакс зөвлөлийг улс төрийн жижиг намууд сүүлийн нэг гишүүний орон тоонд нэр дэвшигчээ санал болгоогүй байна гэдэг үндэслэлээр удааж байсан. 2006 оны 6 сард Дээд шүүх санал болгож, зөвлөл баталснаар, Ерөнхийлөгч Дээд шүүхийн нэг шүүгч, Давж заалдах шатны 2 шүүгчийг тус тус шинээр томилсон.

Хэрэг хуваарилах нэрийдлээр туршлагатай шүүгчдээс зайлсхийж байна

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч дээд шүүхийн шүүгчдэд хэргийг хуваарилж ямар хэргийг хэн гэдэг шүүгч шийдвэрлэхийг мэддэг. Дээд шүүх нь хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох бөгөөд тус шүүхийн дунд суудлын шийдвэрийг хэлэлцэх их суудлын бүрэлдэхүүнд орох шүүгчдийг томилно.

Их суудлын шүүгчдийг туршлагыг нь харгалзан томилох ёстой хэмээн үзсэн өмгөөлөгч Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэлдэхүүн томилсон шийдвэрт давж заалдаж болно. Гэвч Дэ Силвиа хуульчид болон олон нийтийн эсэргүүцлийг үл хайхран 4 туршлагатай шүүгчийг үл оролцуулан, туршлага багатай 7 шүүгчийг эхлэн томилсон.

Үүнээс хойш энэ нь жишиг болон тогтож, Дэ Силвиа бүх хэргийг хянаж эхэлсэн. Түүний томилгооноос өмнө шүүхийн нарийн бичгийн даргын бүрдүүлж ирсэн дарааллыг Ерөнхий шүүгч албажуулж баталдаг байсан. 1999-2003 онд, Үндсэн хууль зөрчсөнтэй холбоотой бараг бүх чухал ач холбогдолтой хэргүүдийг хэлэлцэх бүрэлдэхүүнд Дээд шүүхийн хамгийн туршлагатай шүүгч Фернандог оруулалгүй хассан бөгөөд улмаар энэ нь түүнийг 2004 оны эхээр хугацаанаасаа 2 жил хагасын өмнө тэтгэвэртээ гарахад хүргэсэн байна. Майкл Фернандо тэтгэвэрт гарсныхаа дараа Дээд шүүхийн Ерөнхий шүүгчтэй зарга үүсгэсэн бөгөөд Дээд шүүхийн

Ерөнхий шүүгч өөрөө уг хэргийн маргалдагч нэг тал нь болж оролцсон атлаа, өөр 2 шүүгчийн хамт өөрөө шүүх бүрэлдэхүүнд нь орж, Майкл Фернандод нэг жилийн хүнд хөдөлмөр хийх ял оноожээ. Майкл Фернандо шүүхийн танхимд дуугаа өндөрсгөж “гомдол гаргахаа мэдэгджээ”². Боловсруулагдаж буй хуулийг эс тооцвол, Шри Ланкад шүүхийг үл хүндэтгэсэнтэй холбоотой харилцааг зохицуулах акт байхгүй. Харин үүний оронд шүүгчийн өөрийнх нь гаргасан (тогтоосон журмаар) хуулиар гагцхүү шүүгчийг шүүмжлэхээс хамгаалсан, тэнцвэрт байдлыг алдагдуулсан хатуу зарчим тогтсон. Шүүгч шударга ёсыг ноцтой зөрчиж, хараат бус байдал алдагдсан ч энэ зарчим үйлчилнэ. Эдгээр нь сэтгүүлчид, шүүмжлэгчдийн дуугүй байх байдлыг өөрчлөхөд хүргэж 2002 оноос эхлэн Эрүүгийн хууль дахь гүтгэн доромжлох гэмт хэргийг хүчингүй болгох мэдээллийн хэрэгслийн кампанит ажил өрнүүлсэн.

Авлигад өртөмтгий шүүх тогтолцоо

Шүүхийн албаны зөвлөл нь, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон Дээд шүүхийн өөр 2 шүүгчээс бүрдэнэ. Эдгээр нь ихэвчлэн туршлагатай, ахмад хүмүүс байдаг. 1994 онд Ард түмний Холбоо засгийн эрхэнд гарах үед хамгийн туршлагатай 2 шүүгч нь Фернандо болон Доктор А.Р.Б Амарасинхэ нар байв. Дэ Силвиа тэднийг хамгийн туршлага багатай 2 шүүгчээр сольсон.

Шүүхийн албаны зөвлөл нь шүүхийн энэ их хүний нөөцийг удирдах үүрэгтэй бөгөөд, шүүхийн захиргаанд шударга ёсыг хангах, доод шатны шүүгчдийн хараат бус байдал болон авлигаас урьдчилан сэргийлэх зорилготой. Уг зөвлөл нь албан тушаалд томилох, дэвшүүлэх, огцруулах мөн сахилгын зөрчлийн асуудлыг хариуцах боловч эдгээрийг шийдвэрлэхэд баримтлах тодорхой шалгуур үгүй. Хэрэв шүүгчид нь улс төрийн шинжтэй заавар, удирдамжид эс захирагдвал сануулж, дараагийн удаа ямар нэгэн шалтгаар ажлаас хална. Эсэргээрээ, захиргаатай улс төрийн нэгэн бүлэглэлд хамаарч байвал сахилгын хариуцлагаас чөлөөлөгдөж, авлига үйлдсэн, хээл хахууль авсан, доод тушаалын ажилтан эсхүл хэргийн оролцогчдыг бэлгийн дарамтанд оруулсан тухай нотлох баримт байсан ч хэрэгсэхгүй өнгөрөөдөг.³

Марга Институтын⁴ хийсэн судалгааны дүн, доод шатны шүүхийн авлигын хэр хэмжээ, тархацыг илрүүлэхэд чухал ач холбогдолтой. 2002 онд 441 хуулийн мэргэжилтэн, шүүхээр үйлчлүүлэгчдээс авсан судалгаанд, тэдний 80 хувь нь “байнга” үнэнч, шударга ажилладаг хэмээн бодохгүй байгаа бөгөөд 5 хүн тутмын

2 brcslproject.gn.apc.org/slmonitor/March2003/chief.html

3 Олон улсын Барын Холбоо, Шүүхийн хараат бус байдал болон хууль дээдлэх ёсны уналт (Лондон: ОБХ, 2001), www.ibanet.org/humanrights/Sri_Lanka.cfm; ба Виктор Иван, Дуусаагүй тэмцэл: Шри Ланкийн шүүх болон Дээд шүүхийн даргыг мөрдөн илрүүлэх нь (Колумби: Раваяа, 2003).

4 www.margasrilanka.org

нэг нь, “хэзээ ч” үнэнч, шударга ажилладаггүй гэжээ. Шүүгчид, хуульчид, шүүхийн ажилтнуудын дунд хийсэн судалгаанаас үзэхэд, тэдний 80 хувь нь шүүхийн тогтолцоо нь байнга үнэнч, шударга байж чаддаггүй гэсэн байна. Бүх оролцогчдын 83 хувь нь шүүх авлигад идэгдсэн, харин дөнгөж 17 хувь нь авлигад өртөөгүй хэмээжээ.

Тус судалгаанаас үзэхэд, хээл хахууль авсан 226 тохиолдол мэдээлэгдсэн бөгөөд үүнд холбогдсон албан тушаалтны хамгийн том бүлэг бол шүүхийн туслах ажилтнууд юм (32 хувь нь). Ихэнхи хээл хахуулийг хэргийн хуралдааныг товлуулах, шүүхийн зарлан дуудах хуудсыг бичүүлж авахын тулд өгдөг. Үүнээс бусад ашиг ологчид нь прокурор, цагдаа, өмгөөлөгчид байдаг байна. Зарим шүүгчид, бусад шүүгчдээ хээл хахууль авсан гэж тодорхойлсон 5 тохиолдол байгаа хэдий ч хамгийн бага хээл хахууль авдаг нь шүүгчид болж таарсан байна.

Зөвлөмж

- Дээд шатны шүүхүүдэд хэрэг хуваарилах журмыг өөрчилж, тохиолдлын журмаар хуваарилдаг болгох нь шүүхийн шударга байдлыг хангаж, шүүгчид, шүүхийн ажилтнуудаас албан тушаалаа урвуулан ашиглах явдлыг зогсооход чухал үүрэг гүйцэтгэнэ. Шүүгч албан үүргээ гүйцэтгэж байгаагаас бусад тохиолдолд хэргийн материалтай танилцахыг хориглоно. Хэрэг хуваарилах журмыг хэвлэн нийтлэх ёстой.
- Шүүхийн үйл ажиллагааны хяналт, шүүгч өөрийн үйлдэлдээ хариуцлага хүлээдэг байх нь үр дүнтэй шүүхийн тогтолцооны загвар юм. Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн бусад шийдвэрийг эргэн дүгнэх процесс үгүй, эсхүл шүүгчид шүүн таслах ажиллагаанаас гадна жижиг сажиг захиргааны шинжтэй асуудалд ихээхэн орооцолдож, цаг алдах нь зохимжтой биш байх болно.
- Парламентаас шүүгч нарыг импичментын журмаар огцруулах нь төдийлөн үр дүнтэй бус, учир нь улс төрчдийн хамгаалалтанд байдаг шүүгч нь уг үйл ажиллагаанаас зайлсхийж чадна. Хамтын нөхөрлөлийн орнуудын хараат бус шүүгчдийн комиссоор Шри Ланкийн шүүгч нарыг шалгах ажиллагааг хийлгэх боломжтой.
- Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн үйлдэл нь шүүхийн шударга байдалд онцгой нөлөөтэй. Засгийн газар нь хянан шалгах хараат бус комиссоор одоогийн албан тушаалтнуудын хууль бус үйл ажиллагааны талаарх гомдлуудыг шийдвэрлүүлэх ёстой.
- Доод шатны шүүхүүдийг Шүүхийн албаны зөвлөлийн зоргоороо авирлах явдал, хууль бус шийдвэрээс хамгаалах нь зүйтэй.
- Шүүгчийн ёс зүйн дүрэм батлагдаж, ашиг сонирхлын зөрчил, нийгэмд биеэ

авч явах байдал, шүүгчийн эсрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц нь хэвлэн нийтлэгдэх шаардлагатай.

- Шүүгчдийн холбоо нь, Шүүхийн албаны зөвлөл болон Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн шууд болон шууд бус нөлөөгүйгээр чиг үүргээ хэрэгжүүлэх ёстой.
- Шүүхийн салбар дахь аливаа тусламж, санхүүгийн дэмжлэг нь ил тод байж, шүүгчид олгох нэмэлт боломжуудын шалгуур нээлттэй байх нь зүйтэй.

*Кишали Пинто Жаяавардана ба Ж. К. Велимуна
(Шри Ланк дахь ТИ, Колумби)*

Туркийн шүүхийн үйл ажиллагаа: авлигыг ул үндсээр нь устгах зорилготой байна

Эрх зүйн тогтолцоо: Эрх газрын эрх зүй, мөрдөн шалгах зарчим, прокурор нь шүүх эрх мэдэлдээ хамаардаг

100,000 хүн тутамд ногдох шүүгчийн тоо: 7,0¹

Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 16,505 ам.доллар²

Дээд шүүхийн шүүгчийн цалин: 34,660 ам.доллар³

Нэг хүнд ногдох УНБ: 4,710 ам.доллар⁴

Шүүхийн жилийн төсөв: 1.2 тэрбум ам.доллар⁵

Жилийн нийт төсөв: 8.2 тэрбум ам.доллар⁶

Жилийн төсөвт эзлэх хувь: 1.0

Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шат хүртэл давж заалдах боломжтой эсэх: Гийм

Шүүгчид сахилгын хариуцлага ногдуулах байгууллага: Хараат

Шүүхээс гаргасан бүх шийдвэрүүд олон нийтэд ил тод: Үгүй

Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Үгүй

- | | | | |
|--|-------------|-------------|--------------------------|
| 1. Хууль зүйн яам (2006) | 2. Мөн тэнд | 3. Мөн тэнд | |
| 4. Дэлхийн банкны хөгжлийн түвшинг тодорхойлогч (2005) | | | 5. Санхүүгийн яам (2006) |
| 6. CIA Дэлхийн үйл явдлын товчоон (2005) | | | |

Туркийн бүгд найрамдах улсын эхний 60 жилд, шүүхийн авлига харьцангуй доод төвшинд байсан бол сүүлийн 20 жилд олон нийтийн зүгээс шүүхэд итгэх итгэл суларч байгааг судалгаа харуулжээ. 2005 оны Дэлхий нийтийн авлигын хэмжүүрт дурдсанаар, судалгаанд оролцогчид 1-5 (5 оноо хамгийн их авлигатайд тооцогдоно) оноогоор дүгнэхэд, тэд шүүхэд 4 оноо өгчээ.

Мэдээллийн хэрэгслүүдээр шүүгч, прокурортой холбоотой дуулиан тарьсан мэдээллүүд цацагдаж, дээрх нөхцлийн талаар мэдээлэл өгч байна. Энэ нь, авлигын талаар мэдээлэх мэдээллийн хэрэгслийн чадавхи өссөнөөс илүү авлига өссөнийг харуулж байна. Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн эрх чөлөө төдийлөн өсөөгүй.

Туркийн Үндсэн хуульд, “хууль ёсны тэгш эрх”, “шүүхийн хараат бус байдал ба шударга шүүхээр шүүлгэх”, түүнчлэн хууль дээдлэх ёсыг тунхагласан байдаг хэдий ч, эдгээр заалт эс хэрэгжин, авлига оршиж байна. Авлигын төвшин илт өссөн нь, ард түмний зүгээс, татварын байгууллагын дараа, шүүхийг 2 дахь авлигад идэгдсэн салбар гэж үзэхэд хүргэсэн байна.¹

Дээрх үнэлэмжийг батлах зарим нотолгоо бий. 1999 онд Акденизийн Их сургуулийн профессор Хэйритин Окцесиз, Истанбул хотын Барын холбоотой хамтран түүний гишүүн 666 өмгөөлөгчдөөс 631-ийг нь судалгаанд хамруулахад

1 TI –ийн Дэлхий нийтийн Авлигын Хэмжүүрийн жил бүрийн судалгааны дүнг www.transparency.org сайтаас үзнэ үү.

үр дүн нь шүүхэд авлига оршин буйг (95 хувь нь) нотолсон.² Үүний дараа профессор Окцесизыг үүгээр нь шалтаглан мөрдөн шалгаж эхэлсэн бөгөөд судалгааг үргэлжлүүлэхээр зориглох хүн дахин олдсонгүй.

Шүүхийн авлига өсөн нэмэгдэж байгаа нь шүүхийн тогтолцоо бүхэлдээ авлигад идэгдсэн гэсэн үг биш юм. Ахмад, туршлагатай албан тушаалтнууд авлигын тархалтыг хүчтэй шүүмжилж, түүнийг үндсээр нь таслан зогсоож, шүүхийг нийгмийн шударга ёсны тулгын чулуу болгоход үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Эдгээр хүмүүс, Сократын “Шударга ёсноос дээр зүйл үгүй” хэмээх үгийг уриа болгож ажилласан бөгөөд, 2005 онд Турк дахь ТИ—ээс, шүүхийн авлигын хандлагыг өөрчлөхөд оруулсан хувь нэмрийг үнэлж Шударга ёс ба авлигын Эсрэг шагналыг гардуулсан.³

Шүүхийн томилгоонд улс төрийн зүгээс нөлөөлөх нь

Шүүхийн тогтолцоон дахь хамгийн гол байгууллага бол Шүүгч, прокурорын дээд зөвлөл бөгөөд бүх шүүгч, прокурорын үйл ажиллагааг уялдуулж, шүүхийн байгууламжийн шударга ёсыг хангах үүрэгтэй. Мөн түүнчлэн энэ нь шүүхийн тогтолцооны халдашгүй байдлын баталгаа болох ёстой.⁴ Дээд зөвлөл нь 7 гишүүнээс бүрдэнэ. Үүнд: Хууль зүйн сайд болон түүний орлогч нарийн бичгийн дарга, Давж заалдах шатны (Яргитай) 3 шүүгч, захиргааны хэргийг давж заалдах шатны шүүхийн (Данистай) 2 шүүгчээс тус тус бүрдэнэ.

Дээд зөвлөл нь Хууль зүйн яаман дээр хуралдах бөгөөд яамны аппарат нь тус зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ. Шүүхийн хараат бус байдалд нөлөөлөх энэхүү гажуудлыг Ерөнхийлөгч Ахмет Несдэт Сэээр 2005 оны парламентын жилийн⁵ нээлтэн дээр хэлсэн үгэндээ тэмдэглэн хэлсэн. Мөн Туркийг Европын Холбоонд элсүүлэх асуудлыг хэлэлцэх үеэр, Европын Хорооны ахиц дэвшлийн тайланд уг асуудлыг шүүмжлэн бичжээ.⁶

Шүүхийн үйл ажиллагааг сулруулж буй нэгэн хүчин зүйлс нь, дээд зөвлөлийн бүрэлдэхүүн дэх Хууль зүйн яамны нөлөөгөөр дамжин шүүгчийн томилгоонд нөлөөлөх төрийн нөлөө юм.⁷ Хууль зүйн яамны зүгээс нөлөөлөх нь албан

2 Заман /Турк/, 2001.2.8 нд болон Харриэт /Турк/, 2000.2.9 нд профессор Окцесизтэй тус тус хийсэн ярилцлага

3 2004 онд Ерөнхий прокурор Нури Ок, прокурор асан Цмэр Сха Алданий хамт шүүхийн шийдвэрт нөлөөлдөг бүлгийг илрүүлсний төлөө, 2005 оны 5 сард Турк дахь ТИ —ээс Шударга ёс ба Авлигын Эсрэг шагналыг олгосон. Мөн хөл бөмбөгчин Сэфэр Хакан Олгун спортын авлигыг илрүүлсэн. For further information, www.saydamlik.org сайтыг үзнэ үү

4 Миллиэт (Турк), 1997.1.14 ба Харриэт (Турк), 2004.8.20

5 Ерөнхийлөгч Ахмет Несдэт Сэээрийн хэлсэн үг. 2005.10.1

6 Европын Хороо, 2005 оны Туркийн ахиц дэвшлийн тайлан, Брюссель, 2005.11.9

7 2004. АНУ, Шүүхийн шинэчлэлийн тайлан. 2004.1 сар

тушаалтнуудын шийдвэрийг хянах, бүх шатны шүүгч, прокурорыг томилох, албан тушаал дэвшүүлэх, шилжүүлэх, мөн халдашгүй дархан эрхийг түдгэлзүүлэх зөвшөөрлийг олгодог. Хууль зүйн сайд томилох, шилжүүлэх хүмүүсийн нэрсийг хянаж үздэг бөгөөд энэхүү эрх нь шүүгч, прокурорыг шаардлагатай үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас холдуулах боломжийг олгодгоороо муу нөлөөтэй.

Нэгэн жишээнээс үзэхэд, 2003 оны “Мэс засал” нэртэй ажиллагааны үеэр дээд шатны шүүхийн шийдвэрт нөлөөлөхөөр тохиролцсон бүлгийг илрүүлэх үүрэгтэй ажиллаж байсан прокурор Омэр Сюха Алданыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас шилжүүлсэн. Бүлгийн нэгэн гишүүн болох хуульч Сэнк Гурэл нь дээд зөвлөлийн даргын хүү байсан юм.⁸ Гурэл нь 6 сарын хорих ялаар шийтгүүлсэн боловч, эцэст нь торгох, эрхийг нь 3 сар хүртэл хасах шийтгэл болж буурсан байна.

Шүүгчийн халдашгүй эрхээ урвуулан ашиглах нь

Шүүгч, прокурорын хараат бус байдлыг хангах зорилгоор, тэдгээрт мөрдөн шалгах ажиллагаанаас ангид байх, тэр ч байтугай хээл хахууль авсан тохиолдолд ч мөн адил халдашгүй эрхийг олгодог. Тиймээс албан тушаалаа урвуулан ашиглах байдал газар авсан төдийгүй дээд зөвлөл тэр бүр энэхүү халдашгүй эрхийг түдгэлзүүлдэггүй нь үүнд нэрмээс болдог. Шүүхийн энэхүү халдашгүй байдал нь, улс төрчид, хүнд сурталтанд хэргийг өөрийн талд шийдвэрлүүлэх боломж олгоно.

Жишээ нь “Мэс засал” нэртэй ажиллагааны үеэр, дээд зөвлөл нь гэмт бүлгийн толгойлогчийн эцэг болох Эргюль Гурэлийн халдашгүй дархан эрхийг цуцлахаас татгалзсан бөгөөд энэ нь түүний эсрэг хэрэг үүсгэх боломжгүй болгосон. Түүнд сахилгын арга хэмжээ ногдуулж, албадан тэтгэвэрт нь гаргасан байна. Энэ хэрэг шүүхэд итгэх ард түмний итгэлийг сулруулж, шүүхийн байгууллагын албан тушаалтнуудын дундах төрөл садны харилцаа нь хэрхэн шүүхийн шийдвэрт нөлөөлж болдогийг харуулсан.⁹ Асуудлыг бүр хурцатгасан зүйл нь, 2004 оны 5 сард Эргюль Гурэл Давж заалдах шатны шүүх дэхь Ерөнхий прокурорын албан тушаалд хамгийн олон санал авчээ. Ерөнхийлөгч Сизэр 5 нэр дэвшигчээс санал хураалтаар 2-т орсон Нури Окийг томилсон байна.

Шүүхийн тогтолцооны дээд шатанд шүүмжлэлттэй өөр олон асуудал бий. 2004 оны 8 сард, мэдээллийн хэрэгслээр, Давж заалдах шатны Ерөнхий шүүгч Эраслан Өзкаяг мафийнхантай холбоотой хэмээн сэжиглэсэн мэдээлэл цацагдсан.¹⁰ Тэрээр хэвлэл мэдээллийнхний эсрэг гүтгэн доромжилсон хэмээн

8 Харриэт (Турк), 2004.1.15.

9 Миллиэтийн 2006 оны 2 сарын 16 ны өдрийн дугаарт нийтлэсэнээр, Истанбулын прокурорын дарга, 3 шүүхийн хүн амины хэрэгт буруутай хэмээн үзсэн шийдвэрийг үл хэрэгсэн, өөрийн найз, түүний хүү, хүргэн хүү нарыг сулласны төлөө шалгагдаж байна. Гэрчийн мэдүүлсэнээр, прокурорын дарга нь найзынхаа охины хуриман дээр, тэр гэр бүлтэй дотно харилцаатай байсныг тогтоосон.

10 Радикал (Турк), 2004.8.22

хэрэг үүсгүүлсэн боловч шийдвэр түүний эсрэг гарсан байна. Гэвч цагдаагийн байгууллагаас халдашгүй дархан эрхтэй учраас түүнд хэрэг үүсгэж чадаагүй.

Шүүхийн хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх зарим механизм ажилладаг. Туршлага шаардсан, ихээхэн маргаантай эсхүл ихээхэн шуугиан дагуулсан хэргээс бусад тохиолдолд хэргийг шүүгч нарт тохиолдлын журмаар хуваарилдаг. Гэвч шүүгч, прокурорын сахилгын процесс зэрэг шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл ерөнхийдөө хомс байдагаас дээрх сахилгын асуудлыг зохицуулсан механизм нь үр дүнтэй ажиллахад хүндрэлтэй байсаар байна.

Шинжээчийн дүгнэлтийг урвуулан ашиглах

Хууль зүйн сайд Симел Сисекис бол “шинжээч” (билиркиси)-ийн дүгнэлтийг хуулийн системд ашиглахыг эсэргүүцдэг олон хүний нэг юм. “Шинжээчийн мэдүүлэг”-ийг ашигладаг системтэй байгаа цагт та хэзээ ч авлигатай тэмцэж чадахгүй гэж тэр хэлдэг.¹¹ Шүүхэд техникийн асуудлуудыг шийдвэрлэх шинжээчид эсвэл хэргийн газарт очих хугацаа, эсвэл найдвартай шинжилгээ хийлгэх мэргэжилтнүүд байдаггүйгээс тэд хувийн шинжээчдийн мэдээллийг ашигладаг. Тэд ихэнхдээ илт хуурамч мэдээлэл өгдөгөөс шүүгчид тэдний мэдээллийг үнэлэх нь ховор байдаг.

Шинжээчид том, жижиг хэргүүдийн аль алинд нь хариуцагч талаас хээл хахууль авч, тэднийг хамгаалахын тулд хуурамч мэдээлэл ирүүлдэг. Жишээ нь, авлигатай холбоотой “Цагаан энерги” хэрэг дээрх шинжээчийн дүгнэлтэд, сонирхогч талууд шийдвэр гаргагч нарт биеэ үнэлэгч, цаг, очир алмаазан зүүлт, машин зэргийг санал болгох нь шийтгэл хүлээх хээл хахуульд тооцогдохгүй¹² гэжээ. Үүнтэй төсөөтэй бас нэг жишээ бол, барилга угсрагчдын буруугаас шалтгаалан сургуулийн дотуур байр нурж 84 хүүхэд амь үрэгдсэн хэрэгт гарсан шинжээчийн дүгнэлтэд тэднийг буруугүй хэмээгээд, уг барилга нурсан нь түүнийг угсарсан материалд хангалттай төмөр, цемент байхгүйгээс болоогүй харин уг барилгыг барихад ашигласан тухайн орон нутгийн барилгын материалын чанар муугаас болсон гэсэн дүгнэлтийг ирүүлжээ.¹³

Авлигыг зогсоох оролдлогууд

Өнгөрсөн 2 жил гаруй хугацаанд, олон шүүгч, прокурорууд хээл хахууль авсан, шүүхийн шийдвэрт нөлөөлөхийг оролдсон хэргээр хорих ялаар шийтгүүлсэн. Мөн зөвлөлийн дарга, давж заалдах шатны шүүгчид, давж заалдах шатны дэд ерөнхий нарийн бичгийн дарга зэрэг албан тушаалтнууд албан тушаал буурсан байна.

11 Миллиэт (Турк), 2004.1.7

12 Харриэт (Турк), 2006.2.17.

13 Миллиэт (Турк), 2004.6.25

Нури Ок болон бусад авлигын эсрэг тэмцэгчид шүүх тогтолцоог авлигаас цэвэрлэхийн тулд мөрдөн шалгах ажиллагаануудыг явуулж байна. Тэд “Мэс засал” ажиллагааг (Нэстэр I), амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд Нэстэр II-ийг үргэлжлүүлэн явуулж байна. Уг ажиллагааны дүнд олон шүүгч, прокурорын хууль бус үйл ажиллагааг илрүүлсэн.¹⁴

Энэхүү амжилт нь хямд үнээр олдоогүй. “Мэс засал” ажиллагааг хариуцаж байсан прокурор албан тушаалаасаа чөлөөлөгдсөн. Мөн шүүхийн салбарыг цэвэрлэхэд улс төрийн болон төрийн байгууллагуудын зүгээс маш бага дэмжлэг үзүүлж байлаа. Жишээ нь, эмчилгээний зориулалттай мансууруулах бодистой холбоотой олон сая долларын залилангийн хэргийг шалгаж байсан прокурор сүүлд мэдэгдэхдээ хэдийгээр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хангалттай цацагдсан ч холбогдох яамд шалгалтыг үргэлжлүүлэхийг хүсээгүй учир зогсоосон гэжээ.¹⁵

Туркийн шүүхийн тогтолцооны ил тод байдлыг хангахын тулд шүүхийн шийдвэр болон бусад бичиг баримтуудыг интернетэд байршуулах ёстой юм. Шүүгч нарын төлөөллийг олон улсын хурал, зөвлөгөөнд явуулж, Банглорын болон Будапештын зарчим мэтийн олон улсын авлигатай тэмцэх стандартад үйл ажиллагаагаа нийцүүлэх нь зүйтэй.

Мөн бусад өөрчлөлтүүдийг яаралтай хийх шаардлага байна. Шүүхийн үйл ажиллагаан дахь улс төрийн нөлөөг бууруулах, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг Үндсэн хуулиар баталгаажуулах хэрэгтэй. Дээд зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, шүүгчийн халдашгүй дархан байдлыг цуцлах нь зөв.

Хууль зүйн сайд болон түүний нарийн бичгийн дарга нар Дээд зөвлөлийн бүрэлдэхүүнд орохоос татгалзаж, прокурорын дарга, бусад прокурор, боломжтой тохиолдолд хуульчдыг бүрэлдэхүүнд нь оруулах шаардлагатай. Шүүгчийг томилох, шилжүүлэх болон шүүхтэй холбоотой бусад асуудалд засгийн газраас нөлөөлөх явдлыг хориглож, нэр дэвшигчдийн жагсаалтыг батлахад Хууль зүйн яамны оролцоог бууруулах ёстой. Дээд зөвлөл нь өөрийн төсөв, ажлын албатай байж, ажлын алба нь Хууль зүйн яамнаас өөр газар байрлах ёстой.

Дараагийн зөвлөмж бол, хувийн шинжээчдийн мэдүүлгийг хүлээн зөвшөөрдөгийг хориглож, хэрэгт ач холбогдол бүхий техникийн шинжтэй мэдээллээр хангахад туслах үүрэг бүхий, гэрээгээр ажиллах төрийн албан тушаалтнуудыг томилох

14 2006 оны 5 сард Прокурорын дарга Нури Ок болон прокурор Сюха Алдантай хийсэн ярилцлага

15 Саба (Турк), 2006.5.30

шаардлагатай. Мөн шүүгч, прокурор, өмгөөлөгч нарын боловсролыг дээшлүүлэх хэрэгтэй. 2006 оны 4 сард Их сургуулийн дээд зөвлөл хуулийн сургуулийн сургалтын хугацааг 4 жил байсныг 5 жил болгож өөрчлөх шийдвэр гаргасан.

Улс төрч, бизнес эрхлэгчидтэй харилцах хязгаарыг тодорхойлсон ёс зүйн дүрэм боловсруулан мөрдүүлэх, анх шүүгчээр томилогдохдоо өргөдөг тангараганд үүнийг нь тусгах, жил бүр тангарагийг нь сэргээн сануулдаг байх нь зүйтэй юм.

Эцэст нь, шүүгчид өдөрт 60 хүртэл хэрэг хянаж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж бэрхшээл учирдаг. Энэ нь шүүгчид хэрэг бүрт шаардлагатай, зохистой хугацаа зарцуулж чаддаггүйн нэг шалтгаан юм. Шүүгч, прокурорын цалин бусад төрийн байгууллагын албан хаагчидтай харьцуулахад боломжийн байдаг ч, том хотуудын амьдралын өртөгтэй жишихэд, харьцангуй доогуур бөгөөд хүрэлцээ муу байдаг.¹⁶

Туркийн ТИ, Истанбул

16 Нокта (Турк), 2004.7.5

Их Британийн Нэгдсэн Вант улс (НВУ)—ын шүүхийн хариуцлага, ил тод байдлын тогтолцоог боловсронгуй болгох нь

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, мэтгэлцэх зарчим
100,000 хүн тутамд ногдох шүүгчийн тоо: 2.5 (Англи, Уэльст), 3.6 (Умард Ирландад), 4.5 (Шотландад)¹
Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 182,848 ам.доллар²
Дээд шүүхийн шүүгчийн цалин: 369,601 ам.доллар³
Нэг хүнд ногдох ҮНБ: 37,600 ам.доллар⁴
Шүүхийн жилийн төсөв: 6.28 тэрбум ам.доллар⁵
Жилийн нийт төсөв: 354.6 тэрбум ам.доллар⁶
Жилийн төсөвт эзлэх хувь: 1.8
Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хиртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм
Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Бүрэн хараат бус⁷
Шүүхээс гаргасан бүх шийдвэрүүд нийтэд ил тод байдаг: Тийм
Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1. Шүүхийн үр дүнг Сайжруулах Европын хороо (ШСЕХ)
2. www.dca.gov.uk/judicial/2004salfr.htm
3. Мөн тэнд
4. Дэлхийн банкны хөгжлийн түвшинг тодорхойлогч (2005)
5. Англи, Уэльс, Шотландын шүүх, прокурорын хууль зүйн туслалцаа, ШСЕХ (2006)
6. Мөн тэнд
7. Гүйцэтгэх болон шүүх эрх мэдэл нь бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулдаг. Шүүхийн бүх ажиллагаа ил тод. Умард Ирланд, Шотландад зарим тохиолдолд шүүгчийг халахад, парламентад урьдчилан санал оруулдаг.

Нэгдсэн Вант улсын шүүгчид нь, хараат бус, шударга, өндөр ёс зүйтэй, шүүхийн авлига бараг үгүй¹ тул, олон улсад нэр хүндтэй. Лордын танхимын дарга асан, Лорд Вулф, “Манай шүүгчдийн ёс зүйн стандарт нь, бидний хууль ёсны бахархал”² мөн гэсэн байдаг. Гэвч шүүхийн тогтолцоо шүүмжлэлээс ангид байх хараахан болоогүй бөгөөд ард түмэн, шүүхийн тогтолцоо хуучирсан, гажигтай байгаа нь саяхан боловсруулагдсан Үндсэн хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна гэж үздэг.

НВУ–д, Англи ба Уэльсийн, Умард Ирландын, Шотландын гэсэн шүүн таслах ажиллагааны 3 хэсэг оршин тогтнож байдаг. 1999 оноос хойш гүйцэтгэх эрх мэдлийн (Шотландад хууль тогтоох эрх мэдлийн) бүрэн эрхүүд бүс нутгийн удирдлагуудад шилжсэн. Бүх бүс нутаг өөрийн шүүхийн тогтолцоотой. Одоогийн байдлаар, Лордын танхимын Давж заалдах хороо нь, Шотланд дахь эрүүгийн

- 1 ‘Нэгдсэн Вант улсын үнэлгээний тайлан’, Страсбург 2001 оны 9 сарын 10-14 ний өдөр.
- 2 Шүүхийн ёс зүйн дүрэм, 2006 оны 6 сард эхний хэсэг нь хэвлэгдсэн, at www.judiciary.gov.uk/docs/judges_council/published_guide0606.pdf

хэргээс бусад бүх хэргийг давж заалдах эцсийн шүүх байна. 2009 онд НВУ–ын шинэ Дээд шүүх үйл ажиллагаагаа явуулж эхлэнэ. Энэ нь Англи, Уэльс, Умард Ирландын бүх хэргийг, түүнчлэн Шотландын захиргааны давж заалдах хэргийг шийдвэрлэх бүрэн эрхтэй, бие даасан, хараат бус шүүх байх болно.³

Шүүхийн авлигын цар хүрээ

НВУ –д шүүхийн авлига маш ховор тохиолдол бөгөөд хэрэв энэ талаар мэдээлэл ирвэл нарийн шалгадаг. Жишээ нь, Жеффри Скривен 1983 онд гэрлэлтээ цуцлуулсан шүүхийн шийдвэрт сэтгэл дундуур байсан бөгөөд 1995–2000 оны хооронд 11 удаа албан тушаалтнуудын эсрэг гомдол гаргасан бөгөөд тэдгээр нь “шүүхийг авлигад автуулах албан ёсны мафи”, “шүүхийн авлигыг нуун дарагдуулах хуйвалдаан”, “залилангийн хуйвалдаан”, “трибуналын шүүх нь хэргийг шударга, хараат бусаар шийдвэрлээгүй” гэх мэт хэргүүд байв. Скривений авлигатай холбоотой мэдээллийг маш нарийн шалгасны эцэст, үндэслэлгүй хэмээн буцааж байсан бөгөөд энэ хэрэг нь, иргэд шүүхэд хандах эрхийн суурь зарчмыг хангахад шүүгч ямар үнэ цэнэтэй болохыг харуулсан. Англи, Уэльсэд гомдол гаргагчийг хангалттай үндэслэлгүй гэж үзэх шалтгаантай бол гомдлыг хянан хэлэлцэх ажиллагааг зогсоож, тухайн гомдолоо дахин гаргахыг хориглох зохицуулалттай. Скривений хэрэг 5 жил үргэлжилсэн бөгөөд 11 удаа шүүх хурал хийж, түүний гомдол гаргахыг хориглох шийдвэр гаргах хүртэл баримт, нөхцөлүүдийг маш анхааралтай судлан үзсэн.⁴

НВУ–ын шүүхэд эргэлзэх сэтгэл маш бага байдаг ч, шүүхийн тогтолцооны нэлээд хэсгийг эзлэх, цагдаа, Эзэн хааны Прокурорын алба болон бусад агентлагууд нь байнга хурц шүүмжлэлд өртдөг. 2006 оны 4 сард Зохион байгуулалттай хүнд гэмт хэрэгтэй тэмцэх алба байгуулагдсан бөгөөд одоогоор НВУ–ын зохион байгуулалттай гэмт хэргүүдийг шалгаж байна. Уг байгууллага нь, гэмт хэрэгтнүүд цаашдын үйл ажиллагааг явуулахын тулд авлига үйлддэгийг, мөн “НВУ–д хууль хэрэгжүүлэгч олон түшмэдүүд хээл хахууль авч гэмт хэрэгтнүүдтэй холбогдсон” болохыг тогтоожээ.⁵ Жишээ нь, цагдаагийн алба нь өөрийн дотоод дахь авлигатай олон жилийн турш тэмцэж байна.⁶ ВВС–гийн сурвалжлагчийн саяхан мэдээлснээр, хэл хахууль авсан 2 цагдаа Стивен Лоренсийг хөнөөсөн хэрэгт шалгагдаж,⁷ мөн нийслэл хотын 5 цагдаа мөнгө угаах хэргээр баривчлагдсан ч цагдаагийн байгууллагын нэр хүнд өсөөгүй юм.⁸

3 www.judiciary.gov.uk

4 НМ. Ерөнхий прокурор Скривений эсрэг Хатан хааны шүүх (Титмийн албаны жагсаалт) СО/1632/99, СО/3563/98, 2000.2.4; Өөр нэг жишээ нь, Ливерпүүлийн 2 шүүгч авлигын хэрэгт шалгагдаж, 2002 оны 5 сард гэм буруугүй нь тогтоогдсон. Таймс (НВУ), 2002.5.18.

5 www.soca.gov.org

6 Нэгдсэн Вант улсын үнэлгээний тайлан’ (2001)

7 ВВС 1, Стивен Лоренсийг хөнөөсөн залуус, 2006.7.26

8 Гардиан (НВУ), 2006.11.10

НВУ дахь авлигын одоогийн таамаглалын нөхцөл байдал нь, 2007 оны ТИ–ийн Дэлхийн нийтийн авлигын хэмжүүрт зааснаар ихээхэн доогуур байна. 2006 оны зун 1,025 иргэдээс асуулга авахад, “шүүхийн /хуулийн байгууллагад” авлига бий юу гэсэн асуултанд, тэдний 39 хувь нь энэ систем нь авлигад автагдсан гэж хариулсан бөгөөд НВУ нь, Итали, Францаас илүү авлигатай улс гэжээ. Энэ нь гайхмаар үр дүн бөгөөд магадгүй үүнд зөвхөн шүүх, шүүгчээс илүүтэй хууль зүйн бүхэл тогтолцоонд санаа зовох хандлага нь нөлөөлсөн байж болох юм. Шүүгчийн авлигын талаарх мэдээлэл хаяа ирдэг бөгөөд харин хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын авлигын талаарх мэдээлэл, мөн тэдний буруутайг тогтоох нь илүү түгээмэл.⁹ Дээрх хэргүүдийн талаар, мэдээллийн хэрэгслээр болон засгийн газрын агентлагуудаар дамжуулан олон нийтэд хүргэсэн нь тэднийг түгшээхэд хүргэсэн байж болох юм.

Улс төрийн нөлөө

Түүхийн турш, НВУ–д төрийн эрх мэдлийг бүрэн төгс хуваарилж байгаагүй. Лорд Канцлер нь нэгэн зэрэг Лордын танхимын спикер, шүүх эрх мэдлийг тэргүүлэгч, гүйцэтгэх эрх мэдлийн төлөөлөгчийг хавсран гүйцэтгэдэг нь эрх мэдлийг хуваарилах зарчмыг үгүйсгэж байгааг харуулдаг. Эрх мэдлийн тэнцвэрт байдал нь гагцхүү хуульчдын (шүүгчдээр тэргүүлүүлсэн) хараат бус байдал ба “ардчилсан үзэлт Британийн улс төрчид”–ийн үзэл санааны нэгдлийн үндсэн дээр оршин тогтож байна.¹⁰

Ийм байдлаар эрх мэдлийн тэнцвэрийг хадаглах нь үргэлж амар байдаггүй бөгөөд засгийн газар шүүхийн хараат бус байдлыг алдагдуулсан хэмээн үе үе шүүмжлэлд өртөж байсан. 1996 онд НУБ–ын Шүүгч, хуульчдын Хараат бус байдлын талаарх тусгай Мэдээлэгч нь, Дотоод хэргийн нарийн бичгийн даргын холбогдолтой шүүхийн шийдвэрт сайд нарын хийсэн тайлбарыг үзээд “ноцтой зовниж” буйгаа мэдэгдсэн. Хэсэг төрийн нарийн бичгийн дарга нар, шүүгчид болон тэдгээрийн шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүмжилсэн.¹¹ Тухайлбал, 2003 онд Дэвид Бланкет үндэсний сонинд, “шүүгчидтэй хийсэн дайн”¹²– ыхаа, мөн Лордын Танхимын жишиггүй мэтгэлцээний тухай хурцаар шүүмжлэн бичсэн. Энэ нь цааш одоог хүртэл үргэлжлэн, Дотоод хэргийн төрийн нарийн бичгийн дарга Жон Райд, 2006 оны 6 сард шүүгчийг нэгэн тодорхой хэрэгт дэндүү “зөөлөн” ял оноосон гэж,¹³ мөн 9 сард Иракийн зарим иргэдийг тус

9 2006 оны 1 сард Титмийн Прокурорын албаны мөрдөн байцаагчид, төрийн байгууллагын журам зөрчсөн гэм буруу нь тогтоогдсон. www.bbc.co.uk, 2006.1.10

10 Р. Стивенс, ‘Гэм буруугүйн хохирол уу?’ “Шүүхийн хараат бус байдал ба Эрх мэдлийн хуваарилалт”, Оксфордын Хууль зүйн сэтгүүл 19 (3) (1999).

11 Эдийн засаг, нийгмийн зөвлөл, E/CN.4/1996/37, 1996.3.1.

12 Ийвнин стандарт (НВУ), 2003.5.12; Дэйли Мэйл (НВУ), 2003.2.20.

13 Таймс (НВУ), 2006.6.14.

улсаас хөөн гаргах өөрийнх нь шийдвэр шүүхээр хэлэлцэгдэж байгааг үл хэрэгсэн тэдэнд уг шийдвэрийг хэрэгжүүлэхийг түдгэлзүүлэх бүрэн эрх олгогдоогүй л бол¹⁴ тэднийг хөөн гаргахаар шийдвэрлэх байсан хэмээн өөр нэгэн шүүгчийг шүүмжлэн бичсэн байна.

Үндсэн хуулийн эрс шинэчлэлүүд ба албан ёсны эрх мэдлийн хуваарилалт

2003 оны 6 сард засгийн газраас Үндсэн хуулинд суурь өөрчлөлт хийхээр төлөвлөж буйг мэдэгдсэн. 2006 оны 4 сард, 2005 онд батлагдсан Үндсэн хуулийн Шинэчлэлийн Акт (ҮША) хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Энэ нь дараах 4 гол харилцааны зохицуулалтанд өөрчлөлт оруулсан. Үүнд: Шүүхийн хараат бус байдал; Лорд Канцлерийн алба; Дээд шүүхийг байгуулах; Англи, Уэльсэд шүүгч томилох хороог байгуулах тухай асуудлууд хамаарна. Ийм өөрчлөлтүүд хийгдсэн ч, прокурорын газрын гажууд тогтолцоо хэвээр үлдсэн. Ерөнхий прокурор нь нэгэн зэрэг засгийн газрын Ерөнхий хууль зүйн зөвлөх, засгийн газрын гишүүн, эрүүгийн хуулийн хэрэгжилтэнд эцсийн хариуцлага хүлээгч, төрийн прокурорын даргын болон Ноцтой залилангийн хэрэг хариуцсан албаны даргын үйл ажиллагааны талаар парламентад хариуцан тайлагнадаг, мөн нийтийн ашиг сонирхолтой холбоотой бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.¹⁵

2005 оны ҮША-д заасны дагуу, Лорд Канцлер нь Англи, Уэльсийн шүүх эрх мэдлийг тэргүүлэгч мөн шүүгч байхаа больсон. Лорд Ерөнхий шүүгч нь Англи, Уэльсийн шүүх эрх мэдлийг тэргүүлж, урьд Лорд Канцлерийн эрхэлж байсан 400 орчим үүргийг хүлээн авсан. Цаашлаад, Лорд Канцлер болон “бусад эзэн хааны сайд нар нь шүүхтэй холбоотой аливаа чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шүүхийн бие даасан байдлыг зөвшөөрч, хүндэтгэлтэй хандах” бөгөөд одоо шүүхийн хараат бус байдлыг хангах хууль зүйн үүрэгтэй болж байна.¹⁶ Эдгээрт “шүүхээс тусгай үйлчилгээ шаардахгүй” байж, тодорхой шүүхийн шийдвэрт нөлөөлөхгүй байх, “шүүгчид чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах зайлшгүй дэмжлэгийг үзүүлэх” зэрэг чиг үүргүүд хамаарна.¹⁷

Шотландын гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн 2006 оны 2 сард “Шотландын шүүхийн байгууллага, түүний удирдлагыг боловсронгуй болгох, шүүхийн захиргааны өдөр тутмын ажилд гүйцэтгэх эрх мэдлийн оролцоог бууруулах, мөн шүүхийн ёс зүйн зөрчлийн талаарх журмыг боловсруулах” саналыг боловсруулсан. Тухайн бичиг баримтыг анхны хэлэлцүүлгээр таатай хүлээж аваагүй. Шерифийн Холбоо (шүүгчдийн холбоо), Магистрат ба шүүгчдийн нөхөрлөлийн холбоо нь санал болгож буй томилгооны журам нь шүүгчийн тогтвортой ажиллахад нь муугаар

14 Гардиан (НВУ), 2006.9.4

15 Дэлгэрэнгүй мэдээллийг www.islo.gov.uk сайтаас үзнэ үү.

16 Үндсэн хуулийн шинэчлэлийн акт 2005, s 3 (1).

17 Мөн тэнд s 3 (5) ба 3 (6) (b).

нөлөөлж, гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүнээс шүүхийн үйл ажиллагаанд зохисгүй нөлөө үзүүлэх аюултай гэж мэдэгдсэн.¹⁸ Хойд Ирландын Шүүхийн тухай 2002 оны хуульд “шударга ёсыг сахиулах, хууль хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий” аливаа этгээд нь шүүхийн бие даасан байдлыг хүндэтгэх ёстой хэмээн заажээ

Шүүхийн ил тод байдал

2002 онд Шотландаас эхлэн, нийт НВУ даяар, бүх шүүн таслах ажиллагааны томилгооны журмыг шинэчлэсэн. 2005 оны ҮША-д заасны дагуу 2006 оны 4 сард, Англи, Уэльсэд Шүүгч томилох зөвлөл байгуулагдсан. Энэхүү хараат бус байгууллага нь, хуульч мэргэжлийн болон мэргэжлийн бус хүмүүсээс бүрдэнэ. Мэргэжлийн бус хүн тэргүүлэх бөгөөд ур чадварт суурилсан тогтолцоонд тулгуурлан нэр дэвшигчдийг сонгох, зөвлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Лорд Канцлераар томилуулахаар нэг сул орон тоонд нэг нэр дэвшигчийг санал болгоно.¹⁹ Одоогоор магистратуудын томилгоонд уг журмыг хэрэгжүүлээгүй боловч, цаашид уг журмын дагуу томилогдно. Үндсэн хуулийн Хэрэг эрхлэх газар (ҮХГ) нь сонгон шалгаруулалтын процессыг эрхлэн явуулж байна. Шинэ Дээд шүүхийн гишүүдийг томилох ажлыг гүйцэтгэхээр тусгай байгууллага байгуулагдан ажиллана. Бүх томилгооны зөвлөл нь, Төлөөллийн танхим дахь Үндсэн хуулийн шинэчлэлийн Сонгох хороонд томилгооны процессын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлэх үүрэгтэй.²⁰ Англи, Уэльсэд шүүхийн томилгоотой холбоотой гомдлыг шинэ Шүүхийн томилгоо ба Ёс зүйн Омбудсмэн авч хэлэлцэнэ.²¹

НВУ-ын шинэ Дээд шүүх 2009 оноос үйл ажиллагаагаа эхлэн хэрэгжүүлнэ

2005 оны ҮША-нд НВУ-д шинэ Дээд шүүхийг байгуулах талаар заасан. Давж заалдах эцсийн шатны шүүгчид нь Лордын танхимийн гишүүд байхаа больж, байгууллагын хувьд болон байршлын хувьд бие даасан байдалтай байна. Шинэ Дээд шүүх нь, парламентын эсрэг талд Мидлсекс Гилдхолд байрлах болно.²² Шинэ

18 МШНХ, ‘Шотландын гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүнд зөвлөх бичиг “Орчин үеийн Шотландад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь”’, at www.scotland.gov.uk/Resource/Doc/925/0034075.pdf#search_%22CMJA%20response%20to%20strengthening%20judicial%20independence%20scotland%22

19 www.judicialappointments.gov.uk

20 Constitutional Affairs Select Committee.. Үндсэн хуулийн Хэрэг эрхлэх Сонгох Хороо, ‘Шүүгч томилох хорооны үйл ажиллагаа’, Хүндэт Лорд шүүгч Уша Прашар ба Шүүхийн томилгооны зөвлөлийн мэргэжлийн бус гишүүний засварлаагүй гар бичмэл, аман баримтаас. 2006.7.18. НС 1554-1 -ээр хэвлэгднэ.

21 www.judicialombudsman.gov.uk

22 www.dca.gov.uk/supreme/index.htm

Дээд шүүхийн хэрэгцээ, түүнийг хэрхэн ажиллуулах талаар нэлээд хэлэлцсэн.²³ ҮХГ нь 2 үндэслэл гарган тавьсан. Нэгт: Одоогийн нөхцөл байдал нь гүйцэтгэх эрх мэдлээс тусгаар, ард түмэнд итгэл төрүүлэхүйц, бүрэн хараат бус шүүх байна уу гэдэг асуудал, хоёрт: олон туршлагатай, ахмад шүүгчдийн одоогийн явцуу ажлын нөхцлийг өөрчилж, илүү сайн боломж, нөхцлөөр хангах.²⁴ 2003 оны 4 сард Европын Зөвлөлөөс ирүүлсэн илтгэлд, Лорд Канцлерийн шүүхийн чиг үүргийг хүчингүй болгож, бие даасан шинэ Дээд шүүх байгуулах талаар тусгасан.²⁵ Түүнчлэн, энэхүү өөрчлөлт нь НВУ-ын шүүх тогтолцоо нь Европын өнөөгийн практикт нийцнэ гэсэн үг.

Шүүгчийн ёс зүй, хариуцлага

НВУ-ын шүүгчид шийдвэрээ бичгээр тайлбарлах ёстой байдаг бөгөөд тэр нь давж заалдах шатанд сайтар хянагдах боломжтой байдаг юм. Мөн жил бүр өөрийн үйл ажиллагааг хариуцан тайлагнаж, интернетэд байршуулж байх практик тогтоод байна. Түүнээс гадна, шүүгчид нь тодорхой асуудлыг Сонгох хорооны өмнө тайлбарлахаар дуудагдаж байсан жишээ бий. Шаардлагатай бол уг журам цаашид үргэлжлэн хэрэгжих бөгөөд 2005 оны ҮША-нд зааснаар, НВУ-ын аль ч хэсгийн Ерөнхий шүүгч нь парламентад “өөрт буюу бусад шүүгчдэд хамааралтай асуудлаар, өөрөөр хэлбэл НВУ-ын тухайн хэсгийн шүүхийн захиргааг төлөөлөн” бичгээр хүсэлт ирүүлж болно.²⁶

Англи, Уэльсэд шүүгчдийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам тодорхой болж, нийтийн хүртээл болсон нь, Шүүгчийн ёс зүйн дүрэм нэртэйгээр интернетэд байршсан. Мөн шүүгчийн ёс зүйтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх шинэ Шүүхийн өргөдөл, гомдлын алба ажиллана. Хүлээн авч хэлэлцэх эхний хэрэг нь харьцангуй залуу шүүгчид болох Хан, “Ж” нарын асуудал бөгөөд тэд хоёул хууль бус цагаачийг хөлслөн ажиллуулж, хууль бус харилцаа тогтоосон хэргээр шалгагдсан.²⁷ Шүүхийн олон нийттэй харилцах алба 2006 оны 10 сард мэдээлснээр, Лорд Канцлер болон Лорд Ерөнхий шүүгч нь, “хангалттай үндэслэл байгаа тул Шүүхийн өргөдөл, гомдлын алба нь зөрчлийг

23 Жишээг, Эндрью Лэ Сюэр., НВУ –н шинэ дээд шүүхийн барилга (Оксфорд: Оксфордын Их сургуулийн хэвлэл, 2003); news.bbc.co.uk/1/hi/uk_politics/3532197.stm –аас үзнэ үү.

24 Үндсэн хуулийн Хэрэг эрхлэх газар (ҮХГ), Үндсэн хуулийн шинэчлэл: Нэгдсэн Вант улсын Дээд шүүх (Лондон:ҮХГ, 2003). ҮХГ –ийн мэдээлснээр, нэг шүүгч ажлын өрөө ч байхгүй байна.

25 Европын Зөвлөл, “НВУ-ын Үндсэн хуулийн тогтолцоон дахь Лорд Канцлерийн алба”, баримт 9798, 2003.4.1

26 2005 оны Үндсэн хуулийн шинэчлэлийн акт. s 5(1)

27 Гардиан (НВУ), 2006.10.20; www.cps.gov.uk/news/pressreleases/158_06.html

шалгах ажиллагааг үргэлжлүүлнэ” гэж дүгнэлт гаргасан. Зөрчлийг шалгаж дуустал тэдгээрийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх болно.²⁸

Дүгнэлт

Англи, Уэльсэд саяхан хийгдсэн шинэчлэлүүд нь, шүүх засаглалд тулгараад байсан нээлттэй, ил тод байдлын асуудлыг нэлээд сайн шийдвэрлэсэн. Шүүгчийг сонгох, томилох журмыг сайжруулах зэргээр ил тод байдлыг дээшлүүлж, мэдээлэл хүлээн авах чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг илүү ихээр нэмэгдүүлсэн. Гэвч, шүүхийн тогтолцоог өргөн хүрээнд нь авч үзвэл байгууллагын тогтолцооны шинжтэй урхагтай асуудал болон зарим эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага дахь авлигын асуудал зэрэг нь шийдвэрлэгдээгүй үлдсэн. Эдгээр асуудлын талаарх мэдээлэл нэмэгдсээр байгаа боловч шүүх, хуулийн байгууллагын дотооддоо нарийн хяналт тавих чадвар болон идэвхитэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл хослосноор тэдгээр асуудлуудыг олж тодорхойлон, шийдвэрлэхээр ажиллаж байна.

*Кэйла Лики, Өмгөөлөгч
(одоогоор өмгөөлөл хийхгүй байгаа),
Лондоны Их сургууль*

Замбийн шүүхийг шинэчлэхийн төлөө тэмцэл

Эрх зүйн тогтолцоо: Заншлын эрх зүй, мэтгэлцэх болон олон талт зарчим
100,000 хүнд ногдох шүүгчийн тоо: 0,4¹
Шүүгчийн цалингийн эхлэх хэмжээ: 26,340 ам.доллар²
Дээд шүүхийн шүүгчийн цалин: 27,340 ам.доллар³
Нэг хүнд ногдох УНБ: 490 ам.доллар⁴
Шүүхийн жилийн төсөв: 16,0 сая ам.доллар⁵
Жилийн нийт төсөв: 2,6 тэрбум ам.доллар⁶
Жилийн төсөвт эзлэх хувь: 0,6
Шүүхийн шийдвэрийг шүүхийн хамгийн дээд шатны шүүх хүртэл давж заалдах боломжтой эсэх: Тийм
Шүүхийн сахилгын асуудал хариуцсан байгууллага ба захиргааны удирдлага: Хараат бус
Шүүхээс гаргасан бүх шийдвэрүүд нийтэд ил тод байдаг: Үгүй
Шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх: Тийм

1 Шүүхийн бүртгэл /2006/ 2 Хууль зүйн баримт бичиг. Дугаар 55 /2005/ 3 Мөн тэнд.

4 Дэлхийн банкны хөгжлийн түвшинг тодорхойлогч (2005)

5 Замбийн бүгд найрамдах улсын төсөв /2005/ 6 Мөн тэнд.

Замбийн шүүхийн тогтолцоог Дээд шүүх тэргүүлж, түүний дор 453 орон нутгийн шүүх ажиллана. Тэдгээрийн дунд дүүрэг бүрт 1 нийт 53 дунд шатны шүүх, 9 мужид байнгын ажиллагаатай 4 дээд шатны шүүх байна. Замби холимог эрх зүйн тогтолцоотой бөгөөд, 73 угсаатны бүлгийн уламжлалт эрх зүй, Английн түгээмэл эрх зүйд суурилсан үндсэн хуулийн эрх зүй зэрэгцэн оршино. Дээд шатны шүүхүүд нь эрүү, иргэний болон, давж заалдсан хэргүүдийг хянан хэлэлцэх бөгөөд түгээмэл эрх зүйг мөрдөнө. Орон нутгийн шүүхүүд уламжлалын эрх зүйг удирдлага болгоно. Эдгээр эрх зүйн хэм хэмжээнүүд хоорондоо зөрчилдөх нь нийтлэг. Зан заншилтай зөрчилдөх тул, ихэвчлэн гэрлэлт, эд хөрөнгө, өв залгамжлалтай холбоотой хэрэг, маргааныг шийдвэрлэхэд түгээмэл эрх зүйгээс, уламжлалын эрх зүйг хэрэглэх нь илүү. Орон нутгийн шүүгчид албан ёсны сургалтад хамрагддаггүй, харин туршлага, ерөнхий мэдрэмж, заншлыг харгалзан үзнэ.¹

Доод шатны албан ёсны шүүхэд, хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн байх шаардлагатай 3 төрлийн магистрат байдаг нь орон нутгийн магистрат, орон нутгийн ахмад магистрат, орон нутгийн ерөнхий магистрат нар болно. Ерөнхийлөгч нь, Дээд болон дээд шатны шүүгчдийг, орон нутгийн ерөнхий магистрат нарын дундаас туршлага, чадварыг харгалзан томилох бөгөөд үндэсний чуулган тэдгээрийг батална.

1 АНУ төрийн департамент, Замбийн Бүгд найрамдах улсын баримт (Вашингтон Д.С.: 2005).

Дээд шатны шүүхүүд авлигаас ангид бус байна

Замбид авлига нь олон төрийн байгууллага болон шүүхэд сөргөөр нөлөөлж байна.² 2004 онд Дэлхийн банкнаас өрх гэр, төрийн алба, бизнесийн байгууллагуудын дунд авлигын талаарх хэд хэдэн судалгаа явуулсан.³ Өрхийн 40, бизнесийн байгууллагын менежерүүдийн 25 хувь нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхайлахын тулд хээл хахууль өгдөг гэжээ. Энэ нь шүүхийн тогтолцоонд иргэдийн итгэх итгэл хэр суларсаныг харуулна. Тухайлбал: судалгаанд оролцсон өрхийн 80 хувь нь шүүхийн үйлчилгээ хэрэгтэй боловч, шүүхээр үйлчлүүлэх эсэхээ мэдэхгүй, бизнесийн байгууллагын 60 хувь нь мөнгийн өгүүлжээ.⁴

Орон нутгийн шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх явц хамгийн хурдан байдгийн учир нь тэдний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа энгийн байдаг оршино. Гэвч зарим шүүгчид энэхүү давуу байдлыг ашиглан хээл хахууль өгөхийг шаарддаг. Жишээ нь: 70 настай орон нутгийн шүүгч асан, 2002 онд авлигын хэрэгт холбогдсон гомдол гаргагчаас K50 000 (12,95 ам.доллар) өгөхийг шаардсан хэрэгт буруутай нь тогтоогдсон.⁵

Доод шатны шүүхүүдэд авлига ихээхэн газар авсан гэх боловч энэ нь дээд шатны шүүхүүдэд байхгүй гэсэн үг биш юм. 2002 онд Пост сонин нийтийн хөрөнгөнөөс 40 сая ам. доллар завшсан залилангийн талаарх мэдээллийг илрүүлэн нийтлэсэн. Уг хэрэгт Ерөнхийлөгч асан Фредерик Чилуба, түүний тагнуулын газрын дарга Завиер Чунгу, хэд хэдэн сайд нар, түүнчлэн 168,000 ам.долларын хээл хахууль авсан Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Матью Нгулубу нар холбогджээ.⁶ Ерөнхий шүүгч асан уг хөрөнгийг хүлээн авсан гэдгийг няцаагаагүй бөгөөд тэрээр ямар нэгэн ял шийтгэл хүлээлгүй тэтгэвэртээ гарсан байна.⁷

Өмнөх засаглалын үед шүүх нь төрийн эрх мэдэлтнүүдэд үйлчилдэг гэж шүүмжлүүлж байсан. Анхаарал татахуйц нэгэн жишээ бол, Ерөнхийлөгч асан Чилубагийн сонгуулийн маргаантай хэрэгт дээд шүүх гүйцэтгэх эрх мэдлийн дарамтанд орсон хэмээн олон нийт таамагладаг явдал юм.⁸ Тэр үеийн дээд шүүхийн Ерөнхий шүүгч асан Матью Нгулубу их хэмжээний мөнгө нууцаар хүлээн авч, гүйцэтгэх засаглалтай холбоотой хэрэгт “зөөлөн” хандаж байгаа нь мэдрэгддэг байлаа. Гэхдээ засгийн газрын Үндсэн хууль зөрчсөн, эрх мэдлээ

2 Дэлхийн банк, Замбийн үндэсний засаглалын талаарх судалгаа (Вашингтон D.C.: 2003).

3 Мөн тэнд

4 Мөн тэнд

5 Авилгын эсрэг мэдээ. Замби. 2000 оны 4-6 сар

6 Пост. Замби. 2002.8.7

7 Замнэт. Замби. 2002.7.9

8 Жишээ нь. Кристин Мулундика түүний талынхан ард түмний эсрэг, Замбийн дээд шүүх SCZ/25/1995.

урвуулан ашигласан үйл ажиллагааны эсрэг шүүхээс шүүн таслах ажиллагаа явуулж байсан хэд хэдэн тохиолдол буй.

Дэлхийн банкны 2004 оны судалгаагаар, бизнесийн менежерүүдийн 52 хувь нь шүүх нь засгийн газар, эдийн засгийн дарамтнаас хараат бөгөөд шударга, ил тод үйл ажиллагаа явуулдаггүй гэжээ.⁹ Зарим судлаачдын тайлбараас үзвэл, шүүгчид нь гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байх байна гэх боловч судалгааны дүнгээс үзвэл шүүхээр үйлчлүүлэгчид бодит байдал дээр тийм биш хэмээн үзжээ.¹⁰ Үүний нэгэн шалтгаан нь, Ерөнхийлөгчид олгогдсон үзэмжээрээ томилох эрх мэдэл нь шударга, урамшуулах тогтолцоонд тулгуурласан, улс төрийн товч байдлыг хадгалсан шалгууруудыг үгүйсгэх өргөн боломжийг түүнд олгодог. Авлигад ихээхэн автсан шүүгчдийг доод шатны шүүхээс олж болох ба тэдгээр нь дээд шатны байгууллагад шилжсэн тохиолдолд сурвалжлах, судлах зүйл нилээдгүй гарах болов уу.¹¹

Санхүү, хүний нөөцийн тарчиг байдал

Шүүгч, магистратуудын цалин хангалттай бус байгаа бөгөөд ялангуяа доод шатны шүүгчдийн цалин хөлс хүрэлцээгүй байна. 1997 оны 7 сард шүүгчдийн цалинг 2 дахин нэмсэн боловч, анхан шатны шүүхийн шүүгч, магистратуудад нэмэгдэл олгоогүй.¹²

Хүрэлцээгүй шүүгчдийн тоо шийдвэрлэх ёстой хэргийн тоо хоорондоо үл зохицно. Хууль зүйн яамны мэдээлснээр 2002 онд, 65 дүүрэгт 150 магистрат, 453 орон нутгийн шүүхэд 900 орчим шүүгч нар ажиллаж байна. Шүүхийн захиргааны ерөнхий зохицуулагчийн мэдээлснээр, 23 магистрат 72 магистратын хийх ёстой ажлыг гүйцэтгэж байна. Орон нутгийн шүүхийн тухай хуулийн 54-д заасны дагуу, шүүхийн албаны зөвлөл нь тэнцэнэ гэж үзсэн бүхий л хүмүүсийг олдож байгаа хэмжээгээр нь л орон нутгийн шүүхийн шүүгч, ажилтнуудаар томилж байгаа ажээ.¹³ Магистратуудын тоо цөөн, сургалт хангалтгүй байгаа нь чадвар муутай хувь хүмүүс (зарим нь чөлөөнд гарсан жирийн нэг төрийн албан хаагч байх бөгөөд тэднийг омгийн ахлагч нар санал болгодог) ихээхэн нарийн зохицуулалттай хууль хэрэглэж, маргаантай хүнд хэргүүдийг шийдвэрлэхэд хүргэж байгаа бөгөөд энэ тохиолдолд зөвхөн хэргийн оролцогчдыг төлөөлөн уг хэрэг дээр ажиллаж буй өмгөөлөгч нарт найдах хэрэг гарна. Ийм байдлаар шүүгчид нь үйлчлүүлэгчдээ

9 Дэлхийн банк 2003

10 Олон улсын хуульчдийн хороо /ОУХХ/, ‘Шүүхийн эсрэг дайралт – Замби 2002’ /Женев. ОУХХ, 2002/ at www.icj.org

11 Нчеклеко: Замбийн авилгын талаарх Афронэтийн уншигчид (Люсака: Афронэт, 2002).

12 Замбийн онлайн мэдээ /Замби/, 1997 оны 7 сарын 7

13 ОУХХ /2002 он/

хамгийн ашигтай шийдвэр гаргуулах хүсэлтэй өмгөөлөгчдөөс хараат болоход бэлэн байдаг.

Жишээ нь, Люсакагийн нэгэн магистрат Сидней Чилеш гэгчийг “марихуан” тарьж ургуулсан, худалдаалсан гэж буруутган 5.1 сая (1,322 ам.доллар)-аар торгосон. Тэрхүү магистрат нь ийм төрлийн хэрэгт торгуулийн ял байхгүй байхад уг магистрат нь өмгөөлөгч талын буруу тайлбарыг шууд хүлээн авч, торгууль ногдуулсан нь өөрөө хуулиа мэдэхгүй байдлаас шалтгаалсан байжээ. Давж заалдах шатны шүүгч 5 жилийн хүнд хөдөлмөр хийлгэн хорих ял оноохын оронд хуулийг ингэж илт буруу хэрэглэсэн тохиолдлыг гайхан хүлээн авчээ.¹⁴ Мэдээллийн хомсдол, наад захын хэрэгцээний нөөц дутагдалтай байдаг нь асуудлыг улам дордуулах бөгөөд анхан шатны шүүгчид уламжлалт эрх зүйн мэдлэгтээ тулгуурлан шийдвэр гаргаж байна. Учир нь орон нутгийн шүүхүүдэд хууль эрх зүйн шинжлэх ухааны мэдлэг, мэдээлэл олгох ном зохиол хүрдэггүй.¹⁵

Засгийн газар нь шүүгчдийг тоног төхөөрөмж, ажлын байр, орон сууцаар хангах үүрэг хүлээдэг боловч шүүхийн барилгын асуудал ихээхэн цочирдмоор хүнд нөхцөлтэй байна. Магистратууд нь дээд шатны шүүгчдийн адил өөрийн номын сангаар үйлчлүүлэх, хэргийн цахим ажиллагаа явуулах боломжоор хангагдаагүй. Энэ нь ажлын үр дүнг бууруулж, хэргийн ажиллагааг удаашруулдаг. Ерөнхийлөгч Лэви Мвоновосо 2006 оны 3 сард Люсакад болсон магистратын шүүхийн байрны нээлтэн дээр хэлсэн үгэндээ уг асуудлыг хүлээн зөвшөөрсөн.¹⁶ Энэхүү доголдол нь олон нийтийн итгэлийг сулруулж, дотор ажиллагсдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байна. Улс төрч болохоосоо өмнө хуульчаар ажиллаж байсны хувьд Ерөнхийлөгч энэ бүх байдлыг сайн ойлгож байгаагаар илэрхийлээд шүүхийн ажиллах нөхцөлийг сайжруулах, шүүхийн ажилтнуудын чадварыг дээшлүүлэх, тэдэнд сургалт зохион байгуулах, шүүхийн орон байрыг орчин үеийн болгох, шинээр барих асуудлыг шийдвэрлэх талаарх хөтөлбөрийг дэмжиж ажиллахаа амалсан.

“Шинэ тохиролцоо” өөртөө шүүхийн шинэтгэлийн асуудлыг тусгасан

Ерөнхийлөгч Мвоновосо 2002 онд албан тушаалаа аваад авлигын эсрэг үйл ажиллагааг хүчтэй явуулж эхэлсэн. Түүний “Шинэ тохиролцоо” хэмээх хөтөлбөр нь Замбийг авлигаас ангид хөгжүүлэх бодлого барьж байв.¹⁷ Шүүхийн шинэтгэлийн өнөөгийн чиглэл нь шүүхийн барилгуудыг шинээр барьж, бүрэн

14 Сидней Чилеш ард түмний эсрэг 05/2004, www.zamlil.ac.zm

15 Германы хөгжлийн алба (ГХА), “Замби: Хууль зүйн шинэчлэл – нийгмийг өөрчлөх түлхүүр”, www.zambia.ded.de

16 2006 оны 3 сарын 28. Ерөнхийлөгчийн хэлсэн үг, www.statehouse.gov.zm/index.php?option_com_content&task_view&id_69&Itemid_5

17 Шинэ хэлэлцээрийг www.statehouse.gov.zm/index.php?option_com_content&task_view&id_87&Itemid_55 гэсэн вэб хуудаснаас үзэж болно

тоноглох явдал юм. Засгийн газар Луапула ба өмнөд мужууд дахь шүүхүүдэд хөрөнгө хуваарилж, дээрх шинэтгэлийг хэрэгжүүлж байгаа бөгөөд донор орнууд ихээхэн санхүүгийн тусламж үзүүлж байна.

Люсака дахь Магистратын цогцолборыг барихад зориулж Норвеги улс 3 сая орчим ам.доллар, Швед улс тоноглоход зориулж 650,000 орчим ам.доллар, Хятад улс цахим бичлэгийн төхөөрөмжүүдийг шүүхийн ажилтнуудад тусламжаар өгсөн.¹⁸

АНУ шүүхэд суурилсан эвлэрүүлэн зуучлах үйлчилгээний хөтөлбөрийг 2000 оноос хэрэгжүүлж эхлээд, 2005 онд АНУ-д бэлтгэгдсэн 90 Замбийн иргэд 1,800 орчим удаа эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ үзүүлсэн.¹⁹ Германы хөгжлийн агентлаг GTZ нь шүүхтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд, Замбийн хууль зүйн хөгжлийн хороо, хөдөөгийн ТББ-ууд нь хүн амын доторх эмэгтэйчүүдийн эрх зүйн байдлыг сайжруулах, орон нутгийн шүүхийн ажилтнуудын хүрээнд хууль, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон нийгмийн асуудлаар сургалт явуулж, анхаарлаа хандуулж байна.²⁰

Замбийн Авлигын эсрэг хороо нь авлигатай тэмцэхийн тулд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах хэрэгтэй болохыг мэдэгдэж, Үндэсний авлигын эсрэг бодлого, стратегийг боловсруулсан. Үүнд авлигын эсрэг үйл ажиллагаагаа төрийн гол байгууллагуудад чиглүүлж, тэдгээрт авлигаас урьдчилан сэргийлэх шинэ арга хэмжээнүүдийг тусгасан.²¹ 2006 оны шүүгчийн ёс зүйн дүрмээр (нэмэлт, өөрчлөлт) шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зохицуулж байгаа бөгөөд, түүнд шүүгчийн эсрэг гомдлыг хянан шийдвэрлэх эрх хэмжээ бүхий тусдаа байгууллагыг үүсгэн байгуулах талаар тусгасан.²²

Хэдий тийм ч авлига байсаар байна гэсэн олон нийтийн төсөөлөл өссөөр байна

Ерөнхийлөгч Мвоновосо амласан ёсоороо төрийн байгууллагууд дахь авлигын эсрэг чадах бүхнээ хийсэн боловч, Люсакагийн иргэдийн дунд 2005 онд хийсэн судалгаагаар шүүхүүд сайжраагүй гэсэн хариулт өгсөн нь урам хугарахад хүргэж байна. Албан байгууллагуудыг авлигын үзүүлэлтээр жагсаахад шүүхийн байдал улам дордсон.

18 www.statehouse.gov.zm/index.php?option_com_content&task_view&id_69&Itemid_5

19 2005 оны 3 сарын 30, zambia.usembassy.gov/zambia/pr033005.html

20 ЖТЗ.

21 Хорооны талаарх товч мэдээллийг www.icac.org.hk/news/issue26eng/button4.htm вэб хуудаснаас үзнэ үү.

22 Бүрэн эхийг www.zamlit.ac.zm вэб сайтад байрлах Замбийн хууль зүйн мэдээллийн төвөөс үзэж болно.

Судалгаанд оролцсогчдын 60 хувь нь энэ засгийн газар өмнөх засгийн газраас илүү авлигын асуудлыг нухацтайгаар авч үзэж, тодорхой ажил хийж байна гэж үнэлжээ.²³ Шүүхийн байрыг сайжруулах, ажилтнуудын сургалтыг зохион байгуулах гэх зэрэг амлалтууд хэрэгжих эсэх нь хүлээлт үүсгэж, анхаарал татсан хэвээр байна. Үүний зэрэгцээ дараах асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй.

- Шүүхэд шаардлагатай байгаа ажилтнуудыг шинээр томилох, мэргэжлийн сургалтуудыг үргэлжлүүлэн чанартай зохион байгуулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх
- Чадвартай шүүхийн ажилтан, албан хаагчдыг бэлтгэх, ирээдүйн үргэлжилсэн сургалтын талаар бодлого боловсруулах зайлшгүй шаардлагатай
- Шүүгч, магистрат, анхан шатны шүүгчдийг томилох аргыг шинэчлэх
- Тусламж үзүүлэх донор байгууллагууд, хөтөлбөр хэрэгжүүлэгч нар хөтөлбөрөө боловсруулахаас өмнө шүүхэд аль хэсэгт, ямар асуудлуудад дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай байгаа талаар шүүхийнхэнтэй зөвлөлдөх хэрэгтэй

*Давиес Чикаланга, Гүүдвел Лунгу ба Нгоза Ези
(Люсака дахь Замбын ТИ)*

23 Мусонда Лимба, Люсака дахь санал асуулга: Оршин суугчдийн авилгын талаарх үнэлэмж (Люсака: Замбийн ТИ, 2006). www.tizambia.org.zm